



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА САНДАГИЙН БЯМБАЦОГТ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2026.05.29 № 3Г-1/57

танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг төслийг дагалдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Н.УЧРАЛ

000264001933



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.05.21 № МЭТ/1757
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг төслийг дагалдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгнө үү.

Хавсралт ³⁰⁵ хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Б.ЭНХБАЯР

000265006594

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 11 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

“14.ХЭЛЭЛЦСЭН нь: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэн дэмжээд, Засгийн газрын гишүүдээс гаргасан саналыг тусган Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2026.04.07 № 01/2856

танай 2026.03.27 ны № 01/1035 -т

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД
Т.АУБАКИР ТАНАА

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгож байна.

Хүндэтгэсэн,



З.МЭНДСАЙХАН

9761000500



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26-75-33
Цахим шуудан: info@mojha.gov.mn
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2026.04.10	№	1/1781
танай	2026.03.27	-ны № 01/1035 -т


ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД Т.АУБАКИР ТАНАА

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгов.



Хууль зүй, дотоод хэргийн яам
Удирдлага
Сайд
Сайнбуян Амарсайхан
2026.04.14 14:52

БАТЛАВ.
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД



Т.АУБАКИР

2025 оны 12 сарын 12 өдөр

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД



Б.ЭНХБАЯР

2025 оны 12 сарын 12 өдөр

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна. Үүнд:

1.1. Хууль зүйн үндэслэл

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай бие даасан хууль 2008 онд батлагдсанаас хойш удирдлагын тогтолцоо, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан, зөвлөлийн хариуцах чиг үүрэг, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын ангиллыг тодорхой болгох зэрэг асуудлаар 2012, 2015 онуудад томоохон нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Манай улс Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын 155 (Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай), 167 (Барилгын аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай), 176 (Уурхай дахь аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай) дугаар конвенцод тус тус нэгдэн орсноор үндэсний хэмжээнд ажилтан хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төрийн бодлогоор зохицуулах, хэрэгжилтийг хангуулах үүргийг олон улсын өмнө хүлээсэн.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 2.6.1-д хөдөлмөрийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг шинэчилж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн, цалин хөлсний тогтолцоог боловсронгуй болгох, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.2.11-д Хөдөлмөр, нийгмийн гурван талт оролцоонд тулгуурлан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тогтолцоог сайжруулах, 2.1.1.16-д Эрэгтэйчүүдийн зонхилон ажилладаг салбарт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийг бууруулах зорилт тус тус дэвшүүлсэн.

Түүнчлэн Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын багц хууль, Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль тус тус

шинэчлэн батлагдсан нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг зайлшгүй шинэчлэн боловсруулах хэрэгцээг бий болгож байна.

1.2.Практик шаардлага

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг шинэчлэн боловсруулах хэрэгцээ шаардлагыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу урьдчилан тандан судалсны үндсэн дээр хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах дараах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон. Үүнд:

1.Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаарх конвенцууд нь “Occupational Safety and Health” буюу “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд” гэсэн өргөн агуулгаар тодорхойлогдож, бусад улс орнууд ч “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд” гэсэн нэршлээр хуулиа батлан мөрдөж байна. Мөн Хөдөлмөрийн тухай хуулийн 2021 оны шинэчилсэн найруулгаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг олон улсын жишгээр “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд” гэж нэрлэж, ажилтныг хөдөлмөрийн хэвийн нөхцөлөөр хангах ажил олгогчийн үүргийг тодорхой болгон хуульчилсан.

Иймд хуулийн нэршлийн хувьд олон улсын хэм хэмжээ, шаардлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулах хуулийн төслийн нэрийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хууль гэж томъёолно.

2.Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй бүтээн байгуулалтын томоохон төслүүд, эдийн засгийн өсөлтийн улмаас ажиллах хүчний эрэлт 2035 онд 19.1 хувиар, үүнээс эрсдэл өндөртэй уул уурхай, олборлолтын салбарт 32.5, боловсруулах үйлдвэрт 63.3, барилгын салбарт 55.9 мянган хүнээр нэмэгдэх төлөвтэйг хөдөлмөрийн зах зээлийн таамаглалаар тодорхойлжээ.

Манай улсын нийт хүн амын 39 хувь нь ажиллах хүч бөгөөд ажил хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн 41 хувь (521 мянган хүн) нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин үүсэх эрсдэлтэй салбарт ажиллаж байна.

Улсын хэмжээнд 1972-2024 онд 10359 хүн мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан ба сүүлийн 5 жилд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын 2125 тохиолдол бүртгэгдэж, 275 хүн нас барсан байна.

Хөдөлмөрийн эрүүл мэндийн зохицуулах харилцаа, агуулга нь хөдөлмөрийн эрүүл ахуйн асуудлаас өргөн хүрээтэй тул ажилтны эрүүл мэндийн үзлэг, тандалт, ажил мэргэжлийн тохироо, сэргээн засах тусламж үйлчилгээний талаарх зохицуулалтыг олон улсын конвенц, хэм хэмжээнд нийцүүлэн сайжруулж, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт илрүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх үр нөлөөг нэмэгдүүлэх шаардлага үүсэж байна.

3.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний тогтолцоо нэгдмэл биш, санхүүжилтийн эх үүсвэр, мэргэжлийн байгууллага, асуудал хариуцсан мэргэжилтний чиг үүрэг, салбар дундын уялдаа холбоог нарийвчлан тодорхойлоогүй, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, албан бус салбарт ажиллагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал зохицуулалтгүйгээс хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Манай яамнаас олон улсын системийн инженерчлэлийн аргачлалыг ашиглан салбарын хуулиуддаа системийн шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд хийсэн шинжилгээгээр хуулийн зорилгыг хүрэх үр дүнд үндэслэн тодорхойлж, оролцогч талуудын эрх, үүргийг ангилах, хэмжиж болохуйц үр дүн, эргэх холбоог сайжруулан боловсруулахыг зөвлөж, хуулийн системийн хэв шинжүүдийг 60.7 хувь бүрдүүлсэн гэж үзсэн байна.

4.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндэд тавигдах шаардлагыг тодорхой болгож, өндөрт ажиллах аюулгүй ажиллагаа, хязгаарлагдмал орчин, хими, биологи, эргономик, нийгэм-сэтгэл зүйн хүчин зүйлс зэрэгт тавих шаардлагыг шинээр зохицуулах хэрэгцээ үүсээд байна.

5.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үйл ажиллагааны үндсэн зарчим нь осол, өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгддэг. Одоогоор үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоо бүрдээгүй, даатгалын сангаас ажил олгогч, даатгуулагчид үзүүлэх үйлчилгээ хомс байна. Иймд ажил хөдөлмөртэй холбоотойгоор үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, уг үйл ажиллагааг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалтай уялдуулах шаардлагатай юм.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2, 25.1.4. дэх заалтыг тус тус үндэслэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиар зохицуулж байсан харилцааг өргөжүүлж, нийгэм, эдийн засагт гарч байгаа шинэ өөрчлөлт, чиг хандлагатай уялдуулан шинэчилсэн найруулгын төсөл хэлбэрээр боловсруулна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын зорилт нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний бодлого, зарчмыг тодорхойлж, хяналтын тогтолцоо, ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг хангах, ажилтан, хөдөлмөр эрхлэгч иргэнийг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, ажил хөдөлмөртэй холбоотой осол, өвчнөөс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн салбарын хөгжлийн чиг хандлага, олон улсын гэрээ, конвенцын шаардлагад нийцүүлэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хууль нэртэйгээр шинэчилсэн найруулгын төслийг бэлтгэж, ажил, хөдөлмөр эрхлэгч хүний эрүүл мэнд, аюулгүй байдлыг ажлын байрны сөрөг, аюултай хүчин зүйлсээс хамгаалах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд тулгамдсан асуудлыг үндэсний хэмжээнд шийдвэрлэх бүтэц, тогтолцооны шинэлэг зохицуулалтыг тусгана. Хуулийн төсөлд дараах асуудлыг зохицуулахаар тусгана. Үүнд:

1/хуулийн нийтлэг үндэслэл, зорилт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлаар үндэсний хэмжээнд баримтлах бодлого, зарчмыг тусгахаас гадна Хөдөлмөрийн тухай хуультай уялдуулан хамрах хүрээг тодорхойлно;

2/үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомж, стандарт, техникийн зохицуулалт, шаардлагыг тодорхойлж,

хязгаарлагдмал орчин, хими, биологи, эргономик, нийгэм-сэтгэл зүйн хүчин зүйлс зэрэгт тавих шаардлагыг шинээр зохицуулна;

3/хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний тогтолцоог өргөжүүлэн салбар дундын уялдаа холбоог хангаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал, төрийн хяналттай уялдуулж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжлийн байгууллагын зохицуулалтыг нэмж тусгана;

4/урьдчилан сэргийлэлтэд чиглэсэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалыг ажлын байрны эрсдэлийг бууруулах, арилгах зорилгод нийцүүлэх, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ, эрүүл мэндийн үзлэг тандалт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн цахим системийг хөгжүүлэх зэрэг зохицуулалтыг тусгана;

5/үйлдвэрлэлийн осол, аюултай тохиолдол, мэргэжлээс шалтгаалсан өвчний бүртгэл, мэдээлэл, статистик болон хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн хөдөлмөр зохицуулалт, сэргээн засах тусламж үйлчилгээ зэрэг харилцааг зохицуулна;

6/хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтын талаарх зохицуулалт, хяналт хэрэгжүүлэх байгууллагын чиг үүрэг, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хяналтын улсын байцаагчид тавих шаардлага, бүрэн эрх зэрэг асуудлыг зохицуулна;

7/хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага болон маргаан шийдвэрлэх асуудлыг зохицуулна.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар

Хуулийн төслийг боловсруулахад Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон хөдөлмөрийн таатай нөхцөлөөр хангагдах иргэний эрхийг хамгаалах зарчмыг баримтална.

Хуулийн төсөл батлагдсанаар дотоод болон гадаадын аж ахуйн нэгж, байгууллагад эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, сөрөг үр дагавар үүсэхгүй бөгөөд дараах эерэг үр дагавар бий болно. Үүнд:

- ажил, хөдөлмөр эрхлэхтэй холбоотой ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан, хяналт, цахимжилт, салбар дундын уялдаа, мэргэжлийн холбоо, оролцогч талуудын чиг үүргийг оновчтой тодорхойлж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үйлчилгээг өргөжүүлснээр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний тогтолцоо бий болно гэж үзэж байна;

- урьдчилан сэргийлэлтэд суурилсан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын зохицуулалтыг бий болгосноор ажил олгогч, даатгуулагчид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэлт, хөдөлмөрийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болон санхүүгийн дэмжлэг авах эерэг нөлөөтэй;

- Мөн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн байгууллагын эрх, үүргийг тодорхой болгосноор ажилтан эрүүл, аюулгүй ажлын байраар хангагдах нөхцөл бүрдэж, ажил, хөдөлмөр эрхлэгч хүн амын дундаж наслалт, амьдралын чанарт эерэг нөлөө үзүүлнэ;

- Хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан аливаа зохицуулалт тусгаагүй бөгөөд хууль хэрэгжсэнээр ажлын байранд ажилтан, иргэний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, эрүүл, аюулгүй байр, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулахад дэвшил гарна гэж үзэж байна.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээнд нийцсэн байх бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Барилгын тухай хууль, Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль, Малын генетик нөөцийн тухай хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Хувийн хамгаалалтын тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Шүүх шинжилгээний тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Эрүүл ахуйн тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг хүчингүй болгох хуулийн төслийг боловсруулна.✓

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Манай улс Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 155, Барилгын аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 167, Уурхай дахь аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 176 дугаар конвенцод тус тус нэгдэн орсноор үндэсний хэмжээнд ажилтан хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төрийн бодлогоор зохицуулах, хэрэгжилтийг хангуулах үүргийг олон улсын өмнө хүлээсэн.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай бие даасан хууль 2008 онд батлагдсанаас хойш удирдлагын тогтолцоо, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан, зөвлөлийн хариуцах чиг үүрэг, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын ангиллыг тодорхой болгох зэрэг асуудлаар 2012, 2015 онуудад томоохон нэмэлт, өөрчлөлт оруулсан байдаг.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2.6.1-д хөдөлмөрийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг шинэчилж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн, цалин хөлсний тогтолцоог боловсронгуй болгох, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.2.11-д Хөдөлмөр, нийгмийн гурван талт оролцоонд тулгуурлан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тогтолцоог сайжруулах, 2.1.1.16-д Эрэгтэйчүүдийн зонхилон ажилладаг салбарт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийг бууруулах зорилт тус тус дэвшүүлсэн.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй бүтээн байгуулалтын томоохон төслүүд, эдийн засгийн өсөлтийн улмаас ажиллах хүчний эрэлт 2035 онд 19.1 хувиар, үүнээс эрсдэл өндөртэй уул уурхай, олборлолтын салбарт 32.5, боловсруулах үйлдвэрт 63.3, барилгын салбарт 55.9 мянган хүнээр нэмэгдэх төлөвтэйг хөдөлмөрийн зах зээлийн таамаглалаар тодорхойлсон.

Манай Улсын нийт ажиллагчдын 38.4 хувь (521 мянган хүн) нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний эрсдэлтэй салбарт ажиллаж байгаа бөгөөд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин үүсэх эрсдэл өндөртэй ажлын байранд 224 мянган хүн нь ажиллаж байна.

Улсын хэмжээнд 1972-2025 онд 10411 хүн мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдаж, сүүлийн 5 жилд /2021-2025/ үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын 2678 тохиолдол бүртгэгдэж, нас барсан 308 хүн байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг шинэчлэн боловсруулах хэрэгцээ шаардлагыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу урьдчилан тандан судалсны үндсэн дээр хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг дараах байдлаар тодорхойлсон.

1. Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаарх конвенцууд нь “Occupational Safety and Health” буюу “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд” гэсэн өргөн агуулгаар тодорхойлогдож,

бусад улс орнууд ч “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд” гэсэн нэршлээр хуулиа батлан мөрдөж байна. Мөн Хөдөлмөрийн тухай хуулийн 2021 оны шинэчилсэн найруулгаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг олон улсын жишгээр “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд” гэж нэрлэж, ажилтныг хөдөлмөрийн хэвийн нөхцөлөөр хангах ажил олгогчийн үүргийг тодорхой болгон хуульчилсан. Иймд хуулийн нэршлийн хувьд олон улсын хэм хэмжээ, шаардлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулах хуулийн төслийн нэрийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хууль гэж томъёолно.

2. Хөдөлмөрийн эрүүл мэндийн зохицуулах харилцаа, агуулга нь хөдөлмөрийн эрүүл ахуйн асуудлаас өргөн хүрээтэй тул ажилтны эрүүл мэндийн үзлэг, тандалт, ажил мэргэжлийн тохироо, сэргээн засах тусламж үйлчилгээний талаарх зохицуулалтыг олон улсын конвенц, хэм хэмжээнд нийцүүлэн сайжруулж, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт илрүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх үр нөлөөг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндэд тавигдах шаардлагыг тодорхой болгож, өндөрт ажиллах аюулгүй ажиллагаа, хязгаарлагдмал орчин, хими, биологи, эргономик, нийгэм-сэтгэл зүйн хүчин зүйлс зэрэгт тавих шаардлагыг шинээр зохицуулах хэрэгцээ шаардлага үүсээд байна.

3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үйл ажиллагааны үндсэн зарчим нь осол, өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгддэг. Одоогоор үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоо бүрдээгүй, даатгалын сангаас ажил олгогч, даатгуулагчид үзүүлэх үйлчилгээ хомс байна. Иймд ажил хөдөлмөртэй холбоотойгоор үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, уг үйл ажиллагааг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалтай уялдуулах шаардлагатай юм.

4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний тогтолцоо нэгдмэл биш, санхүүжилтийн эх үүсвэр, мэргэжлийн байгууллага, асуудал хариуцсан мэргэжилтний чиг үүрэг, салбар дундын уялдаа холбоог нарийвчлан тодорхойлоогүй, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, албан бус салбарт ажиллагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал зохицуулалтгүйгээс хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Манай яамнаас олон улсын системийн инженерчлэлийн аргачлалыг ашиглан салбарын хуулиуддаа системийн шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд хийсэн шинжилгээгээр хуулийн зорилгыг хүрэх үр дүнд үндэслэн тодорхойлж, оролцогч талуудын эрх, үүргийг ангилах, хэмжиж болохуйц үр дүн, эргэх холбоог сайжруулан боловсруулахыг зөвлөж, хуулийн системийн хэв шинжүүдийг 60.7 хувь бүрдүүлсэн гэж үзсэн байна.

5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын зорилт нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний бодлого, зарчмыг тодорхойлж, хяналтын тогтолцоо, ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг хангах, ажилтан, хөдөлмөр эрхлэгч иргэнийг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, ажил хөдөлмөртэй холбоотой осол, өвчнөөс урьдчилан сэргийлэх харилцааг зохицуулахад оршино.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн салбарын хөгжлийн чиг хандлага, олон улсын гэрээ, конвенцын шаардлагад нийцүүлэн Хөдөлмөрийн

аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хууль нэртэйгээр шинэчилсэн найруулгын төслийг бэлтгэж, ажил, хөдөлмөр эрхлэгч хүний эрүүл мэнд, аюулгүй байдлыг ажлын байрны сөрөг, аюултай хүчин зүйлсээс хамгаалах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд тулгамдсан асуудлыг үндэсний хэмжээнд шийдвэрлэх бүтэц, тогтолцооны шинэлэг зохицуулалтыг тусгаж, хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 7 бүлэгтэйгээр боловсруулсан.

Хууль батлагдсанаар ажил, хөдөлмөр эрхлэхтэй холбоотой ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан, хяналт, цахимжилт, салбар дундын уялдаа, мэргэжлийн холбоо, оролцогч талуудын чиг үүргийг оновчтой тодорхойлж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үйлчилгээг өргөжүүлснээр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний тогтолцоо бий болно гэж үзэж байна.

Урьдчилан сэргийлэлтэд суурилсан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын зохицуулалтыг бий болгосноор ажил олгогч, даатгуулагчид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэлт, хөдөлмөрийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болон санхүүгийн дэмжлэг авах, мөн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн байгууллагын эрх, үүргийг тодорхой болгосноор ажилтан эрүүл, аюулгүй ажлын байраар хангагдах нөхцөл бүрдэж, ажил, хөдөлмөр эрхлэгч хүн амын дундаж наслалт, амьдралын чанарт эерэг нөлөө үзүүлнэ.

Хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан аливаа заалт байхгүй бөгөөд хууль хэрэгжсэнээр ажлын байранд ажилтан, иргэний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, эрүүл, аюулгүй байр, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулахад дэвшил гарна гэж үзэж байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, яамны цахим хуудсанд байршуулан иргэд, олон нийтээс санал авч хуулийн төсөлд тусгасан.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн тухай

Удиртгал, үндэслэл, шаардлага:

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль анх 2008 онд батлагдсан бөгөөд үүнээс өмнө Хөдөлмөрийн тухай хуулийн нэг бүлгээр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн харилцааг зохицуулж байсан¹. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль нь ажил, хөдөлмөр эрхлэгч хүнийг ажлын байрны аюултай, хортой хүчин зүйлсээс хамгаалж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн. Уг хууль хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага, зохион байгуулалт, хяналт, ажил олгогч, ажилтны үүрэг, хариуцлага, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, түүний санхүүжилт зэрэг нийтлэг шаардлагыг тусгасан 9 бүлэг, 37 зүйлтэй².

Монгол Улс Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай 155 дугаар конвенцод нэгдсэн тул Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжоо уг конвенцтой нийцүүлэх үүрэг олон улсад хүлээсэн.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай анхдагч хууль /2008 он/ батлагдсанаар салбарын хууль эрх зүйн орчин бүрдэж ажил, хөдөлмөр эрхэлж буй иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр бодит ахиц дэвшил гарсан.

Тухайлбал, аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан, бүтэц, зөвлөл ажиллах тогтолцоо бүрэлдэж, сургалт, мэдээлэл сурталчилгааг зохион байгуулах, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдлыг судлан бүртгэх, мэдээлэх, ажилтны урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулах, хөдөлмөрийн нөхцөл болон эрсдэлийг үнэлэх, хөдөлмөрийн эрүүл ахуй, хяналт шалгалтын үйл ажиллагаа тогтмолжсон.

Мөн үндэсний болон аймаг, орон нутгийн түвшинд нийгмийн түншлэлийн талуудын оролцоо нэмэгдэж, байгууллагын түвшинд ажилтны төлөөллийн оролцоог хангах механизм боловсронгуй болсноор хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх соёл төлөвшихөд чухал хувь нэмэр оруулсан олон үр дүн, ололт амжилтад хүрсэн.

¹ Хөдөлмөрийн тухай хууль, 1999 оны 5 дугаар сарын 14-ны өдөр

² Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 оны 5 дугаар сарын 22-ны өдөр

Гэсэн хэдий ч хууль батлагдсанаас хойш 18 жилийн хугацаанд манай улсын нийгэм, эдийн засаг, үйлдвэрлэлийн салбар, хөдөлмөрийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг зохицуулахтай холбоотой хөдөлмөрийн харилцаа, нийгмийн даатгал, стандартчилал, нийгмийн эрүүл мэнд зэрэг бусад салбарын хууль тогтоомжууд шинэчлэгдэн боловсронгуй болсон.

Иймээс өнгөрсөн хугацаанд бий болсон ахиц дэвшлийг улам бататган сайжруулах, олон улсын чиг хандлага, сайн туршлагад нийцүүлэн эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх хэрэгцээ, шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Сүүлийн жилүүдэд Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль (2017 он), Хөдөлмөрийн тухай хууль (2021 он), Төрийн хяналт шалгалтын тухай хууль (2022 он), Нийгмийн даатгалын багц хууль (2023 он), Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль (2024 он) зэрэг хуулиудад шинэчлэгдсэн нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтэд нөлөө үзүүлэх болсон.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад хүний эрүүл мэнд, аюулгүй байдлыг зохицуулах заавал мөрдөх норматив хэмжээг техникийн зохицуулалтаар батлах, стандарт нь сайн дурын үндсэн дээр сонгон хэрэглэх зохицуулалттай болсон³.

Хөдөлмөрийн тухай хуульд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй”-н асуудлыг олон улсын жишгээр “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд” гэж нэрлэж, ажилтныг хөдөлмөрийн хэвийн нөхцөлөөр хангах ажил олгогчийг үүргийг илүү тодорхой болгосон⁴.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчлэлээр үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг салбараар нь бус ажлын байрны эрсдэлээс хамаарч ялгаатай тогтоох дэвшил гарсан. Гэвч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээг санхүүжүүлэх боломж хязгаарлагдмал хэвээр байна.⁵

2024 онд батлагдсан Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуульд хөдөлмөрийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нийгмийн эрүүл мэндийн тусламж үйл ажиллагаанд хамаарна гэж заасан ч ажилтны эрүүл мэндийн үзлэг, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг оношлох, бүртгэх, мэдээлэх, хөдөлмөрийн чадвар алдалтаас сэргийлэх, ажил мэргэжлийн тохироог үнэлэх зэрэг асуудлын зохицуулалтад дэвшил гараагүй ба энэ арга хэмжээнд эрүүл мэндийн салбарын оролцоо сул байсаар байна.⁶

³ Стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, 2017 он

⁴ Хөдөлмөрийн тухай хууль, 2021 он

⁵ Нийгмийн даатгалын ерөнхий хууль, 2023

⁶ Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль, 2024

Хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны эрэлт нийлүүлэлтийн таамаглал судалгааны тайланд ажиллах хүчний тоо өнөөгийнхөөс 2035 он гэхэд 19.1 хувиар нэмэгдэх таамаглалыг тооцсон⁷. Түүнчлэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний өндөр эрсдэлтэй уул уурхай, олборлолтын салбарт шаардлагатай ажиллагчдын тоо 2035 онд гэхэд 31.9 хувь (32.5 мянган хүн), боловсруулах үйлдвэрт 34.1 хувь (63.3 мянган хүн), барилгын салбарт 36.6 хувь (55.9 мянган хүн)-иар нэмэгдэх хандлагатай байна. Ийнхүү үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний эрсдэлтэй ажилтнуудын тоо 2035 он хүртэл нэмэгдэх хандлагатай байгаа тул үүнтэй уялдуулан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага тулгарч байна.

Ажилтан хүн үйлдвэрлэлийн осолд өртөх эсвэл мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр өвчлөхөд эрүүл мэндээрээ хохирч хөдөлмөрийн чадвар, амь насаа алдах, эд хөрөнгийн хохирол учрахаас гадна тухайн хувь хүн, ажил олгогч болон нийгмийн даатгалын санд зардлын дарамтыг үүсгэдэг. Түүнчлэн мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр өвчлөх эрсдэлтэй хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллагчид өндөр насны тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр эрт тогтоолгож, нийгмийн даатгалын сангаас гарах зардлыг улам бүр нэмэгдүүлж байна.

Манай улсад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс хүн амын эрүүл мэнд, нийгэм, эдийн засагт үзүүлж буй сөрөг нөлөөллийг судалсан судалгаа хомс байна. Судлаач О.Алтансүх нарын тогтоосноор мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр хөдөлмөрийн чадвараа алдсан хүмүүс өвчний оношноос хамаарч дунджаар 8.05 жилийг амьдралаасаа алдаж байна⁸. Ажилтан хүн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр хөдөлмөрийн чадвараа алдах эсвэл нас барсан тохиолдолд Хөдөлмөрийн хуулийн 125 дугаар зүйлийн дагуу ажил олгогч нөхөн төлбөр төлөх үүрэг хүлээдэг.

Дээрх судалгаанд Эрдэнэт үйлдвэр төрийн өмчит үйлчилгээний газраас мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр хөдөлмөрийн чадвараа алдсан нэг ажилтанд жилд дунджаар 4.5 сая, нийтдээ 1.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгожээ. 2020 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны захиалгаар хийгдсэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний нийгэм, эдийн засгийн нөлөөллийн судалгааны тайланд дурдсанаар үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас манай улсын эдийн засагт жилд 127.8 тэрбум төгрөгийн хохирол учирч буйг тодорхойлсон. Үүний 60.1 тэрбум нь ажилтанд учирч буй цалин орлогын алдагдал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардал зэрэг, 19.7 тэрбум нь нөхөн төлбөр, бүтээмжийн алдагдал зэрэг, 37.9 тэрбум нь улсаас гарах нийгмийн даатгал, бусад зардал гэжээ⁹. Түүнчлэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас ажилтны, түүний гэр бүлд учирсан сэтгэл санааны хохирол, амьдралаас

⁷ Монгол Улсын Хөдөлмөр зах зээлийн дунд хугацааны эрэлт, нийлүүлэлтийн таамаглал, 2024 он

⁸ О.Алтансүх, Анагаах ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл: Монгол Улс дахь Зэсийн хүдэр баяжуулах үйлдвэрийн хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөл, ажиллагсдын мэргэжлээс шалтгаалсан өвчин, түүний дарамтын судалгаа, 2023

⁹ ХНХЯ, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний нийгэм, эдийн засгийн нөлөөллийн судалгаа, 2020 он

алдагдсан жил (нас баралт), амьдралын чанарын алдагдал, алдагдсан боломж зэрэг мөнгөн дүнгээр тооцох боломжгүй хохирлыг тодорхойлоогүй байна.

Эдгээр тоо баримт нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний урьдчилан сэргийлэлт манай улсад тулгамдсан асуудал болсныг илтгэж байна. Иймд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн урьдчилан сэргийлэлтийн үр нөлөөг улам сайжруулан боловсронгуй болгож, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын гэрээ, конвенцод нийцүүлэн шинэчлэх хэрэгцээ, шаардлага тулгарч байна.

Дээрх нөхцөл байдал, судалгаа, зөвлөмжид тулгуурлан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн бодлогын шинэчлэлийг тодорхойлж, эрх зүйн орчныг шинэчлэх ажлыг эрчимжүүлж Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдах хуулийн төслүүд, Хууль тогтоомжийн тухай хуульд заасан холбогдох судалгаа, баримт бичгүүдийг боловсруулсан.

Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан хууль санаачлагчаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах үүрэг бүхий техникийн ажлын хэсгийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 27-ний өдрийн А/21 дүгээр тушаалаар баталж, хуулийн төслийг боловсруулсан.

Мөн хуулийн төслийг эцэслэн боловсруулж, хэлэлцүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг нийгмийн түншлэгч талууд болон эрдэмтэн, судлаачдын өргөтгөсөн бүрэлдэхүүнтэй Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 04 дүгээр сарын 10-ний өдрийн А/88 дугаар тушаалаар байгуулан ажилласан.

Хуулийн төслийг боловсруулах хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, хуулийн хэрэгцээ шаардлагын урьдчилан тандан судалсан судалгаа, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ болон холбогдох зардлын тооцоолол, хуулийн төслийг дагаж нэмэлт, өөрчлөлт орох хуулийн төслийг боловсруулсан.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн эхний хувилбарт санал авахаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны цахим хуудсанд 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр байршуулан иргэд, олон нийтээс санал авсан. Холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, иргэд, олон нийтээс ирүүлсэн саналыг тусган дахин боловсруулалт хийж мөн яамны цахим хуудсанд 2026 оны 02 дугаар сарын 05-ны өдөр байршуулсан.

Мөн Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу дээрх цахим хуудсанд холбогдох судалгаа болон хуулийн төслийг байршуулан иргэд, олон нийт, сонирхлын бүлэг, мэргэжлийн холбоодын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж хуулийн төслийн хэрэгцээ шаардлагын тандан судалгаа болон хуулийн төслийг танилцуулан саналыг авч, зарим эрсдэл өндөртэй салбарын төлөөллүүдтэй ажлын хэсгийн гишүүд биечлэн уулзалт зохион байгуулан санал солилцсон. Тухайлбал;

Засгийн газрын гишүүд, нийслэлийн удирдлага, Баян-Өлгий аймагт баруун бүсийн 5 аймаг, нийслэлийн 9 дүүргийн хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч, хөдөлмөр, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан төлөөллүүдийн уулзалт зохион байгуулж, хуулийн төслийг хэлэлцүүлэн саналыг албан бичгээр болон цахимаар авсан.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний чуулган зохион байгуулж, чуулганд оролцогчдод хуулийн төслийг танилцуулан /QR код үүсгэн байршуулж/ санал авч ажилласан.

Хуулийн төслийн хэлэлцүүлгийг нийт 5 удаа зохион байгуулж, төрийн болон төрийн бус 30 гаруй байгууллагад санал авах албан бичгийг хүргүүлсэн бөгөөд, 100 гаруй иргэдээс ирүүлсэн саналыг судалж, хуулийн төсөлд тусгасан.

Түүнчлэн хуулийг төсөл, үзэл баримтлал, танилцуулгыг англи хэл дээр орчуулан Олон улсын хөдөлмөрийн байгууллагад хүргүүлж зөвлөмж авч, хуулийн төсөлд зөвлөмжийн дагуу тусган ажилласан.

Одоо мөрдөгдөж буй Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн төслийн харьцуулалт хийсэн.

Хуулийн төсөлд зохицуулахаар тусгасан харилцааны агуулга, зохицуулалт:

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2, 25.1.4. дэх заалтууд болон холбогдох судалгаанд үндэслэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиар зохицуулж байсан харилцааг өргөжүүлж, нийгэм, эдийн засагт гарч байгаа шинэ өөрчлөлт, чиг хандлагатай уялдуулан шинэчилсэн найруулгын төсөл хэлбэрээр боловсруулсан.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн салбарын хөгжлийн чиг хандлага, олон улсын гэрээ, конвенцын шаардлагад нийцүүлэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хууль нэртэйгээр шинэчилсэн найруулгын төслийг бэлтгэж, ажил, хөдөлмөр эрхлэгч хүний эрүүл мэнд, аюулгүй байдлыг ажлын байрны сөрөг, аюултай хүчин зүйлсээс хамгаалах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд тулгамдсан асуудлыг үндэсний хэмжээнд шийдвэрлэх бүтэц, тогтолцооны шинэлэг зохицуулалтыг тусгасан.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын зорилт нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний бодлого, зарчмыг тодорхойлж, хяналтын тогтолцоо, ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг хангах, ажилтан, хөдөлмөр эрхлэгч иргэнийг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, ажил хөдөлмөртэй холбоотой осол, өвчнөөс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь 7 бүлэг, 64 зүйлтэй байна. Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасны дагуу бүлэг тус бүрээр багцлан дараах байдлаар танилцуулъя. Үүнд.

Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл

Хуулийн нийтлэг үндэслэл, зорилт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлаар үндэсний хэмжээнд баримтлах бодлого, зарчмыг тусгахаас гадна энэ хуулиар дараах хүн, хуулийн этгээдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн харилцааг зохицуулахаар боловсруулсан.

- Монгол Улсын нутаг дэвсгэрт ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой хөдөлмөрийн харилцаанд оролцогч ажил олгогч, ажилтан болон хувиараа хөдөлмөр эрхлэгч;
- Хөдөлмөрийн тухай хуулийн 3.6 дахь хэсэгт заасан хүн;
- Хугацаат болон гэрээт цэргийн алба хаагч, сонсогч, оюутан цэрэг, дайчилгааны сургууль, цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн;
- Ял эдэлж байгаа хоригдол.

Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаарх конвенц нь “Occupational Safety and Health” буюу “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд” гэсэн өргөн агуулгаар тодорхойлогдож, бусад улс орнууд ч “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд” гэсэн нэршлээр хуулиа батлан мөрдөж байна. Мөн Хөдөлмөрийн тухай хуулийн 2021 оны шинэчилсэн найруулгаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг олон улсын жишгээр “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд” гэж нэрлэж, ажилтныг хөдөлмөрийн хэвийн нөхцөлөөр хангах ажил олгогчийн үүргийг тодорхой болгон хуульчилсан байдаг.

Иймд хуулийн нэршлийн хувьд олон улсын хэм хэмжээ, шаардлагад нийцүүлэн хуулийн төслийн нэрийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хууль гэж томъёолсон.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний бодлого нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний бодлого нь ажил, хөдөлмөр эрхэлж байгаа хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, ажил хөдөлмөртэй холбоотой осол, бэртэл гэмтэл, өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдэж, хуулийн шинэчлэлд дараах зарчмыг тусгасан.

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:
- Монгол Улсад мөрдөгдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлага нэгдмэл байх;
- хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг дэмжих;
- хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаарх мэдээллийн ил тод, үнэн бодит байдлыг хангах.

Хоёрдугаар бүлэг. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлага

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулиар хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчин болон үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хангах заавал мөрдөх шаардлагыг техникийн зохицуулалтаар тогтоох зохицуулалттай байдаг.

Иймээс Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг Хөдөлмөрлөх явцад хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, ажил, хөдөлмөртэй холбоотой бэртэл гэмтэл, өвчнөөс урьдчилан сэргийлэхэд мөрдөгдөх шаардлага, хэм хэмжээг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандартаар тогтоохоор тусгасан.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ) болон ОУХБ-аас 1950 онд хөдөлмөрийн эрүүл мэндийн зорилгыг “бүх төрлийн ажил хөдөлмөр эрхэлдэг ажилтны бие махбод, сэтгэл зүй, нийгмийн сайн сайхан байдлыг хамгийн дээд хэмжээнд байлгах, дэмжих, хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөр эрхлэлтээс шалтгаалан ажилтны эрүүл мэндэд үүсэж болзошгүй сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх, ажилтны бие махбод, сэтгэл зүйн чадавхад тохирсон ажил хөдөлмөрөөр хангах” гэж тодорхойлсон байдаг.¹⁰

Дээрх судалгаа болон олон улсын чиг хандлагатай уялдуулан үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хэм хэмжээ, шаардлагыг тодорхойлж, хязгаарлагдмал орчин, хими, биологи, эргономик, нийгэм-сэтгэл зүйн хүчин зүйлс зэрэгт тавих шаардлагыг шинээр хуулийн төсөлд тусган боловсруулсан.

Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаарх бусад хууль тогтоомжид заасан шаардлага нь энэ хуулиар тогтоосон хэм хэмжээтэй нийцсэн байхаар боловсруулсан.

Гуравдугаар бүлэг: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний тогтолцоо

¹⁰ ОУХБ, ХАБЭМ-ийн нэвтэрхий толь, <https://www.iloencyclopaedia.org/part-ii-44366/occupational-health-services>

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний тогтолцоо нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага түүний харьяа аймаг, дүүргийн төрийн захиргааны байгууллага, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллага, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний болон салбар хороо, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжлийн байгууллага, холбоо, аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн бүтэц, ажилтнаас бүрдэнэ. Энэ хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд үндэсний тогтолцоонд оролцогч талуудын чиг үүрэг, эрх үүрэг, нийтлэг үүргийг нарийвчлан тодорхойлсон.

Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний тогтолцоог өргөжүүлэн салбар дундын уялдаа холбоог хангаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал, төрийн хяналттай уялдуулж, хөдөлмөрийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч мэргэжлийн байгууллага, мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургууль зэргийг нэмж өргөн утгаар тодорхойлон хуулийн төсөлд тусгасан.

Гуравдугаар бүлгийн Нэгдүгээр дэд бүлэг:

Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл байгуулах, орон тооны ажилтан ажиллуулах норматив болон аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн дүрмийг Хөдөлмөрийн сайдын 2015 оны 06 дугаар сарын 22-ны А/144 тушаалаар батлан хэрэгжүүлж байна.

Энэ хуулийн төсөлд дээрх дүрмээр зохицуулагдаж байсан харилцааг энэ бүлэгт нарийвчлан **“Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан бүтэц, зохион байгуулалт”**-ыг тусгасан.

Ажлын байрны аюултай хүчин зүйлээс ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, ажил, хөдөлмөртэй холбоотой осол, бэртэл, гэмтэл, өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг хангах, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал, ажил олгогч шууд хариуцан ажиллах зохицуулсан.

Мөн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомж, шаардлагыг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг байгууллагын үйл ажиллагааны онцлог, ажлын байрны эрсдэлийн түвшин, ажилтны тоог харгалзан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн орон тооны бус зөвлөл болон асуудал хариуцсан бүтэц, ажилтны чиг үүргийг хамааруулсан байдаг. Аж ахуйн нэгж, байгууллагын нэгжийн дарга, ахлах ажилтан тэдгээртэй адилтгах албан тушаалтан нь дараах чиг үүргийг ажлыг байрны тодорхойлолтод тусгахаар хуулийн төсөлд тусгасан.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т заасан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг ААНБ-га төдийлөн хангалттай хэрэгжүүлдэггүй хуулийн хэрэгжилт хангалттай бус байдаг. Иймд энэ асуудлыг мөн хуулийн төсөлд төсвийн байгууллага нь тухайн жилийн батлагдсан төсвийн 0.5 хувиас, аж ахуйн нэгж, байгууллага эрсдэлийн түвшнээс хамааран үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг хангуулах, ажил хөдөлмөртэй холбоотой осол, бэртэл, гэмтэл, өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсөв, зардлыг жил бүр баталж, зарцуулж байхаар тусгасан.

Хуулийн төсөлд дээрх асуудлуудыг тусгаснаар аж ахуйн нэгж, байгууллагын чиг үүрэг, хариуцлагын асуудлыг тодорхой болгож, ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулах болно.

Гуравдугаар бүлгийн Хоёрдугаар дэд бүлэг:

Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн суурь тогтолцооны 187 дугаар конвенцод үндэсний хууль тогтоомжийн нийцлийн судалгаа, үнэлгээ хийж, мөн хуулийн урьдчилсан хэрэгцээ, шаардлагын тандан судалгаанд хувиараа хөдөлмөр, эрхлэгч иргэн, жижиг дунд хөдөлмөр эрхлэгчдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зохицуулалт хангалтгүй байна гэж дүгнэгдсэн.

Иймээс Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын гэрээ конвенцод нийцүүлж, хуулийн төсөлд ажил олгогч, ажилтан, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн эрх, үүрэг болон ажил, хөдөлмөр эрхэлж байгаа ажилтны хөдөлмөрийн зохистой нөхцөлөөр хангуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан.

Дөрөвдүгээр бүлэг: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэлт

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зарчим нь ажил, хөдөлмөр эрхлэгч хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалахад чиглэж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төрийн захиргааны хяналттай нэгдмэл, харилцан уялдаатайгаар салбар дунд хамтын ажиллагаа, идэвхтэй оролцоонд суурилан хэрэгжүүлнэ.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн техникийн зохицуулалт, стандартын шаардлагыг дараах байдлаар тогтоож зохицуулахаар тусгасан: Үүнд:

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн техникийн зохицуулалт нь ажлын байранд ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах, үйлдвэрлэлийн осол,

мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд заавал мөрдөх шаардлагыг тогтооно;

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн стандарт нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд тавих шаардлага, техникийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд мөрдөх хэм хэмжээ, аргачлал, зааврыг тогтооно;

Дээрх шаардлагыг шинээр боловсруулах, шинэчлэх асуудлыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллага хариуцна.

Урьдчилан сэргийлэлтэд чиглэсэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалыг ажлын байрны эрсдэлийг бууруулах, арилгах зорилгод нийцүүлэх, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ, эрсдэлийн үнэлгээ, эрүүл мэндийн үзлэг тандалт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн цахим системийг хөгжүүлэх, хөдөлмөр эрхэлж буй ажилтны амь нас, эрүүл мэндийн даатгалд хамруулах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алсан иргэн, нас барсан иргэний ар гэрт олгох тэтгэмж, нөхөн төлбөрийн асуудал зэрэг зохицуулалтыг тусгасан болно.

Тавдугаар бүлэг: Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний бүртгэл, мэдээлэл, хөдөлмөр зохицуулалт, сэргээн засах тусламж үйлчилгээ

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний бүртгэл мэдээллийг сайжруулах,

аюултай тохиолдол, мэргэжлээс шалтгаалсан өвчний бүртгэл, мэдээлэл, статистик болон хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн хөдөлмөр зохицуулалт, сэргээн засах тусламж үйлчилгээ зэрэг харилцааг зохицуулна.

Зургаадугаар бүлэг: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн болон хөндлөнгийн, олон нийтийн, дотоод хяналтын чиг үүрэг, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хяналтын улсын байцаагчид тавих шаардлага, бүрэн эрх зэрэг асуудлыг зохицуулна.

Долоодугаар бүлэг: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, маргаан шийдвэрлэх

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага болон маргаан шийдвэрлэх асуудлыг зохицуулна.

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙГ ДАГАЛДУУЛАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээнд нийцсэн байх бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан дагалдаж нэмэлт, өөрчлөлт оруулах Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Барилгын тухай хууль, Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль, Малын генетик нөөцийн тухай хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Хувийн хамгаалалтын тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Шүүх шинжилгээний тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг хүчингүй болгох хуулийн төслийг тус тус боловсруулсан.

Дээрх нийт дагалдах 21 хуулийн төслийн 16-н хуульд өмнө нь ашиглагдаж байсан хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй зэрэг нэр томъёог Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн нэр томъёотой уялдуулан өөрчлөлт оруулан боловсруулсан.

Харин 5 дагалдах хуулийн төслийг /Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Химийн хорт ба аюултай бодисын тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль/ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай уялдуулан эрх зүйн зохицуулалтын нэмэлт, өөрчлөлт оруулахаар боловсруулсан. Иймд эдгээр хуулийн гол агуулга, хуулийн зохицуулалтыг дараах байдлаар тусгасан.

1. Нийгмийн даатгалын ерөнхий хууль

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 26 дугаар зүйлд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллагын чиг үүргийн 26.1.4, 26.1.6, 26.1.7, 26.1.8-д мэргэжлээс шалтгаалсан өвчний оношилгоо, эрт илрүүлэлт, бүртгэл мэдээлэл, сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлэх асуудлыг заасан. Хуулийн төсөлд заасан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллага буюу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл

мэндийн төв нь анх 1967 онд Мэргэжлээс шалтгаалах өвчнийг судлах улсын диспансер нэртэйгээр байгуулагдаж байсан мэргэжлийн байгууллага юм.

2023 онд батлагдсан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын 37.9-д “Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг оношлох, эмчлэх, сэргээн засах, сувилах, хөдөлмөр зохицуулалт хийх, төрөлжсөн нарийн мэргэжлийн болон хөдөлмөрийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх чиг үүрэг бүхий Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллагын харьяанд ажиллуулна.” гэж заасан.

Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа агентлаг, байгууллага бөгөөд чиг үүргийн давхардал үүсгэхээс сэргийлж Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37.3, 37.9, 37.12-д Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын төрөлжсөн мэргэжлийн эмнэлгийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллагын харьяанд ажиллуулахаар нэмэлт өөрчлөлтийг боловсруулсан.

2.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлээс даатгуулагч буюу ажилтныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд тэтгэвэр олгох, сэргээн засах тусламж, үйлчилгээний зардлыг санхүүжүүлэхэд чиглэдэг.

Тиймээс хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдуулан Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуультай дараах өөрчлөлтийг оруулахаар боловсруулав.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээний талаарх 13.1.3, 13.1.4 дэх заалтыг “13.1.3.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн, шинэ техник, технологи, инновац нэвтрүүлсэн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх сайн туршлагыг сурталчлах;” “13.1.4.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгаан, нөхцөлийг судлах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн техникийн зохицуулалтыг боловсруулах, урьдчилан сэргийлэлтийн талаарх бодлого, шийдвэр, хэрэгжилтийг үнэлэхэд чиглэсэн судалгаа, эрдэм шинжилгээ, хяналт, шинжилгээ, үнэлгээ.” Гэж тус тус өөрчлөн найруулав.

Дөрөвдүгээр бүлэг “Эрүүл мэндийн нөхөн сэргээлт” -ийг Эрүүл мэнд, хөдөлмөрийн нөхөн сэргээлт” гэж өөрчлөн найруулж тус бүлэгт хөдөлмөрийн сэргээн засалтын харилцааг нэмснээр үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан иргэнийг зөвхөн эрүүл мэндийн хувьд сэргээн засах тусламж үзүүлэх төдийгүй ажил хөдөлмөр эрхлэх ур чадварт суралцан дахин хөдөлмөр эрхлэхэд нь дэмжих зохицуулалтыг шинээр нэмэв. Түүнчлэн өмнө нь хэрэглэгдэж байсан “нөхөн сэргээлт” гэх хуучны нэршлийг “сэргээн засах” гэж эрүүл мэндийн салбарын хууль тогтоомжид ашиглагддаг нэршлээр өөрчлөв.

Тавдугаар бүлэг Ажил олгогчид үзүүлэх хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаарх зохицуулалтад 15.1.1 дэх заалтыг өөрчлөн найруулж, ажлын байрны хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийг сайжруулсан ажил олгогчид үзүүлэх хөнгөлөлтийг шинээр нэмэв.

Зургаадугаар бүлэгт 16.4 дүгээр заалтад “Мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, түгээх, ашиглах, хянах, хадгалах, хамгаалах журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэснийг “Мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, түгээх, ашиглах, хянах, хадгалах, хамгаалах, тэдгээртэй холбоотой зардлыг санхүүжүүлэх журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж өөрчлөн найруулав.

3.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 5.4-д ажил, хөдөлмөртэй холбоотой хүчин зүйлээр үүсгэгддэг мэргэжлээс шалтгаалсан өвчлөл, осол, гэмтэл, хордлогоос ажилтныг хамгаалах, хөдөлмөрийн чадварыг хадгалах үйл ажиллагаа явуулахыг хөдөлмөрийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамаарна гэж заасан.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай уялдуулан Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 5.4 дэх заалтыг “Энэ хуулийн 5.1.3-т заасан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хүрээнд ажил хийж байгаа хүнийг ажил, хөдөлмөртэй холбоотой бэртэл, гэмтэл, өвчин, хордлогоос урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг хамгаалах, хөдөлмөрийн чадварыг хадгалах үйл ажиллагаа явуулна,” гэж өөрчлөн найруулав.

Түүнчлэн Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний удирдлага, зохион байгуулалтын талаарх 11 дүгээр зүйлд хөдөлмөрийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хариуцсан байгууллагыг тодорхой болгож “11.1.6. хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллага” гэсэн заалтыг шинээр нэмэв.

4.Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 11 дүгээр зүйлд Химийн хорт болон аюултай бодис, цацраг идэвхт бодист тавигдах шаардлагыг тодорхойлсон. Энэ зохицуулалттай уялдуулан Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 13 дугаар зүйлд Химийн хорт ба аюултай бодис ашиглахад тавих үндсэн шаардлагыг өөрчлөн найруулсан.

5.Эрүүл ахуйн тухай хууль

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 40.3 дахь заалтад “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн стандартыг шинээр боловсруулах, шинэчлэх асуудлыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллага хариуцна.” гэж боловсруулсан. Хуулийн төслийн энэ заалттай уялдуулан хуулийн давхардлыг арилгаж Эрүүл ахуйн тухай хуулийн “6.3.Ажлын байрны эрүүл ахуйн стандартыг эрүүл мэндийн болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран боловсруулж, стандартчиллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.”гэсэн заалтыг хүчингүй болгуулахаар өөрчлөлт оруулав.

Уг дэлгэрэнгүй танилцуулгыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3-т заасны дагуу боловсрууллаа. Дээрх дагалдах хуулийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн нэр томъёо, үг хэллэг, утга найруулгатай уялдуулан нэмэлт, өөрчлөлт оруулан боловсруулсан.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202..оны.....дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬ

(Шинэчилсэн найруулга)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний бодлого, зарчмыг тодорхойлж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдлага, хяналтын тогтолцоог бүрдүүлэх, хүний эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг хангах, ажил хөдөлмөртэй холбоотой осол, бэртэл гэмтэл, өвчнөөс урьдчилан сэргийлэхэд оршино.

2 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомж

2.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Химийн хорт болон аюулгүй бодисын тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хуулиар дараах хүн, хуулийн этгээдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн харилцааг зохицуулна:

3.1.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой хөдөлмөрийн харилцаанд оролцогч ажил олгогч, ажилтан болон хувиараа хөдөлмөр эрхлэгч;

3.1.2.Хөдөлмөрийн тухай хуулийн 3.6 дахь хэсэгт заасан хүн;

3.1.3.хугацаат болон гэрээт цэргийн алба хаагч, сонсогч, оюутан цэрэг, дайчилгаатай сургууль, цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн;

3.1.4.ял эдэлж байгаа хоригдол.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. "ажлын байр" гэж иргэн, ажилтны гүйцэтгэх ажил үүрэгтэй холбоотойгоор хүрэлцэн очих ёстой ажил олгогчийн шууд ба шууд бус хяналтын дор байх бүх байрыг;

4.1.2. "ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ" гэж хөдөлмөрлөх явцад хүний ажил үүргээ гүйцэтгэх чадвар, эрүүл мэндэд дагнасан буюу хамссан байдлаар нөлөөлөх ажлын байрны хими, физик, биологи, эргономикийн сөрөг хүчин зүйлийн өртөлтийг стандартын дагуу хэмжиж, зөвшөөрөгдөх хэмжээтэй харьцуулан дүгнэх хөдөлмөрийн эрүүл ахуйн үйл ажиллагааг;

4.1.3. "ажлын байрны хөдөлмөрийн хэвийн нөхцөл" гэж ажлын байрны орчны болон хөдөлмөрийн үйл ажиллагааны сөрөг хүчин зүйлс ажилтны ажил үүргээ гүйцэтгэх чадвар, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхгүй байхыг;

4.1.4. "ажлын байрны аюултай хүчин зүйл" гэж хүний амь нас, эрүүл мэнд, хөдөлмөрлөх чадварт сөргөөр нөлөөлж ажил, хөдөлмөртэй холбоотой гэмтэл бэртэл, өвчин, хордлого үүсгэх үр дагавар бүхий ажлын байрны хүчин зүйлийг;

4.1.5. "ажил хөдөлмөртэй холбоотой бэртэл гэмтэл, өвчин" гэж үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин болон ажлын байрны сөрөг хүчин зүйлийн үйлчлэлийн улмаас үүссэн бэртэл гэмтэл, өвчнийг;

4.1.6. "аюултай тохиолдол" гэж ажилтанд бэртэл гэмтэл, өвчин үүсгэх эсхүл нас баралтад хүргэх өндөр эрсдэл бүхий ажлын байрны нөхцөл, үйлдвэрлэлийн осолд дөхсөн тохиолдлыг;

4.1.7. "ажлын тусгай хувцас" гэж ажлын байрны аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс ажилтныг хамгаалах зориулалт бүхий хувцас, гутал, малгай, бээлий зэрэг хэрэгслийг;

4.1.8. "мэргэжлээс шалтгаалсан өвчин" гэж Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 2.1.1-д заасныг;

4.1.9. "өндөр эрсдэлтэй ажлын байр" гэж хөдөлмөрлөх явцад ажилтанд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин үүсэх магадлал ихтэй болох нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээгээр тогтоогдсон ажлын байрыг;

4.1.10. "үйлдвэрлэлийн осол" гэж хөдөлмөр эрхлэгч иргэн хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах ажлын байрны аюултай хүчин зүйлийн үйлчлэлд өртөж гэмтэж, өвчилсөн эсхүл амь насаа алдахыг;

4.1.11. "хөдөлмөрийн аюулгүй байдал" гэж хөдөлмөрлөх явцад хүний амь нас, эрүүл мэндэд аюултай ажлын байрны хүчин зүйлийг арилгах, ажил, хөдөлмөртэй холбоотой бэртэл гэмтэл, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг;

4.1.12. "хөдөлмөрийн эрүүл мэнд" гэж хөдөлмөрлөх явцад хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй хими, физик, биологи, эргономикийн хүчин зүйлээс шалтгаалан хүний бие махбод өөрчлөлт орж, өвчлөх, хөдөлмөрийн чадвараа түр болон бүрэн алдахаас урьдчилан сэргийлэх, ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүнд хөдөлмөрийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх үйл ажиллагааг;

4.1.13."хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд" гэж хөдөлмөрлөх явцад хүний амь нас, эрүүл мэндэд аюултай болон сөрөг нөлөөлөл бүхий ажлын байрны хүчин зүйлийг арилгах, бэртэл гэмтэл, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээхэд чиглэсэн нэгдмэл үйл ажиллагааг;

4.1.14."хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэлт" гэж ажилтныг ажил, хөдөлмөртэй холбоотой бэртэл гэмтэл, өвчнөөс хамгаалах зорилгоор инженер технологи, удирдлага зохион байгуулалт, хувь хүнд чиглэсэн урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээг хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандартын шаардлагад нийцүүлэн төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх, тасралтгүй сайжруулахыг;

4.1.15."хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ" гэж үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин үүсгэх ажлын байрны аюултай, сөрөг хүчин зүйлийг илрүүлэх, түүний эрсдэлийг стандарт, аргачлалаар үнэлэх үйл явцыг;

4.1.16."хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг" гэж ажлын байрны аюултай, сөрөг хүчин зүйлээс шалтгаалан хөдөлмөрлөх явцад хүний эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэлийг тогтоох, ажил үүргээ гүйцэтгэх чадварыг магадлах, ажил мэргэжлийн тохироог тодорхойлох, ажил хөдөлмөртэй холбоотой өвчин, бэртэл гэмтлээс урьдчилан сэргийлэх эмнэлгийн үзлэгийг;

4.1.17."хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалт" гэж хөдөлмөрлөх явцад хүний эрүүл мэндэд хөдөлмөрийн нөхцөл нь сөргөөр нөлөөлж буй эсэхийг хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэгт үндэслэн тодорхойлж, ажил, хөдөлмөртэй холбоотой өвчнөөс урьдчилан сэргийлэлтийн үндэслэл, нотолгоог бий болгох үйл ажиллагааг;

4.1.18."хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжилтэн" гэж тухайн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн эсхүл хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжлийн цогц чадамжаа хүлээн зөвшөөрүүлсэн, дээд боловсролтой хүнийг;

4.1.19."хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн ажилтан" гэж аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хууль тогтоомж, шаардлагын дагуу зохион байгуулах мэдлэг, чадамж бүхий хүнийг;

4.1.20."химийн хорт болон аюултай бодис" гэж Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 3.1.1, 3.1.2-т заасныг;

4.1.21."хувийн хамгаалах хэрэгсэл" гэж хөдөлмөрлөх явцад ажлын байрны аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс хүнийг хамгаалах зориулалт бүхий хэрэгслийг.

5 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний бодлого, зарчим

5.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний бодлого нь ажил, хөдөлмөр эрхэлж байгаа хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, ажил хөдөлмөртэй холбоотой осол, бэртэл гэмтэл, өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдэнэ.

5.2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

5.2.1.Монгол Улсад мөрдөгдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлага нэгдмэл байх;

5.2.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг дэмжих;

5.2.3.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаарх мэдээллийн ил тод, үнэн бодит байдлыг хангах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ШААРДЛАГА

6 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг тогтоох

6.1.Хөдөлмөрлөх явцад хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, ажил, хөдөлмөртэй холбоотой бэртэл гэмтэл, өвчнөөс урьдчилан сэргийлэхэд мөрдөгдөх шаардлага, хэм хэмжээг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандартаар тогтооно.

6.2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаарх бусад хууль тогтоомжид заасан шаардлага нь энэ хуулиар тогтоосон хэм хэмжээтэй нийцсэн байна.

6.3.Стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллага хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн стандартыг шинээр боловсруулах, шинэчлэх, хүчингүй болгоход хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал авна.

7 дугаар зүйл. Үйлдвэрлэлийн орчин, барилга байгууламж болон үндсэн, суурин тоног төхөөрөмж, хэрэгслийг эзэмших, ашиглахад тавих шаардлага

7.1.Аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэлийн орчин нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг хангасан байна.

7.2.Ажил олгогч барилгын ажил хийх, машин техник, тоног төхөөрөмж угсрах, суурилуулах, турших, засвар хийхдээ хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг хангасан байна.

7.3.Барилга байгууламжийн зураг төсөл нь тухайн барилга байгууламжийн барилга барилга угсралтын ажлын явцад ажилтны аюулгүй байдал, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх шаардлагыг хангана.

7.4.Барилга байгууламж болон барилга байгууламжид тогтмол суурилуулж, салгаж шилжүүлэхгүйгээр ашиглах зориулалтын үндсэн, суурин тоног төхөөрөмж, хэрэгслийг хоёр буюу түүнээс дээш хүн, хуулийн этгээд хамтран эзэмших, эсхүл ашиглах бол эзэмшигч, ашиглагч дараах шаардлагыг хангах үүрэгтэй:

7.4.1.эзэмшигч, ашиглагч нь үйлдвэрлэлийн орчинд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг хангаж ажиллах талаар харилцан тохиролцож, гэрээнд тусгах;

7.4.2.үйлдвэрлэлийн явцад химийн хорт ба аюултай бодис хэрэглэж байгаа эзэмшигч, ашиглагч нь энэ тухай харилцан мэдээлж, аюулгүй байдлыг хангах хамтарсан арга хэмжээ авах.

7.5.Энэ хуулийн 7.4.1-д заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд үйлдвэрлэлийн барилга байгууламж болон үндсэн, суурин тоног төхөөрөмж, хэрэгслийг эзэмшигч, ашиглагч зэрэгцэн эзэмшихийг хориглоно.

7.6.Энэ хуулийн 7.4.2-т заасны дагуу мэдээлээгүйн улмаас учирсан хохирлыг буруутай тал хариуцна.

Тайлбар: Энэ зүйлд заасан "үйлдвэрлэлийн орчин" гэдэгт аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны талбай, гадна орчныг ойлгоно.

8 дугаар зүйл. Машин механизм, тоног төхөөрөмжид тавих шаардлага

8.1.Үйлдвэрлэлийн зориулалттай, хүний эрүүл мэндэд аюул учруулж болох машин механизм, тоног төхөөрөмжийн талаар ажил олгогч, хүн, хуулийн этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:

8.1.1.машин механизм, тоног төхөөрөмжийн бүтэц, хийц, хөдөлгөөнт хэсэг, удирдлага, дохиоллын систем, ажлын байр, гарц, шат, хашлага, хамгаалах хэрэгсэл зэрэг бүрдэл хэсэг нь аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байх;

8.1.2.машин механизм, тоног төхөөрөмжийг ажиллуулах, засвар үйлчилгээ хийх үед мөрдөх ашиглалт, аюулгүй ажиллагааны заавар, техникийн паспорттай байх;

8.1.3.машин механизм, тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ, тохируулгыг техникийн баримт бичигт заасан хугацаанд тогтмол хийх.

8.2.Машин механизм, тоног төхөөрөмжийг бусдад шилжүүлэхдээ ашиглалтын паспорт, гэрчилгээний хамт шилжүүлнэ.

8.3.Цахилгааны тоног төхөөрөмж нь удирдлага, дохиолол, хаалт, хамгаалалттай, тохиолдож болзошгүй осол, бэртэл, гэмтлээс урьдчилан сэргийлэх хэрэгслээр тоноглогдсон байна.

8.4.Цахилгааны тоног төхөөрөмж нь зураг төслийн дагуу угсрагдсан, газардуулга, газардуулгын даацын баталгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, цахилгаан ашиглалтын аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагыг хангасан байна.

8.5.Энэ хуулийн 8.1-8.4-т заасан шаардлагыг хангаагүй машин механизм, тоног төхөөрөмжийг ашиглахыг хориглоно.

9 дүгээр зүйл. Өргөх байгууламжид тавих шаардлага

9.1.Өргөх байгууламжийг эзэмшигч, ашиглагч хүн, хуулийн этгээд нь өргөх байгууламжийн бүрэн бүтэн байдлыг хангаж, ослоос урьдчилан сэргийлэх үүрэгтэй.

9.2.Өргөх байгууламжид мэргэжлийн байгууллагаар техникийн магадалгаа хийлгэж, зохих зөвшөөрлийг авсан байх бөгөөд өргөх, зөөх ажиллагааг сургалтад хамрагдсан ажилтан удирдана.

9.3.Өргөх байгууламж ашиглагч хүн, хуулийн этгээд нь засвар үйлчилгээ, тохируулгыг техникийн баримт бичигт заасан хугацаанд хийж, эрх бүхий байгууллагаар баталгаажуулна.

9.4. Зориулалтын бус өргөх төхөөрөмжөөр хүнийг өргөх, буулгах, тээвэрлэх үйлдэл хийхийг хориглоно.

9.5. Энэ хуулийн 9.1-9.4-т заасан шаардлагыг ажил олгогч хангасан байна.

Тайлбар: Энэ зүйлд заасан “өргөх байгууламж” гэдэгт босоо болон хэвтээ чиглэлд хүн, ачаа өргөх, тээвэрлэх зориулалт бүхий суурин болон хөдөлгөөнт тоног төхөөрөмжийг ойлгоно.

10 дугаар зүйл. Уурын ба ус халаах зуух, даралтат сав, шугам хоолойд тавих шаардлага

10.1. Уурын ба ус халаах зуух, даралтат сав, шугам хоолой угсрах, ашиглах хүн, хуулийн этгээд дараах шаардлагыг хангасан байна:

10.1.1. уурын ба ус халаах зуух, даралтат сав, шугам хоолойд зохих журмын дагуу туршилт, тохируулга, баталгаажуулалт хийлгэж, техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж, ашиглах холбогдох зөвшөөрлийг авсан байх;

10.1.2. уурын ба ус халаах зуух, даралтат сав, шугам хоолойг аюулгүй ашиглах, удаан хугацаагаар зогсоох болон хадгалах үеийн ашиглалтын журамтай байх;

10.1.3. уурын ба ус халаах зуух, даралтат сав, шугам хоолойн ашиглалтын үед осол, гэмтэл, саатлаас шалтгаалан ажилтан, бусад хүн бэртэж, гэмтэхээс урьдчилан сэргийлэх дохиоллын болон хамгаалалтын хэрэгслээр тоноглож, анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах.

11 дүгээр зүйл. Химийн хорт болон аюултай бодис, цацраг идэвхт бодистой харьцан ажиллахад тавих шаардлага

11.1. Химийн хорт болон аюултай бодис, цацраг идэвхт бодис, материал үйлдвэрлэдэг, ашигладаг ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгч нь ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах талаар дараах шаардлагыг хангасан байна:

11.1.1. химийн хорт болон аюултай бодисын хууль тогтоомжийн дагуу ажил олгогч, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн ажлын байрандаа химийн хорт болон аюултай бодис, цацраг идэвхт бодисыг үйлдвэрлэдэг, ашигладаг болон завсрын бүтээгдэхүүн, хаягдал хэлбэрээр ялгаруулдаг бол эдгээр бодисын бүртгэл, тэмдэглэлийг хөтлөх;

11.1.2. химийн хорт болон аюултай бодис, цацраг идэвхт бодистой харьцдаг, нөлөөлөлд нь дам өртдөг хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажилтныг хор аюулын мэдээллээр хангаж, аюулгүй ажиллах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай мэдлэг, дадлыг олгох сургалтыг зохион байгуулсан байх;

11.1.3. химийн хорт болон аюултай бодис, цацраг идэвхт бодис үйлдвэрлэдэг, ашигладаг болон завсрын бүтээгдэхүүн, хаягдал ялгаруулдаг ажлын байранд ажилладаг хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдалд богино болон урт хугацаанд учирч болзошгүй сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийж, түүнийг арилгах, бууруулах инженер технологи, удирдлага зохион байгуулалт, хувь хүнд чиглэсэн арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлэх;

11.1.4.Монгол Улсад ашиглах, хэрэглэхийг хязгаарласан химийн хорт ба аюултай бодис, тэдгээрийн нэгдэлтэй харьцан ажилладаг ажилтны бүртгэлийг хөтөлж, тухайн ажилтны өртөлтийг үнэлсэн хэмжилтийн дүн, хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг, тандалт болон урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн тайланг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн цахим удирдлагын системд жил бүр илгээх.

11.2.Ажил олгогч нь стандартаар тогтоосон зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн химийн хорт ба аюултай бодисын өртөлт бүхий ажлын байранд ажилтныг ажиллуулахыг хориглоно.

11.3.Химийн хорт болон аюултай бодис хэрэглэх, харьцан ажиллахтай холбоотой аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд тавигдах бусад шаардлагыг холбогдох хуулиар зохицуулна.

11.4.Химийн хорт болон аюултай бодис, цацраг идэвхт бодисын хэрэглээтэй холбоотой осол, хордлого гарсан тохиолдолд үйлдвэрлэлийн ослын нэгэн адил судлан бүртгэнэ.

11.5.Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах, худалдаалах, түгээх, цэнэглэх, тээвэрлэх үйл ажиллагаанд дараах шаардлагыг тавина:

11.5.1.химийн болон аюултай бодис хадгалах, ашиглах, устгах журмыг баримтлах;

11.5.2.аюултай ачаа илгээгч нь гарч болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө, аюулгүй ажиллагааны зааврыг батлуулж, тээвэрлэгч байгууллага, жолооч, дагалдан яваа ажилтанд танилцуулж, баталгаажуулах;

11.5.3.шингэрүүлсэн шатдаг хий тээвэрлэгч авто тээврийн хэрэгслийн торх нь даралтат савны стандартыг хангаж, хяналтын байгууллагаас аюултай ачаа тээвэрлэх зөвшөөрөл авах;

11.5.4.шингэрүүлсэн шатдаг хий, аюултай ачаа тээвэрлэх маршрутыг замын хөдөлгөөний эрчим, бартаа саад бага байхаар сонгож, тээвэрлэх цэг, хугацаа, замын хөдөлгөөнд оролцох чиглэлийг орон нутгийн онцгой байдлын болон замын цагдаагийн албанд мэдэгдэж, зөвшилцөх, аюулгүй тээвэрлэх зөвлөмж, даалгавар авах;

11.5.5.аюултай ачаа тээвэрлэх, онцгой ажил гүйцэтгэх бүрд аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх;

11.5.6.автомашинд хий түгээх станц нь орон сууц, олон нийтийн барилга байгууламжаас ерөнхий сүлжээний авто замын хөвөө, захаас галын аюулгүй байдлын зайг хангах.

Тайлбар: Энэ зүйлд заасан “хордлого” гэдэгт химийн хорт болон цацрагт идэвхт бодисын нөлөөгөөр цочмог хэлбэрээр богино хугацаанд хордохыг ойлгоно.

12 дугаар зүйл. Галын аюулгүй байдалд тавих шаардлага

12.1.Энэ хуулийн 3.1-д заасан этгээд нь Галын аюулгүй байдлын хууль тогтоомж, техникийн зохицуулалт, галын аюулаас урьдчилан сэргийлэх болон гал унтраах дүрэм, журам, стандарт, техникийн зохицуулалтыг хангаж ажиллах үүрэг хүлээнэ.

12.2.Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгч нь галын дохиолол болон гал унтраах тусгай тоноглол, гарц, орцын зураглалыг гал гарч болзошгүй ажлын байр бүрд байрлуулан, тэдгээрийг тогтмол ажиллагаатай байлгаж, ажилтныг уг тоноглолыг ашиглаж сургасан байна.

12.3.Галын аюулгүй байдлыг хангах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг, хариуцлагыг Галын аюулгүй байдлын тухай, Зөрчлийн тухай хуулиар зохицуулна.

13 дугаар зүйл. Хязгаарлагдмал орчинд тавих шаардлага

13.1 Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгч нь өөрийн эзэмшлийн барилга, байгууламж болон ажил, үйлчилгээ явуулдаг ажлын байран дахь хязгаарлагдмал орчныг тодорхойлон бүртгэнэ.

13.2.Хязгаарлагдмал орчинд ажил, үйлчилгээ явуулах үед ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэлийг үнэлж, арилгах эсхүл хяналтад авах арга хэмжээг ажил олгогч хэрэгжүүлнэ.

Тайлбар: Хязгаарлагдмал орчин гэдэгт хүн байнга ажиллах зориулалтгүй, орц, гарц хязгаарлагдмал, агааржуулалт хангалтгүй, шугам хоолойн худаг, бохирын шугам, нөөц сав зэрэг хагас эсвэл бүтэн хаалттай орчнууд хамаарна.

14 дүгээр зүйл. Өндрийн ажлын аюулгүй байдалд тавих шаардлага

14.1.Ажилтан, хувиараа хөдөлмөр эрхлэгч нь өндрийн түвшний зөрүүтэй байрлал болон өндөрт ажил үүрэг гүйцэтгэхэд ажил олгогч нь дараах шаардлагыг хангасан байна:

14.1.1.сургалтад хамрагдаж өндөрт аюулгүй ажиллах мэдлэг, чадвар, дадал эзэмшсэн хүнийг ажиллуулах, шаардлагатай хувийн хамгаалах хэрэгслээр хангах;

14.1.2.өндрийн ажлыг эхлүүлэхээс өмнө өөрийн болон бусад хүний аюулгүй байдалд эрсдэл учруулж болзошгүй нөхцөл байдлыг үнэлж, аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

14.1.3.ажил үүргээ гүйцэтгэж байгаа хүнийг уналтаас хамгаалах тоног төхөөрөмжийг зөв сонгон суурилуулж, засвар үйлчилгээ хийж, баталгаат байдлыг тогтмол шалгаж, хяналт тавих;

14.1.4.үйлдвэрлэлийн ослын тохиолдолд хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, бэлэн байдлыг хангах.

15 дугаар зүйл. Хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөлд тавих ерөнхий шаардлага

15.1.Ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөл нь ажилтны эрүүл мэнд, хөдөлмөрийн чадварт богино болон урт хугацаанд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх шаардлагыг хангана.

15.2.Ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөлийг стандарт, аргачлалаар хийсэн хэмжилт, үнэлгээнд үндэслэн тодорхойлно.

16 дугаар зүйл. Биологийн хүчин зүйлд тавих шаардлага

16.1. Ажил олгогч нь хүнд халдварлах, өвчин үүсгэх сөрөг нөлөөтэй нян, вирус, мөөгөнцөр, шимэгч, биологийн гаралтай хорт бодис болон тэдгээрийг агуулсан материал, хаягдалтай харьцдаг ажил, албан тушаалын бүртгэлийг хөтөлнө.

16.2. Энэ хуулийн 16.1-д заасан ажил үүрэг гүйцэтгэдэг ажилтны ажлын байрны эрсдэлийг арилгах, бууруулах, хяналтад авах арга хэмжээг ажил олгогч хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлнэ.

17 дугаар зүйл. Эргономикийн хүчин зүйлд тавих шаардлага

17.1. Үйлдвэрлэл, үйлчилгээний барилга байгууламж, тоног төхөөрөмж, ажлын байрны зохион байгуулалт, багаж, хэрэгсэл, бараа материалын савлагаа, жин, хөдөлмөрлөх үеийн ажилтны биеийн байрлал, олон давтагдах үйлдэл бүхий ажил, ажлын нэг үйлдлийн үргэлжлэх хугацаа нь урт болон богино хугацаанд ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх шаардлагыг хангасан байна.

18 дугаар зүйл. Ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгсэлд тавих шаардлага

18.1. Ажил олгогч нь ажлын байрны аюул, эрсдэлийг инженер технологи, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээгээр бүрэн арилгах эсхүл бууруулах боломжгүй тохиолдолд стандартын шаардлага хангасан ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгслийг ажилтанд олгож, зохистой хэрэглээнд хяналт тавина.

18.2. Ажил олгогч нь ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгслийг сонгохдоо ажлын байран дахь аюултай хүчин зүйлсийн шинж чанар, өртөлтийн болон эрсдэлийн түвшин, хөдөлмөрийн нөхцөл, бусад хамгаалах хэрэгсэлтэй хамт хэрэглэх байдлыг харгалзана.

18.3. Ажил олгогч нь ажилтанд олгох ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгслийн нэр, төрөл бүхий жагсаалтыг баталж мөрдүүлнэ.

18.4. Ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгслийг турших, мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах, худалдаж авах, хадгалах, цэвэрлэх, засварлах, ариутгах зардлыг ажил олгогч хариуцна.

18.5. Ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгсэл нь стандартад нийцсэн байна.

18.6. Ажил олгогч эсхүл ажилтан ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгсэл нь аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн шаардлага хангаж байгаа эсэхэд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулж болно.

19 дүгээр зүйл. Ажлын байрны нийгэм-сэтгэл зүйн орчин

19.1. Ажил олгогч ажил үүргийн хуваарилалт, төлөвлөлт, ачаалал болон ажилтан, ажил олгогч, гуравдагч этгээд хоорондын харилцаа, байгууллагын соёл нь ажилтны сэтгэл зүйн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй, хувь хүний ажил, амьдралын зохистой тэнцвэрийг алдагдуулахгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ.

19.2. Ажил олгогч нь Хөдөлмөрийн тухай хуулийн 6,7 дугаар зүйлд заасан ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхалтаас ангид орчин бүрдүүлж, ажлын байран дахь дарамт, хүчирхийллээс урьдчилан сэргийлнэ.

20 дугаар зүйл. Ажлын байрны эрүүл ахуйн тусгай шаардлага

20.1. Ажил олгогч нь ажлын байрны орчин, хөдөлмөрийн нөхцөл, үйлдвэрлэл, үйлчилгээний онцлогоос хамааран ажлын байрны эрүүл ахуйн дараах тусгай шаардлагыг хангана:

20.1.1. халуун, хүйтэн, салхитай, хур тунадастай зэрэг гадаа, халаалтгүй орчинд ажиллаж байгаа ажилтныг түр завсарлах, амрах, дулаацах, хоргодох зориулалтаар тоноглож, тохижуулсан амрах байраар хангах;

20.1.2. халуун, хүйтэн нөхцөл болон гадаа ажилладаг ажилтныг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангах;

20.1.3. хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажил үүрэг гүйцэтгэдэг ажилтныг эрүүл ахуйн шаардлага хангасан, шим тэжээллэг хүнсний бүтээгдэхүүн, хоолоор үнэгүй хангах;

20.1.4. ажилтны хөдөлмөрлөх хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн, тусгайлан төхөөрөмжилсөн хувцас солих, түр амрах, хооллох, бие засах, усанд орох, дулаацах зэрэг зориулалтын ахуйн байраар хангах.

20.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байр нь тохирох хэрэглэгдэхүүнээр тоноглогдсон, орц, гарц, шат, ариун цэврийн өрөөгөөр саадгүй нэвтрэх боломжоор хангагдсан байна.

20.3. Гамшиг, ослын үед хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах төлөвлөгөөтэй, түүнийг хэрэгжилтийн бэлэн байдлыг хангасан, зориулалтын тэмдэг, тэмдэглэгээ байршуулсан байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦОО

21 дүгээр зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний тогтолцоо

21.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний тогтолцоо нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага түүний харьяа аймаг, дүүргийн төрийн захиргааны байгууллага, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллага, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний болон салбар хороо, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжлийн байгууллага, холбоо, аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн бүтэц, ажилтнаас бүрдэнэ.

22 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

22.1. Улсын Их Хурал нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

22.1.1. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаарх үндэсний бодлогыг тодорхойлох;

22.1.2. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаарх олон улсын гэрээ, конвенцод Монгол Улс нэгдэн орох асуудлыг шийдвэрлэх;

22.1.3. хуульд заасан бусад бүрэн эрх.

23 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

23.1.Засгийн газар нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

23.1.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаарх төрийн бодлогыг боловсруулж, хэрэгжилтийг хангах;

23.1.2.өөрийн бүрэн эрхийн хүрээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлаар гадаад улс, олон улсын байгууллагатай гэрээ, хэлэлцээр байгуулах, цуцлах;

23.1.3.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаарх төрийн хяналтыг зохион байгуулах, хэрэгжүүлэх;

23.1.4.хуульд заасан бусад бүрэн эрх.

24 дугаар зүйл. Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

24.1.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

24.1.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх;

24.1.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын төрийн захиргааны хяналтын бодлогыг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулах;

24.1.3.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллагын бүтэц, орон тоо, дүрмийг батлах;

24.1.4.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжлийн хүний нөөцийн бодлого, хэрэгцээг тодорхойлж, холбогдох байгууллагатай хамтран ажиллах;

24.1.5.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлаар олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх;

24.1.6.гадаад улстай хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлаар гэрээ, хэлэлцээр байгуулах, олон улсын гэрээ конвенцод нэгдэх асуудлыг судлах, шийдвэрлүүлэх;

24.1.7.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөж, санхүүжилтийг шийдвэрлүүлэх;

24.1.8.хуульд заасан бусад бүрэн эрх.

25 дугаар зүйл. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

25.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

25.1.1.мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан хүнд сэргээн засах, хөдөлмөрийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

25.1.2.мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бүртгэх, мэдээлэх, статистик мэдээллийн сан үүсгэх, харилцан мэдээлэл солилцох;

25.1.3.хөдөлмөрийн эрүүл мэндийн мэргэжилтнийг бэлтгэх, давтан сургах, мэргэжлийн индексийг батлах;

25.1.4.аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагаар дамжуулан хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулах, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг илрүүлэх;

25.1.5. хуульд заасан бусад бүрэн эрх.

Тайлбар: Энэ зүйлд заасан хөдөлмөрийн эрүүл мэндийн мэргэжилтэн гэдэг хөдөлмөрийн эрүүл ахуй, хөдөлмөрийн эрүүл мэнд судлал, мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын чиглэлээр төрөлжсөн мэргэшил эзэмшсэн эрүүл мэндийн мэргэжилтнийг ойлгоно.

26 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн Үндэсний хороо, түүний бүрэн эрх

26.1.Төрийн захиргааны төв байгууллага, ажил олгогч, ажилтны эрх ашгийг хамгаалах болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжлийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн Үндэсний хороо /орон тооны бус/-г /цаашид “Үндэсний хороо” гэх/ хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний, салбар хороог тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэд тус тус байгуулж ажиллуулна.

26.2.Үндэсний хорооны дүрэм, бүрэлдэхүүнийг талуудын саналыг үндэслэн Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны дарга, салбар хороо, зөвлөлийн дүрмийг Үндэсний хорооны дарга тус тус батална.

26.3.Хөдөлмөрийн тухай хуулийн 15.4-т заасан аймаг, нийслэлийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо нь тухайн орон нутгийн түвшинд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлаар нийгмийн түншлэлийг хэрэгжүүлнэ. Сум, дүүрэгт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн зөвлөлийг Засаг даргын шийдвэрээр байгуулж болно.

26.4.Үндэсний хороо нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

26.4.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлаар төрийн бодлого боловсруулах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлаар санал, зөвлөмж гаргах;

26.4.2.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, үр дүнтэй танилцах;

26.4.3.олон улсын хөдөлмөрийн байгууллагын холбогдох конвенцод нэгдэн орох асуудлаар санал, зөвлөмж боловсруулах;

26.4.4.нийгмийн түншлэлийн талуудын түвшинд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлаар төр, ажил олгогч, ажилтны төлөөллийн хооронд харилцан ойлголцол, хамтын ажиллагааг дэмжих, мэргэжил арга зүйгээр хангах.

26.5.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллага нь Үндэсний хорооны ажлын албаны үүргийг гүйцэтгэнэ.

26.6.Үндэсний хорооны үйл ажиллагааны зардлыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний, салбар хорооны үйл ажиллагааны зардлыг уг асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний жил бүрийн төсвийн багцад тус тус тусгана.

27 дугаар зүйл. Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

27.1.Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь улсын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих, урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

27.2.Аймаг, дүүргийн хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

27.2.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах;

27.2.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийг ажил олгогч, иргэдэд сурталчлах;

27.2.3.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдлагын цахим системээр дамжуулан холбогдох мэдээллийг ажил олгогчоос авах;

27.2.4.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах;

27.2.5.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төрийн захиргааны хяналт хэрэгжүүлэх;

27.2.6.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

28 дугаар. Аймаг сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

28.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

28.1.1.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгө болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн зөвлөлийн үйл ажиллагааны холбогдох зардлыг төсөвт тусгаж, хэрэгжилтэд хяналт тавих;

28.1.2.үйлдвэрлэлийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийн хэрэгжилт болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар тухайн шатны Засаг даргын тайлан, мэдээллийг хэлэлцэн үнэлэлт дүгнэлт өгөх;

28.1.3.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар холбогдох шийдвэр гарган, хэрэгжилтэд хяналт тавих;

28.1.4.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаар бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага аж ахуйн нэгж, байгууллага, иргэний оролцоог хангаж, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах;

28.1.5.хуульд заасан бусад эрх.

29 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

29.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг харьяа засаг захиргааны нэгжид хангуулах чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

29.1.1.засаг захиргааны нэгжид хамаарах төсвийн байгууллагуудад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг төлөвлөж, хэрэгжүүлэх;

29.1.2.хүний эрүүл мэнд, амь насанд ноцтой хохирол учруулсан үйлдвэрлэлийн томоохон ослын үед түүний хор уршгийг арилгах, хүн амыг авран хамгаалахад чиглэсэн арга хэмжээг шуурхай зохион байгуулах;

29.1.3.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

30 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллагын чиг үүрэг

30.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

30.1.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

30.1.2.ажил олгогч, ажилтан, иргэнд зориулсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, сурталчилгааг зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

30.1.3.ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг хэмжих, үнэлэх, химийн бодисын хордлогын шалтгааныг судлан тогтоох, дүгнэлт, зөвлөмж гаргах;

30.1.4.хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулах, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт илрүүлэх, оношлох, ажилтны хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох, хөдөлмөр зохицуулалт, магадлал хийх;

30.1.5.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээний аргачлал батлах, ажил олгогч, ажилтан, холбогдох талд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

30.1.6.мэргэжлээс шалтгаалсан өвчний оношилгоо, сэргээн засах тусламж үйлчилгээний удирдамж, аргачлал батлах, хэрэгжилтийг хангах;

30.1.7.мэргэжлээс шалтгаалсан өвчний болон эрсдэлтэй ажлын байрны мэдээллийн сан бүрдүүлэх;

30.1.8.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсан иргэнд сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх;

30.1.9.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний шалгуур үзүүлэлтийн мэдээллийн сан бүрдүүлэх, судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг хөгжүүлэх;

30.1.10.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн салбарын мэргэжилтнийг мэргэшүүлэх;

30.1.11.хөдөлмөрийн эрүүл ахуйн хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх;

30.1.12.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдлагын цахим системийг нэвтрүүлэх, ажиллуулах, ашиглах;

30.1.13.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжилтний цогц чадамж, мэргэшлийн түвшнийг үнэлж, зөвшөөрүүлэх, мэргэшлийн зэрэг олгох шалгуур үзүүлэлтийг тогтоох;

30.1.14.хуульд заасан бусад чиг үүрэг.

30.2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

31 дүгээр зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжлийн байгууллагын чиг үүрэг

31.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжлийн байгууллагад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургууль, хөдөлмөрийн эрүүл ахуйн шинжилгээний лаборатори, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний байгууллага, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын байгууллага, хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан иргэнд сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллага, мэргэжлийн холбоо зэрэг мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг бусад байгууллага хамаарна.

31.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжлийн байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

31.2.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургууль нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжилтнийг Боловсролын хууль тогтоомжийн дагуу бэлтгэж, мэргэшүүлэх;

31.2.2.хөдөлмөрийн эрүүл ахуйн шинжилгээний лаборатори нь ажлын байран дахь ажилтны эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлсийг стандартын дагуу шинжлэн тодорхойлж, мэргэжлээс шалтгаалсан өвчний эрсдэл, хөдөлмөрийн нөхцөлийг үнэлэх, химийн бодисын хордлогын шалтгааныг судлан тогтоох, хувийн хамгаалах хэрэгслийг шалган турших;

31.2.3.ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний байгууллага энэ хуулийн 43 дугаар зүйлд заасан шаардлагын дагуу хэмжилт шинжилгээнд үндэслэн ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг үнэлж, мэргэжлээс шалтгаалсан өвчний эрсдэлийг арилгах, бууруулах зөвлөмжийг ажил олгогч, ажилтан, холбогдох талд өгөх;

31.2.4.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын байгууллага нь ажил олгогч, ажилтан, иргэнд ажил хөдөлмөртэй холбоотой осол, бэртэл, гэмтэл, өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн мэдлэг, дадлыг олгох сургалтыг хууль тогтоомжоор тогтоосон шаардлагад нийцүүлэн зохион байгуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн ажилтан бэлтгэх;

31.2.5.хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг зохион байгуулах эрүүл мэндийн байгууллага нь хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэн хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг, тандалт хийх, ажилтны ажил мэргэжлийн тохироог үнэлэх, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт илрүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, хөдөлмөр зохицуулалтын асуудлаар ажилтан, ажил олгогчид зөвлөх;

31.2.6.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон иргэнд сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллага нь сэргээн засах, эмчлэх, сувилах үйлчилгээг эмнэл зүйн удирдамж, аргачлалын дагуу зохион байгуулж хөдөлмөр зохицуулалт хийх.

32 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжлийн холбооны чиг үүрэг

32.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжлийн холбоо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

32.1.1.мэргэжлийн чиглэлээр стандарт, техникийн зохицуулалт, удирдамж, заавар, зөвлөмж боловсруулах, олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэхэд төрийн байгууллага, холбогдох талуудтай хамтран ажиллах;

32.1.2.салбарын мэргэжилтний мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх, эрдэм шинжилгээ, инновацыг дэмжих, сайн туршлагыг түгээх;

32.1.3.тухайн чиглэлийн мэргэжилтэнд тавигдах мэргэжлийн цогц чадамж, мэргэшлийн зэргийг үнэлэх, хүлээн зөвшөөрөх;

32.1.4.төрийн байгууллагын зарим чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гэрээний үндсэн дээр гүйцэтгэх;

32.1.5.хууль тогтоомжид заасан бусад.

33 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжилтний эрх, үүрэг

33.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжилтэн нь дараах эрхтэй:

33.1.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлаар хүн, хуулийн этгээдэд мэргэжлийн зөвлөгөө өгөх;

33.1.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжилтний ёс зүй, хүний амь нас, эрүүл мэндэд харш үйлдэл хийлгэхээр шаардсан тохиолдолд татгалзах;

33.1.3.ажил үүргээ биелүүлэхэд шаардлагатай эрүүл, аюулгүй ажиллах нөхцөлөөр хангуулах;

33.1.4.мэргэшлийн зэргээ баталгаажуулах, мэргэшлийн зэргийн нэмэгдэл авах;

33.1.5.хууль тогтоомжид заасан бусад эрх.

33.2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжилтэн нь дараах үүрэгтэй:

33.2.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг биелүүлж, хүнлэг, энэрэнгүй үзлийг эрхэмлэн, мэргэжлээ хүний эрүүл мэнд, аюулгүй байдлын эсрэг ашиглахгүй байх;

33.2.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлага зөрчигдсөнөөс хүний амь нас, эрүүл мэндэд аюултай нөхцөл үүссэн бол холбогдох талд анхааруулах, аюулаас сэргийлэх талаарх мэдээлэл, зөвлөгөө өгөх;

33.2.3.мэргэжлийн үйл ажиллагаандаа хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандарт, хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн удирдамжийг мөрдөх;

33.2.4.ажил үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн хувь хүн, байгууллагын мэдээллийн нууцлалыг хадгалах, хууль тогтоомжийн дагуу эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэх зорилгоор хэрэглэх;

33.2.5.мэргэшлийн ур чадвараа байнга дээшлүүлэх;

33.2.6.хууль тогтоомжид заасан бусад.

НЭГДҮГЭЭР ДЭД БҮЛЭГ

Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн зохион байгуулалт

34 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан бүтэц, зохион байгуулалт

34.1.Ажлын байрны аюултай хүчин зүйлээс ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, ажил, хөдөлмөртэй холбоотой осол, бэртэл, гэмтэл, өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг хангах, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч шууд хариуцна.

34.2.10 хүртэл ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь энэ хуулийн 34.1-д заасан үүргийг хэрэгжүүлэхэд үйл ажиллагааны онцлог, ажлын байрны эрсдэлийн түвшнээс хамаарч хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлыг ажил олгогч өөрөө хариуцах эсхүл аль нэг ажилтнаар хавсран эсхүл гэрээгээр гүйцэтгүүлнэ.

34.3.Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь энэ хуулийн 34.1-д заасан үүргийг хэрэгжүүлэхэд байгууллагын үйл ажиллагааны онцлог, ажлын байрны эрсдэлийн түвшин, ажилтны тоог харгалзан дараах байдлаар зохион байгуулна:

34.3.1.11-50 хүртэл ажилтантай бол хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлыг аль нэг ажилтнаар хавсран гүйцэтгүүлэх, эсхүл орон тооны ажилтан эсхүл гэрээгээр гүйцэтгүүлэх;

34.3.2.51-200 хүртэл ажилтантай бол орон тооны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн ажилтантай байх, хөдөлмөрийн эрүүл ахуйч, мэргэжлээс шалтгаалсан өвчний эмчийг орон тоогоор эсхүл гэрээгээр ажиллуулж болно;

34.3.3.201-500 хүртэл ажилтантай бол хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан бүтэцтэй байх, хөдөлмөрийн эрүүл ахуйч, мэргэжлээс шалтгаалсан өвчний эмчийг орон тоогоор эсхүл гэрээгээр ажиллуулах;

34.3.4.501 ба түүнээс дээш ажилтантай бол хөдөлмөрийн аюулгүй байдал болон хөдөлмөрийн эрүүл мэндийн нэгж бүхий хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан бүтэц ажиллуулах.

34.4.10 ба түүнээс дээш ажилтан ажиллуулж байгаа эсхүл энэ хуулийн 34.3-д зааснаас бусад хүн, хуулийн этгээд үйл ажиллагааны онцлог, ажилтны тооноос хамааран хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлыг аль нэг ажилтнаар хавсран гүйцэтгүүлэх эсхүл орон тооны ажилтан ажиллуулах эсхүл гэрээгээр гүйцэтгүүлж болно.

35 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн орон тооны бус зөвлөл

35.1.50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд ажил олгогчид дэмжлэг үзүүлэх, ажилтны оролцоог хангах зорилгоор Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн орон тооны бус зөвлөлийг ажиллуулна.

35.2.50-иас цөөн ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь нийт ажилтны саналд үндэслэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн орон тооны бус зөвлөл байгуулан ажиллуулж болно.

35.3.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнд ажил олгогч болон ажилтнаас сонгогдсон төлөөлөл ажиллана. Орон тооны бус зөвлөлийн гишүүдэд урамшуулал олгож болно.

36 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан бүтэц, ажилтны чиг үүрэг

36.1.Энэ хуулийн 34.2-т заасан асуудал хариуцсан бүтэц, ажилтан нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдлагын тогтолцоог хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэн нэвтрүүлж, хэрэгжилт, үр дүнд хяналт тавьж, тасралтгүй сайжруулахтай холбоотой дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

36.1.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн бодлого, дүрэм, журмыг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, ажил олгогчоор батлуулан мөрдөх, түүнийг тасралтгүй сайжруулах;

36.1.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах мэргэжлийн хүний нөөц, төсөв, удирдлага зохион байгуулалтын ажлыг төлөвлөх, хэрэгжилтэд хяналт тавих асуудлаар ажил олгогчид зөвлөх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;

36.1.3.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн арга хэмжээний төлөвлөгөө, шаардлагатай төсвийг батлуулах, ажлын байран дахь аюул, эрсдэлийг арилгах, бууруулах асуудлаар холбогдох удирдах албан тушаалтан, ажилтанд

мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, гүйцэтгэлийг үнэлж, ажил олгогчид танилцуулах;

36.1.4.ажлын байран дахь ажил, хөдөлмөртэй холбоотой осол, бэртэл, гэмтэл, өвчин үүсгэх аюулыг илрүүлэх, хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөлийг хэмжих, эрсдэлийн үнэлэх, арилгах, бууруулах, ажилтны аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, үр дүнг үнэлэх;

36.1.5.хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг, тандалтыг хөдөлмөрийн нөхцөлөөс хамааруулан зохион байгуулж, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт илрүүлэх, оношлуулах, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, мэргэжлээс шалтгаалсан өвчний тохиолдлыг бүртгэх, мэдээлэх;

36.1.6.үйлдвэрлэлийн ослын хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах, ослын шалтгаанд дүн шинжилгээ хийх, давтан гарахаас урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэх, аюултай тохиолдлыг бүртгэх, мэдээлэх;

36.1.7.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын хэрэгцээг тодорхойлж, сургалтын төлөвлөгөө боловсруулах, сургалтын чанарыг үнэлэх;

36.1.8.ажлын байран дахь аюултай хүчин зүйл, ажлын орчны нөхцөл, онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгслийн нэр, төрөл бүхий жагсаалт боловсруулж, ажил олгогчоор батлуулах, түүний чанар, зохистой хэрэглээнд хяналт тавих;

36.1.9.ажилтанд зориулсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх нэгж ажиллуулдаг бол нэгжийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэн зохион байгуулах;

36.1.10.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандарт болон аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн дүрэм, журмын хэрэгжилтэд үзлэг, шалгалт, дотоод хяналт хийж, гарсан зөрчлийг арилгуулах;

36.1.11.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийн шаардлага, дүрэм, журмыг зөрчсөн албан тушаалтан, ажилтанд хариуцлага хүлээлгэх саналаа ажил олгогчид гаргах;

36.1.12.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

37 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын бүтцийн нэгжийн удирдах албан тушаалтны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаар хүлээх чиг үүрэг

37.1.Аж ахуйн нэгж, байгууллагын нэгжийн дарга, ахлах ажилтан тэдгээртэй адилтгах албан тушаалтан нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

37.1.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, өөрийн харьяалах ажлын байр болон үйлдвэрлэлийн орчинд тохирсон дүрэм, журмыг боловсруулахад оролцох;

37.1.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, зохион байгуулах, хяналт тавих, үр дүнг тооцох, удирдлагын тогтолцоог нэвтрүүлэхэд манлайлан ажиллах;

37.1.3.ажлын байран дахь аюулыг үнэлэх, арилгах, аюултай тохиолдлыг бүртгэн мэдээлэх;

37.1.4.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх;

37.1.5.өөрийн харьяалах нэгжийн нийт ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын хэрэгцээг тодорхойлох, сургалт зохион байгуулах, мэдлэг, дадлыг үнэлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа өгөх;

37.1.6.энэ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд ажил олгогч болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн ажилтантай хамтран ажиллах.

37.2. Аж ахуйн нэгж, байгууллагын нэгжийн дарга, ахлах ажилтан тэдгээртэй адилтгах албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтод энэ хуулийн 37.1 дэх хэсэгт заасан чиг үүргийг тусгана.

38 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн санхүүжилт

38.1. Аж ахуйн нэгж, байгууллага эрсдэлийн түвшнээс хамааран үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг хангуулах, ажил хөдөлмөртэй холбоотой осол, бэртэл, гэмтэл, өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсөв, зардлыг жил бүр баталж, дараах арга хэмжээнд зарцуулна:

38.1.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн бүтэц, ажилтан, зөвлөлийн чиг үүрэгт хамаарах үйл ажиллагаа;

38.1.2.ажил хөдөлмөртэй холбоотой осол, бэртэл, гэмтэл, өвчнөөс урьдчилан сэргийлэх;

38.1.3.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;

38.1.4.ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилт хийх;

38.1.5.ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх;

38.1.6.хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг, тандалт;

38.1.7.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, зааварчилгаа, сургалтын орчныг бүрдүүлэх;

38.1.8.ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгслээр хангах, тэдгээрийн шалгалт, туршилт;

38.1.9.ажлын байр, үйлдвэрлэлийн орчны аюул, эрсдэлгүй байдлыг хангах, аюулыг тусгаарлах хаалт, хашилт, дохиоллын систем байршуулж, тэмдэг, тэмдэглэгээ хийх;

38.1.10.ажилтныг сувилах, хөдөлмөрийн чадвар алдалтыг сэргээн засах;

38.1.11.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх бусад арга хэмжээ.

38.2.Ажилтан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн арга хэмжээний аливаа зардлыг хариуцахгүй.

ХОЁРДУГААР ДЭД БҮЛЭГ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаар ажил олгогч, ажилтан, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн эрх, үүрэг

39 дүгээр зүйл. Ажил хөдөлмөр эрхэлж байгаа ажилтны хөдөлмөрийн зохистой нөхцөлөөр хангуулахтай холбогдсон нийтлэг эрх, үүрэг

39.1. Ажил, хөдөлмөр эрхэлж байгаа ажилтан дараах эрхтэй байна:

39.1.1. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлага хангасан ажлын байранд ажиллах;

39.1.2. үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд даатгуулах;

39.1.3. ажлын байрны нөхцөл, эрүүл мэнд, амь насанд эрсдэл учруулж болзошгүй аюултай хүчин зүйл, тэдгээрийг тодорхойлсон хэмжилт, үнэлгээний үр дүнгийн талаар бодит мэдээлэл авах;

39.1.4. ажил, үүргээ биелүүлэх явцад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хэм хэмжээ зөрчигдсэн болон амь нас, эрүүл мэндэд нь аюултай нөхцөл бий болсон тохиолдолд ажлаа зогсоож, энэ талаар ажил олгогчид мэдэгдэх;

39.1.5. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хэлэлцэхэд биечлэн эсхүл төлөөлөгчөөрөө дамжуулан оролцож, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхийг ажил олгогчоос шаардах;

39.1.6. хууль тогтоомжид заасан бусад.

39.2. Ажил, хөдөлмөр эрхэлж байгаа хүн, ажилтан дараах үүрэгтэй байна:

39.2.1. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хэм хэмжээ, технологийн горимыг чанд мөрдөх;

39.2.2. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдаж зохих мэдлэг, дадлыг эзэмших;

39.2.3. хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад амь нас, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх нөхцөл бий болсон тохиолдолд аюулгүй ажиллагааны дүрэм, журамд заасны дагуу шуурхай арга хэмжээ авах;

39.2.4. ажил, хөдөлмөртэй холбоотой сөрөг нөлөөллөөс эрүүл мэндээ хамгаалах, хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэгт хамрагдах;

39.2.5. ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу зөв хэрэглэх;

39.2.6. ажил, үүргээ аюулгүй гүйцэтгэх дадал эзэмших, осол бэртэл, хордлогоос сэргийлэх, болзошгүй аюул, ослын үед анхны тусламж үзүүлэх чадвартай байх;

39.2.7. өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлд учруулахгүй байх;

39.2.8. ажил олгогчийн зүгээс хууль тогтоомжийн хүрээнд нийцүүлэн тавьсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг биелүүлж ажиллах;

39.2.9.гүйцэтгэх ажил үүрэгтэй холбоотойгоор үүсэх аюулыг илрүүлэх, эрсдэлийг үнэлэхэд оролцох;

39.2.10.хууль тогтоомжид заасан бусад.

40 дүгээр зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаар ажил олгогчийн нийтлэг эрх, үүрэг

40.1.Ажил олгогч нь дараах нийтлэг эрхтэй байна:

40.1.1.энэ хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан ажилтныг томилох, чөлөөлөх, бүтэц, орон тооны бус зөвлөл байгуулах;

40.1.2.ажлын байрны онцлогт нийцсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаарх хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг баталж, мөрдүүлэх;

40.1.3.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн дүрэм, журмыг зөрчсөн ажилтанд энэ хууль болон Хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд заасан хариуцлага хүлээлгэх;

40.1.4.хоёр ба түүнээс дээш гүйцэтгэгчтэй ажил, үйлчилгээ үзүүлж байгаа бол захиалагч, ерөнхий болон бусад гүйцэтгэгчээс ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг хангаж ажиллахыг шаардах;

40.1.5.хууль тогтоомжид заасан бусад.

40.2.Ажил олгогч нь дараах нийтлэг үүрэгтэй байна:

40.2.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлага хангасан ажлын байрны нөхцөлийг бүрдүүлэх инженер технологи, удирдлага зохион байгуулалт, хувь хүнд чиглэсэн арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлэх удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх;

40.2.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг хангуулах, ажил хөдөлмөртэй холбоотой осол, бэртэл, гэмтэл, өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах зардлыг баталж, зарцуулах;

40.2.3.үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад хүний амь нас, эрүүл мэндэд аюултай нөхцөл үүссэн тохиолдолд уг үйл ажиллагааг яаралтай зогсоож, аюулыг шуурхай арилгах;

40.2.4.ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийг үнэлэх, бууруулах, арилгах, уг үйл ажиллагаанд удирдах ажилтан, ажилтны төлөөллийг томилж ажиллуулах;

40.2.5.эрсдэлтэй ажлын байранд аюулыг анхааруулах, хориглох, сануулах, заах тэмдэг, санамж байрлуулах, аюулыг тусгаарлах хаалт, хашилт, дохиоллын систем байршуулж, тэмдэглэгээ хийх;

40.2.6.ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх;

40.2.7.ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөл болон ажилтны хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэгт үндэслэн хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалтыг зохион байгуулах;

40.2.8.ажил олгогчид зориулсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдах;

40.2.9.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдаж, шаардлагатай мэдлэг, дадлыг эзэмшсэн, шалгалтад тэнцсэн, аюулгүй ажиллах зааварчилгаа авсан, шаардлагатай бол хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан ажилтнаар ажил үүрэг гүйцэтгүүлэх;

40.2.10.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, аюултай тохиолдлын талаар тэмдэглэл, бусад шаардлагатай мэдээллийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдлагын цахим системд илгээх;

40.2.11.үйлдвэрлэлийн осол гарсан тохиолдолд хяналтын улсын байцаагч, холбогдох байгууллагад нэн даруй мэдэгдэж, шаардлагатай арга хэмжээг авах;

40.2.12.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан ажилтанд хууль тогтоомжийн дагуу нөхөн төлбөр олгох;

40.2.13.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий этгээдийг ажлын байранд саадгүй нэвтрүүлэх, албан шаардлага, албан даалгаврыг биелүүлэх;

40.2.14.хууль тогтоомжид заасан бусад.

40.3.Захиалагч, ерөнхий болон туслан гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг хангах урьдчилан сэргийлэх арга хэмжээ, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас ажилтанд учирсан хохирлыг нөхөн төлөх, амь нас, эрүүл мэндийн даатгалд хамруулах зэрэгт зайлшгүй шаардагдах хөрөнгө, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаар харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгана. Хэрэв гэрээнд энэ талаар тусгаагүй бол хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй гэм буруутай тал нь учирсан хохирол, гэм хорыг ажилтны өмнө хариуцна.

41 дүгээр зүйл. Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрх, үүрэг

41.1.Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн дараах эрхтэй байна:

41.1.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжоор тогтоосон шаардлагыг хангахтай холбоотой зардлыг ажил үйлчилгээний төлбөр, төсөвт тусган гүйцэтгүүлэгч, захиалагчаас гаргуулах;

41.1.2.захиалгаар гүйцэтгэх ажил, үйлчилгээний үед захиалагч, ерөнхий гүйцэтгэгчээс хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаар харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг ажил гүйцэтгэх гэрээнд тусгах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлага хангаж ажиллахыг шаардах;

41.1.3.захиалгаар ажил, үйлчилгээ гүйцэтгэх үед хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг хангаагүйгээс гарсан осол, гэмтэл, өвчний улмаас учирсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх;

41.1.4.хууль тогтоомжид заасан бусад.

41.2.Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн дараах үүрэгтэй байна:

41.2.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг хангаж өөрийн болон бусдын эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл учруулахгүй байх;

41.2.2.ажил, хөдөлмөрийн онцлогт нийцсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан байх;

41.2.3.ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийх;

41.2.4.тухайн салбарт тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг мөрдөх;

41.2.5.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд даатгуулах;

41.2.6.хууль тогтоомжид заасан бусад.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

42 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зарчим

42.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь ажил, хөдөлмөр эрхлэгч хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалахад чиглэж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төрийн захиргааны хяналттай нэгдмэл, харилцан уялдаатайгаар салбар дунд хамтын ажиллагаа, идэвхтэй оролцоонд суурилан хэрэгжинэ.

42.2.Үндэсний түвшинд хэрэгжүүлэх үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн 4 жил тутам баталж, хэрэгжүүлнэ.

42.3.Аймаг, дүүргийн түвшинд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг аймаг, дүүргийн хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцаж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

42.4.Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийн шаардлагыг хангаж, ажлын байранд ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах, ажил хөдөлмөртэй холбоотой осол, бэртэл, гэмтэл, өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.

43 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн техникийн зохицуулалт, стандарт

43.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн техникийн зохицуулалт нь ажлын байранд ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд заавал мөрдөх шаардлагыг тогтооно.

43.2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн стандарт нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд тавих шаардлага, техникийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд мөрдөх хэм хэмжээ, аргачлал, зааврыг тогтооно.

43.3.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн стандартыг шинээр боловсруулах, шинэчлэх асуудлыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллага хариуцна.

44 дүгээр зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ

44.1.Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээг стандарт, аргачлалын дагуу тогтмол хийж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлнэ.

44.2.Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн нь ажлын байрандаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээний үр дүн, урьдчилан сэргийлэх талаарх мэдээллийг эрсдэлд өртөж байгаа ажилтан, холбогдох талд танилцуулна.

44.3.Ажил олгогч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ, түүний мөрөөр хэрэгжүүлсэн хэрэгжүүлсэн ажлын тайланг тухай бүр удирдлагын цахим системд оруулна.

45 дугаар зүйл. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ

45.1.Ажил олгогч нь ажлын байр шинээр бий болгох, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, нөхцөл өөрчлөгдөх бүрд ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгэнэ.

45.2.Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээгээр хэвийн бус нөхцөлтэй нь тогтоогдсон болон химийн хорт болон аюултай бодис агуулсан түүхий эд, материал ашигладаг ажлын байранд жил бүр хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэнэ.

45.3.Хөдөлмөрийн хэвийн нөхцөлтэй ажлын байранд таван жил тутамд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэнэ.

45.4.Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг итгэмжлэлийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагаас итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага стандартын дагуу хийнэ.

45.5.Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх мэргэжилтэн нь хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэшлээр суралцсан, ажил хөдөлмөртэй холбоотой өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, үр нөлөөг нь үнэлэх чадвартай, мэргэжлээрээ ажилласан туршлагатай байна.

45.6.Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийсэн хуулийн этгээд үнэлгээний тайланг ажил олгогчид танилцуулснаас хойш ажлын 15 өдрийн дотор удирдлагын цахим системд оруулна.

45.7.Ажилтан өөрийн ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгэх хүсэлтээ ажил олгогчид гаргаж болно.

46 дугаар зүйл. Хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилт

46.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээгээр ажилтан хими, физик, эргономик, биологийн зэрэг аюултай хүчин зүйлд өртөж байгаа нь тогтоогдвол ажил олгогч хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилт хийж, хэмжилтийн үр дүнд үндэслэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.

46.2.Хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилтийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжилтэн баталгаат байдлыг хангасан хэмжих хэрэгслийг ашиглан стандартын дагуу хийнэ.

46.3.Хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилтээр ажилтан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн аюултай хүчин зүйлд өртөж байгаа нь тогтоогдвол ажил олгогч энэ талаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдлагын цахим системд мэдээлнэ.

47 дугаар зүйл. Хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг, тандалт

47.1.Ажил олгогч нь хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилт эсхүл ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний дүнд үндэслэн хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэгт хамруулах шаардлагатай ажлын байрны жагсаалтыг гаргана.

47.2.Энэ хуулийн 47.1-д заасан жагсаалтад хамаарах ажилтныг хөдөлмөрийн эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгт ажил олгогчийн зардлаар хамруулж, ажил мэргэжлийн тохироог тодорхойлуулна.

47.3.Өндөр эрсдэлтэй ажилд шинээр орох болон хөдөлмөрийн нөхцөл нь солигдож байгаа ажилтныг хөдөлмөрийн эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулна.

47.4.Ажилтны хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэгийн дүнд үндэслэн ажил олгогч шаардлагатай бол хөдөлмөр зохицуулалт хийнэ.

47.5.Хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалтыг ажилтны хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээнд үндэслэн зохион байгуулж, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт илрүүлж, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлнэ.

47.6.Хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалт, мэргэжлээс шалтгаалсан өвчний жагсаалт болон бүртгэх, мэдээлэх журмыг хөдөлмөрийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

48 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийн удирдлага

48.1.Ажил олгогч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийн болон хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ, хэмжилт, тандалт, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, аюултай тохиолдолд хийсэн дүн шинжилгээ болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдлагын цахим системийн бүртгэл, мэдээлэлд үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.

48.2.Ажил олгогч нь ажлын байрны аюултай хүчин зүйлийг арилгах, бууруулах, орлуулах инженер технологи, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг үр нөлөөгөөр эрэмбэлж дангаар нь эсхүл хамтад нь хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулна.

48.3.Ажлын байран дахь аюулыг арилгах боломжгүй бол ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор стандарт шаардлага хангасан ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгслээр хангана.

49 дүгээр зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт

49.1.Ажил олгогч, удирдах албан тушаалтан, ажилтан, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад жил бүр хамрагдаж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай мэдлэг, дадалтай болсон байна.

49.2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт нь дараах төрөлтэй байна:

49.2.1.ажил олгогч, удирдах ажилтны;

49.2.2.нийт ажилтны;

49.2.3.хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний;

49.2.4.өндөр эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа иргэн, ажилтны;

49.2.5.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн ажилтны.

49.3.Дээд, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага нь суралцагч, иргэнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдлэг, ур чадвар, дадлыг эзэмшүүлнэ.

49.4.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн сурагч, хүүхдэд осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх мэдлэг, дадал олгох сургалтыг мэргэжлийн холбоо, сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулна.

50 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдлагын цахим систем

50.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдлагын цахим систем нь (цаашид “удирдлагын цахим систем” гэх) Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд заасан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын мэдээллийн сан болон дараах мэдээллээс бүрдэнэ:

50.1.1.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд даатгуулсан ажил олгогч, даатгуулагчийн бүртгэл;

50.1.2.хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан даатгуулагчийн бүртгэл;

50.1.3.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан ажил олгогч, даатгуулагчийн бүртгэл;

50.1.4.аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн ажилтан, мэргэжилтний бүртгэл;

50.1.5.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хяналт, шалгалтын мэдээлэл;

50.1.6.бусад мэдээлэл.

50.2.Удирдлагын цахим системийн нууцлал, хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангах үүргийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн

асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллага нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран хариуцна.

50.3.Удирдлагын цахим систем нь мэдээллийн нөөц сантай байна.

50.4.Удирдлагын цахим системийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг хангахтай холбоотой үйл ажиллагааны зардлыг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлнэ.

51 дүгээр зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн санхүүжилт

51.1.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үндэсний түвшинд хэрэгжүүлэх санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

51.1.1.улсын болон орон нутгийн төсөв;

51.1.2.гадаад, дотоодын иргэн, хуулийн этгээдийн хандив;

51.1.3.гадаадын зээл, тусламж;

51.1.4.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас зарцуулах хөрөнгө;

51.1.5.хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

51.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн арга хэмжээнд шаардагдах төсвийг тухайн засаг захиргааны нэгжийн Засаг дарга Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулан зарцуулна.

51.3.Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн энэ хуулийн 36, 38 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангахад шаардагдах зардлыг хариуцна.

51.4.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дагуу ажил олгогч, ажилтан, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн холбогдох зардал, санхүүжилтийг олгоно.

52 дугаар зүйл. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал

52.1.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын асуудлыг хариуцна.

52.2.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь хэмжээг даатгуулагчийн ажлын байран дахь эрсдэлийн түвшнээс хамааруулан тогтооно.

52.3.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 13.1-д заасны дагуу санхүүжүүлнэ.

53 дугаар зүйл. Ажилтны амь нас, эрүүл мэндийн даатгал

53.1.Эрсдэл өндөртэй ажлын байранд ажиллаж байгаа ажилтныг амь нас, эрүүл мэндийн даатгалд даатгуулна. Амь нас, эрүүл мэндийн нэмэлт даатгалын хураамжийг ажил олгогч хариуцна.

53.2.Энэ хуулийн 53.1-д заасан ажилтны амь нас, эрүүл мэндийн даатгалын хураамжийг удирдлагын цахим системд үндэслэн эсхүл ажлын байранд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр тодорхойлсон эрсдэлийн түвшнээс хамааруулан холбогдох хууль тогтоомжийн дагуу тогтооно.

53.3.Ажилтны амь нас, эрүүл мэндийн даатгалын байгууллага нь даатгуулагчид дараах зардлыг олгоно:

53.3.1.үйлдвэрлэлийн осолд орсон хүнд үзүүлэх эмнэлгийн яаралтай тусламж, ослын газраас эмнэлэг хүргэх болон эмчилгээний зардал;

53.3.2.хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээхтэй холбоотой протез, ортопед, сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний зардлын үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох жишиг зардлаас давсан хэсэг;

53.3.3.гэрээгээр тохиролцсон бусад.

53.4.Энэ хуулийн 53.3.3-д заасан гэрээнд дараах зардал, нөхөн төлбөрийг олгохоор харилцан тохиролцож болно:

53.4.1.ажил олгогч, даатгуулагчид чиглэсэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний урьдчилан сэргийлэлт болон эрүүл мэндийн үйлчилгээний зардал;

53.4.2.Хөдөлмөрийн тухай хуулийн 125.1-д заасан нөхөн төлбөрийг ажилтан эсхүл түүний гэр бүлд олгох.

ТАВДУГААР БҮЛЭГ

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЭЛ, ХӨДӨЛМӨР ЗОХИЦУУЛАЛТ, СЭРГЭЭН ЗАСАХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

54 дүгээр зүйл. Үйлдвэрлэлийн осол, аюултай тохиолдлыг мэдэгдэх, бүртгэх, хянан баталгаажуулах, мэдээллийн сан бүрдүүлэх

54.1.Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь үйлдвэрлэлийн осол, аюултай тохиолдлыг бүртгэх, мэдээлэх, статистик өгөгдлийн сан бүрдүүлэх асуудлыг хариуцна.

54.2.Энэ хуулийн 3.1-д заасан хүн Нийгмийн даатгалын сангаас олгох Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 3.1-д заасан тохиолдолд осолд өртсөний улмаас гэмтсэн, өвчилсөн, эсхүл амь насаа алдсан бол үйлдвэрлэлийн осолд тооцож, шалтгааныг нь тогтоох акт, дүгнэлт үйлдэнэ.

54.3.Ажил олгогч нь өөрийн зардлаар үйлдвэрлэлийн осолд өртсөн хүнд анхны тусламж үзүүлэх, ослын газраас эмнэлэгт хүргэх, эмчилгээ, үзлэг, шинжилгээг хийлгэх арга хэмжээг нэн даруй авна. Осолд өртсөн хүн энэ хуулийн 53 дугаар зүйлд

заасан амь нас, эрүүл мэндийн даатгалд даатгуулсан бол эмнэлгийн яаралтай тусламж, ослын газраас эмнэлэг хүргэх болон эмчилгээний зардлыг даатгалын байгууллагаас ажил олгогчид нөхөн олгоно.

54.4. Ажил олгогч үйлдвэрлэлийн осол, аюултай тохиолдлын хор уршгийг арилгах, аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

54.5. Ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, аюултай тохиолдлыг техникийн зохицуулалтын дагуу судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс (цаашид "комисс" гэх)-ыг байгуулж ажиллуулна.

54.6. Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга тухайн засаг захиргааны нэгжид ажиллаж байгаа хувиараа хөдөлмөр эрхлэгч хүн үйлдвэрлэлийн осолд өртсөн тохиолдолд ослыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссыг байгуулж ажиллуулна.

54.7. Комисс нь үйлдвэрлэлийн осол гарснаас хойш ажлын таван өдрийн дотор судлан бүртгэх бөгөөд акт үйлдэж, энэ хуулийн 59.1-д заасан хяналтын улсын байцаагчид ажлын гурван өдрийн дотор хүргүүлнэ.

54.8. Комисс нь аюултай тохиолдол гарснаас хойш ажлын таван өдрийн дотор судлан бүртгэж, энэ хуулийн 50.1-д заасан удирдлагын цахим системд бүртгүүлэн тухайн тохиолдол дахин гарахаас урьдчилан сэргийлж ажиллана.

54.9. Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэсэн актыг хяналтын улсын байцаагч ажлын таван өдрийн дотор хянан баталгаажуулж, энэ хуулийн 50.1-д заасан удирдлагын цахим системд бүртгүүлнэ.

54.10. Хяналтын улсын байцаагч үйлдвэрлэлийн ослын актыг зөвшөөрөөгүй эсхүл хүний амь нас хохирсон үйлдвэрлэлийн ослын тохиолдолд дүгнэлт гаргана.

54.11. Үйлдвэрлэлийн осол нь зам тээврийн шинжтэй бол тээврийн цагдаагийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн хяналтын улсын байцаагч үйлдвэрлэлийн ослын актыг баталгаажуулна.

54.12. Зүрх, судасны эрхтэн тогтолцооны эмгэгийн улмаас ажилтан ажил үүргээ гүйцэтгэж байх үедээ нас барсан тохиолдолд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төрийн үйлчилгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн хяналтын улсын байцаагч үйлдвэрлэлийн ослын актыг баталгаажуулна.

54.13. Үйлдвэрлэлийн ослын улмаас ажилтны эрүүл мэндэд хүнд гэмтэл, бэртэл учирсан, нас барсны улмаас мэргэжлийн байгууллагын шинжилгээ, магадалгаа шаардлагатай бол ослыг судлан бүртгэсэн акт, дүгнэлт гаргах хугацааг ажлын 30 өдөр хүртэл нэг удаа сунгаж болно.

54.14. Ажил олгогч нь хяналтын улсын байцаагчийн баталгаажуулсан үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэсэн акт, дүгнэлтийг ажил олгогч эсхүл харьяалах Засаг дарга, нийгмийн даатгалын байгууллага, осолдогч эсхүл түүний гэр бүлд мэдэгдэнэ.

54.15. Ноцтой хор аюул, хохирол ихтэй үйлдвэрлэлийн осол гарсан тохиолдолд тухай бүр Засгийн газраас томилсон комисс судлан бүртгэнэ.

54.16. Ажил олгогч, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 54.5, 54.6-т заасан үүргээ биелүүлээгүй эсхүл үйлдвэрлэлийн ослын акт, дүгнэлтийг осолд өртсөн хүн, ажилтан зөвшөөрөхгүй бол гомдлоо дээд шатны байгууллага болон шүүхэд гаргаж холбогдох хуулийн дагуу шийдвэрлүүлнэ.

54.17. Үйлдвэрлэлийн ослын актыг хянан баталгаажуулснаас хойш ажлын 15 өдрийн дотор ажил олгогч тухайн ослын шалтгаан, нөхцөлийг арилгах, давтан гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хяналтын улсын байцаагчаар батлуулж хэрэгжүүлнэ.

54.18. Сум, дүүргийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн зөвлөл харьяа засаг захиргааны нэгжийн хувиараа хөдөлмөр эрхлэгчид бүртгэгдсэн үйлдвэрлэлийн ослын тохиолдолд дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг аргалгах, давтан гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.

54.19. Ажил олгогч үйлдвэрлэлийн ослыг нуун дарагдуулахыг хориглоно.

55 дугаар зүйл. Мэргэжлээс шалтгаалсан өвчний бүртгэл, мэдээлэл, түүнтэй холбогдсон хөдөлмөр зохицуулалт

55.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллага нь мэргэжлээс шалтгаалсан өвчний оношийг баталгаажуулах, хөдөлмөр зохицуулалт хийх, хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох, бүртгэх, мэдээлэх, статистик мэдээллийн сан бүрдүүлэх асуудлыг хариуцна.

55.2. Ажил олгогч нь мэргэжлээс шалтгаалсан өвчний тохиолдол бүрийг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний дүнд үндэслэн бүртгэн мэдээлж, шаардлагатай тохиолдолд хөдөлмөр зохицуулалт хийж, ажилтныг хөдөлмөрийн чадвар алдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна.

55.3. Эрүүл мэндийн байгууллага нь үзлэгээр илэрсэн мэргэжлээс шалтгаалсан өвчний шинж тэмдэг бүхий тохиолдлыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллагад мэдээлж, онош баталгаажуулалт хийлгэнэ.

55.4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллага баталгаажуулсан мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бүртгэж, эрүүл мэндийн статистик хариуцсан байгууллагад мэдээлнэ.

55.5. Мэргэжлээс шалтгаалсан өвчтэй хүний хөдөлмөрийн чадварын магадалгааг Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн Мэргэжлээс шалтгаалсан өвчний салбар зөвлөл хийнэ.

55.6. Мэргэжлээс шалтгаалсан өвчтэй хүний хөдөлмөрийн чадвар нь тэтгэвэр тогтоолгох хэмжээгээр алдагдаагүй бол Мэргэжлээс шалтгаалсан өвчний салбар зөвлөлийн дүгнэлт, хөдөлмөр зохицуулалт хийх зөвлөмжийг тухайн хүн болон ажил олгогчид өгнө.

55.7. Мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас ажилтны хөдөлмөр зохицуулалтыг хийж өөр ажилд томилогдохтой холбогдуулан дахин мэргэшүүлэх шаардлагатай бол түүнтэй холбогдсон зардлыг ажил олгогч гаргана.

55.8. Мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар нь тэтгэвэр тогтоолгох хэмжээгээр эргэн сэргээгдэхгүйгээр алдагдсан бол хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг Мэргэжлээс шалтгаалсан өвчний салбар зөвлөлөөс хугацаагүй тогтооно.

56 дугаар зүйл. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчтэй хүнд зориулсан сэргээн засах тусламж, үйлчилгээ

56.1. Мэргэжлээс шалтгаалсан өвчин оношлогдсон эсхүл үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсан хүнд сэргээн засах тусламж, үйлчилгээг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллага, төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага үзүүлнэ.

56.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллагаас үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсан хүний хөдөлмөрийн чадварыг хадгалах, сэргээн засах төлөвлөгөөг боловсруулж, эмнэлгийн хяналт үзлэг зохион байгуулах, сэргээн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

56.3. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсан хүнд сэргээн засах эмнэлгийн тусламж, үйлчилгээнд үзүүлэх эмнэл зүйн удирдамжийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллага батална.

56.4. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авч байсан хүн өндөр настны тэтгэвэрт шилжсэн нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчтэй хүнд зориулсан сэргээн засах тусламж, үйлчилгээ авах эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

56.5. Энэ хуулийн 56.4-т заасан сэргээн засах тусламж, үйлчилгээний зардлыг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлнэ.

56.6. Сэргээн засах тусламж, үйлчилгээний зардал үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох жишиг зардлаас давсан тохиолдолд зөрүүг ажил олгогч хариуцах эсхүл энэ хуулийн 53.3.2-д заасны дагуу даатгалын байгууллагаас олгоно.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН БИЕЛЭЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ

57 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт

57.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэж, хараат бус, шударга, нээлттэй, ил тод, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, хяналтад хамрагдаж байгаа талуудын хууль ёсны эрх, ашиг сонирхол, нэр төрийг хүндэтгэх зарчмыг баримтална.

57.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд дараах хяналтыг тавина:

54.2.1. төрийн захиргааны хяналт;

54.2.2. аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналт;

54.2.3.ажилтны төлөөллийн байгууллагын хяналт;

54.2.4.хөндлөнгийн хяналт.

58 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төрийн захиргааны хяналт

58.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих төрийн захиргааны хяналтыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, орон нутагт хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ.

58.2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төрийн захиргааны хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу эрх олгосон хяналтын улсын байцаагч гүйцэтгэнэ.

58.3.Төрийн захиргааны хяналтыг хэрэгжүүлэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлаар урьдчилан сэргийлэх, төлөвлөгөөт, гүйцэтгэлийн хяналтыг төлөвлөхдөө энэ хуулийн 50.1-д заасан удирдлагын цахим системийн өгөгдөл, мэдээлэлд үндэслэнэ.

58.4.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлаар урьдчилан сэргийлэх, төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг гүйцэтгэхдээ шалгуулагч талд урьдчилан мэдэгдэхгүйгээр хийнэ.

59 дүгээр зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төрийн захиргааны хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх улсын байцаагчийн бүрэн эрх

59.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төрийн захиргааны хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9-д зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

59.1.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийн талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх, хуулийн хэрэгжилтийг хангуулах;

59.1.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн бүтэц, зохион байгуулалт, санхүүжилт, хөдөлмөрийн нөхцөл болон ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийн бүхий л асуудлын биелэлтийг шалгах, хэрэгжилтийг хангуулах;

59.1.3.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжоор тогтоосон шаардлага, хэм хэмжээний хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, хэрэгжилтийг хангуулах;

59.1.4.ажлын байр, үйлдвэрлэлийн орчинд ажилтан болон хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулах нөхцөл үүссэн тохиолдолд тухайн ажил, үйлчилгээ, үйл ажиллагааг шууд зогсоох, аюулгүй байдлыг хангуулах;

59.1.5.үйлдвэрлэлийн осол, аюултай тохиолдлыг судлан бүртгэсэн, мэдээлсэн болон ослын шалтгаан, хүчин зүйлийг тогтоосон байдалд хяналт тавих, үйлдвэрлэлийн ослын талаар дүгнэлт гаргах;

59.1.6.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаарх хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал гаргах;

59.1.7.хуульд заасан бусад бүрэн эрх.

60 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналт

60.1.Ажил олгогч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийн хэрэгжилт, эрсдэлийн үнэлгээний дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтэд дотоод хяналт тавина.

60.2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн дотоод хяналтын дүнг ажил олгогч болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн орон тооны бус зөвлөл эсхүл нийт ажилтанд танилцуулна.

60.3.Ажил олгогч дотоод хяналтын явцад илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах үүрэгтэй.

60.4.Ажилтны төлөөлөгч болон ажилтан нь аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналт тавих үйл ажиллагаанд оролцох эрхтэй.

61 дүгээр зүйл. Ажилтны төлөөллийн байгууллагын хяналт

61.1.Ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллага, мэргэжлийн холбоо нь ажилтны төлөөллийн байгууллагын хяналтыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

61.1.1.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний талаар үнэн зөв мэдээлэл авах;

61.1.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийн зөрчлийг арилгах шаардлагыг ажил олгогчид тавих;

61.1.3.хөдөлмөрийн болон хамтын гэрээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаар хүлээсэн үүргийн биелэлт, түүний явцыг дүгнэж, нийт ажилтанд мэдээлэх;

61.1.4.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийн төсөлд санал өгөх;

61.1.5.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомж, хөдөлмөрийн болон хамтын гэрээ, хэлэлцээрт тусгагдсан асуудлаар үүссэн маргааныг хэлэлцэх, шийдвэрлэхэд оролцох;

61.1.6.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар болон хөдөлмөрийн нөхцөлийг дордуулсан, ажилтны эрүүл мэнд, амь насыг хамгаалах үүргээ биелүүлэхгүй байгаа албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, хамтарсан хяналт шалгалт хийх саналаа холбогдох байгууллагад тавих.

62 дугаар зүйл. Хөндлөнгийн хяналт

62.1.Итгэмжлэлийн асуудал хариуцсан байгууллагаас итгэмжлэгдсэн байгууллага итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтод заасны дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн дараах хөндлөнгийн хяналтыг ажил олгогч, ажилтны хүсэлтээр хийж болно:

62.1.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийн нийцлийн үнэлгээ;

62.1.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ;

62.1.3.ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ;

62.1.4.хувийн хамгаалах хэрэгслийн сорил, туршилт;

62.1.5.хууль тогтоомжид заасан бусад.

62.2.Хөндлөнгийн хяналт хэрэгжүүлэх байгууллага нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн чиглэлээр мэргэшсэн ажилтантай, хөндлөнгийн хяналтын байгууллагад тавигдах шаардлага хангасан байна.

62.3.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хөндлөнгийн хяналтын байгууллага нь хяналт хийсэн тайланг удирдлагын цахим системд тухай бүр илгээнэ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧИГЧДӨД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

63 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

63.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

64 дүгээр зүйл. Бусад

64.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлаар ажил олгогч, ажилтан болон хөдөлмөр эрхэлж байгаа хүн, хуулийн этгээдийн хооронд үүссэн маргааныг холбогдох хуулийн дагуу шийдвэрлэнэ.

64.2.Энэ хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт заасан журмыг боловсруулан батална.

ГАРЫН ҮСЭГ

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ
ХУУЛИЙГ ДАГАЛДАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ЖАГСААЛТ**

№	Хуулийн нэр	Төсөл
1	Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	+
2	Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	+
3	Гэрээт харуул хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	+
4	Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	+
5	Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	+
6	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	+
7	Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	+
8	Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	+
9	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	+
10	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	+
11	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	+
12	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	+
13	Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	+
14	Хог хаягдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	+
15	Хувийн хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	+
16	Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	+
17	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	+
18	Шүүх шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	+
19	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	+
20	Эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	+
21	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай	+

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202...оны...дүгээр
сарын...ны өдөр

Улаанбаатар хот

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн гарчгийн “Эрүүл ахуйн нөхцөл, аюулгүй ажиллагааг хангах” гэснийг “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг хангах” гэж, 44.1 дэх хэсгийн “хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн нөхцөл” гэснийг “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлага” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202...оны...дүгээр
сарын...ны өдөр

Улаанбаатар хот

БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Барилгын тухай хуулийн 37.1.9 дэх заалтын “эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын” гэснийг “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг” гэж; 40.1.4 дэх заалтын “хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны” гэснийг “хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны” гэж; 40.1.5 дахь заалтын “талбайн орчны хөдөлмөр хамгааллын дэглэмийг сахиулж” гэснийг “талбай болон үйлдвэрлэлийн орчны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг хангаж” гэж; 40.1.13 дахь заалтын “техникийн ослоос сэргийлсэн хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны нөхцөлийг” гэснийг “техникийн болон үйлдвэрлэлийн ослоос сэргийлсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202...оны...дүгээр
сарын...ны өдөр

Улаанбаатар хот

**ГЭРЭЭТ ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 8.2.3 дахь заалтын “хөдөлмөр хамгаалал” гэснийг “хөдөлмөрийн аюулгүй байдал” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202...оны...дүгээр
сарын...ны өдөр

Улаанбаатар хот

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 10.15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

1/10.15 дугаар зүйл.

“6.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн санхүүжилтийг хууль тогтоомжид нийцүүлэн төсөвлөж, зарцуулаагүй бол хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.Захиалагч, ерөнхий болон туслан гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаар харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаагүй, зайлшгүй шаардагдах хөрөнгө, санхүүжилтийг хууль тогтоомжид нийцүүлэн төсөвлөөгүй, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй бол хүнийг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

8.Ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийг үнэлэх, бууруулах, арилгах үүргээ биелүүлээгүй бол хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

9.Үйлдвэрлэлийн осол, аюултай тохиолдлыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссыг байгуулж ажиллуулаагүй эсхүл хуульд заасан хугацаанд акт үйлдэж, хяналтын улсын байцаагчид хүргүүлээгүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 10.15 дугаар зүйлийн гарчгийн “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн” гэснийг “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн” гэж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “эрүүл ахуйн” гэснийг “эрүүл мэндийн” гэж, 1.2 дахь заалтын “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт” гэснийг “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийн шаардлага, техникийн зохицуулалт” гэж, 2 дахь хэсгийн “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг” гэснийг “Үйлдвэрлэлийн ослыг” гэж, 3 дахь хэсгийн “эрүүл ахуйн” гэснийг “эрүүл мэндийн” гэж, 4 дэх хэсгийн “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого” гэснийг “үйлдвэрлэлийн осол” гэж, 5 дахь хэсгийн “Ажилтны эрүүл мэндийн” гэснийг “Хөдөлмөрийн эрүүл мэндийн” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202...оны...дүгээр
сарын...ны өдөр

Улаанбаатар хот

МАЛЫН ГЕНЕТИК НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Малын генетик нөөцийн тухай хуулийн 19.1.4 дэх заалтын “хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн” гэснийг “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202...оны...дүгээр
сарын...ны өдөр

Улаанбаатар хот

МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн дараах заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/15 дугаар зүйлийн 15.2.5 дахь заалт:

“15.2.5.үйлдвэрлэлийн дадлагыг удирдах багш нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуульд заасны дагуу ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу хэрэглэх;”

2/16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалт:

“16.1.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуульд заасны дагуу шим тэжээллэг хүнсний бүтээгдэхүүнээр хангагдах;”

3/17 дугаар зүйлийн 17.1.3, 17.1.4 дэх заалт:

“17.1.3.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуульд заасны дагуу шим тэжээллэг хүнсний бүтээгдэхүүнээр хангагдах;

17.2.4.үйлдвэрлэлийн дадлагын үед Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуульд заасны дагуу ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу хэрэглэх.”

2 дугаар зүйл.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 2.1 дэх хэсгийн “эрүүл ахуйн” гэснийг “эрүүл мэндийн” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202...оны...дүгээр
сарын...ны өдөр

Улаанбаатар хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/37 дугаар зүйлийн 37.3, 37.9, 37.11, 37.12 дахь хэсэг:

“37.3.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Эрүүл мэндийн магадлалын зөвлөл, Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлтэй байна.

37.9.Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг оношлох, эмчлэх, сэргээн засах, сувилах, хөдөлмөр зохицуулалт хийх, төрөлжсөн нарийн мэргэжлийн болон хөдөлмөрийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх чиг үүрэг бүхий Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллагын харьяанд ажиллуулна.

37.11.Энэ хуулийн 37.10-т заасан салбар нэгжийн даргыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

37.12.Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын төрөлжсөн мэргэжлийн эмнэлгийн ажиллах дүрмийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллагын дарга батална.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202...оны...дүгээр
сарын...ны өдөр

Улаанбаатар хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ,
МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨРИЙН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалт, 4.2 дахь хэсэг:

“4.1.9.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын мэдээллийн санг ашиглах, хадгалах, хамгаалахтай холбогдох зардал;

4.2.Энэ зүйлийн 4.1.6-д заасан төлбөр олгох, зарцуулах чиг үүргийг нийгмийн даатгалын төрийн захиргааны байгууллага болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллага хамтран хэрэгжүүлнэ.”

2/13 дугаар зүйл 13.1.5 дахь заалт:

“13.1.5.шинээр ажилд орох даатгуулагчийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн 47.2-т заасан хөдөлмөрийн эрүүл мэндийн урьдчилсан үзлэг.”

3/14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.2, 14.1.6, 14.1.7 дахь заалт:

“14.1.1.мэргэжлээс шалтгаалсан өвчний онош баталгаажуулах, хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоохтой холбоотой эмнэлгийн үзлэг, шинжилгээний;

14.1.2.хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгаан, онош баталгаажуулахтай холбоотой хөдөлмөрийн нөхцөлийг судлан тогтоох хэмжилт, лабораторийн шинжилгээний;

14.1.6.хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагчид үзүүлэх хөдөлмөрийн сэргээн засах үйлчилгээний;

14.1.7.даатгуулагчийн хөдөлмөрийн чадварыг хадгалах, сэргээн засах төлөвлөгөө боловсруулах, эмчилгээ, сувилгааны хэрэгцээг тодорхойлох, үр дүнг хянахад чиглэсэн эмнэлгийн хяналтын үзлэг, шинжилгээний.”

2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дараах бүлэг, зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/2 дугаар зүйлийн 2.1.4, 2.1.5 дахь заалт:

“2.1.4.”үйлдвэрлэлийн осол” гэж Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн 4.1.10-т заасныг;

2.1.5.“хордлого” гэж Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн тайлбарт заасныг.”

2/3 дугаар зүйл.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин:

3 дугаар зүйлийн 3.1, 3.2 дахь хэсэг:

“3.1.Даатгуулагч дараах нөхцөл байдлын үед үйлдвэрлэлийн осолд өртсөн тохиолдолд энэ хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгоно;

3.2.Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх, тогтоохтой холбогдсон харилцааг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулиар зохицуулна.”

3/4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалт:

“4.1.7.даатгуулагчийн эрүүл мэнд, хөдөлмөрийн сэргээн засах зардлын төлбөр.”

4/13 дугаар зүйл.Даатгуулагчид олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, ажил олгогчид үзүүлэх хөнгөлөлт, чөлөөлөлт

13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, 13.1.3, 13.1.4 дэх заалт:

“13.1.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд дараах арга хэмжээг хамааруулна;

13.1.3.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн, шинэ техник, технологи, инновац нэвтрүүлсэн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх сайн туршлагыг сурталчлах;

13.1.4.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгаан, нөхцөлийг судлах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн техникийн зохицуулалтыг боловсруулах, урьдчилан сэргийлэлтийн талаарх бодлого, шийдвэр, хэрэгжилтийг үнэлэхэд чиглэсэн судалгаа, эрдэм шинжилгээ, хяналт, шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ.”

5/14 дүгээр зүйлийн 14.1.5 дахь заалт, 14.7, 14.11 дэх хэсэг:

“14.1.5.хөдөлмөрийн чадварыг сэргээн засахтай холбогдсон протез, ортопедийн;

14.7.Даатгуулагчид үзүүлэх эрүүл мэнд, хөдөлмөрийн сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно.

14.11.Энэ хуулийн 14.1.2-т заасан зардлын төлбөрийг олгоход баримтлах жишиг үнийг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална.”

6/15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, 15.2 дахь хэсэг, 15.2.2, 15.2.3 дэх заалт:

“15.1.1.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлсэн, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн нөхцөлийг сайжруулсан тохиолдолд шимтгэлийн болон хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх зардлын хөнгөлөлт;

15.2.Энэ хуулийн 15.1.1-д заасан шимтгэлийн хөнгөлөлтийг дараах нөхцөлийг 3 жил дараалан хангасан ажил олгогчийн сүүлийн жилд төлсөн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн 15 хүртэлх хувиар тооцож, ажил олгогчид 3 жил тутамд нэг удаа, хөдөлмөрийн нөхцөлөө сайжруулсан ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэсэн зардлын 20 хүртэл хувийг нэг удаа тус тус үзүүлнэ;

15.2.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн нөхцөлийг сайжруулах, шинэ техник, технологи, инновац нэвтрүүлэхэд хөрөнгө оруулалт хийсэн;

15.2.3.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн 38.1.5-д заасны дагуу хийлгэсэн ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний үр дүнд үндэслэн ажлын байран дахь эрсдэлийг арилгасан.”

7/16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэг:

“16.4.Мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, түгээх, ашиглах, хянах, хадгалах, хамгаалах, тэдгээртэй холбоотой зардлыг санхүүжүүлэх журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

3 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн Дөрөвдүгээр бүлгийн гарчгийн “Эрүүл мэндийн нөхөн сэргээлт” гэснийг “Даатгуулагчийн эрүүл мэнд, хөдөлмөрийн сэргээн засалт” гэж, 14 дүгээр зүйлийн гарчгийн “Эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр” гэснийг “Эрүүл мэнд, хөдөлмөрийн сэргээн засах зардлын төлбөр” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202...оны...дүгээр
сарын...ны өдөр

Улаанбаатар хот

**НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуульд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй.

11 дүгээр зүйлийн 11.1.6 дахь заалт:

“11.1.6.хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллага.”

2 дугаар зүйл. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 5.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг:

“5.4.Энэ хуулийн 5.1.3-т заасан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хүрээнд ажил хийж байгаа хүнийг ажил, хөдөлмөртэй холбоотой бэртэл, гэмтэл, өвчин, хордлогоос урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг хамгаалах, хөдөлмөрийн чадварыг хадгалах үйл ажиллагаа явуулна.”

3 дугаар зүйл. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 2.1 дэх хэсгийн “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль” гэснийг “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хууль” гэж өөрчилсүгэй.”

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202...оны...дүгээр
сарын...ны өдөр

Улаанбаатар хот

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дараах хэсгийг дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“31.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь зохих хууль тогтоомжийн дагуу уурхайд ажиллагчийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлага болон тухайн сум, дүүргийн иргэдийн аюулгүй байдлыг хангах тодорхой үйл ажиллагаа явуулна.”

2 дугаар зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн гарчгийн “Эрүүл ахуйн нөхцөл, аюулгүй ажиллагааг хангах” гэснийг “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг хангах” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202...оны...дүгээр
сарын...ны өдөр

Улаанбаатар хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19.1/4 дэх заалтын “хөдөлмөр хамгаалал, нийгмийн” гэснийг “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202...оны...дүгээр
сарын...ны өдөр

Улаанбаатар хот

ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 19.1 дэх хэсгийн "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэгт" гэснийг "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт" гэж өөрчилсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202...оны...дүгээр
сарын...ны өдөр

Улаанбаатар хот

**ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ**

1 дүгээр зүйл.Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 13 дугаар зүйлд дараах агуулгатай 13.10 дахь хэсэг нэмсүгэй:

“13.10.Аж ахуйн нэгж, байгууллага нь химийн хорт болон аюултай бодистой харьцан ажилладаг ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалахад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийг мөрдөнө.”

2 дугаар зүйл.Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 2.1 дэх хэсгийн “...Гамшгаас хамгаалах тухай хууль,” гэсний дараа “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хууль,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 8.2 дахь хэсгийн “аюулгүй ажиллагааны дүрэм” гэснийг “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлага” гэж, 13.1 дэх хэсгийн “хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны нөхцөл, шаардлагыг” гэснийг “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг” гэж, 13.2 дахь хэсгийн “эрх бүхий байгууллагаас тогтоосон” гэснийг “стандартаар тогтоосон” гэж, 13.3 дахь хэсгийн “өөрийн аюулгүй ажиллагааны дүрмийг боловсруулан нутаг дэвсгэрийнхээ байгаль орчны болон эрүүл ахуйн улсын байцаагчаар хянуулж мөрдөнө.” гэснийг “өөрийн химийн ослоос урьдчилан сэргийлэх, ослын үед ажиллах аюулгүй ажиллагааны журмыг боловсруулж мөрдөнө.” гэж, 13.4 дэх хэсгийн “мэргэжлийн зохих мэдлэг, дадлага туршлагатай 18-аас дээш настай хүнийг ажиллуулна.” гэснийг “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн 46.2.4-т заасан сургалтад хамрагдаж аюулгүй ажиллагааны болон мэргэжлийн зохих мэдлэг, дадал, туршлагатай 21-ээс дээш настай хүнийг ажиллуулна.” гэж, 13.6 дахь хэсгийн “аюулгүй ажиллагаа, болзошгүй осол, эрсдэлээс сэргийлэх” гэснийг “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202...оны...дүгээр
сарын...ны өдөр

Улаанбаатар хот

ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хог хаягдлын тухай хуулийн дараах заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

17 дугаар зүйлийн 17.1.9 дэх заалт:

“17.1.9.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлага хангасан тоног төхөөрөмжтэй;”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202...оны...дүгээр
сарын...ны өдөр

Улаанбаатар хот

ХУВИЙН ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хувийн хамгаалалтын тухай хуулийн 8.2.3 дахь заалтын “хөдөлмөр хамгаалал” гэснийг “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202...оны...дүгээр
сарын...ны өдөр

Улаанбаатар хот

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хөдөлмөрийн тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг:

“3.2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндтэй холбогдсон харилцааг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулиар зохицуулна.”

2/4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх заалт:

“4.1.11.”ажлын байрны хөдөлмөрийн хэвийн нөхцөл” гэж Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн 4.1.3-т заасныг;”

3/92 дугаар зүйлийн 92.4 дахь хэсэг:

“92.4.Уртын ээлжээр ажиллах ажилтны нэг ээлжид ажил үүрэг гүйцэтгэх хугацаа 14 хоног, амрах хугацаа 14 хоног байх бөгөөд ажил мэргэжил, үйл ажиллагааны онцлогтой уялдуулан ажил үүрэг гүйцэтгэх дээд хязгаар 20 өдөр, амрах доод хязгаар 10 өдөр байхаар ажил олгогч, ажилтан хөдөлмөрийн гэрээгээр харилцан тохиролцож болно.”

4/121 дүгээр зүйлийн 121.1 дэх хэсэг:

“121.1.Ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг хангах, ажилтны эрүүл мэндийг хамгаалах, эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулиар зохицуулна.”

2 дугаар зүйл.Хөдөлмөрийн тухай хуулийн 43.2.8 дахь заалтын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 3.1.15-д заасан” гэснийг “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн 4.1.1-т заасан” гэж, мөн хуулийн 42.1.2 дахь заалт, 42.2.5 дахь заалт, 43.2.3 дахь заалт, 88.3 дахь хэсэг, 120.4 дэх хэсэг, 121 дүгээр зүйлийн гарчгийн “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн” гэснийг “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202...оны...дүгээр
сарын...ны өдөр

Улаанбаатар хот

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 29.9.12 дахь заалтын “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн” гэснийг “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн” гэж, 29.13.5 дахь заалтын “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” гэснийг “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202...оны...дүгээр
сарын...ны өдөр

Улаанбаатар хот

ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шүүх шинжилгээний тухай хуулийн 53.1.2 дахь заалтын “хөдөлмөр хамгаалал,” гэснийг “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд,” гэж, 77.2 дахь хэсгийн “тусгай хэрэгсэл, хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас, техник хэрэгслийн” гэснийг “ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах болон техник хэрэгслийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202...оны...дүгээр
сарын...ны өдөр

Улаанбаатар хот

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 163.4 дэх хэсэг, 211.1.3 дахь заалт, 214.1 дэх хэсэг, 216.1.2 дахь заалтын “хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны” гэснийг “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн” гэж, 163.4 дэх хэсэг, 207.5.5 дахь заалтын “хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны” гэснийг “хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202...оны...дүгээр
сарын...ны өдөр

Улаанбаатар хот

ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүл ахуйн тухай хуулийн 6.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“6.1.Ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлага, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх асуудлыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулиар зохицуулна.”

2 дугаар зүйл. Эрүүл ахуйн тухай хуулийн 2.1 дэх хэсгийн “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн” гэснийг “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн” гэж; 6.1 дэх хэсгийн гарчгийн “эрүүл ахуйн” гэснийг “эрүүл мэндийн” гэж; 13.1.5 дахь заалтын “хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны” гэснийг “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Эрүүл ахуйн тухай хуулийн 6.3 дахь хэсгийг хүчингүй болгосугай.

4 дугаар зүйл. Энэ хуулийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202...оны...дүгээр
сарын...ны өдөр

Улаанбаатар хот

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ
ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.2008 оны 5 дугаар сарын 22-ны өдөр баталсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль /Шинэчилсэн найруулга/-ийг хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт
- 2 дугаар зүйл.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомж
- 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ
- 4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт
- 5 дугаар зүйл.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний бодлого, зарчим

**ХОЁРДУГААР БҮЛЭГ
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ШААРДЛАГА**

- 6 дугаар зүйл.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг тогтоох
- 7 дугаар зүйл.Үйлдвэрлэлийн орчин, барилга байгууламж болон үндсэн, суурин тоног төхөөрөмж, хэрэгслийг эзэмших, ашиглахад тавих шаардлага
- 8 дугаар зүйл.Машин механизм, тоног төхөөрөмжид тавих шаардлага
- 9 дүгээр зүйл.Өргөх байгууламжид тавих шаардлага
- 10 дугаар зүйл.Уурын ба ус халаах зуух, даралтат сав, шугам хоолойд тавих шаардлага
- 11 дүгээр зүйл.Химийн хорт болон аюултай бодис, цацраг идэвхт бодистой харьцан ажиллахад тавих шаардлага
- 12 дугаар зүйл.Галын аюулгүй байдалд тавих шаардлага
- 13 дугаар зүйл.Хязгаарлагдмал орчинд тавих шаардлага
- 14 дүгээр зүйл.Өндрийн ажлын аюулгүй байдалд тавих шаардлага
- 15 дугаар зүйл.Хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөлд тавих ерөнхий шаардлага
- 16 дугаар зүйл.Биологийн хүчин зүйлд тавих шаардлага
- 17 дугаар зүйл.Эргономикийн хүчин зүйлд тавих шаардлага
- 18 дугаар зүйл.Ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгсэлд тавих шаардлага
- 19 дүгээр зүйл.Ажлын байрны нийгэм-сэтгэл зүйн орчин
- 20 дугаар зүйл.Ажлын байрны эрүүл ахуйн тусгай шаардлага

**ГУРАВДУГААР БҮЛЭГ
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН
ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦОО**

- 21 дүгээр зүйл.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний тогтолцоо
- 22 дугаар зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх
- 23 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх
- 24 дугаар зүйл.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх
- 25 дугаар зүйл.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх
- 26 дугаар зүйл.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн Үндэсний хороо, түүний бүрэн эрх
- 27 дугаар зүйл.Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

28 дугаар.Аймаг сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

29 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

30 дугаар зүйл.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллагын чиг үүрэг

31 дүгээр зүйл.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжлийн байгууллагын чиг үүрэг

32 дугаар зүйл.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжлийн холбооны чиг үүрэг

33 дугаар зүйл.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжилтний эрх, үүрэг

НЭГДҮГЭЭР ДЭД БҮЛЭГ

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

34 дүгээр зүйл.Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан бүтэц, зохион байгуулалт

35 дугаар зүйл.Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн орон тооны бус зөвлөл

36 дугаар зүйл.Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан бүтэц, ажилтны чиг үүрэг

37 дугаар зүйл.Аж ахуйн нэгж, байгууллагын бүтцийн нэгжийн удирдах албан тушаалтны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаар хүлээх чиг үүрэг

38 дугаар зүйл.Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн санхүүжилт

ХОЁРДУГААР ДЭД БҮЛЭГ

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАЛААР АЖИЛ ОЛГОГЧ, АЖИЛТАН, ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

39 дүгээр зүйл.Ажил хөдөлмөр эрхэлж байгаа ажилтны хөдөлмөрийн зохистой нөхцөлөөр хангуулахтай холбогдсон нийтлэг эрх, үүрэг

40 дүгээр зүйл.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаар ажил олгогчийн нийтлэг эрх, үүрэг

41 дүгээр зүйл.Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрх, үүрэг

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

42 дугаар зүйл.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зарчим

43 дугаар зүйл.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн техникийн зохицуулалт, стандарт

44 дүгээр зүйл.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ

45 дугаар зүйл.Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ

46 дугаар зүйл.Хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилт

47 дугаар зүйл.Хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг, тандалт

48 дугаар зүйл.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийн удирдлага

49 дүгээр зүйл.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт

50 дугаар зүйл.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдлагын цахим систем

51 дүгээр зүйл.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн санхүүжилт

52 дугаар зүйл.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал

53 дугаар зүйл.Ажилтны амь нас, эрүүл мэндийн даатгал

ТАВДУГААР БҮЛЭГ

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЭЛ, ХӨДӨЛМӨР ЗОХИЦУУЛАЛТ, СЭРГЭЭН ЗАСАХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

54 дүгээр зүйл.Үйлдвэрлэлийн осол, аюултай тохиолдлыг мэдэгдэх, бүртгэх, хянан баталгаажуулах мэдээллийн сан бүрдүүлэх

55 дугаар зүйл.Мэргэжлээс шалтгаалсан өвчний бүртгэл, мэдээлэл, түүнтэй холбогдсон хөдөлмөр зохицуулалт

56 дугаар зүйл.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчтэй хүнд зориулсан сэргээн засах тусламж, үйлчилгээ

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН БИЕЛЭЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ

57 дугаар зүйл.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт

58 дугаар зүйл.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төрийн захиргааны хяналт

59 дүгээр зүйл.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төрийн захиргааны хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх улсын байцаагчийн бүрэн эрх

60 дугаар зүйл.Аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналт

61 дүгээр зүйл.Ажилтны төлөөллийн байгууллагын хяналт

62 дугаар зүйл.Хөндлөнгийн хяналт

ДОЛООДУГААР БҮЛЭГ

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧИГЧДӨД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

63 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

64 дүгээр зүйл.Маргааныг шийдвэрлэх



**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ**

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН
ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ
ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**Улаанбаатар хот
2025 он**

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГ

ХҮСНЭГТ

УДИРТГАЛ

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

- 1.1 Үнэлгээ хийх шалтгаан
- 1.2 Үнэлгээ хийх хүрээ
- 1.3 Үнэлгээний шалгуур үзүүлэлт
- 1.4 Үнэлгээг харьцуулах хэлбэр
- 1.5 Үнэлгээний шалгуур үзүүлэлтийн томъёолол
- 1.6 Үнэлгээний мэдээлэл цуглуулах арга

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

- 2.1 Мэдээлэл цуглуулах

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

- 3.2.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбарын өнөөгийн нөхцөл байдал;
- 3.2.2 Өмнө нь хийгдсэн хуулийн хэрэгжилтийн судалгааны дүнд хийсэн үнэлгээ
- 3.2.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, үнэлгээ;

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

ТОВЧИЛСОН ҮГ

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
АНУ	Америкийн нэгдсэн улс
АШУУИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
МШӨ	Мэргэжлээс шалтгаалсан өвчин
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ҮОХХ	Үйлдвэрлэлийн осол хурц хордлого
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчин
ҮОМШӨДС	Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчнийг судлан бүртгэх
ҮОМШӨСБ	Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчнийг даатгалын сан
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ХАБЭМ	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд
ХЭМ	Хөдөлмөрийн эрүүл мэнд
ХАБ	Хөдөлмөрийн аюулгүй байдал
ХАБЭМТ	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ILO	International Labor Organization
MNS	Mongolian National standard
WHO	World Health Organization

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай болон бусад хуулийн үнэлэгдэх зүйл, заалтууд
- Хүснэгт 2. Мэдээллийн үнэлгээ
- Хүснэгт 3. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, 2020-2024 он
- Хүснэгт 4. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, салбараар 2020-2024 он
- Хүснэгт 5. Мэргэжлээс шалтгаалах өвчлөл, салбараар 1972-2024 он
- Хүснэгт 6. Мэргэжлээс шалтгаалах өвчлөл салбараар, 2020-2024 он
- Хүснэгт 7. Мэргэжлээс шалтгаалах өвчний шинэ тохиолдлын тоо, 2020-2024 он
- Хүснэгт 8. Зарим салбарын ХАБЭА-н хуулийн хэрэгжилтийн дүн
- Хүснэгт 9. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдүүд

УДИРТГАЛ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль анх 2008 онд батлагдсан бөгөөд үүнээс өмнө Хөдөлмөрийн тухай хуулиар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй(ХАБЭА)-н талаарх харилцааг зохицуулж байв¹. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль нь ажил, хөдөлмөр эрхлэгч хүнийг ажлын байрны аюултай, хортой хүчин зүйлсээс хамгаалж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин(ҮОМШӨ)-өөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн. Уг хууль хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага, зохион байгуулалт, хяналт, ажил олгогч, ажилтны үүрэг, хариуцлага, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, түүний санхүүжилт зэрэг нийтлэг шаардлагыг тусгасан 9 бүлэг, 37 зүйлтэй². Тус хууль батлагдсанаас хойш 2011, 2012, 2015 онуудад томоохон нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулсан байдаг.

Монгол Улс Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай 155 дугаар конвенцод нэгдсэн тул Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжоо уг конвенцтой нийцүүлэх үүрэг олон улсад хүлээсэн.

Сүүлийн жилүүдэд Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль (2017 он), Хөдөлмөрийн тухай хууль (2021 он), Төрийн хяналт шалгалтын тухай хууль (2022 он), Нийгмийн даатгалын багц хууль (2023 он), Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль (2024 он) зэрэг хуулиуд шинэчлэгдсэн нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтэд нөлөө үзүүлэх болсон.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад хүний эрүүл мэнд, аюулгүй байдлыг зохицуулах заавал мөрдөх норматив хэмжээг техникийн зохицуулалтаар батлах, стандарт нь сайн дурын үндсэн дээр сонгон хэрэглэх зохицуулалттай болсон³.

Хөдөлмөрийн тухай хуульд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй”-н асуудлыг олон улсын жишгээр “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд” гэж нэрлэж, ажилтныг хөдөлмөрийн хэвийн нөхцөлөөр хангах ажил олгогчийг үүргийг илүү тодорхой болгосон⁴.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчлэлээр ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийг салбараар нь бус ажлын байрны эрсдэлээс хамаарч ялгаатай тогтоох дэвшил гарсан. Гэвч ҮОМШӨ-ний даатгалын сангаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээг санхүүжүүлэх боломж хязгаарлагдмал хэвээр байна.⁵

2024 онд батлагдсан Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуульд хөдөлмөрийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нийгмийн эрүүл мэндийн тусламж үйл ажиллагаанд хамаарна гэж заасан ч ажилтны эрүүл мэндийн үзлэг, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг оношлох, бүртгэх, мэдээлэх, хөдөлмөрийн чадвар

¹ Хөдөлмөрийн тухай хууль, 1999 оны 5 дугаар сарын 14-ны өдөр

² Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 оны 5 дугаар сарын 22-ны өдөр

³ Стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, 2017 он

⁴ Хөдөлмөрийн тухай хууль, 2021 он

⁵ Нийгмийн даатгалын ерөнхий хууль, 2023

алдалтаас сэргийлэх, ажил мэргэжлийн тохироог үнэлэх зэрэг асуудлын зохицуулалтад дэвшил гараагүй ба энэ арга хэмжээнд эрүүл мэндийн салбарын оролцоо сул байсаар байна.⁶

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойш 5 жил тутамд хийнэ гэж заасан байдаг. Иймд дээрх хуулийн 51.3-т заасан үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт буюу “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-д заасны дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийв.

⁶ Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль, 2024

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Төлөвлөх үе шатны зорилго нь үнэлгээ хийх хүрээг тогтоож, түүнд тохирсон шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход чиглэгдэнэ. Энэ үе шатанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох
- Үнэлгээ хийх хүрээг тогтоох
- Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох
- Харьцуулах хэлбэрийг сонгох
- Шалгуур үзүүлэлтийг томъёолох
- Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

ХАБЭА нь ажилтан болон ажил олгогчийн хооронд үүссэн хөдөлмөрийн харилцааны асуудал юм. Хөдөлмөр эрхлэлтийн явцад аюулгүй ажиллагааны шаардлага хангагдаагүй улмаас ажилтан хүн үйлдвэрлэлийн осолд орж бэртэл гэмтэл авах, цаашлаад амь насаа алдах эрсдэлтэй. Хөдөлмөрийн эрүүл ахуйн шаардлага хангагдаагүй нөхцөлд ажилтан хүн ажилласан тохиолдолд ажлын байрны шалтгаант хордлогод өртөх, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр өвчлөх эрсдэл үүсдэг. Тиймээс ажил хөдөлмөр эрхэлж буй иргэн хүний амь нас, эрүүл мэндийг ажлын орчин бий болгон сөрөг хүчин зүйлсээс хамгаалах шаардлагатай.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 4 дүгээрт “Монгол Улсын иргэн ...хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах эрхтэй” гэж заасан⁷. Үндсэн хуулийн энэхүү заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрх зүйн орчин бүрэлдэн тогтсон.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2.6.1-д хөдөлмөрийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг шинэчилж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн, цалин хөлсний тогтолцоог боловсронгуй болгох, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.2.11-д Хөдөлмөр, нийгмийн гурван талт оролцоонд тулгуурлан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тогтолцоог сайжруулах, 2.2.1.16-д Эрэгтэйчүүдийн зонхилон ажилладаг салбарт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийг бууруулах зорилт тус тус дэвшүүлсэн.

Онолын хувьд бүх төрлийн ажил хөдөлмөр эрхэлж буй хүмүүс ажлын байрны шалтгаант осол, өвчлөлд өртөх тодорхой түвшний эрсдэлд өртөж байдаг. Тиймээс ХАБЭА-н талаарх төрийн бодлогыг бүх ажиллах хүчнийг эрүүл, аюулгүй ажиллах нөхцөлөөр хангахад чиглэх нь зүйтэй.

⁷ Монгол Улсын Үндсэн хууль

Манай улсад 1972-2024 оны хооронд 10359 хүн мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсан байна. Мөн сүүлийн 5 жилд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын 2125 тохиолдол бүртгэгдэж, 275 хүн нас барсан байна.

Хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны эрэлт нийлүүлэлтийн таамаглал судалгааны тайланд ажиллах хүчний тоо өнөөгийнхөөс 2035 он гэхэд 19.1 хувиар нэмэгдэх таамаглалыг тооцсон⁸. Түүнчлэн ҮОМШӨ-ний хамгийн өндөр эрсдэлтэй уул уурхай, олборлолтын салбарт шаардлагатай ажиллагсдын тоо 2035 онд гэхэд 31.9 хувиар (32.5 мянган хүн), боловсруулах үйлдвэрт 34.1 хувиар (63.3 мянган хүн), барилгын салбарт 36.6 хувиар (55.9 мянган хүн) нэмэгдэх хандлага тооцоологдсон. Ийнхүү ҮОМШӨ-ний эрсдэлтэй ажиллагсдын тоо 2035 он хүртэл нэмэгдэх хандлагатай байна.

Ажилтан хүн үйлдвэрлэлийн осолд өртөх эсвэл МШӨ-өөр өвчлөхөд эрүүл мэндээрээ хохирч хөдөлмөрийн чадвар, амь насаа алдах, эд хөрөнгийн хохирол учрахаас гадна тухайн хувь хүн, ажил олгогч болон нийгмийн даатгалын санд зардлын дарамтыг үүсгэдэг. Түүнчлэн МШӨ-өөр өвчлөх эрсдэлтэй хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллагсад өндөр насны тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр эрт тогтоолгож, нийгмийн даатгалын санд зардлыг улам бүр нэмэгдүүлж байна.

Түүнчлэн ҮОМШӨ-ний улмаас ажилтны, түүний гэр бүлд учирсан сэтгэл санааны хохирол, амьдралаас алдагдсан жил (нас баралт), амьдралын чанарын алдагдал, алдагдсан боломж зэрэг мөнгөн дүнгээр тооцох боломжгүй хохирлыг тодорхойлоогүй байна. Эдгээр тоо баримт нь ҮОМШӨ-ний урьдчилан сэргийлэлт манай улсад тулгамдсан асуудал болсныг илтгэж байна.

Эдгээр үндэслэл шаардлагын дагуу одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Хөдөлмөрийн Аюулгүй Байдал Эрүүл Ахуйн тухай хууль”-ийн хэрэгжилтийн үр дүнд судалгаа, шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл бэрхшээл, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлж, тулгамдсан асуудлыг хэрхэн шийдвэрлэх, цаашид өөрчлөх, шинэчлэх шаардлагатай эсэхийг тодорхойлох зорилгоор хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийлээ.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Үнэлгээний хүрээг тогтоох нь хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэгддэг. Энэ нь үнэлгээ хийх болсон шалтгаануудтай харилцан уялдаа, хамааралтайгаар хийгдэх ажиллагаа бөгөөд тодорхойлогдсон эерэг, сөрөг нөхцөл байдал, хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудал, үр дагавар бүхий харилцаатай холбогдсон хуулийн зохицуулалтыг илрүүлнэ. Үнэлгээний хүрээг тогтоохдоо үнэлгээ хийх ажлын төлөвлөлт, зохион байгуулалт, хүний нөөц, цаг хугацаа, гарах зардлыг харгалзан үздэг тул тухайн хуулийн зорилго, үнэлгээний шалгуурт хамгийн ихээр нөлөөлж болохуйц хуулийн зохицуулалтыг зөв сонгох нь

⁸ Монгол Улсын Хөдөлмөр зах зээлийн дунд хугацааны эрэлт, нийлүүлэлтийн таамаглал, 2024 он

чухал байдаг. Энэхүү үнэлгээний хувьд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 6 бүлэг 26 зүйлийг хамруулав.

Үнэлгээг дараах агуулгын хүрээнд нэгтгэн үнэлэхээр хамрах хүрээг тогтоов. Үүнд:

1.2.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбарын өнөөгийн нөхцөл байдал;

1.2.2. Өмнө нь хийгдсэн хуулийн хэрэгжилтийн судалгааны дүнд хийсэн үнэлгээ

1.2.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, үнэлгээ;

1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хамрах хүрээ, онцлогоос хамааран дараах гурван шалгуур үзүүлэлтийг сонгов. Үүнд:

1. Зорилгод хүрсэн түвшин;
2. Практикт нийцэж байгаа байдал;

1.3.1 “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Тус шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт бүхэлд нь үнэлгээ хийхэд зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийг хэрэглэх нь зохимжтой байдаг. Энэхүү онцлог нь тус судалгааны зорилгод нийцэж буй юм. Энэхүү шалгуур үзүүлэлтээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн зорилгодоо хүрсэн эсэхийг тогтооно.

1.3.2 “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Үнэлгээний энэ хэсэгт “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд ХАБЭА-н тухай хуулийн холбогдох зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг, сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон болно.

Энэ шалгуур үзүүлэлтээр ихэвчлэн тухайн хуулийг хэрэгжүүлэгч этгээдээс болон байгууллагаас уг зохицуулалт практикт хэрэгжиж чадаж байгаа эсэхийг тогтооход түлхүү ашигладаг. Мөн хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон амьдралд гарч байгаа эерэг болон сөрөг ямар үр дагаврууд байгааг тодорхойлох бөгөөд хуулийн зохицуулалтын ойлгомжтой байдал, түүнийг хэрэгжүүлэх боломж бололцоо практикт байгаа эсэхийг тооцох нь чухал юм.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хуульд заасан арга хэмжээг дээрх шалгуурын дагуу үнэлэхдээ энэхүү үнэлгээний тайлангийн 1.2-т дурдсан агуулга, хамрах хүрээнд нийцүүлэн үнэлэх юм.

Хүснэгт 1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай болон бусад хуулийн үнэлэгдэх зүйл, заалтууд

д/д	Үнэлэгдэх бүлэг, зүйл	Үнэлэгдэх хэсэг
1	Нэгдүгээр бүлэг: 2, 3, 5 дугаар зүйл	2 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 5 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар төрөөс баримтлах бодлого, зарчим
2	Хоёрдугаар бүлэг: 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 17 дугаар зүйл	6 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт 7 дугаар зүйл. Үйлдвэрлэлийн орчин, барилга байгууламжид тавих шаардлага 8 дугаар зүйл. Үйлдвэрлэлийн барилга байгууламжийг болон үндсэн, суурин тоног төхөөрөмж хэрэгслийг хамтран эзэмших, ашиглахад тавих шаардлага 9 дүгээр зүйл. Машин механизм, тоног төхөөрөмжид тавих шаардлага 10 дугаар зүйл. Өргөх, зөөх, тээвэрлэх механизмд тавих шаардлага 11 дүгээр зүйл. Даралтат сав, шугам хоолойд тавигдах шаардлага 12 дугаар зүйл. Химийн хорт ба аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг, биологийн идэвхт бодистой харьцахад тавих шаардлага 13 дугаар зүйл. Галын аюулгүй байдалд тавих шаардлага 14 дүгээр зүйл. Эрүүл мэндийн үзлэг 15 дугаар зүйл. Ажилтныг ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах 17 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон мэргэжлийн сургалт
3	Дөрөвдүгээр бүлэг: 19, 25, 26 дугаар зүйл	19 дүгээр зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцах байгууллагын тогтолцоо 25 дугаар зүйл. Бүх шатны засаг даргын бүрэн эрх, 25 ¹ дүгээр зүйл. Аймаг, сум, нийслэл, дүүрэг, хорооны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтны чиг үүрэг 26 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээний санхүүжилт
4	Тавдугаар бүлэг: 27, 28 дугаар зүйл	27 дугаар зүйл. Аж ахуйн нэгж байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц, зохион байгуулалт 28 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар ажил олгогчийн эрх, үүрэг
5	Зургаадугаар бүлэг: 29, 30, 31 дүгээр зүйл	29 дүгээр зүйл. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын үед авах арга хэмжээ 30 дугаар зүйл. Мэргэжлээс шалтгаалах өвчин, түүнтэй холбогдсон хөдөлмөр зохицуулалт 31 дүгээр зүйл. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ
6	Долоодугаар бүлэг: 32, 33, 34, 35	32 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль тогтоомжийн биелэлтэд тавих шаардлага 33 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төрийн захиргааны хяналт

		34 дүгээр зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар тавих олон нийтийн хяналт 35 дугаар зүйл. Аж ахуйн нэгж байгууллагын дотоод хяналт
--	--	--

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхдээ түүний хэрэгжилттэй холбоотой үүссэн асуудал буюу үнэлэх болсон шалтгаан, тогтоосон хүрээ, шалгуур үзүүлэлтээс хамааран, аль болох тохиромжтой харьцуулах хэлбэрийг сонгоно. Үүнд:

- Байх ёстой болон одоо байгаа
- Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойших
- Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших
- Тохиолдол судлах

Энэхүү судалгаанд “**Байх ёстой болон одоо байгаа**” харьцуулах хэлбэрийг тохиромжтой гэж үзэж сонгов. ХАБЭА-н тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан үр дагавар /одоо байгаа нөхцөл байдал/-ыг Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээгээр тогтоосон шаардлага зэрэгтэй харьцуулах хэлбэрээр тус хуулийн зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтоохыг зорьсон болно.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох

“Шалгуур үзүүлэлтийг томъёолох” гэдэг нь сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр тодорхой таамаглал дэвшүүлэх буюу асуулт тавьдаг бөгөөд үнэлгээний хүрээнд хамаарах зохицуулалтад “Зорилтод хүрсэн түвшин ямар байна вэ?”, “Практикт хэрхэн нийцэж байна вэ?” гэх асуултын хүрээнд гүйцэтгэх юм.

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, хэсгийн зорилгод хүрсэн түвшин, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль батлагдсанаас хойших хугацааны бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг судлах, жил бүрийн тайлан, мэдээ болон судалгааг гаргуулах, олон улсын байгууллага, гадаад, дотоодын зөвлөхүүдийн хийж гүйцэтгэсэн тайлан, зөвлөмжийг судлах, харьцуулалт хийх зэрэг аргыг ашиглана.

Мэдээлэл цуглуулах аргын хувьд “Байгаа мэдээллийг цуглуулж ашиглах” аргыг сонгон хэрэгжүүллээ. Байгаа мэдээллийг цуглуулах хүрээнд холбогдох хууль тогтоомж, эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайланг цуглуулж үнэлгээ хийхэд ашигласан болно.

ХОЁР.ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

2.1.Мэдээлэл цуглуулах

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх мэдээллийг цуглуулахдаа баримт бичгийн судалгаа, харьцуулсан судалгааны аргад тулгуурлан гүйцэтгэв.

Баримт бичгийн судалгаа: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлийн хууль тогтоомж, гарын авлага, нийгмийн даатгалын сангийн тайлан, мэдээ, олон улсын байгууллага, гадаад, дотоодын зөвлөхүүдийн хийж гүйцэтгэсэн тайлан, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагаас гаргасан тайлан, судалгааг ашигласан болно.

Харьцуулсан судалгаа: Монгол Улсын олон улсын гэрээ, хөгжлийн түвшин ижил төстэй улс, орнуудын хууль тогтоомж, хөтөлбөрүүдийн туршлага, мэдээллийг харьцуулалт хийх зорилгоор цуглуулж ашиглалаа.

Хууль эрх зүйн акт

- Монгол Улсын Үндсэн хууль
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 оны 5 дугаар сарын 22-ны өдөр
- Хөдөлмөрийн тухай хууль, 2021 оны 7 дугаар сарын 02-ны өдөр
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль, 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль, 2024 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр
- Эрүүл ахуйн тухай хууль, 2016 оны 2 дугаар сарын 04-ний өдөр
- Стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, 2017 он
- ХНХЯ, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2021 он
- ХНХС-ын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/155 Журам шинэчлэн батлах тухай-Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам
- ЭМС, ХНХС-ын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/441, А/192 Даатгуулагч хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалт батлах тухай
- ХНХС-ын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/221 Жагсаалт, журам батлах тухай Газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт", тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох "Газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтыг хэрэглэх журам"
- ЭМС, ХНХС-ын 2024 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн А/293, А/133 Заавар батлах тухай, Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний заавар

- ХНХС, ЭМС-ын 2023 оны А/152, А/388 дугаар тушаалаар баталсан МШӨ-ний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг тогтоосон жагсаалт мөрдөгдөж байна.

Олон улсын гэрээ, конвенц

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 1981 оны 155 дугаар конвенц (Нэгдэн орсон 2005 он)
- Уул уурхай дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 1996 оны 176 дугаар конвенц (Нэгдэн орсон 2015 он)
- Барилгын салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 1998 оны 167 дугаар конвенц (Нэгдэн орсон 2020 он)

Судалгааны тайлан, эмхэтгэл

- Монгол улс дахь Мэргэжлээс шалтгаалсан өвчний төлөв байдал, ХАБЭМТ, 2025 он
- Монгол Улсын Хөдөлмөр зах зээлийн дунд хугацааны эрэлт, нийлүүлэлтийн таамаглал, 2024 он
- Нийгмийн даатгалын бүртгэлийн мэдээлэл, 2024 он
- Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын бүртгэл мэдээллийн систем
- ХНХЯ, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний нийгэм, эдийн засгийн нөлөөллийн судалгаа, 2020 он
- ХНХЯ, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг дэмжих тогтолцооны тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 187 дугаар конвенцыг Монгол Улсын хууль тогтоомжтой харьцуулсан үнэлгээ, 2023 он
- Аж ахуйн нэгж байгууллагууд дахь хөдөлмөрийн эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдал, ХАБЭМТ, 2025 он

Эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл

- Э.Эрдэнэчимэг, Хөдөлмөрийн эрүүл мэндийн мэргэжлийн хүний нөөц, эрдэм шинжилгээ илтгэл, 2024 он
- А.Цэнгэлмаа, Хөдөлмөрийн эрүүл ахуйн 2024 бага хурал: Хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ, Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ, 2024 он
- Д.Нарансүх, Хөдөлмөрийн эрүүл ахуйн 2024 бага хурал: Мэргэжлээс шалтгаалсан өвчний бүртгэл, мэдээллийн тогтолцоо илтгэл, 2024 он

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

3.1. Мэдээллийг үнэлэх

ХАБЭА-н тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд цуглуулсан мэдээллийг үнэлэв.

Хүснэгт 2. Мэдээллийн үнэлгээ

Үнэлгээний шалгуур	Үнэлгээ	Тайлбар
Хангалттай эсэх	Тийм	Үнэлгээ хийхэд шаардлагатай статистик, тоон мэдээлэл, дотоодын болон олон улсын байгууллага, зөвлөхүүдийн тайлан мэдээллүүдийг холбогдох байгууллагууд болон албан ёсны вэб хууднаас татаж авч ашиглав.
Зайлшгүй шаардлагатай буюу хамааралтай мэдээлэл эсэх	Тийм	
Бодитой эсэх	Тийм	

3.2. Шалгуур үзүүлэлт болон харьцуулах хэлбэрийг үнэлэх

ХАБЭА-н тухай хууль болон энэ чиглэлийн бусад хуульд заасан ХАБЭА-н хөтөлбөр, арга хэмжээ, түүний хэрэгжилттэй холбоотой үүссэн асуудал буюу үнэлэх болсон шалтгаан, тогтоосон хүрээ, шалгуур үзүүлэлтээс хамааран “Зорилтод хүрсэн түвшин ямар байна вэ?”, “Практикт хэрхэн нийцэж байна вэ?” гэсэн шалгуурын дагуу үнэлэхдээ “Байх ёстой болон одоо байгаа” харьцуулах хэлбэрийг ашиглан энэхүү үнэлгээний тайлангийн 1.2-т дурдсан агуулга, хамрах хүрээнд нийцүүлэн үнэллээ.

3.2.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбарын өнөөгийн байдал

ХАБЭА-н салбарт хөдөлмөрийн эрүүл мэндийн асуудал тулгамдсан асуудлын нэг болсон. Өндөр эрсдэлтэй 29,425 аж ахуйн нэгжүүдийн 235 (0,8 хувь) нь хуулийн хугацаанд ажлын байрандаа хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэсний 30% нь стандартын шаардлага хангаагүй буюу МШӨ-өөр өндөр эрсдэлтэй тодорхойлогдсон. Эдгээр салбарын ажиллагсдын 11.3% нь эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх хугацаат үзлэгт хамрагдсан.⁹

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн дагуу ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийг ажилтны ажлын байрны эрсдэлийн төвшнөөс хамааран 0.5, 1.5, 2.5 хувиар ажил олгогч нь төлдөг. Нийгмийн даатгалын статистик бүртгэлээр 2024 оны эхний 5 сарын өссөн дүнгээр ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийг 2.5 хувиар төлдөг 224 мянган хүн байгаа нь ажиллагчид (1 сая 285 мянга)-ын 17 хувьтай тэнцэж байна¹⁰.

2020 онд ХНХЯ-ны захиалгаар хийгдсэн Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний нийгэм, эдийн засгийн нөлөөллийн судалгааны тайланд дурдсанаар ҮОМШӨ-д зарцуулсан нийт зардал 2019 онд 127.8 тэрбум төгрөгт хүрсэн байна. Нийт зардлын 91% буюу 116.4 тэрбум төгрөгийг үйлдвэрлэлийн осол, 9% буюу 11.4 тэрбум төгрөгийг МШӨ-ний хохирол эзэлж байна. Эдийн засагт учруулах нийт хохирлоос ажилтанд 60.1 тэрбум төгрөг, ажил олгогчид 19.7 тэрбум төгрөг, улсад 37.9 тэрбум төгрөгийн зардал тус тус ногдож байна. Хариуцагч гурван талд учруулах шууд зардалд бүтээмжийн зардал, хувь хүнд гарах зардал, эрүүл мэнд нөхөн сэргээлтийн зардал, хууль эрх зүйн зардал багтсан. Шууд бус зардалд ажилтан болон түүний гэр бүлийн орлого, асаргаа, сэтгэл санааны хохирол, алдагдсан боломжууд, ажил олгогчийн зүгээс олгох нөхөн олговор зэрэг зардлууд хамаардаг¹¹.

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын төлөв байдал

Сүүлийн 5 жилд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын 2124 тохиолдолд нийт 2222 хүн өртсөн байна. Үүнээс 2092 (98.5 хувь) нь үйлдвэрлэлийн ослын, 32 (1.5 хувь) нь хурц хордлогын тохиолдол байна. Бүртгэгдсэн нийт тохиолдлын 66 буюу 3,1 хувь нь бүлэг осол, хордлого байна.

ҮОХХ-ыг сүүлийн 5 жилээр авч үзвэл тохиолдлын тоо өссөн бөгөөд 2024 оны тохиолдлыг 2023 онтой харьцуулахад 283 тохиолдол буюу 1.7 дахин өссөн байна.

Хүснэгт 3. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, 2020-2024 он

Он	Ослын тохиолдлын тоо	Осолд өртсөн хүний тоо	Ослын хэлбэр	
			Үхэлд хүргэсэн (нас барсан)	Үхэлд хүргээгүй (гэмтсэн, хордсон)
2020	354	354	40	313
2021	256	256	34	223
2022	395	395	57	338
2023	408	408	57	351
2024	711	809	87	722
Нийт	2124	2222	275	1947

⁹ ХНХЯ, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2021 он

¹⁰ Нийгмийн даатгалын бүртгэлийн мэдээлэл, 2024 он

¹¹ ХНХЯ, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний нийгэм, эдийн засгийн нөлөөллийн судалгаа, 2020 он




График 1. YOXX, 2020-2024 он

Осол, хурц хордлогод өртсөн 2222 хүний 275 буюу 12.4% нь үхэлд хүргэсэн, 1947 буюу 87.6% нь үхэлд хүргээгүй буюу гэмтсэн, хордсон ослын тохиолдолд өртсөн байна.

2020-2024 онуудад бүртгэгдсэн 2124 үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдолд хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцдаа амь нас нь үрэгдсэн 275, хөнгөн гэмтсэн, хордсон 1947, нийт 2222 хүний үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын актыг хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчид хянан баталгаажуулсан байна. Сүүлийн 5 жилийн YOXX-ыг салбараар нь авч үзвэл уул уурхай, олборлолтын салбарт 421(19.0%), Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбарт 288 (12.9%), боловсруулах үйлдвэрт 248(11.1%), барилгын салбарт 208 (9.3%) тээвэр болон агуулахын үйл ажиллагааны салбарт 211(9.5%) тохиолдол бүртгэгдсэн нь нийт ослын 61.8%-ийг эзэлж байна.

Хүснэгт 4. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, салбараар 2020-2024 он

Салбар	Үхэлд хүргээгүй (гэмтсэн, хордсон)	Үхэлд хүргэсэн (нас барсан)	Нийт	Хувь,%
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	28	8	36	1.6
Уул уурхай, олборлолт	362	59	421	19.0
Боловсруулах үйлдвэрлэл	232	16	248	11.1
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	39	10	49	2.2
Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	53	6	59	2.6
Барилга	154	54	208	9.3
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	58	7	65	2.9
Тээвэр болон агуулахын үйл ажиллагаа	181	30	211	9.5

Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	68	1	69	3.1
Мэдээлэл, холбоо	20	3	23	1.0
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	46	3	49	2.2
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1	0	1	0,04
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	9	1	10	0.4
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	16	2	18	0.8
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	257	31	288	12.9
Боловсрол	79	10	89	4.0
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	156	10	166	7.4
Урлаг, үзвэр, тоглоом наадам	8	6	14	0.6
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	178	18	196	8.8
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	1	0	1	0.04
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	2	0	2	0.08
Бүгд	1947	275	2222	100%

ҮОХХ гарахад хүний хүчин зүйл 913(41.0%), ажлын байрны орчин 770 (34.6%), техник технологи 295 (13.3%), удирдлагын тогтолцоо 245(11.0%) тохиолдолд нөлөөлсөн болохыг судалжээ.¹²




График 2. Осол, хурц хордлого гарахад нөлөөлсөн хүчин зүйл /2020-2024 он/

¹² Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын бүртгэл мэдээлэл <https://inspection.huduimur-halamj.gov.mn/>

Мэргэжлээс шалтгаалсан өвчний төлөв байдал

ХАБЭМТ-д 1972-2024 оны хооронд мэргэжлээс шалтгаалсан өвчний нийт 10359 тохиолдол бүртгэгдсэн. МШӨ-нийг оношлогдсон салбараар нь авч үзвэл уул уурхай, геологийн салбар 59.5% буюу хамгийн өндөр, эрчим хүчний салбар 10.6%, боловсруулах үйлдвэр 10.2%, хүнс, хөнгөн үйлдвэр 6.3%-ийг эзэлж байна. Нийгмийн Даатгалын Ерөнхий Газрын мэргэжлээс шалтгаалах өвчний эрүүл мэндийн магадлах салбар зөвлөлийн статистик бүртгэлд 2025 оны эхний хагас сарын байдлаар 2123 хүн мэргэжлээс шалтгаалах өвчнөөр хөдөлмөрийн чадавх алдалтын тэтгэвэрт байна.

Хүснэгт 5. Мэргэжлээс шалтгаалах өвчлөл, салбараар 1972-2024 он

Салбар	1972-1979	1980-1989	1990-1999	2000-2009	2010-2019	2020-2024	1972-2024												
Уул уурхай, геологи	63.4	76.4	54.0	87.6	62.9	226.1	54.1	1699	63.0	295	83.2	273	59.5	6168					
Эрчим хүч	2.2	27	6.6	107	9.9	354	18.1	570	6.6	31	4.0	13	10.6	1102					
Боловсруулах үйлдвэр	4.8	58	10.8	176	11.8	425	9.2	288	19.2	90	7.0	23	10.2	1060					
Хүнс, хөнгөн үйлдвэр, НААУ	6.6	80	6.6	107	4.5	160	9.3	292	2.8	13	0.6	2	6.3	654					
ХАА	6.3	76	6.5	105	1.9	69	1.9	61	0.4	2	0.3	1	3.0	314					
Соёл, боловсрол	2.6	31	5.5	90	2.1	77	1.1	36	0.6	3	1.8	6	2.3	243					
Эрүүл мэнд	4.6	56	2.7	44	1.5	54	1.9	59	3.0	14	0.6	2	2.2	229					
Барилга угсралт	3.2	39	3.5	56	2.0	71	0.9	29	0.2	1	0.3	1	1.9	197					
Зам тээвэр төмөр зам	1.1	13	1.4	22	1.4	52	2.7	86	3.6	17	1.5	5	1.9	195					
Төрийн удирдлага, батлах	1.3	16	1.2	19	1.6	56	0.3	10	0.2	1	0.6	2	1.0	104					
Зам тээвэр Авто	3.7	45	1.3	21	0.4	14	0.4	12	0.2	1	0.0	0	0.9	93					
							1205		1623		3593		3142		468		328		10359

МШӨ-нийг хүйсийн байдлаар авч үзэхэд эрэгтэйчүүд 8219 буюу 79.3%-ийг, эмэгтэйчүүд 2140 буюу 20.7%-ийг тус бүр эзэлж байна. Хүйсийн хувьд мэргэжлээс шалтгаалах эрүүл мэндийн бодлого хэрэгжүүлэх, мэргэжлийн салбар бүрийн өвчлөлийг нарийвчлан судлах шаардлагатайг онцолсон байна.




График 3. Мэргэжлээс шалтгаалсан өвчин, салбараар, хүйсээр

МШӨ-нийг оношлогдсон байдлаар нь авч үзвэл тоосжилтын болон хордлогын шалтгаант гуурсан хоолойн архаг үрэвсэл 39.0% (n=4037) буюу хамгийн өндөр хувийг, дээд доод мөчний мэдрэлийн язгуурын дарагдлын хам шинж 16.2% (n=1676), антракоз-антрасиликоз 10.2% (n=1676), холимог тоосоор үүсгэгдсэн пневмокониоз 7.0% (n=771), тохой үений хэлбэр хөдөлгөөн алдагдах эмгэг 4.1% (n=425), шуугианы нөлөөгөөр үүссэн сонсгол бууралт 3.2% (n=327)-ийг тус тус эзэлж байна. (График 4.)




График 4. МШӨ-ний оношлогдсон байдал

МШӨ-нийг сүүлийн 5 жилээр авч үзвэл нийт хяналтад байгаа тохиолдлын тоо буурч байгаа ч уул уурхай болон эрчим хүчний салбарт мэргэжлээс шалтгаалсан уушгины өвчлөлийн эрсдэлүүд үргэлжилсээр байна. Буурч байгаа үзүүлэлтэд өөрийн хүсэлтээрээ өндөр насны тэтгэвэрт гарах асуудал болон нас баралт нөлөөлнө. (Хүснэгт 6)

Сүүлийн 5 жилд бүртгэгдсэн шинэ тохиолдлын тоог график 5, хүснэгт 7-өөс харахад МШӨ буурах хандлага ажиглагдсангүй. Энэхүү үр дүн нь зорилтот хяналт-шинжилгээ, илрүүлэх, оношлох, бүртгэх механизмыг сайжруулах хэрэгтэйг харуулж байна.¹³

Хүснэгт 6. Мэргэжлээс шалтгаалах өвчлөл салбараар, 2020-2024 он

Салбар	2020	2021	2022	2023	2024
Уул уурхай олборлолт	2137	2035	1993	1950	1729
Барилга	375	352	332	305	266
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	211	195	171	149	117
Боловсруулах үйлдвэрлэл	136	132	112	109	91
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	21	22	19	15	11
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	36	33	29	26	24
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	7	6	7	6	4
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	7	7	7	8	7
Боловсрол	7	7	7	7	8
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	7	6	6	6	6

¹³ ХАБЭМТ-ийн Хөдөлмөрийн Анагаах Ухааны Газрын Мэргэжлээс Шалтгаалсан Өвчний Эмнэлэг

Мэдээлэл холбоо	5	3	3	3	3
Урлаг, үзвэр, тоглоом наадам	5	5	4	4	4
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	5	5	4	3	3
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	2	2	1	1	0
Нийт	2961	2810	2695	2592	2273

Хүснэгт 7. Мэргэжлээс шалтгаалах өвчний шинэ тохиолдлын тоо, 2020-2024 он

Д/д	Он	Хяналтын өвчтөн	Шинэ тохиолдол
1	2020	2961	38
2	2021	2810	50
3	2022	2695	94
4	2023	2592	60
5	2024	2273	86




График 5. МШӨ-ний шинэ тохиолдлын тоо, 2020-2024 он

3.2.2. Өмнө нь хийгдсэн хуулийн хэрэгжилтийн судалгааны дүн

Хөнгөн үйлдвэр, автозам, уул уурхайн салбарын ХАБЭА-н тухай хуулийн хэрэгжилтийг судалсан дүн:

Хөнгөн үйлдвэр, зам, тээвэр, уул, уурхайн салбарт 2018, 2019, 2020 онуудад ХАБЭА-н тухай хууль тогтоомж хэрхэн хэрэгжиж байгаатай газар дээр нь танилцах, илэрсэн зөрчлийг арилгуулах, зөвлөн туслах үйл ажиллагааны хүрээнд нийт 1944 ААНБ-ын ХАБЭА-н удирдлага зохион байгуулалт, 17904 ажлын байрны орчин нөхцөл, 17549 тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд үзлэг хийсэн. Үзлэгийн үр дүнгээс үзэхэд ААНБ-ын удирдлага, зохион байгуулалт хөнгөн үйлдвэрийн салбарт 37.4%, автозамын салбарт 55.3%, уул уурхайн салбарт 69.2%, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал

50.1%, 54.7%, 66.4%, ажлын байрны эрүүл ахуйн шаардлага 70%, 63.7%, 72.1%-тай тус тус үнэлэгдсэн байна. ХАБЭА-н тухай хууль тогтоомжийн улсын үзлэгийн дундаж дүн хөнгөн үйлдвэрийн салбарт 52.4%, автозамын салбарт 57.9%, уул уурхай салбарт 69.8%-тай байна.¹⁴

Хүснэгт 8. Зарим салбарын ХАБЭА-н хуулийн хэрэгжилтийн дүн

№	Зүйл, заалт	Хөнгөн үйлдвэр Тоо (хувь)	Автозам Тоо (хувь)	Уул уурхай Тоо (хувь)
Аж ахуйн нэгж байгууллагын тоо		n=1635	n =139	n =170
1	ХАБЭА-н удирдлага, зохион байгуулалт			
1.1	ХАБЭА-н төлөвлөгөөтэй	500(30)	86(62)	137(80.5)
1.2	ХАБ хариуцсан ажилтантай	658(40)	116(83.5)	168(98.8)
1.3	Эрүүл ахуйч эмчтэй	237(14.5)	-	70(41.2)
1.4	ҮОХХСБ орон тооны бус байнгын комисстой	337(20.6)	67(48)	114(67)
1.5	Ажлын байрны ХНҮ хийлгэсэн	223(13.6)	10(7.2)	59(34.7)
1.6	Эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн	251(15.4)	52(37.4)	107(62.9)
Үнэлэгдсэн дундаж хувь		37.4%	55.3%	69.2%
2	Тоног төхөөрөмжийн аюулгүй байдал			
2.1	Нийт тоног төхөөрөмжийн тоо	n =14245	n =1086	n =2218
2.2	Моног төхөөрөмжийн гэрчилгээтэй	570 (4)	39(3.5)	359(16.2)
2.3	Техник ашиглалтын паспорттой	866(6)	76(6.9)	437(19.7)
2.4	Аюулгүй ажиллагааны заавартай	890(7)	93(8.5)	393(17.7)
2.5	Цахилгаан тоног төхөөрөмжийн газардуулга хийгдсэн	1184(8)	51(4.6)	441(19.9)
2.6	Туршилт тохируулгын акттай	421(3)	37(3.4)	420(18.9)
Үнэлэгдсэн дундаж хувь		50.1%	54.7%	66.4%
3	Ажлын байрны орчин нөхцөл			
3.1	Нийт ажлын байрны тоо	n =11175	n =2343	n =4387
3.2	Ажлын байрны дулааны стандарт шаардлага хангасан	1651(15)	85 (2.6)	151(3.4)
3.3	Харьцангуй чийглэгийн стандарт хангасан	1327(12)	-	137(3.1)
3.4	Химийн бодисын ууршилт, тоосыг зайлуулах агааржуулалтын системтэй	642(6)	61(34.4)	102(2.3)
3.5	Байгалийн гэрэлтүүлэг хангалттай	1455(13)	104(4.4)	160(3.6)
3.6	Зохиомол гэрэлтүүлэг хангалттай	1550(14)	-	155(3.5)
3.7	Ажлын байрны эмх цэгц, зохион байгуулалтыг хангасан	1227(11)	80(1.8)	158(3.6)
Үнэлэгдсэн дундаж хувь		70%	63.7%	72.1%
Улсын үзлэгийн дүн		52.4%	57.9%	69.8%

Барилга, боловсруулах үйлдвэрлэл, цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамжийн салбарын ХАБЭА-н тухай хуулийн хэрэгжилтийн судалгааны дүн:

Барилга, боловсруулах үйлдвэрлэл болон цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамжийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа нийт 766 ААНБ-ын 34 төрлийн ажил хөдөлмөр эрхэлж байгаа 6037 ажиллагсдыг хамруулсан. Судалгааны үр дүнгээс дурдахад ХАБЭА-н тухай хуулийн хэрэгжилтийн байдлаар барилгын салбарт 74.4%, боловсруулах үйлдвэрийн салбарт 70.4%, цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарт 74.2%-тай хэрэгжиж байна гэсэн үзүүлэлтийг гаргажээ. ХАБЭА-н тухай хуулийн мэдлэг ажил олгогчийн 47.5%, ажилтны 67.2% нь мэдлэг дутмаг, хангалтгүй үнэлэгдсэн ба хуулийн ойлгомжгүй бүлэг, заалтыг тодруулахад ХАБЭА-н тухай

¹⁴ ГБХНХЯ, Хөнгөн үйлдвэр, автозам, уул уурхайн салбарын ХАБЭА-н тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийн тайлан

хуулийн нэр томъёо, найруулга, ХАБЭА-н шаардлага, стандарт, ажиллагсдын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах иргэн, ажилтны эрх, үүрэг, тогтолцоо, бүрэн эрх, санхүүжилт, зохион байгуулалт, ҮО, МШӨ, ХХ-г судалж бүртгэх, хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт, хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын асуудлуудыг дурдсан байна.

Зарим зүйл заалтын хэрэгжилтийг дурдахад ХАБЭА-н сургалтын төлөвлөгөө байгаа хэдий ч зарим ААНБ-д сургалтын өрөө, тоног төхөөрөмж байхгүй, хуулийн хэрэгжилт 55.3%, ҮОХХСБ орон тооны бус байнгын комисс байгуулсан ААНБ боловсруулах үйлдвэрийн салбарт 35.9%, барилгын салбарт 37.3%, ХАБЭА-н дотоод хяналтын журамтай ч дотоод хяналтын нэгж байхгүй ААНБ цөөнгүй, хуулийн хэрэгжилтийн түвшин 46.4%-тай үнэлэгдсэн байна. Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын 42.0% буюу таван байгууллагын 2 нь ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтантай, 58% нь уг асуудлыг удирдах албан тушаалтан болон бусад албан тушаалын хүмүүс хавсран хариуцаж байна.¹⁵

Аж ахуйн нэгж байгууллагууд дахь ХАБЭА-н тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд хийсэн судалгааны үр дүн:

Нийт 119 ААНБ-д хөдөлмөрийн эрүүл ахуйн ажилтан, зөвлөлтэй эсэх, эрсдэлийн үнэлгээ хийж бодлого төлөвлөгөөтэй ажилладаг эсэх, химийн хүчин зүйлтэй харьцан ажилладаг ажилтнуудыг биомониторингийн шинжилгээнд хамруулсан эсэх, сургалтын хамрагдалт, түр амрах, дулаацах байр шаардлага хангаж байгаа эсэх, хөндлөнгийн үнэлгээнд хамрагдсан эсэх, эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан эсэх, сургалтын хөтөлбөртэй эсэх, ажлын тусгай хувцас хамгаалах хэрэгслийн жагсаалт баталж мөрддөг эсэхийг судалсан байна. Судалгааны үр дүнд хөдөлмөрийн эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан, зөвлөлтэй байгууллага 61.3%, эрсдэлийн үнэлгээ хийж бодлого төлөвлөгөөтэй ажилладаг байгууллага 56.3%, эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамрагддаг байгууллага 84.9%, биомониторингийн шинжилгээнд хамруулсан байгууллага 15.1%, сургалтын хөтөлбөртэй байгууллага 71.4%, химийн бодисын сургалт авдаг байгууллага 34.5%, амрах байртай 66.4%, ажлын тусгай хувцас хамгаалах хэрэгслийн жагсаалт баталж мөрдөгдөж ажилладаг 88.2% байна. 119 аж ахуй нэгж байгууллагын дүн шинжилгээгээр хөдөлмөрийн эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилт харилцан адилгүй, хангалтгүй түвшинд байна гэж дүгнэжээ.¹⁶

Өмнө хийгдсэн ХАБЭА-н тухай хуулийн хэрэгжилтийг үнэлсэн судалгааны үр дүн, зөвлөмжөөс харахад хэрэгжилтийн түвшинд хангалтгүй байна.

3.2.3.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулийн хэрэгжилт, үнэлгээ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх төрийн бодлого, үндсэн зарчмыг тодорхойлж, төрийн байгууллагын удирдлага, хяналтын тогтолцоо, ажлын байранд тавигдах

¹⁵ ХНХЯ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт, ХАБЭА-н тухай хуулийн хэрэгжилтийн судалгааны тайлан

¹⁶ ХЭА-2025 бага хурал, ХАБЭМТ, Аж ахуйн нэгж байгууллагууд дахь ХАБЭА-н тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд хийсэн судалгааны үр дүн

хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангах, ажилтан, хөдөлмөр эрхлэгч иргэнийг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилготойгоор 9 бүлэг, 37 зүйлтэйгээр 2008 оны 05 дугаар сарын 22-ны өдөр батлагдсан.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж

Хуулийн 2 дугаар зүйлд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ” гэж заасан. 2008 онд хууль батлагдсанаас хойш ХАБЭА-н харилцааг зохицуулахад оролцдог дараах хуулиуд шинээр батлагдаж, шинэчлэн найруулагдсан байна.

Шинээр батлагдсан хууль:

- Эрүүл ахуйн тухай хууль, 2016 он
 - 6 дугаар зүйл. Ажлын байран тавих эрүүл ахуйн шаардлага
 - 13 дугаар зүйл. Аж ахуйн нэгж байгууллагын эрх, үүрэг
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль, 2023 он
 - 5 дугаар зүйл. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, үйл ажиллагааны чиглэл

Шинэчлэн найруулагдсан хууль:

- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай, 2017 он
 - 5 дугаар зүйл. Техникийн зохицуулалтын зорилго
 - 9 дүгээр зүйл. Үндэсний стандарт
 - 13 дугаар зүйл. Тохирлын үнэлгээний зорилго, хамрах хүрээ
 - 15 дугаар зүйл. Тохирлын үнэлгээний байгууллага
- Хөдөлмөрийн тухай хууль, 2021 он
 - Наймдугаар бүлэг. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд
 - Бусад зүйл
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль, 2023 он
 - 3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ
 - 6 дугаар зүйл. Нийгмийн даатгалын төрөл
 - Гуравдугаар бүлэг. Нийгмийн даатгалын шимтгэл
 - Бусад
- Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, 2023 он
 - Бүхэлдээ ҮОМШӨ-ний даатгалын асуудлыг зохицуулсан

ХАБЭА-н тухай хуулийн 3 дугаар зүйл, Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

Хуулийн 3 дугаар зүйлд 22 нэр томъёоны тодорхойлолт ашиглагдаж байна. Эдгээр зарим нэр томъёо нь шинжлэх ухаан, мэргэжлийн салбар, олон улсад түгээмэл хэрэглэгддэг тодорхойлолтоос зөрүүтэй байна.

“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” гэхээс илүүтэйгээр “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд” гэсэн нэршил олон улсын конвенц, стандарт,

мэргэжлийн ном сурах бичигт ашиглагддаг. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг багтаасан өргөн хүрээний ойлголт юм.

Олон улсын хөдөлмөрийн байгууллага(ОУХБ)-ын 155, 161, 167, 176, 187 дугаар конвенцүүд нь “Occupational Safety and Health” буюу “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд” нэртэй.¹⁷ Монгол Улс 1997 онд 155, 2015 онд 167, 2020 онд 176 дугаар конвенцод тус тус нэгдэх үед конвенцын нэрийг Монгол хэл рүү орчуулахдаа “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (Occupational safety and hygiene)” гэж эх нэршлээс нь зөрүүтэй орчуулан хэрэглэж байна. Энэ зөрүүтэй нэршил нь үндэсний хууль тогтоомжид мөн нэгэн адил хэрэглэгдэж ирсэн ба хөдөлмөрийн эрүүл ахуйн асуудалд илүүтэй төвлөрч, ажилтны эрүүл мэндийн үзлэг, тандалт, ажил мэргэжлийн тохироо зэрэг хөдөлмөрийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний асуудлууд орхигдсон байна.¹⁸

ОУХБ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн нэвтэрхий тольд “Хөдөлмөрийн эрүүл ахуй нь ажлын байрнаас үүсэж, ажилтан, ойр орчмын оршин суугчдад нөлөөлж болзошгүй аюултай хүчин зүйлсийг урьдчилан таамаглах, таньж илрүүлэх, хэмжиж үнэлэх, хяналт тавьж бууруулах шинжлэх ухаан” гэж тодорхойлогдсон¹⁹.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ) болон ОУХБ-аас 1950 онд хөдөлмөрийн эрүүл мэндийн зорилгыг “бүх төрлийн ажил хөдөлмөр эрхэлдэг ажилтны бие махбод, сэтгэл зүй, нийгмийн сайн сайхан байдлыг хамгийн дээд хэмжээнд байлгах, дэмжих; хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөр эрхлэлтээс шалтгаалан ажилтны эрүүл мэндэд үүсэж болзошгүй сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх, ажилтны бие махбод, сэтгэл зүйн чадавхад тохирсон ажил хөдөлмөрөөр хангах” гэж тодорхойлсон²⁰.

Мэргэжлийн ном, олон улсын стандартад бичсэнээр “ажлын байран дахь эрсдэл” гэдэг нь ажилтан ажлын байрны аюултай хүчин зүйлийн өртөлтийн улмаас осолд орох эсвэл өвчлөх магадлал юм²¹. Хуульд үүнээс зөрүүтэй тодорхойлсон байна.

“Үйлдвэрлэлийн ажлын байрыг хөдөлмөрийн нөхцөлөөр аттестатчилах” гэсэн нэр томъёо хуульд орсон ямар нэг хууль, дүрэм, журам, стандартад ашиглагдахгүй байна.

2017 онд батлагдсан Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулиар стандартууд нь сонгон хэрэглэх зохицуулалттай болсон ба заавал мөрдөх хэм хэмжээг техникийн зохицуулалтаар тогтоох болсон. Тиймээс хуульд тодорхойлсон “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт” гэсэн нэршлийг дахин найруулах, “техникийн зохицуулалт”-ын тодорхойлолтыг нэмэх шаардлагатай болж байна.

¹⁷ ОУХБ-ын конвенцын жарсаалт <https://normlex.ilo.org/dyn/normlex/en/f?p=NORMLEXPUB:12000:0::NO::>

¹⁸ ХНХЯ, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг дэмжих тогтолцооны тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 187 дугаар конвенцыг Монгол Улсын хууль тогтоомжтой харьцуулсан үнэлгээ, 2023 он

¹⁹ ОУХБ, ХАБЭМ-ийн нэвтэрхий толь, <https://www.iloencyclopaedia.org/part-iv-66769/occupational-hygiene-47504>

²⁰ ОУХБ, ХАБЭМ-ийн нэвтэрхий толь, <https://www.iloencyclopaedia.org/part-ii-44366/occupational-health-services>

²¹ Д.Нарансүх, Хөдөлмөрийн эрүүл ахуй сурах бичиг, 2022 он

ХАБЭА-н тухай хуулийн 5 дугаар зүйл, Төрөөс баримтлах бодлого, зарчим

Монгол Улсын нэгдэн орсон ОУХБ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн 155 дугаар конвенцын "Гишүүн орон үндэсний нөхцөл, дадалд нийцүүлэн ажил олгогч болон ажилчдыг төлөөлөх томоохон байгууллагатай зөвшилцөн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, ажлын орчны асуудлаар харилцан уялдаатай үндэсний бодлогыг боловсруулан хэрэгжүүлж, үе үе хянан үзнэ" гэж заасан.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд үндэсний бодлого гэж тусгайлан тодорхойлоогүй ч 5.1 дугаар зүйлд заасан "төрөөс баримтлах бодлого, зарчим"-ыг тодорхойлсон.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу ХАБЭА-н Үндэсний хороо тогтмол хуралдаж, ХАБЭА-н талаарх хууль тогтоомж, дүрэм, журам, бусад асуудлыг хуульд заасны дагуу ажилтан, ажил олгогчийн төлөөлөлтэй хэлэлцэж, бодлого боловсруулах, хэрэгжилтэд нь хяналт тавихад оролцох боломжийг бүрэн олгох зохицуулалт хэрэгжиж байна.

ХАБЭА-н тухай хуулийн хоёрдугаар бүлэг, 6 дугаар зүйл, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт

Хөдөлмөрийн эрүүл ахуйн стандартууд нь шинжлэх ухаан, технологийн хөгжил, олон улсын жишигт нийцсэн байх шаардлагатай бөгөөд стандартын хэрэгжилт, холбогдох хууль тогтоомжтой уялдсан байдал, үр нөлөөг үнэлж, шаардлагатай шинэчлэл хийх зорилгоор улсын үзлэгийг 2025 оны 2 дугаар сард зохион байгуулсан. ХАБЭА-н хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 156 стандартад үзлэг хийснээс хүчингүй болгох 57, холбогдох заалтуудыг дахин хянах 6, дахин шинэчлэх 47, цаашид хэвээр мөрдөх 46 стандарт байна гэсэн үзлэгийн дүн гарсан. Шинэчлэн батлагдсан 38 стандартын 26 стандарт нь хөдөлмөрийн аюулгүй байдлын, 12 стандарт нь хөдөлмөрийн эрүүл ахуйн стандарт байна.²²

Хууль тогтоомжийн хэрэгжилтэд төрийн хяналт шалгалтаар ажил олгогч нараас дээрх стандартын хэрэгжүүлсэн байх шаардлага тавьдаг. Ялангуяа хэм хэмжээг тогтоосон 33 стандартыг заавал мөрдсөнөөр ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангагдана.

2017 онд батлагдсан Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 4.1.2 дугаар зүйлд "стандарт" гэж тодорхой хүрээнд хэм хэмжээ бий болгоход чиглэсэн ерөнхий зарчим, үзүүлэлтийг сонирхогч талууд зөвшилцөн боловсруулж баталсан, сонгон хэрэглэх баримт бичгийг; 4.1.3 дугаар зүйлд "техникийн зохицуулалт" гэж бүтээгдэхүүний тодорхойлолт, боловсруулалт, үйлдвэрлэлийн арга, стандарт, техникийн үзүүлэлт болон шаардлагыг эш татаж, эсхүл тэдгээрийн агуулгыг тусгаж эрх бүхий байгууллагаас баталсан заавал дагаж мөрдөх баримт бичгийг хэлнэ гэж тодорхойлсон. Энэ тодорхойлолтын дагуу аж ахуйн нэгж, байгууллагууд ХАБЭА-н стандартыг заавал мөрдөхгүй байж болох нөхцөл үүссэн. Харин ХАБЭА-н хэм хэмжээг тогтоосон нэг ч техникийн зохицуулалт өнөөг хүртэл батлагдаагүй.

²²ГБХНХЯ, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төв.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд стандарт, техникийн зохицуулалтын эрх зүйн хэм хэмжээний талаарх нэмэлт өөрчлөлт хийгдээгүй.

Хуулийн 6.2-ийн дагуу аль нэг салбарын яам стандарт боловсруулах, батлуулах, нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг тухайн салбарын төрийн захиргааны төв байгууллага хариуцах талаар заасан. Яам бодлого боловсруулах түвшний байгууллага тул ХАБЭА-н стандартыг давтамжтай хянах, шинэчлэх, сайжруулах, хүчингүй болгох, шинээр боловсруулах зэрэг хэрэгжилтийн түвшний ажлыг хариуцах боломжгүй байна. Практикт үүнтэй холбоотойгоор стандартын шинэчлэл төлөвлөлтэйгөөр тогтмол хийгдэж чадахгүй, ХАБЭА-н стандартын шинэчлэл хариуцсан байгууллага байхгүй бөгөөд ихэнхдээ мэргэжлийн холбоо, аж ахуйн нэгж, төсөл хөтөлбөрийн санаачилгаар стандартын шинэчлэл хэрэгждэг. Стандарт, хэмжил зүйн газар зөвхөн боловсруулсан стандартын төслийг хүлээн авч техникийн хороогоор хэлэлцүүлж, батлуулах үүрэгтэй.

ХАБЭА-н тухай хуулийн 7-13 дугаар зүйл, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага

Хуулийн 7-13 дугаар бүлгээр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг тогтоосон боловч үүнд практикт тохиолдож буй МШӨ, хурц хордлого, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой дараах шаардлагууд багтаагүй. Үүнд:

- Хязгаарлагдмал орчинд тавигдах шаардлага
- Хавдар үүсгэдэг, үр удамд нөлөөлдөг, нөхөн үржихүйд нөлөөлдөг хорт бодист тавигдах шаардлага
- Хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөлд тавигдах шаардлага хамаарна.

Манай улсад ус, цахилгаан хангамж, харилцаа холбооны шугам сүлжээний худаг, зоорь зэрэг хязгаарлагдмал орчинтой холбоотой хурц хордлого, үйлдвэрлэлийн ослын улмаас хүний амь нас жил бүр хохирч байна. Тухайлбал 2019 онд Улаанбаатар хотын бохир ус цэвэрлэх байгууламжид гарсан хязгаарлагдмал орчинд гарсан үйлдвэрлэлийн ослын улмаас 4, ус дамжуулах шугам хоолойд гарсан ослын улмаас 2 хүн нас барсан. Үүнийг зохицуулсан ямар нэг хуулийн зохицуулалт, техникийн зохицуулалт, стандартын зохицуулалт Монголд хэрэгжихгүй байхгүй. АНУ, Англи, Австрали, Сингапур зэрэг орнууд хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагааны шаардлагыг заавал мөрдөх эрх зүйн зохицуулалтаар зохицуулах практиктэй.

Аливаа химийн бодисыг үйлдвэрлэх, хэрэглэх зэргээр ажилчид нэн түрүүнд өртдөг. Түүнчлэн ажилчдын өртөлт эцсийн хэрэглэгчид, ердийн хүн амаас хавьгүй өндөр байдаг. Хавдар үүсгэдэг, үр удам, нөхөн үржихүйд нөлөөлдөг хорт бодист өртөхөд богино хугацаанд ямар нэг шинж тэмдэг илрэхгүй ч урт хугацааны дараа хорт хавдар, үр удамд нь төрлөхийн гажиг, үргүйдэл үүсгэх зэрэг ноцтой сөрөг үр дагавартай. Тиймээс улс орнууд эдгээр бодисын хэрэглээнд маш болгоомжтой хандаж, тусгай шаардлагыг тогтоодог²³. Тухайлбал Хавдрын судалгааны олон улсын

²³ Eurostat Statistics Explained, [https://ec.europa.eu/eurostat/statistics-explained/index.php?title=Glossary:Carcinogenic,_mutagenic_and_reprotoxic_\(CMR\)](https://ec.europa.eu/eurostat/statistics-explained/index.php?title=Glossary:Carcinogenic,_mutagenic_and_reprotoxic_(CMR))

агентлагаас химийн бодисуудыг хүнд хавдар үүсгэх шинж чанараар ангилж, хүний эрүүл мэндийг хамгаалах асуудлыг зөвлөдөг.²⁴

Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 3.1.4.-д "хязгаарласан химийн бодис" гэж зөвхөн зөвшөөрсөн газарт, заасан зориулалт, хэмжээ, технологийн дагуу тодорхой хяналтын дор хэрэглэхийг зөвшөөрсөн химийн хорт ба аюултай бодис, тэдгээрийн нэгдлийг хэлнэ" гэж заасан.²⁵ Засгийн газрын 2011 оны тогтоолоор асбестийг хязгаарласан бодисын жагсаалтад оруулсан. Дулааны цахилгаан станц, галт тэрэгний зүтгүүрийн засварын газар, төмөрлөгийн үйлдвэр зэрэгт асбестийг галд тэсвэртэй, дулаан тусгаарлах материалаар ашигладаг тул ердийн хүн ам гэхээсээ илүүтэй ажилчид өртдөг. Гэвч хуульд заасан "зөвшөөрсөн газарт, заасан зориулалт, хэмжээ, технологийн дагуу тодорхой хяналтын дор хэрэглэх" зохицуулалт хэрэгжихгүй байгаа ажилтнуудын дунд асбестаар үүсгэгдсэн хавдар бүртгэгдсээр байна.²⁶

Химийн хорт ба аюултай бодисын тухай хуулийн 13 дугаар зүйлээр химийн хорт болон аюултай бодис ашиглахад тавих үндсэн шаардлагыг тогтоож, ажлын байран дахь химийн бодисын хэрэглээ, ХАБЭА-н асуудлуудыг зохицуулсан байна.

ХАБЭА-н шаардлага нь хүний эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой заавал мөрдөх хэмжээ тул Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу техникийн зохицуулалтаар зохицуулах нь зүйтэй. Нөлөөтэйгөөр аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг хуулиар нарийвчлан журамлан тогтоох нь тохиромжгүй тул ерөнхий шаардлагыг хуульд зааж, нарийвчлан шаардлагыг техникийн зохицуулалтаар тогтоох хэрэгцээ байна.

Хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөлийн шаардлагыг стандартаар тогтооно гэж заасан. Стандартад ажилчид ажлын байрандаа зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн тоос, шуугиан, хорт бодист өртөх нь эрүүл ахуйн шаардлага зөрчигдөж, МШӨ-өөр өвчлөх эрсдэлтэй нөхцөл үүсдэг. Иймд ажил олгогч нь хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулж, өртөлтийг зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бууруулж, ажилтнаа хамгаалах шаардлагатай. Гэвч хуульд ийм зохицуулалт тусгагдаагүй.

ХАБЭА-н тухай хуулийн 14 дүгээр зүйл, Эрүүл мэндийн үзлэг

Хуулийн 14 дүгээр зүйлээр ажилтны эрүүл мэндийн үзлэгийн асуудлыг зохицуулж байна. Үндсэн хуулийн 16.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 120.1 дүгээр зүйлийн дагуу ажилтны эрүүл мэндийн үзлэг нь ажил хөдөлмөр эрхлэгч иргэн нь ажил хөдөлмөртэй холбоотой өвчнөөр өвчлөх, хөдөлмөрийн чадвар алдахаас урьдчилан сэргийлэхэд чиглэх ёстой. Түүнчлэн ажилтны эрүүл мэндийн байдал нь зарим эрсдэлтэй ажил хөдөлмөр эрхлэхэд хязгаарлалт болдог тул төрөлжсөн мэргэшлийн эмч "ажил мэргэжлийн тохироо"-г үнэлэх зайлшгүй шаардлага тулгардаг.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд ажилтны эрүүл мэндийн үзлэгийн асуудлыг зохицуулахдаа "эрсдэлтэй ажилтнуудад ажил хөдөлмөртэй холбоотой өвчнөөс сэргийлэх, ажил мэргэжлийн тохироог үнэлэх" асуудлыг тодорхой заагаагүй. Үүнтэй холбоотойгоор практикт аж ахуйн нэгжүүд ажилтны эрүүл мэндийн үзлэгийг хөдөлмөрийн нөхцөл, эрсдэлийн төвшнөөс

²⁴ Agents Classified by the IARC Monographs, Volumes 1–136, <https://monographs.iarc.who.int/agents-classified-by-the-iarc/>

²⁵ Химийн хорт болон аюултай бодис <https://legalinfo.mn/mn/detail/526>

²⁶ Damiran Naransukh, Frank AL. Mongolia: Failure of Total Banning of Asbestos. *Ann Glob Health*. 2023 Aug 2;89(1):50. doi: 10.5334/aogh.4035. PMID: 37547483; PMCID: PMC10402788.

хамааран төлөвлөдөггүй, ердийн өвчний илрүүлэг оношилгоо хэлбэрээр зохион байгуулж байна. Энэ нь ажил хөдөлмөртэй холбоотой өвчнийг эрт илрүүлэх, оношлох, хөдөлмөрийн чадвар алдуулахаас урьдчилан сэргийлэхэд үр нөлөөгүй байна.

Хуулийн 14.1 дүгээр зүйлд “Ажил олгогч нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу үйлдвэрлэл, ажил, үйлчилгээтэй холбоотой, зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт ажилтныг хамруулна” гэж заасан.

“...үйлдвэрлэл, ажил, үйлчилгээтэй холбоотой, зайлшгүй шаардлагатай...” эрүүл мэндийн үзлэг хийхээр зохицуулсан нь ямар салбар, ажил мэргэжил эрхлэх хүмүүст зориулагдсан нь тодорхойгүй байна. Мэргэжлийн сурах бичиг, мэргэжлийн удирдамжид ажил хөдөлмөртэй холбоотой өвчин үүсгэх эрсдэлтэй хөдөлмөрийн нөхцөлтэй, аюулгүй ажиллагааны өндөр эрсдэлтэй ажил хийх хүнийг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, “хөдөлмөрийн нөхцөл нь эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлөх, эрүүл мэндийн байдлаас нь шалтгаалан ажлын байрандаа өөрийн болон бусдын аюулгүй байдалд эрсдэл учруулах, бие бялдрын хувьд ажлаа хийж чадах эсэхэд нь ” дүгнэлт гаргах зорилгоор хийнэ гэж заадаг^{27 28}. Гэвч хуулийн заалт энэ агуулгыг тодорхой илэрхийлээгүй байна.

Эрүүл мэндийн салбарт ердийн хүн амын дунд хийгдэж буй үзлэг, эрт илрүүлгээс ялгах, төөрөгдөл үүсгэхгүйн тулд олон улсын жишгээр “Хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг” гэсэн нэр томъёог хэрэглэх нь оновчтой юм. Практикт аж ахуйн нэгжүүд ажилтны эрүүл мэндийн үзлэгийг хөдөлмөрийн нөхцөл, эрсдэлийн төвшнөөс хамааран төлөвлөдөггүй ба ердийн өвчний эрт илрүүлэг оношилгоо хэлбэрээр зохион байгуулж байна. Энэ нь ажил хөдөлмөртэй холбоотой өвчнийг эрт илрүүлэх, оношлох, хөдөлмөрийн чадвар алдуулахаас урьдчилан сэргийлэхэд үр нөлөөгүй, цаашлаад Монгол Улсад мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бүртгэх, мэдээлэх, статистик бүртгэл хөгжихөд сөргөөр нөлөөлж байна.

Хуульд шинэ ажилтныг ажилд авахаас өмнөх хийх эрүүл мэндийн үзлэгийг “урьдчилсан” гэж нэрлэсэн нь оновчгүй байна. Мэргэжлийн ном сурах бичиг, удирдамжид үүнийг “ажилд орохоос өмнөх эрүүл мэндийн үзлэг” (pre-employment medical examination) гэж нэрлэдэг²⁹.

Хуулийн 14.4-д заасны дагуу эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үүрэг зөвхөн ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулах журмыг батлахаар хязгаарлагдаж байна. Хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг нь эрүүл мэндийн байгууллагад хийгддэг эмнэлгийн бөгөөд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ тул дараах хуулиудын дагуу эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хамаарах асуудалд харьяалагдаж байна.

- Эрүүл мэндийн тухай хуулийн 13.2. “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс

²⁷ German Social Accident Insurance, Guidelines for Occupational Medical Examinations. Prophylaxis in Occupational Medicine, 2007

²⁸ John Hobson, Julia Smedley, Fitness for Work: The Medical Aspects, 6th edition, 2019

²⁹ German Social Accident Insurance, Guidelines for Occupational Medical Examinations. Prophylaxis in Occupational Medicine, 2007

урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа хамаарна”;

- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 3.1.1. "эмнэлгийн тусламж, үйлчилгээ" гэж өвчин эмгэг, гэмтэл бэртэл, хүний биеийн үйл ажиллагааны алдагдлыг орчин үеийн болон уламжлалт анагаах ухаанд тулгуурлан оношлох, эмчлэх, сувилах, хөнгөвчлөх, сэргээн засах цогц үйл ажиллагааг”;
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль 5.1. "Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь дараах төрөлтэй байна...5.1.3. хөдөлмөрийн эрүүл мэнд”;

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд хөдөлмөрийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний асуудлыг эрүүл мэндийн салбар, хууль тогтоомжтой уялдуулаагүйгээс эрүүл мэндийн байгууллагуудад МШӨ-ний үзлэг оношилгоо хийгддэггүй, статистик бүртгэл байхгүй, мэргэжлийн хүний нөөцийн хомсдолд орсон зэрэг асуудлыг үүсгэж байна. Түүнчлэн үйлдвэр, уурхайнуудад эмнэлгийн тусгай зөвшөөрөлгүйгээр, хяналтгүй эмнэлгийн үйл ажиллагаа явагдаж байна.

Эрсдэлтэй нөхцөлд ажилладаг ажилтнуудад хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг хийснээр мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт илрүүлэх зорилготой. ХНХС, ЭМС-ын 2023 оны А/152, А/388 дугаар тушаалаар баталсан МШӨ-ний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг тогтоосон жагсаалт мөрдөгдөж байна. Энэ тушаал нь хөдөлмөрийн чадвар нэгэнт алдсан ажилтанд нийгмийн даатгалаас тэтгэвэр олгоход зориулагдсан. Харин хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэгээр илрүүлж оношилсон МШӨ-ний тохиолдлыг бүртгэх, улмаар хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн жагсаалт байхгүй.

Хуульд эрсдэлтэй хөдөлмөрийн нөхцөлд ажилладаг ажилтны эрүүл мэндийн тандалтыг цогцоор авч үзэж, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт илрүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалтаас сэргийлэх, ажилтанд эрүүл мэндийн байдалд тохирсон ажил хөдөлмөр эрхлэх эрхээ эдлэх боломж олгоход чиглэсэн зохицуулалтыг бий болгох шаардлагатай.

ХАБЭА-н тухай хуулийн 15 дугаар зүйл, Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл

Хуулийн 15 дугаар зүйлээр ажилтныг ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах асуудлыг зохицуулж байна. Хуулийн үр нөлөөг улам сайжруулахын тулд ажил олгогч ажилтандаа ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг олгохоос өмнө ажлын байран дахь осол, өвчин үүсгэж болзошгүй аюулыг арилгах илүү үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлага тавигдаагүй.

Ажил олгогч ажлын байран дахь аюулыг арилгах эх үүсвэр, дамжих замд чиглэсэн аюулыг арилгах, орлуулах, агааржуулалт, тусгаарлалт, удирдлага зохион байгуулалт зэрэг дэс дараатай арга хэмжээгээр аюул, эрсдэлийг арилгах, бууруулах боломжийг нэн түрүүн анхаарч, хэрэгжүүлэх ёстой. Эдгээр арга хэмжээ нь аюулыг арилгах боломжгүй тохиолдолд эцсийн хамгаалах арга хэмжээний сонголт нь ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл юм. ХАБЭА-н үндэсний хорооны 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор Ажлын тусгай, хувцас хамгаалах хэрэгсэл

олгох зөвлөмжийг гаргасан. Хуулийн 15.1-д “ажил олгогч нь ажилтныг түүний ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээрхангах үүрэгтэй”, Хуулийн 15.2-д “ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг турших, худалдаж авах, хадгалах, угааж цэвэрлэх, засварлах, ариутгах зардлыг ажил олгогч хариуцна” гэж заасан боловч ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийн сонголтыг хийхдээ ажлын байран дахь аюултай хүчин зүйлсийн шинж чанар, ертөлтийн түвшин, ажлын орчны нөхцөл, бусад хамгаалах хэрэгслийн хэрэглээ зэргийг бодит байдал дээр харгалзан үзэх байдал дутмаг байдаг.

ХАБЭА-н тухай хуулийн 17 дугаар зүйл, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон мэргэжлийн сургалт

Хуулийн 17 дугаар зүйлээр “ажил олгогч”, “ажилтан”, “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн” гэсэн 3 түвшинд зориулсан сургалтыг зохицуулж байна. Ажил олгогч, ажилтанд зориулсан сургалтыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмаар нарийвчлан зохицуулах заалт хэрэгжиж байна. ХАБЭА-ийн мэргэжилтний сургалтыг Боловсролын тухай хууль тогтоомжоор зохицуулах заалттай.

Хуулийн 17.6 дугаар зүйлд заасан **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэнд** “хөдөлмөрийн аюулгүй байдлын мэргэжилтэн”, “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжилтэн”, “хөдөлмөрийн эрүүл ахуйч”, “хөдөлмөрийн эрүүл мэнд судлаач эмч”, “хөдөлмөрийн эрүүл мэндийн сувилагч”, “эргономикийн мэргэжилтэн” зэрэг хамаарна. Гэвч хуулийн 27.4-д инженер, техникийн болон эрүүл ахуйн боловсролтой **хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан** гэсэн нэр томъёог тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл хуульд ХАБЭА-н мэргэжилтэн болон асуудал хариуцсан ажилтан гэсэн хоёр нэршил хэрэглэгдэж байна.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн А/130 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын жишиг хөтөлбөр”-өөр ажил олгогч, ажилтан, эрсдэлтэй ажлын байрны сургалт, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд зориулсан сургалт, ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан бэлтгэх сургалтын асуудлыг зохицуулж байна.³⁰ Өмнө нь ХНХС-ын 2023 оны А/173 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт явуулах болон шалгалт авах журам”-аар ажил олгогч, ажилтан, ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан, сургагч багш бэлтгэх сургалтын асуудлыг зохицуулж байсан нь хуулийн 17.1-д заасан ажил “хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтан болон ажил олгогчийн сургалт”-ын асуудлын хүрээнээс хэтэрсэн байсан.³¹

2024 оны 10 сарын байдлаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн бүртгэж гэрчилгээ олгосон 120 сургалтын төвийг 21,757 хүн 7-14 хоногийн сургалтаар ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтнаар төгсөөд байна³². 2024 оны байдлаар АШУҮИС, ШУТИС, Техник технологийн дээд сургууль, Хөдөлмөрийн

³⁰ ГБ,ХНХС-ын 2025 оны А/130 тоот тушаал

³¹ ХНХС-ын 2023 оны А/173 тоот тушаал, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17048054797081>

³² ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны мэдээлэл, <https://new.tender.gov.mn/mn/osh/certificate>

харилцааны дээд сургуулиудад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжилтэн, Хөдөлмөрийн эрүүл ахуйч, Мэргэжлээс шалтгаалсан өвчний эмч, Эрүүл ахуйч зэрэг мэргэжилтнийг 4 жилийн бакалаврын хөтөлбөрөөр бэлтгэж байна.³³

Хуулийн 17.6 болон 27.4 дүгээр зүйлд заасан ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан болон ХАБЭА-н мэргэжилтэн нэршлийг хянаж нягтлах нь сургалт, мэргэжлийн хүний нөөцийн бодлогод ач холбогдолтой байна.

ХАБЭА-н тухай хуулийн 19 дүгээр зүйл, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тогтолцоо

Хуулийн 19.1 дүгээр зүйлд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцах тогтолцоо нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний харьяа мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллага, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороо, салбар хороо болон аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл, аймаг, сум, нийслэл, дүүрэг, хорооны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, хяналтын байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөл, ажилтнаас бүрдэнэ” гэж тодорхойлсон.

ОУХБ-ын 187 дугаар конвенцод “**хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний тогтолцоо** гэж урьдчилан тогтоосон хугацаанд хүрэх зорилтууд, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийн үндсэн суурь тогтолцоог бүрдүүлж буй дэд бүтцийг хэлнэ” гэж тодорхойлсон.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд **үндэсний тогтолцоог ХАБЭА-н асуудал хариуцсан байгууллагын тогтолцоо** хэлбэрээр тодорхойлсон ба бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшинд хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний хэрэгжилтийн түвшинд мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллага ажиллахаар хуульчилсан. Мөн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналтын байгууллага хяналт тавьж ажиллаж байна.

Үндэсний хороо, салбар хороо, орон нутгийн зөвлөл нь ХАБЭА-н хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтэд ажил олгогч, ажилтны төлөөлөл, салбарын яамд, нутгийн захиргааны байгууллагын оролцоог хангах, дэмжлэг авах үүрэг гүйцэтгэж байна.

Аж ахуйн нэгж, байгууллага нь хууль тогтоомжоор тогтоосноор ажилтныхаа аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах ажил олгогчийн үүргээ биелүүлэх, ХАБЭА-н зөвлөлөөр дамжуулан ажилтны оролцоог хангах хэлбэрээр үндэсний тогтолцоонд оролцож байна.

ОУХБ-ын 187 дугаар конвенцод заасан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний тогтолцооны хүрээнд хэрэгждэг үйл ажиллагааг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

³³ Э.Эрдэнэчимэг, Хөдөлмөрийн эрүүл мэндийн мэргэжлийн хүний нөөц, эрдэм шинжилгээ илтгэл, 2024.

- a) **ХАБЭМ-ийн асуудлаар ажилладаг үндэсний гурван талт зөвлөлдөх байгууллага буюу үндэсний хороо.** Хуулийн 23.1 дүгээр зүйлд заасны дагуу төрийн захиргааны байгууллага, ажил олгогчийн болон ажилтны эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөл бүхий тэнцүү тооны гишүүдээс бүрдсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Үндэсний хороо, салбар хороо, аймаг, нийслэл, сумын зөвлөл;
- b) **ХАБЭМ-ийн мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээ.** Хуулийн 22.1.6 дугаар зүйлд Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага "үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын талаарх тайланг гаргах, хөдөлмөрийн хортой, аюултай нөхцөл бүхий ажлын байрны мэдээллийн сан бүрдүүлэх, холбогдох газар, олон нийтэд мэдээлэх", 25.1.4 дүгээр зүйлд "аймаг, сум, нийслэл, дүүрэг, хорооны ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан "үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх", 33.2.2, 33.3.1, 33.3.7, 33.4.4 дүгээр зүйлүүдэд "хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын байцаагч нарын ХАБЭМ-ийн зөвлөгөө өгөх эрх" зэрэг зохицуулалтыг тус тус заасан.
- Хуульд ХАБЭМ-ийн мэдээлэл, зөвлөгөө өгөх асуудлыг олон нийтэд өгөх асуудлыг ХНХЯ хариуцахаар заасан ч зохицуулалтын хувьд оновчгүйгээс хангалттай хэрэгжихгүй байна. ХНХЯ-ны харьяа ХАБЭМТ тодорхой хэмжээгээр мэдээлэл, зөвлөгөө түгээн ажилладаг ч хүртээмж нь хангалтгүй байна. Аймаг, сум, нийслэл, дүүрэг, хорооны түвшинд ХАБЭМ-ийн зөвлөгөө, мэдээлэл өгөх асуудал практикт хангалтгүй, хариуцах эзэнгүй байна. Хяналтын байцаагч нар ихэнх тохиолдолд тэдний хяналтад хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагад зөвлөгөө өгдөг. ХАБЭМ-ийн мэдээлэл, зөвлөгөө нь ихэнхдээ компани ажлын хүрээнд, гадны төсөл хөтөлбөр эсвэл мэргэжлийн холбоо, сайн дурын үйл ажиллагааны хүрээнд тогтмол бус байдлаар хийгдэж байна. Практикт ХАБЭМ-ийн зөвлөгөө, мэдээллийн хүртээмж хангалтгүй.
- Хуульд заасны дагуу хортой, аюултай нөхцөл бүхий ажлын байрны мэдээллийн санг бий болгоогүй тул холбогдох газар, олон нийтэд мэдээлэх боломжгүй байна.
- c) **ХАБЭМ-ийн сургалт.** Хуулийн 17.1 дүгээр зүйлд "Ажил, хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтан болон ажил олгогч нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу ХАБЭА-н сургалтад хамрагдаж мэдлэг, дадлагатай болсон байна", 17.6 дугаар зүйлд "ХАБЭА-н чиглэлийн мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэх харилцааг Боловсролын тухай, Дээд боловсролын тухай хуулийн дагуу зохицуулна" гэж тус тус заасан.
- d) **Хөдөлмөрийн эрүүл мэндийн үйлчилгээний талаар хуульд тусгайлсан заалт байхгүй.** Хуулийн 31 дүгээр зүйлд "Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ" буюу хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжлийн үйлчилгээ, 14 дүгээр зүйлд "Эрүүл мэндийн үзлэг" буюу хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэгийн асуудлыг зохицуулсан. 30 дугаар зүйлд "Мэргэжлээс шалтгаалах өвчин, түүнтэй холбогдсон хөдөлмөр зохицуулалт"-ын талаар заасан.
- Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг ХНХС-ын 2023 оны А/155 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу Үндэсний итгэмжлэлийн төвөөс итгэмжлэлтэй 7 байгууллага хийж байна. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээнд тогтмол хамрагдвал

зохих эрсдэл өндөртэй 14 мянга орчим аж ахуйн нэгжийн 1.4% нь хамрагддаг. Ажилтны эрүүл мэндийн үзлэгийг Эрүүл мэндийн сайдын 2014 оны А/340 Эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийн журмын дагуу зохион байгуулж байна. Ажилтны эрүүл мэндийн үзлэгийг хөдөлмөрийн нөхцөлөөс хамааруулан зохион байгуулдаг 4 эмнэлэг байна. Бусад эмнэлгүүдэд ажилтны эрүүл мэндийн үзлэгийг ердийн өвчний илрүүлэг хэлбэрээр хийж байна.

- e) **ХАБЭМ-ийн судалгаа.** Хуулийн 21.1.7 дугаар зүйлд Засгийн газрын бүрэн эрхэд "хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх судалгаа, шинжилгээг холбогдох байгууллагаар хийлгэх" гэж заасан энэ үүргийг хариуцах тал тодорхойгүй.
- f) **Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тоо мэдээ цуглуулах, дүн шинжилгээ хийх механизм.** Хуулийн 6 дугаар бүлгээр "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлого, тэдгээрийг судалж бүртгэх" асуудлыг зохицуулсан. Засгийн газрын 269 дугаар тогтоолоор батлагдсан дүрмийн дагуу Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогыг судлан бүртгэх үйл ажиллагаа хэрэгжиж байна. ҮОХХ-ын бүртгэлийг онлайн хэлбэрээр цуглуулж, <https://inspection.hudulmur-halamj.gov.mn/> веб хуудсан нэгтгэгдэж мэдээлэгдэж байна. Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бүртгэх, мэдээлэх асуудлыг ХНХЯ-ны сайдын 2015 оны А/234 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу зохицуулдаг ч зөвхөн МШӨ-өөр хөдөлмөрийн чадвар алдсан тохиолдлыг бүртгэдэг. Эрүүл мэндийн хугацаат үзлэгээр эрт үед илрүүлсэн тохиолдлуудыг бүртгэх, нэгтгэх асуудал хийгдэхгүй байна. ҮОМШӨ-ний тоо, статистикт дүн шинжилгээ хийх механизм хангалттай бүрдээгүй, ОУХБ-ын аргачлалыг ашигладаггүй.
- g) **Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал.** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 18.1.2 дугаар зүйлд ажилтан "үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд хамрагдах" эрхийг, 28.4 дүгээр зүйлд "Эрсдэлийн түвшин их ажлын байранд ажиллаж байгаа ажилтныг амь нас, эрүүл мэндийн даатгалд тухайн ажилтны 36 ба түүнээс дээш сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээгээр заавал даатгуулах" ажил олгогчийн үүргийг заасан. Түүнчлэн ҮОМШӨ-ний даатгалын асуудал нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжоор зохицуулагдаж байна. Хуулийн 26.1 дүгээр зүйлд ХАБЭА-н арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг "үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас зарцуулах хөрөнгө,..." -өөс бүрдэх талаар заасан хэдий ч сургалт, сурталчилгааны үйл ажиллагаагаар хязгаарлагдаж байна.
- h) **Бичил, жижиг, дунд бизнес, албан бус эдийн засгийн ХАБЭМ-ийн нөхцөлийг дэвшилттэйгээр сайжруулах талаар хууль тогтоомжид ямар нэг зохицуулалтгүй.** Үндэсний хэмжээнд ХАБЭМ-ийн бодлогын хэрэгжилтийг голлон хариуцаж ажиллах мэргэжлийн түвшний байгууллага нь хуулийн 22.1.9-д заасан мэргэжлээс шалтгаалсан өвчин, хөдөлмөрийн нөхцөл хариуцсан байгууллагаар хязгаарлагдаж байна. Уг байгууллагын үйл ажиллагаа нь МШӨ-өөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ба ҮОХХ-ын асуудлыг төдийлөн хамрахгүй байна.

ХАБЭА-н тухай хуулийн 25 дугаар зүйл, Засаг захиргааны нэгжийн түвшинд ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны чиг, үүрэг

Хуулийн 25 дугаар зүйлд аймаг, сум, нийслэл, дүүрэг, хорооны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтны чиг үүргийг тодорхойлсон нь засаг захиргааны нэгжийн түвшинд ҮОМШӨ-ний урьдчилан сэргийлэлтийг хэрэгжүүлэх, статистик, мэдээллийн сан бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой.

ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан нь ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжлийн байгууллагатай ямар харилцаатай ажиллах талаар хуульд зохицуулагдаагүй.

Орхон, Дархан-Уул, Өмнөговь, Дундговь зэрэг уул уурхай, үйлдвэрлэл төвлөрсөн, эрсдэлтэй ажлын байр ихтэй засаг захиргааны нэгжид ХАБЭМ-ийн тусламж үйлчилгээ үзүүлэх дэд бүтцийг дэмжих зохицуулалт шаардлагатай эсэхийг тодорхойлох нь зүйтэй.

ХАБЭА-н тухай хуулийн 26 дугаар зүйл, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн санхүүжилт

Хуулийн 26 дугаар зүйл ХАБЭА-н бодлого боловсруулах, хэрэгжилтийг хангах, ажлын байрын түвшинд хэрэгжих арга хэмжээний санхүүжилтийг тодорхойлсон. ҮОМШӨ-ний даатгалын асуудалтай холбоотойгоор нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж ХАБЭА-н санхүүжилтийг зохицуулахад оролцож байна.

Хуулийн 26.1 дүгээр зүйлийн дагуу ХАБЭА-н арга хэмжээг төсөв, байгууллага, иргэний хандив, зээл, тусламж, ҮОМШӨ-ний даатгалын сангаар санхүүжүүлэх зохицуулалттай байна. Үүнээс улсын төсөв болон ҮОМШӨ-ний даатгалын сан тогтвортой санхүүжилтийн эх үүсвэр ба бусад нь тогтмол бус.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 13.2 дугаар зүйлд “Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төлбөр нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн тухайн жилийн шимтгэлийн орлогын 2 хувиас багагүй байна” гэж заасан. Гэвч хуульд уг сангаас зарцуулах зардлын санхүүжилт нь:

- Даатгалын үйл ажиллагаа, хууль тогтоомжтой холбоотой мэдээлэл, зөвлөгөө өгөх сургалт, сурталчилгаа;
- Даатгуулагч, ажил олгогчид зориулсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт;
- ХАБЭА-н арга хэмжээ авч хэрэгжүүлсэн, шинэ техник, технологи, инновац нэвтрүүлсэн ажил олгогчийн шилдэг туршлага, ололт, амжилтыг олон нийтэд сурталчлах;
- ҮОМШӨ-ний чиглэлээр хийх тандалт судалгаа, эрсдэлийн болон хяналт шинжилгээ, үнэлгээнд зарцуулагдахаар хязгаарлагдсан.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18.1 дүгээр зүйлд “ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийг ажлын байрны эрсдэлийн төвшнөөс хамааруулан цалин хөлсний орлогын 0.5, 1.5, 2.5 хувиар тооцох зохицуулалттай. Уг зохицуулалт нь ХАБЭМ-ийн бодит эрсдэлийн түвшин, ҮОМШӨ-ний тохиолдолд суурилагагүй бөгөөд ажил мэргэжлийн төрлөөс хамаарч эрсдэлийн түвшинг шууд тооцож байна.

Хуулийн 28.4 дүгээр зүйлд "Эрсдэлийн түвшин их ажлын байранд ажиллаж байгаа ажилтныг амь нас, эрүүл мэндийн даатгалд тухайн ажилтны 36 ба түүнээс дээш сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээгээр заавал даатгуулна. Ажилтны амь нас, эрүүл мэндийн даатгалын хураамжийг ажил олгогч хариуцах бөгөөд ажилтныг амь нас, эрүүл мэндийн даатгалд даатгуулсан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 125 дугаар зүйлд заасан нөхөн төлбөрийг ажил олгогч олгохгүй байх үндэслэл болохгүй", 26.5.7 дугаар зүйлд "ажилтныг амь нас, эрүүл мэндийн даатгалд хамруулах" тухай заалтын дагуу ажил олгогч нар хувийн даатгалын компаниар ажилтнаа даатгуулдаг. Гэвч уг нэмэлт даатгалаас ҮОМШӨ-өөс урьдчилан сэргийлэх зориулалтаар ажил олгогч, ажилтанд үзүүлэх даатгалын үйлчилгээ, санхүүжилт нь тодорхой зохицуулалтгүй байна.

Хуулийн 26.4 дүгээр зүйлийн дагуу ажил олгогч нь өөрийн байгууллагад хэрэгжүүлэх ХАБЭА-н үйл ажиллагааг бүрэн санхүүжүүлэх тогтолцоотой. Хуулийн 26.2-д "төсвийн байгууллага нь тухайн жилийн батлагдсан төсвийн 0.5 хувиас, аж ахуйн нэгж, байгууллага эрсдэлийн түвшнээс хамааран үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тус тус зарцуулна" гэж заасан.

Аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд ХАБ-ын эрсдэлийн үнэлгээ, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ, ажлын байрны эрүүл ахуйн хэмжилт мониторинг, ажилтны эрүүл мэндийн үзлэг, ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, сургалт зэрэг олон үйл ажиллагаанд зардал төлөвлөх шаардлагатай болдог. Хуулийн 26.2 дугаар зүйлийн хэрэгжилтийн хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагуудын ХАБЭА-н санхүүжилтийг ерөнхийд нь төлөвлөдөг тул хуулийн дагуу зайлшгүй хэрэгжүүлэх зарим үйл ажиллагаандаа зардал төлөвлөхгүй байх асуудал түгээмэл тохиолдож байна.

Хуулийн 18.1, 28.4 дугаар зүйлийн дагуу ажил олгогч ҮОМШӨ-ний даатгал, амь нас, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлж байгаа хэдий ч урьдчилан сэргийлэлтийн үйл ажиллагаанд зориулсан санхүүгийн дэмжлэг даатгалаас авах зохицуулалт байхгүй. Осол, өвчлөлийн тохиолдолд даатгуулагчид тэтгэвэр, тэтгэмж олгох зохицуулалт хэрэгжиж байна.

Хуульд төрөөс хэрэгжүүлж буй үндэсний хэмжээний ХАБЭА-н бодлого, хөтөлбөрийн санхүүжилтийг тодорхой зохицуулаагүй тул ихэнхдээ гадаадын хандив, тусламжаар эдгээр арга хэмжээг санхүүжүүлж байна. ҮОМШӨ-өөс урьдчилан сэргийлэх зорилготой ХАБЭА-н стандарт, техникийн зохицуулалтыг боловсруулах, шинэчлэх, түүний хэрэглээг дэмжих, аж ахуйн нэгжүүдэд аюулгүй ажиллагааны эрсдэлийн үнэлгээ, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт оношлон илрүүлж, хөдөлмөрийн чадвар алдахаас урьдчилан сэргийлэх зэрэгт ҮОМШӨ-ний даатгалын санхүүжилт ашиглагдахгүй байна.

ХАБЭА-н тухай хуулийн 27, 28 дугаар зүйл, Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зохион байгуулалт ба ажил олгогчийн эрх, үүрэг

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль албан салбарын ажил олгогч нарт зориулагдсан зохицуулалттай. Ялангуяа дунд, том хэмжээтэй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд ХАБЭА-н шаардлагыг хангуулахад чиглэсэн ба албан бус салбар, бичил, жижиг бизнест зориулагдсан зохицуулалт байхгүй байна.

Хуулийн 27 дугаар зүйл аж ахуйн, нэгж байгууллагын ХАБЭА-н зохион байгуулалтад тавигдах шаардлагыг, 28 дугаар зүйлээр ХАБЭА-н асуудлаар ажил олгогчийн эрх, үүргийг тодорхойлсон. Ажилтнаа эрүүл, аюулгүй ажлын байраар хангах, үүний тулд ХАБЭА-н үйл ажиллагааг үр нөлөөтэй зохион байгуулж, удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх нь ажил олгогчийн үүрэг юм. Тиймээс хуулийн 27 болон 28 дугаар бүлгийн зохицуулалтууд хооронд харилцан уялдаатай байх шаардлагатай юм.

ОУХБ-аас гаргасан ХАБЭМ-ийн удирдлагын тогтолцоо, ХАБЭМ-ийн чанарын удирдлагын тогтолцооны ISO 45001 стандартад аж ахуйн нэгж, байгууллагын ХЭМАБ-ийн удирдлагын тогтолцоо нь дараах үндсэн бүрэлдэхүүнтэй байхыг зөвлөдөг^{34 35}.

Үүнд:

1. Бодлого, дүрэм, журам боловсруулж, мөрдөх, тасралтгүй сайруулах;
2. Ажил олгогчийн манлайлал, ажилтны оролцоо;
3. ХАБЭМ-ийн үйл ажиллагааны төлөвлөлт;
4. Ажлын байранд дахь аюулыг таньж илрүүлэх, эрсдэлийг үнэлэх, арилгаж, бууруулах хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэх;
5. Хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалт, мониторинг;
6. ҮОМШӨ-ний тохиолдол гарсан үед хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, дүн шинжилгээ;
7. Хууль тогтоомжийн нийцлийг хангах;
8. ХЭМАБ-ийн гүйцэтгэлийн үнэлгээ, тасралтгүй сайжруулалт;
9. Онцгой үеийн бэлэн байдал ба хариу арга хэмжээ;
10. ХЭМАБ-ийн сургалт, чадамжийн үнэлгээ;
11. Удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх шаардлагатай мэргэжилтэн, санхүүжилт, материаллаг нөөц;
12. Баримт бичиг хөтлөлт багтана.

ХАБЭА-н удирдлага тогтолцооны шаардлага нь албан бус салбар, бичил бизнес илүү энгийн байдлаар хэрэгжих нь зүйтэй. Аж ахуйн нэгж, байгууллагын ХАБЭА-н удирдлагын тогтолцоонд тавигдах ерөнхий шаардлагыг хуулийн 27.2, 27.3 дугаар зүйлд ХАБЭА-н асуудал хариуцсан бүтэц, ажилтан, зөвлөлийн чиг үүрэг гэсэн агуулгаар дараах бүрэлдэхүүнтэйгээр тодорхойлсон. Үүнд:

- 27.3.1. ХАБЭА-н бодлого, төлөвлөгөөг боловсруулж, шаардлагатай дүрэм, журмыг шинэчлэн баталж хэрэгжүүлэх;

³⁴ ILO, Occupational Safety and Health Management System, 2016

³⁵ ISO 45001:2018, Occupational Safety and Health Management Systems- Requirements with Guidance for Use

- 27.3.2. ХАБЭА-н удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, хэрэгжилт, үр дүнд хяналт тавих;
- 27.3.3. ХАБЭА-н хууль тогтоомжийн шаардлага, стандарт, салбарын болон аж ахуйн нэгж, байгууллагын мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журмын хэрэгжилтийн байдалд үзлэг, шалгалт хийлгэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах;
- 27.3.4. ХАБЭА-н сургалтын хэрэгцээг тодорхойлох, төлөвлөх, хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах, үр дүнг тооцох, тайлагнах;
- 27.3.5. Ажлын нөхцөл, мэргэжлийн онцлогт тохирсон тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг ажилтанд олгох, норм, чанар, зохистой хэрэглээнд хяналт тавих;
- 27.3.6. ХАБЭА-н хууль тогтоомжийн шаардлага, стандарт, дүрэм, журмыг зөрчсөн албан тушаалтан, ажилтанд хариуцлага хүлээлгэх саналаа ажил олгогчид гаргах;
- 27.3.7. хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

Хуулийн 28.1.4, 28.1.5 дугаар зүйлд ажил олгогчийн ажлын байранд эрсдэлийн үнэлгээ хийх, ажлын байранд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх үүргийг тодорхойлсон. Гэхдээ эрсдэлийн үнэлгээ, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээгээр ажилтны эрүүл мэнд, амь насанд аюул учруулах нөхцөл байдал үүссэн нь тогтоогдсон бол түүнийг эрх бүхий байгууллагад мэдээлэх, залруулах арга хэмжээг хэрэгжүүлэх асуудал зохицуулалтгүй байна.

Ажлын байрны агаар дахь хорт бодисыг хэмжихэд тавих ерөнхий шаардлага, зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 4990:2023 стандартын 3.17-д ажилтны амь насанд эгшин зуур аюул учруулах, эрүүл мэндэд эргэшгүй сөрөг нөлөө үүсгэх эсвэл аюултай орчноос өөрийгөө аврах, чадварыг нь алдагдуулж хурц хордлогод хүргэх агаар дахь тоос, хорт бодисын өртөлтийн түвшинг **амь нас, эрүүл мэндэд нэн аюултай өртөлт** гэж тодорхойлсон. Түүнчлэн ажилтан өдөр бүр өртөхөд эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлж МШӨ үүсгэх ажлын байрны сөрөг хүчин зүйлсийн өртөлтийн **зөвшөөрөгдөх дээд хэмжээг** хөдөлмөрийн эрүүл ахуйн стандартаар тогтоосон. Эрсдэлийн үнэлгээ, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээгээр ажилтан аюултай болон зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн аюултай хүчин зүйлсэд өртөж байгаа нь тогтоогдвол, ажилтны эрүүл мэндийг хамгаалах зорилгоор ажил зогсоох, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, үр дүнг нь эрх бүхий (хяналтын) байгууллагад мэдээлэх зохицуулалт шаардлагатай.

Хуульд заасан аж ахуйн нэгж, байгууллагын ХАБЭА-н зохион байгуулалтад тавигдах шаардлагыг ХАБЭА-н талаарх ажил олгогчийн эрх, үүрэгтэй уялдуулах, олон улсын сайн туршлагатай харьцуулан дахин хянах нь зүйтэй.

Хуулийн 27.4 дүгээр зүйлд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтнаар инженер, техникийн болон эрүүл ахуйн боловсролтой, мэргэшсэн хүнийг ажиллуулна” гэснийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн болгож залруулах нь зүйтэй;

ХАБЭА-н тухай хуулийн 29, 30 дугаар зүйл, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлого, тэдгээрийг судалж бүртгэх

Хуулийн 29 дүгээр зүйлээр ҮОХХ-ийн үед авах арга хэмжээ, бүртгэл, мэдээлэлтэй холбоотой харилцааг зохицуулсан. Хуульд үйлдвэрлэлийн осол болон хурц хордлогын тохиолдлыг ижил зохицуулалтаар судлах, бүртгэх, мэдээлэхээр заасан. ҮОХХ-ыг судлах, бүртгэх, мэдээлэх асуудал Засгийн газрын тогтоолоор нарийвчлан зохицуулагдаж байна.

Химийн бодисоор үүсгэгдсэн хордлого болон механик хүчин зүйлээр үүсгэгдсэн ослын шинж чанар нь өөр тул осол, хурц хордлогын шалтгааныг судлан бүртгэх, мэдээлэх үйл явц нь ялгаатай байх шаардлага тулгарч байна.

Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бүртгэх, мэдээлэх асуудлыг хуульд тодорхой заагаагүй бөгөөд эрүүл мэнд болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтарсан тушаалаар батлахаар зохицуулсан.

МШӨ-ийг илрүүлэх, оношлох, бүртгэх, мэдээлэх, статистик сан үүсгэхэд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хүлээх үүрэг, оролцоог хуульд тодорхойлоогүй байна. Үүнтэй холбоотой практикт эрүүл мэндийн байгууллага дээр хийгдэж буй ажилтны эрүүл мэндийн үзлэгээр МШӨ-ийг илрүүлэх, оношлох үйл ажиллагаа сул, МШӨ-ний статистик бүртгэл хөгжөөгүй байна.

Хуулийн 30.1 дүгээр зүйлд “Мэргэжлээс шалтгаалах өвчний жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална” гэж заасны дагуу ХНХС, ЭМС-ын 2023 оны А/152, А/388 дугаар тушаалаар баталсан МШӨ-ний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг тогтоосон жагсаалт мөрдөгдөж байна. Энэ жагсаалт нь МШӨ-өөр нэгэнт хөдөлмөрийн чадвар алдсан ажилтанд нийгмийн даатгалаас тэтгэвэр олгоход зориулагдсан. Харин хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэгээр эрт илрүүлж оношилсон МШӨ-ний тохиолдлыг бүртгэх, улмаар хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэхэд уг жагсаалтыг ашиглах боломжгүй байна.

ХАБЭА-н тухай хуулийн 31 дүгээр зүйл, Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ

Хуулийн 28.1.5 дугаар зүйлд ажил олгогчид ажлын байрандаа хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх үүрэг хүлээлгэсэн. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ нь ажилтан ажлын байрандаа өртдөг аюултай хүчин зүйлсийн өртөлтийг хэмжсэний үндсэн дээр мэргэжлээс шалтгаалсан өвчний эрсдэлийг үнэлж, хөдөлмөрийн нөхцөлийн ангиллыг тодорхойлдог хөндлөнгийн үнэлгээ юм. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ нь Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтэд ашиглагдаж ажилтны ажлын цаг, цалин хөлсний нэмэгдэл, ээлжийн амралтын хугацаа, тэтгэвэрт гарах насыг тодорхойлоход ашиглагдаж байна.

Хуулийн 31.1 дүгээр зүйлд “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг стандартын асуудал эрхэлсэн байгууллагын итгэмжлэл бүхий мэргэжлийн байгууллага батлагдсан журмын дагуу хийнэ” гэж заасан. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийн хүрээнд стандартын асуудал эрхэлсэн байгууллага

итгэмжлэлийн асуудал хариуцахгүй болсон ба бие даасан итгэмжлэлийн асуудал эрхэлсэн байгууллага байгуулагдсан.

Хуулийн 31.2 дугаар зүйлд “Ажил олгогч нь ажлын байр шинээр бий болгох болон тухайн ажлын байрны үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, нөхцөл өөрчлөгдөх бүрд нь, химийн хорт болон аюултай бодис агуулсан түүхий эд, материал ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа бол жилд нэгээс доошгүй удаа ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг тус тус хийлгэнэ” гэж заасан.

2021 онд хийгдсэн тооллогоор 180 мянган аж ахуйн нэгж, байгууллага тоологдсон. Эдгээрийн 10 мянга нь эрчим хүч, уул уурхай, барилга зэрэг эрсдэл өндөртэй үйл ажиллагаа явуулж байна. 2023 оны байдлаар 210 аж ахуйн нэгж, байгууллага хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээнд хамрагдсан байна³⁶. Түүнчлэн ХАБЭМТ-ийн мэдээллээр сүүлийн жилүүдэд МШӨ-ний шинэ тохиолдлын тоо нэмэгдэх хандлагатай байна. 2010-2012 онд жилд дунджаар 45 шинэ тохиолдол бүртгэгдэж байсан бол 2021-2023 онд жилд дунджаар 78 болж нэмэгдсэн³⁷. Эдгээр тоо баримт нь ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний талаарх хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгож хэрэгжилтийг хангахад анхаарах шаардлагатай илтгэж байна.

ХАБЭА-н тухай хуулийн 32, 33, 34, 35 дугаар зүйл, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт, ААНБ-ын дотоод хяналт

Хуулийн 32.1 дүгээр зүйлд зааснаар ХАБЭА-н хууль тогтоомжийн хяналтыг Улсын их хурал, Засгийн газар, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан, Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга, хяналтын алба, Ажилтны төлөөллийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага хэрэгжүүлэх зохицуулалттай.

2022 онд Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт орж мэргэжлийн хяналтын байгууллагын хэрэгжүүлж байсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналт хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага руу шилжсэн.

Хуулийн 33.1 дүгээр зүйлд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих төрийн захиргааны хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу эрх олгосон хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч гүйцэтгэнэ” гэж заасан.

Хөдөлмөрийн тухай хуулийн 162.1 дүгээр зүйлд “хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч хөдөлмөрийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг хэрэгжүүлнэ” гэж заасан.

Өөрөөр хэлбэл хөдөлмөрийн хяналтын байцаагч Хөдөлмөрийн хуулийн хэрэгжилтэд хяналт тавихаас гадна Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 33.2, 33.4 дүгээр зүйлд заасан хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналтыг

³⁶ А.Цэнгэлмаа, Хөдөлмөрийн эрүүл ахуйн 2024 бага хурал:Хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ, Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ, 2024 он

³⁷ Д.Нарансүх, Хөдөлмөрийн эрүүл ахуйн 2024 бага хурал: Мэргэжлээс шалтгаалсан өвчний бүртгэл, мэдээллийн тогтолцоо илтгэл, 2024 он

хавсран гүйцэтгэж байна. Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын байцаагч Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 33.3, 33.4 дүгээр заасан хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтыг гүйцэтгэж байна.

Хуульд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих төрийн хяналтыг хяналтын байцаагчийн бүрэн эрхийн хүрээгээр тодорхойлсон ба тогтолцооны хэлбэрээр тодорхойлоогүй байна.

2022 оноос өмнө мэргэжлийн хяналтын байгууллагаар хэрэгжиж байсан төрийн хяналт шалгалтын нэгдсэн тогтолцоо салбар яамдад шилжсэн ч ХАБЭА-н хяналтын асуудлыг тогтолцооны түвшинд зохицуулсан хууль эрх зүйн зохицуулалт бий болоогүй байна.

Хуулийн 35 дугаар зүйлд зохицуулсан аж ахуйн нэгж, байгууллагын ХАБЭА-н дотоод хяналтын асуудал нь хуулийн 27 дугаар зүйлд заасан ХАБЭА-н зохион байгуулалт, удирдлагын тогтолцоонд хамаарах асуудал юм.

35.1 дүгээр зүйлд “Ажил олгогч нь үйлдвэрлэлийн цех, тасаг, хэсэг, ажлын байр бүрд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, нийтлэг шаардлага, стандартын хэрэгжилт, ажлын байран дахь эрсдэлийн үнэлгээний дагуу авагдсан арга хэмжээний биелэлтэд дотоодын хяналт тавина” гэж заасан. Ажлын байранд ажилтнуудад осол, өвчлөлийн эрсдэл үүсгэх эрүүл мэндийн болон аюулгүй ажиллагааны хүчин зүйлсийг илрүүлэх, тогтмол хэмжиж хяналт тавих, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний дагуу хэрэгжих шаардлагатай арга хэмжээнд хяналт тавих дотоод хяналтын асуудлууд зохицуулагдаагүй байна.

Хуулийн 28.1.4 дугаар зүйлд ажил олгогчийн үүрэгт заасан “ажлын байранд учирч болзошгүй аюулыг илрүүлэх, тогтоох, үнэлэх, бууруулах, арилгах зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийх” үйл ажиллагаа байгууллагын дотоод хяналтад хамааралтай асуудал юм.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжтой холбоотой тулгамдсан асуудлын хүрээнд дараах талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөхөөр байна.

Хүснэгт 9. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдүүд

№	Эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж буй бүлэг	Тэдгээр эрх, хууль ёсны ашиг сонирхолд хэрхэн нөлөөлөх талаар
1	Ажиллагсад	Үндсэн хуулиар олгогдсон хөдөлмөрийн аятай таатай нөхцөлөөр хангагдах эрхээ эдэлж чадахгүй байна. Үйлдвэрлэлийн осолд өртөх, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр өвчлөх эрсдэлд өртөж байна. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх мэргэжлийн тусламж, үйлчилгээг хангалттай хүртэж чадахгүй байна.
2	Албан бус, бичил, жижиг бизнес салбарын ажиллагсад	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлыг зохицуулсан хуулийн зохицуулалт, дэмжлэг байхгүй тул Үндсэн хуулиар олгогдсон хөдөлмөрийн аятай таатай нөхцөлөөр хангагдах эрхээ эдэлж чадахгүй байна.
3	Ажил олгогчид	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг төлдөг ч хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэлтийн тусламж үйлчилгээ авч чадахгүй байна.

4	Төрийн байгууллага	<p>Ажилтнуудаа үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс хамгаалахад чиглэсэн мэргэжлийн тусламж, үйлчилгээг хангалттай авч чадахгүй байгаа нь осол, өвчлөлийн эрсдэлийг нэмэгдүүлж байна.</p> <p>Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үндэсний тогтолцоо нь төрийн хяналт шалгалт, даатгалын тогтолцоотой уялдаа муутай, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх дэд бүтэц сул хөгжсөн нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.</p>
---	--------------------	--

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6-д заасан аргачлалын дагуу энэхүү хуулийн хэрэгжилтийн үнэлгээг хийж дараах асуудлыг зөвлөмж болгож байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг ОУХБ-ын 155, 176, 167, 187, 161 дүгээр конвенцод нийцүүлэх;
2. ХАБЭМ-ийн үндэсний тогтолцоог зохих агуулга, хамрах хүрээг дахин шинэчлэн тодорхойлж, бүрэлдэхүүнд нь улсын хэмжээнд, аймаг, бүсийн түвшинд ХАБЭМ-ийн бодлогын хэрэгжилтийг хариуцах мэргэжлийн байгууллага болон хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний байгууллага, хөдөлмөрийн эрүүл ахуйн лаборатори, хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг, тандалт хийдэг эмнэлэг, ХАБЭМ-ийн мэргэжлийн үйлчилгээний байгууллага, ХАБЭМ-ийн мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургууль, ХАБЭА-н ажилтан бэлтгэх сургалтын төв зэргийг багтааж, чиг үүрэг, хариуцлагыг тодорхойлох;
3. ХАБЭМ-н арга хэмжээний санхүүжилтийн талаарх зохицуулалтыг тодорхой болгож бусад холбогдох хуулийн шинэчлэлтэй нийцүүлэх;
4. Ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндэд тавигдах шаардлагыг тодорхой болгож ил болон далд уурхай, хязгаарлагдмал орчин, хавдар үүсгэдэг, үр удам, нөхөн үржихүйд нөлөөлдөг хорт бодистой харьцан ажилладаг, биологийн, эргономикийн, нийгэм-сэтгэл зүйн хүчин зүйлс зэрэгт тавигдах шаардлагуудыг шинээр зохицуулах;
5. Аж ахуйн нэгж, байгууллагын ХАБЭА-н зохион байгуулалт болон ажил олгогчийн эрх үүргийн талаарх зохицуулалтыг харилцан уялдаатай болгох, зохион байгуулалтад тавигдах шаардлагыг шинэчлэн сайжруулах;
6. Албан бус салбар, бичил, жижиг бизнест ҮОМШӨ-ний урьдчилан сэргийлэлтийг хэрэгжүүлэх зохицуулалтыг бий болгох;
7. Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний үр дүнг ХАБЭМ-ийн асуудал хариуцсан байгууллагад мэдээлэх, эрсдэл, аюулыг арилгах арга хэмжээний үр дүнг эргэн мэдээлэх байдлаар ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах механизмыг тодорхой болгох;
8. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, осолд дөхсөн тохиолдлуудыг тусад нь бүртгэх, шалтгааныг судлан тогтоох, мэдээлэх байдлаар ҮОХХ, МШӨ-ний бүртгэл, мэдээлэл, статистикийг боловсронгуй болгох;

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт заасны дагуу энэхүү судалгааны үр дүн, зөвлөмж, дүгнэлтэд үндэслэн Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг шинэчлэн найруулах нь зүйтэй гэж үзэж байна.

---000---

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Хууль,эрх зүйн акт

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 оны 5 дугаар сарын 22-ны өдөр
3. Хөдөлмөрийн тухай хууль, 2021 оны 7 дугаар сарын 02-ны өдөр
4. Нийгмийн даатгалын ерөнхий хууль, 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр
5. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль, 2024 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр
6. Эрүүл ахуйн тухай хууль, 2016 оны 2 дугаар сарын 04-ний өдөр
7. Стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, 2017 он
8. ХНХЯ, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2021 он
9. ХАБЭА-н үндэсний хорооны 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 01 дүгээр тогтоол Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл олгох зөвлөмж
10. ХНХС-ын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/155 Журам шинэчлэн батлах тухай-Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам
11. ЭМС, ХНХС-ын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/441, А/192 Даатгуулагч хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалт батлах тухай
12. ХНХС-ын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/221 Жагсаалт, журам батлах тухай Газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт, тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох "Газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтыг хэрэглэх журам"
13. ЭМС, ХНХС-ын 2024 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн А/293, А/133 Заавар батлах тухай, Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний заавар
14. ХНХС, ЭМС-ын 2023 оны А/152, А/388 дугаар тушаалаар баталсан МШӨ-ний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг тогтоосон жагсаалт
15. МУ-ын засгийн газрын тогтоол, 2015 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн 269 дүгээр тогтоол, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм
16. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн А/130 дугаар тушаалаар батлагдсан "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын жишиг хөтөлбөр"
17. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо-Шаардлага, хэрэглэх заавар MNS ISO 45001:2018

18. ХС-ын 2015 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/234 дугаар тушаалаар батлагдсан Мэргэжлээс шалтгаалах өвчнийг бүртгэх, мэдээлэх журам
19. ISO 45001:2018, Occupational Safety and Health Management Systems- Requirements with Guidance for Use

Олон улсын гэрээ, конвенц

20. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 1981 оны 155 дугаар конвенц
21. Уул уурхай дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 1996 оны 176 дугаар конвенц
22. Барилгын салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 1998 оны 167 дугаар конвенц

Судалгааны тайлан, эмхэтгэл

23. Монгол улс дахь Мэргэжлээс шалтгаалсан өвчний төлөв байдал, ХАБЭМТ, 2025 он
24. Монгол Улсын Хөдөлмөр зах зээлийн дунд хугацааны эрэлт, нийлүүлэлтийн таамаглал, 2024 он
25. Нийгмийн даатгалын бүртгэлийн мэдээлэл, 2024 он
26. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын бүртгэл мэдээллийн систем,
27. ХНХЯ, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний нийгэм, эдийн засгийн нөлөөллийн судалгаа, 2020 он
28. ХНХЯ, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг дэмжих тогтолцооны тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 187 дугаар конвенцыг Монгол Улсын хууль тогтоомжтой харьцуулсан үнэлгээ, 2023 он
29. Аж ахуйн нэгж байгууллагууд дахь хөдөлмөрийн эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдал, ХАБЭМТ, 2025 он
30. ILO, Occupational Safety and Health Management System, 2016
31. German Social Accident Insurance, Guidelines for Occupational Medical Examinations. Prophylaxis in Occupational Medicine, 2007
32. Damiran Naransukh, Frank AL. Mongolia: Failure of Total Banning of Asbestos. Ann Glob Health. 2023 Aug 2;89(1):50. doi: 10.5334/aogh.4035. PMID: 37547483; PMCID: PMC10402788.

Эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл

33. Э.Эрдэнэчимэг, Хөдөлмөрийн эрүүл мэндийн мэргэжлийн хүний нөөц, эрдэм шинжилгээ илтгэл, 2024 он
34. А.Цэнгэлмаа, Хөдөлмөрийн эрүүл ахуйн 2024 бага хурал: Хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ, Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ, 2024 он
35. Д.Нарансүх, Хөдөлмөрийн эрүүл ахуйн 2024 бага хурал: Мэргэжлээс шалтгаалсан өвчний бүртгэл, мэдээллийн тогтолцоо илтгэл, 2024 он

Веб хуудас

-
36. www.legalinfo.mn
 37. <https://www.gov.mn/>
 38. <https://new.tender.gov.mn/mn/osh/certificate>
 39. <https://ec.europa.eu/eurostat/statistics>
 40. <https://inspection.hudulmur-halamj.gov.mn/>

_____oOo_____

ХУУЛИЙН ТӨСӨЛД ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТ БАТЛАХ ЭРХ ОЛГОСОН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААР

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт “Хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалт, мэргэжлээс шалтгаалсан өвчний жагсаалт болон бүртгэх, мэдээлэх журмыг хөдөлмөрийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.” гэж тусгасан.

Хуулийн төсөлд тусгасан захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27^{1.1} дэх хэсгийн хуулийн тодорхой зүйл, хэсэг, заалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх, тухайн хуулийн зорилго, зорилт, үйлчлэх хүрээнд нийцсэн байх, захиргааны хэм хэмжээний акт батлахад баримтлах тухайлсан зарчмыг тодорхойлсон байх, зорилго, зохицуулах харилцааны хүрээг тодорхой тусгасан байх, захиргааны хэм хэмжээний акт батлах байгууллага, албан тушаалтныг тодорхойлсон, тухайн этгээдийн хуульд заасан чиг үүрэгт хамааралтай байх, хуулиар тогтоосон иргэн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулаагүй байх зэрэг шаардлагыг хангасан болно.

Энэ хуулийн төсөлд тусгасан хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалт, мэргэжлээс шалтгаалсан өвчний жагсаалт болон бүртгэх, мэдээлэх журам батлагдсанаар хуулийн төслийн 47 дугаар зүйл “Хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг, тандалт”, 55 дугаар зүйлийн “Мэргэжлээс шалтгаалсан өвчний бүртгэл, мэдээлэл, түүнтэй холбогдсон хөдөлмөр зохицуулалт”-ыг тус тус хэрэгжүүлэхэд чиглэгдсэн.



**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ**

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛИЙГ
ШИНЭЧЛЭН НАЙРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫН УРЬДЧИЛСАН
ТАНДАЛТ СУДАЛГАА**

УЛААНБААТАР ХОТ

2025 он

Агуулга

УДИРТГАЛ	4
НЭГ. АСУУДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ	5
1.1 Асуудлын мөн чанар, цар хүрээ	5
1.2 Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдүүд	7
1.3 Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл	8
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж.....	8
Хуулийн нэр томъёо	8
Төрөөс баримтлах бодлого	9
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт.....	10
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага.....	11
Эрүүл мэндийн үзлэг	12
Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл.....	14
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон мэргэжлийн сургалт	14
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тогтолцоо.....	15
Засаг захиргааны нэгжийн түвшинд ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны чиг, үүрэг.....	19
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн санхүүжилт.....	20
Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зохион байгуулалт ба ажил олгогчийн эрх, үүрэг.....	21
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлого, тэдгээрийг судалж бүртгэх.....	23
Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ.....	24
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих	25
ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГО	26
2.1 Гол зорилго, зорилт	26
ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАР, ЭРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ	30
ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨ	35
ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ	36
ЗУРГАА. ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА	37
ДОЛОО. ЗӨВЛӨМЖ	43
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	44

ТОВЧИЛСОН ҮГС

ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
МШӨ	Мэргэжлээс шалтгаалсан өвчин
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ҮО	Үйлдвэрлэлийн осол
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ХАБЭМ	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

УДИРТГАЛ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль анх 2008 онд батлагдсан бөгөөд үүнээс өмнө Хөдөлмөрийн тухай хуулийн нэг бүлгээр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)-н талаарх харилцааг зохицуулж байв¹. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль нь ажил, хөдөлмөр эрхлэгч хүнийг ажлын байрны аюултай, хортой хүчин зүйлсээс хамгаалж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин (ҮОМШӨ)-нөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн. Уг хууль хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага, зохион байгуулалт, хяналт, ажил олгогч, ажилтны үүрэг, хариуцлага, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, түүний санхүүжилт зэрэг нийтлэг шаардлагыг тусгасан 9 бүлэг, 37 зүйлтэй².

Монгол Улс Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай 155 дугаар конвенцод нэгдсэн тул Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжоо уг конвенцтой нийцүүлэх үүрэг олон улсад хүлээсэн.

Сүүлийн жилүүдэд Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль (2017 он), Хөдөлмөрийн тухай хууль (2021 он), Төрийн хяналт шалгалтын тухай хууль (2022 он), Нийгмийн даатгалын багц хууль (2023 он), Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль (2024 он) зэрэг хуулиудад шинэчлэгдсэн нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтэд нөлөө үзүүлэх болсон.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад хүний эрүүл мэнд, аюулгүй байдлыг зохицуулах заавал мөрдөх норматив хэмжээг техникийн зохицуулалтаар батлах, стандарт нь сайн дурын үндсэн дээр сонгон хэрэглэх зохицуулалттай болсон³.

Хөдөлмөрийн тухай хуульд “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй”-н асуудлыг олон улсын жишгээр “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд” гэж нэрлэж, ажилтныг хөдөлмөрийн хэвийн нөхцөлөөр хангах ажил олгогчийг үүргийг илүү тодорхой болгосон⁴.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчлэлээр ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийг салбараар нь бус ажлын байрны эрсдэлээс хамаарч ялгаатай тогтоох дэвшил гарсан. Гэвч ҮОМШӨ-ний даатгалын сангаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээг санхүүжүүлэх боломж хязгаарлагдмал хэвээр байна.⁵

2024 онд батлагдсан Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуульд хөдөлмөрийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нийгмийн эрүүл мэндийн тусламж үйл ажиллагаанд хамаарна гэж заасан ч ажилтны эрүүл мэндийн үзлэг, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг оношлох, бүртгэх, мэдээлэх, хөдөлмөрийн чадвар алдалтаас сэргийлэх, ажил мэргэжлийн тохироог үнэлэх зэрэг асуудлын

¹ Хөдөлмөрийн тухай хууль, 1999 оны 5 дугаар сарын 14-ны өдөр

² Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 оны 5 дугаар сарын 22-ны өдөр

³ Стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, 2017 он

⁴ Хөдөлмөрийн тухай хууль, 2021 он

⁵ Нийгмийн даатгалын ерөнхий хууль, 2023

зохицуулалтад дэвшил гараагүй ба энэ арга хэмжээнд эрүүл мэндийн салбарын оролцоо сул байсаар байна.⁶

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа хийв.

НЭГ. АСУУДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ

1.1 Асуудлын мөн чанар, цар хүрээ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй нь ажилтан болон ажил олгогчийн хооронд үүссэн хөдөлмөрийн харилцааны асуудал юм. Хөдөлмөр эрхлэлтийн явцад аюулгүй ажиллагааны шаардлага хангагдаагүйн улмаас ажилтан хүн үйлдвэрлэлийн осолд орж бэртэл гэмтэл авах, цаашлаад амь насаа алдах эрсдэлтэй. Хөдөлмөрийн эрүүл ахуйн шаардлага хангагдаагүй нөхцөлд ажилтан хүн ажилласан тохиолдолд ажлын байрны шалтгаант хордлогод өртөх, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр өвчлөх эрсдэл үүсдэг. Тиймээс ажил хөдөлмөр эрхэлж буй иргэн хүний амь нас, эрүүл мэндийг эрүүл ажлын орчин бий болгох замаар сөрөг хүчин зүйлсээс хамгаалах шаардлагатай.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 4 дүгээрт “Монгол Улсын иргэн ...хөдөлмөрийн таатай нөхцөлөөр хангуулах эрхтэй” гэж заасан⁷. Үндсэн хуулийн энэхүү заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрх зүйн орчин бүрэлдэн тогтсон.

Онолын хувьд бүх төрлийн ажил хөдөлмөр эрхэлж буй хүмүүс ажлын байрны шалтгаант осол, өвчний тодорхой түвшний эрсдэлд өртөж байдаг. Тиймээс ХАБЭА-н талаарх төрийн бодлогыг бүх ажиллах хүчнийг эрүүл, аюулгүй ажиллах нөхцөлөөр хангахад чиглэх нь зүйтэй. 2023 оны 4-р улиралд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын цахим <http://om.inspection.gov.mn> бүртгэлд бүртгэгдсэн 261 ослын тохиолдлын 83 (31.8%) нь санхүү, даатгал, төрийн удирдлага, батлан хамгаалах, нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэнд зэрэг ҮОМШӨ-ний эрсдэл харьцангуй багатайд тооцогддог салбарт бүртгэгджээ.⁸

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн дагуу ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийг ажилтны ажлын байрны эрсдэлийн түвшнээс хамааран 0.5, 1.5, 2.5 хувиар ажил олгогч төлдөг. Нийгмийн даатгалын статистик бүртгэлээр 2024 оны эхний 5 сарын өссөн дүнгээр ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийг 2.5 хувиар төлдөг 224 мянган хүн байгаа нь нийт ажилтнууд(1 сая 285 мянга)-ын 17 хувьтай тэнцэж байна⁹.

ХАБЭА-н салбарт хөдөлмөрийн эрүүл мэндийн асуудал тулгамдсан асуудлын нэг болсон. Өндөр эрсдэлтэй 29,425 аж ахуйн нэгж, байгууллагын 235 (0,8 хувь) нь хуулийн хугацаанд ажлын байрандаа хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэсний

⁶ Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль, 2024

⁷ Монгол Улсын Үндсэн хууль

⁸ Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын бүртгэл мэдээллийн систем, <http://om.inspection.gov.mn>

⁹ Нийгмийн даатгалын бүртгэлийн мэдээлэл, 2024 он

30% нь стандартын шаардлага хангаагүй буюу МШӨ-нөөр өвдөх өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн. Эдгээр салбарын ажилтнуудын 11.3% нь эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх хугацаат үзлэгт хамрагдсан байна.¹⁰

Хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны эрэлт нийлүүлэлтийн таамаглал судалгааны тайланд ажиллах хүчний тоо өнөөгийнхөөс 2035 он гэхэд 19.1 хувиар нэмэгдэх таамаглалыг тооцсон¹¹. Түүнчлэн ҮОМШӨ-ний өндөр эрсдэлтэй уул уурхай, олборлолтын салбарт шаардлагатай ажиллагчдын тоо 2035 онд гэхэд 31.9 хувь (32.5 мянган хүн), боловсруулах үйлдвэрт 34.1 хувь (63.3 мянган хүн), барилгын салбарт 36.6 хувь (55.9 мянган хүн)-иар нэмэгдэх хандлагатай байна. Ийнхүү ҮОМШӨ-ний эрсдэлтэй ажилтнуудын тоо 2035 он хүртэл нэмэгдэх хандлагатай байгаа тул үүнтэй уялдуулан ХАБЭА-н хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага тулгарч байна.

Ажилтан хүн ҮО-д өртөх эсвэл МШӨ-нөөр өвчлөхөд эрүүл мэндээрээ хохирч хөдөлмөрийн чадвар, амь насаа алдах, эд хөрөнгийн хохирол учрахаас гадна тухайн хувь хүн, ажил олгогч болон нийгмийн даатгалын санд зардлын дарамтыг үүсгэдэг. Түүнчлэн МШӨ-нөөр өвчлөх эрсдэлтэй хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллагчид өндөр насны тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр эрт тогтоолгож, нийгмийн даатгалын сангаас гарах зардлыг улам бүр нэмэгдүүлж байна.

Манай улсад ҮОМШӨ-нөөс хүн амын эрүүл мэнд, нийгэм, эдийн засагт үзүүлж буй сөрөг нөлөөллийг судалсан судалгаа хомс байна. Судлаач О.Алтансүх нарын тогтоосноор МШӨ-нөөр хөдөлмөрийн чадвараа алдсан хүмүүс өвчний оношноос хамаарч дунджаар 8.05 жилийг амьдралаасаа алдаж байна¹². Ажилтан хүн ҮОМШӨ-нөөр хөдөлмөрийн чадвараа алдах эсвэл нас барсан тохиолдолд Хөдөлмөрийн хуулийн 125 дугаар зүйлийн дагуу ажил олгогч нөхөн төлбөр төлөх үүрэг хүлээдэг. Дээрх судалгаанд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас МШӨ-нөөр хөдөлмөрийн чадвараа алдсан нэг ажилтанд жилд дунджаар 4.5 сая, нийтдээ 1.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгожээ. 2020 онд ХНХЯ-ны захиалгаар хийгдсэн Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний нийгэм, эдийн засгийн нөлөөллийн судалгааны тайланд дурдсанаар ҮОМШӨ-ний улмаас манай улсын эдийн засагт жилд 127.8 тэрбум төгрөгийн хохирол учирч буйг тодорхойлсон. Үүний 60.1 тэрбум нь ажилтанд учирч буй цалин орлогын алдагдал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардал зэрэг, 19.7 тэрбум нь нөхөн төлбөр, бүтээмжийн алдагдал зэрэг, 37.9 тэрбум нь улсаас гарах нийгмийн даатгал, бусад зардал гэжээ¹³. Түүнчлэн ҮОМШӨ-ний улмаас ажилтны, түүний гэр бүлд учирсан сэтгэл санааны хохирол, амьдралаас алдагдсан жил (нас баралт), амьдралын чанарын алдагдал, алдагдсан боломж зэрэг мөнгөн дүнгээр тооцох боломжгүй хохирлыг тодорхойлоогүй байна.

Эдгээр тоо баримт нь ҮОМШӨ-ний урьдчилан сэргийлэлт манай улсад тулгамдсан асуудал болсныг илтгэж байна. Иймд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн урьдчилан сэргийлэлтийн үр нөлөөг улам сайжруулан боловсронгуй болгож шинэчлэх хэрэгцээ, шаардлага тулгарч байна. Түүнчлэн

¹⁰ ХНХЯ, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2021 он

¹¹ Монгол Улсын Хөдөлмөр зах зээлийн дунд хугацааны эрэлт, нийлүүлэлтийн таамаглал, 2024 он

¹² О.Алтансүх, Анагаах ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл: Монгол Улс дахь Зэсийн хүдэр баяжуулах үйлдвэрийн хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөл, ажиллагсдын мэргэжлээс шалтгаалсан өвчин, түүний дарамтын судалгаа, 2023

¹³ ХНХЯ, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний нийгэм, эдийн засгийн нөлөөллийн судалгаа, 2020 он

хөдөлмөр, нийгмийн даатгал, нийгмийн эрүүл мэндийн хууль тогтоомжийн шинэчлэл, төрийн хяналт шалгалтын тогтолцоонд гарсан өөрчлөлтэй уялдсан нэмэлт өөрчлөлт Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд хангалттай хийгдээгүй байна. Эдгээр нөхцөл байдлаас үүдэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг шинэчлэх хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах асуудал зүй ёсоор тавигдаж байна.

1.2 Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдүүд

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжтой холбоотой тулгамдсан асуудлын хүрээнд дараах талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөхөөр байна.

Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдүүд

Хүснэгт 1

Д/д	Эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж буй бүлэг	Тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхолд хэрхэн нөлөөлөх талаар
1	Ажилтан	<ul style="list-style-type: none"> • Үндсэн хуулиар олгогдсон хөдөлмөрийн аятай таатай нөхцөлөөр хангагдах эрхээ эдэлж чадахгүй байна. • Үйлдвэрлэлийн осолд өртөх, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр өвчлөх эрсдэлд өндөр байна. • Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх мэргэжлийн тусламж, үйлчилгээг хангалттай хүртэж чадахгүй байна.
2	Албан бус, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч	<ul style="list-style-type: none"> • Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлыг зохицуулсан хуулийн зохицуулалт, дэмжлэг байхгүй тул Үндсэн хуулиар олгогдсон хөдөлмөрийн аятай таатай нөхцөлөөр хангагдах эрхээ эдэлж чадахгүй байна.
3	Ажил олгогч	<ul style="list-style-type: none"> • Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэл төлдөг ч хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэлтийн тусламж үйлчилгээ авч чадахгүй байна. • Ажилтнуудаа үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн мэргэжлийн тусламж, үйлчилгээг хангалттай авч чадахгүй байгаа нь осол, өвчлөл үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж байна.
4	Төрийн байгууллага	<ul style="list-style-type: none"> • Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үндэсний тогтолцоо нь төрийн хяналт шалгалт, даатгалын тогтолцоотой уялдаа муутай, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх дэд бүтэц сул хөгжсөн нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

1.3 Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж

Хуулийн 2 дугаар зүйлд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ” гэж заасан. 2008 онд хууль батлагдсанаас хойш ХАБЭА-н харилцааг зохицуулдаг дараах хуулиуд шинээр батлагдаж, шинэчлэн найруулагдсан байна.

Шинээр батлагдсан хууль:

- Эрүүл ахуйн тухай хууль, 2016 он
 - 6 дугаар зүйл. Ажлын байранд тавих эрүүл ахуйн шаардлага
 - 13 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль, 2023 он
 - 5 дугаар зүйл. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, үйл ажиллагааны чиглэл

Шинэчлэн найруулагдсан хууль:

- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай, 2017 он
 - 5 дугаар зүйл. Техникийн зохицуулалтын зорилго
 - 9 дүгээр зүйл. Үндэсний стандарт
 - 13 дугаар зүйл. Тохирлын үнэлгээний зорилго, хамрах хүрээ
 - 15 дугаар зүйл. Тохирлын үнэлгээний байгууллага
- Хөдөлмөрийн тухай хууль, 2021 он
 - Наймдугаар бүлэг. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд
 - Бусад зүйл
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль, 2023 он
 - 3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ
 - 6 дугаар зүйл. Нийгмийн даатгалын төрөл
 - Гуравдугаар бүлэг. Нийгмийн даатгалын шимтгэл
 - Бусад
- Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, 2023 он
 - Бүхэлдээ ҮОМШӨ-ний даатгалын асуудлыг зохицуулсан.

Хуулийн нэр томьёо

Хуулийн 3 дугаар зүйлд 22 нэр томьёоны тодорхойлолт ашиглагдаж байна. Эдгээр нэр томьёоны зарим нь шинжлэх ухаан, мэргэжлийн салбар, олон улсад түгээмэл хэрэглэгддэг тодорхойлолтоос зөрүүтэй байна.

“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” гэхээс илүүтэйгээр “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд” гэсэн нэршил олон улсын конвенц, стандарт, мэргэжлийн ном сурах бичигт ашиглагддаг. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг багтаасан өргөн хүрээний ойлголт юм.

Олон улсын хөдөлмөрийн байгууллага(ОУХБ)-ын 155, 161, 167, 176, 187 дугаар конвенц нь “Occupational Safety and Health” буюу “Хөдөлмөрийн аюулгүй

байдал, эрүүл мэнд” нэртэй.¹⁴ Монгол Улс 1997 онд 155, 2015 онд 167, 2020 онд 176 дугаар конвенцод тус тус нэгдэх үед конвенцын нэрийг Монгол хэл рүү орчуулахдаа “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (Occupational safety and hygiene)” гэж эх нэршлээс нь зөрүүтэй орчуулан хэрэглэж байна. Энэ зөрүүтэй нэршил нь үндэсний хууль тогтоомжид мөн нэгэн адил хэрэглэгдэж ирсэн ба хөдөлмөрийн эрүүл ахуйн асуудалд илүүтэй төвлөрч, ажилтны эрүүл мэндийн үзлэг, тандалт, ажил мэргэжлийн тохироо зэрэг хөдөлмөрийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний асуудлууд орхигдсон байна.¹⁵

ОУХБ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн нэвтэрхий тольд “Хөдөлмөрийн эрүүл ахуй нь ажлын байрнаас үүсэж, ажилтан, ойр орчмын оршин суугчдад нөлөөлж болзошгүй аюултай хүчин зүйлсийг урьдчилан таамаглах, таньж илрүүлэх, хэмжиж үнэлэх, хяналт тавьж бууруулах шинжлэх ухаан” гэж тодорхойлогдсон¹⁶.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ) болон ОУХБ-аас 1950 онд хөдөлмөрийн эрүүл мэндийн зорилгыг “бүх төрлийн ажил хөдөлмөр эрхэлдэг ажилтны бие махбод, сэтгэл зүй, нийгмийн сайн сайхан байдлыг хамгийн дээд хэмжээнд байлгах, дэмжих, хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөр эрхлэлтээс шалтгаалан ажилтны эрүүл мэндэд үүсэж болзошгүй сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх, ажилтны бие махбод, сэтгэл зүйн чадавхад тохирсон ажил хөдөлмөрөөр хангах” гэж тодорхойлсон¹⁷.

Мэргэжлийн ном, олон улсын стандартад бичсэнээр “ажлын байран дахь эрсдэл” гэдэг нь ажилтан ажлын байрны аюултай хүчин зүйлийн өртөлтийн улмаас осолд орох эсвэл өвчлөх магадлал юм¹⁸. Хуульд үүнээс зөрүүтэй тодорхойлсон байна.

“Үйлдвэрлэлийн ажлын байрыг хөдөлмөрийн нөхцөлөөр аттестатчилах” гэсэн нэр томъёо хуульд орсон ямар нэг хууль, дүрэм, журам, стандартад ашиглагдахгүй байна.

2017 онд батлагдсан Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулиар стандартууд нь сонгон хэрэглэх зохицуулалттай болсон ба заавал мөрдөх хэм хэмжээг техникийн зохицуулалтаар тогтоох болсон. Тиймээс хуульд тодорхойлсон “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт” гэсэн нэршлийг дахин найруулах, “техникийн зохицуулалт”-ын тодорхойлолтыг нэмэх шаардлагатай болж байна.

Төрөөс баримтлах бодлого

Хуулийн 5 дугаар зүйлд ХАБЭА-н талаар төрөөс баримтлах бодлого, зарчмыг тодорхойлсон. Монгол Улсын нэгдэн орсон ОУХБ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн 155 дугаар конвенцын “Гишүүн орон үндэсний нөхцөл, дадалд

¹⁴ ОУХБ-ын конвенцын жагсаалт <https://normlex.ilo.org/dyn/normlex/en/f?p=NORMLEXPUB:12000:0::NO::>

¹⁵ ХНХЯ, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг дэмжих тогтолцооны тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 187 дугаар конвенцыг Монгол Улсын хууль тогтоомжтой харьцуулсан үнэлгээ, 2023 он

¹⁶ ОУХБ, ХАБЭМ-ийн нэвтэрхий толь, <https://www.iloencyclopaedia.org/part-iv-66769/occupational-hygiene-47504>

¹⁷ ОУХБ, ХАБЭМ-ийн нэвтэрхий толь, <https://www.iloencyclopaedia.org/part-ii-44366/occupational-health-services>

¹⁸ Д.Нарансүх, Хөдөлмөрийн эрүүл ахуй сурах бичиг, 2022 он

нийцүүлэн ажил олгогч болон ажилчдыг төлөөлөх томоохон байгууллагатай зөвшилцөн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, ажлын орчны асуудлаар харилцан уялдаатай үндэсний бодлогыг боловсруулан хэрэгжүүлж, үе үе хянан үзнэ” гэж заасан.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд үндэсний бодлого гэж тусгайлан тодорхойлоогүй ч 5.1 дүгээр зүйлд заасан “төрөөс баримтлах бодлого, зарчим”-ыг тодорхойлсон.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу ХАБЭА-н Үндэсний хороо тогтмол хуралдаж, ХАБЭА-н талаарх хууль тогтоомж, дүрэм, журам, бусад асуудлыг хуульд заасны дагуу ажилтан, ажил олгогчийн төлөөлөлтэй хэлэлцэж, бодлого боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавихад оролцох боломжийг бүрэн олгох зохицуулалт хэрэгжиж байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт

2024 оны байдлаар Монгол Улсад 140 гаруй ХАБЭМ-ийн стандарт мөрдөгдөж байна. Эдгээр стандартыг төрөл, хэрэглээгээр нь дараах байдлаар ангилж болно.Үүнд:

- ХАБЭА-н нийтлэг асуудал -8
- Хөдөлмөрийн эрүүл ахуйн заавал мөрдөх хэм хэмжээг тогтоосон -24
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны заавал мөрдөх хэм хэмжээг тогтоосон-9
- Хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилт, шинжилгээний аргын -71
- Хөдөлмөрийн аюулгүй байдлын бусад стандарт -20

Хууль тогтоомжийн хэрэгжилтэд төрийн хяналт шалгалтаар хяналт тавихаас гадна ажил олгогч нараас дээрх стандартын хэрэгжүүлсэн байх шаардлага тавьдаг. Ялангуяа хэм хэмжээг тогтоосон 33 стандартыг заавал мөрдсөнөөр ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангагдана.

2017 онд батлагдсан Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 4.1.2 дугаар зүйлд "стандарт" гэж тодорхой хүрээнд хэм хэмжээ бий болгоход чиглэсэн ерөнхий зарчим, үзүүлэлтийг сонирхогч талууд зөвшилцөн боловсруулж баталсан, сонгон хэрэглэх баримт бичгийг; 4.1.3 дугаар зүйлд "техникийн зохицуулалт" гэж бүтээгдэхүүний тодорхойлолт, боловсруулалт, үйлдвэрлэлийн арга, стандарт, техникийн үзүүлэлт болон шаардлагыг эш татаж, эсхүл тэдгээрийн агуулгыг тусгаж эрх бүхий байгууллагаас баталсан заавал дагаж мөрдөх баримт бичгийг хэлнэ гэж тодорхойлсон. Энэ тодорхойлолтын дагуу аж ахуйн нэгж, байгууллагууд ХАБЭА-н стандартыг заавал мөрдөхгүй байж болох нөхцөл үүссэн.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд стандарт, техникийн зохицуулалтын эрх зүйн хэм хэмжээний талаарх нэмэлт өөрчлөлт хийгдээгүй.

Хуулийн 6.2-т заасны дагуу аль нэг салбарын яам стандарт боловсруулах, батлуулах, нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг тухайн салбарын төрийн захиргааны төв байгууллага хариуцах талаар заасан. Яам бодлого боловсруулах түвшний байгууллага тул ХАБЭА-н стандартыг давтамжтай хянах, шинэчлэх, сайжруулах, хүчингүй болгох, шинээр боловсруулах зэрэг хэрэгжилтийн түвшний ажлыг хариуцах боломжгүй байна. Практикт үүнтэй холбоотойгоор стандартын шинэчлэл тогтмол

хийгдэж чадахгүй байгаа бөгөөд ихэнхдээ мэргэжлийн холбоо, аж ахуйн нэгж, байгууллага төсөл, хөтөлбөрийн санаачилгаар стандартын шинэчлэл хийгддэг. Стандарт, хэмжил зүйн газар зөвхөн боловсруулсан стандартын төслийг хүлээн авч техникийн хороогоор хэлэлцүүлж, батлуулах үүрэг хүлээж байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага

Хуулийн 7-13 дугаар бүлгээр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг тогтоосон боловч үүнд практикт тохиолдож буй МШӨ, хурц хордлого, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой дараах шаардлагууд багтаагүй байна. Үүнд:

- Хязгаарлагдмал орчинд тавигдах шаардлага
- Хавдар үүсгэдэг, үр удамд нөлөөлдөг, нөхөн үржихүйд нөлөөлдөг хорт бодист тавигдах шаардлага
- Хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөлд тавигдах шаардлага хамаарна.

Манай улсад ус, цахилгаан хангамж, харилцаа холбооны шугам сүлжээний худаг, зорь зэрэг хязгаарлагдмал орчинтой холбоотой хурц хордлого, үйлдвэрлэлийн ослын улмаас хүний амь нас жил бүр хохирч байна. Тухайлбал 2019 онд Улаанбаатар хотын бохир ус цэвэрлэх байгууламжид гарсан хязгаарлагдмал орчинд гарсан үйлдвэрлэлийн ослын улмаас 4, ус дамжуулах шугам хоолойд гарсан ослын улмаас 2 хүн нас барсан. Үүнийг зохицуулсан ямар нэг хуулийн зохицуулалт, техникийн зохицуулалт, стандартын зохицуулалт Монголд хэрэгжихгүй байхгүй. АНУ, Англи, Австрали, Сингапур зэрэг орнууд хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагааны шаардлагыг заавал мөрдөх эрх зүйн зохицуулалтаар зохицуулах практиктай.

Аливаа химийн бодисыг үйлдвэрлэх, хэрэглэх явцад ажилчид нэн түрүүнд химийн бодисын нөлөөлөлд өртдөг. Түүнчлэн ажилчдын өртөлт эцсийн хэрэглэгчид, ердийн хүн амаас хавьгүй өндөр байдаг. Хавдар үүсгэдэг, үр удам, нөхөн үржихүйд нөлөөлдөг хорт бодист өртөхөд богино хугацаанд ямар нэг шинж тэмдэг илрэхгүй ч урт хугацааны дараа хорт хавдар, үр удамд төрөлхийн гажиг, үргүйдэл үүсгэх зэрэг ноцтой сөрөг үр дагавартай. Тиймээс улс орнууд эдгээр бодисын хэрэглээнд маш болгоомжтой хандаж, тусгай шаардлагыг тогтоодог¹⁹. Тухайлбал Хавдрын судалгааны олон улсын агентлагаас химийн бодисуудыг хүнд хавдар үүсгэх шинж чанараар ангилж, хүний эрүүл мэндийг хамгаалах асуудлыг зөвлөдөг.²⁰

Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 3.1.4.-т "хязгаарласан химийн бодис" гэж зөвхөн зөвшөөрсөн газарт, заасан зориулалт, хэмжээ, технологийн дагуу тодорхой хяналтын дор хэрэглэхийг зөвшөөрсөн химийн хорт ба аюултай бодис, тэдгээрийн нэгдлийг хэлнэ" гэж заасан.²¹ Засгийн газрын 2011 оны 176 дугаар тогтоолоор асбестийг хязгаарласан бодисын жагсаалтад оруулсан. Дулааны цахилгаан станц, галт тэрэгний зүтгүүрийн засварын газар, төмөрлөгийн үйлдвэр зэрэгт асбестийг галд тэсвэртэй, дулаан тусгаарлах материалаар ашигладаг тул ердийн хүн ам гэхээсээ илүүтэй ажилчид өртдөг. Гэвч хуульд заасан "зөвшөөрсөн газарт, заасан зориулалт, хэмжээ, технологийн дагуу тодорхой хяналтын дор

¹⁹ Eurostat Statistics Explained, [https://ec.europa.eu/eurostat/statistics-explained/index.php?title=Glossary:Carcinogenic,_mutagenic_and_reprotoxic_\(CMR\)](https://ec.europa.eu/eurostat/statistics-explained/index.php?title=Glossary:Carcinogenic,_mutagenic_and_reprotoxic_(CMR))

²⁰ Agents Classified by the IARC Monographs, Volumes 1–136, <https://monographs.iarc.who.int/agents-classified-by-the-iarc/>

²¹ Химийн хорт болон аюултай бодис <https://legalinfo.mn/mn/detail/526>

хэрэглэх” зохицуулалт хэрэгжихгүй байгаа нь ажилтнуудын дунд асбестаар үүсгэгдсэн хавдар бүртгэгдсээр байна.²²

Химийн хорт ба аюултай бодисын тухай хуулийн 13 дугаар зүйлээр химийн хорт болон аюултай бодис ашиглахад тавих үндсэн шаардлагыг тогтоож, ажлын байран дахь химийн бодисын хэрэглээ, ХАБЭА-н асуудлыг зохицуулсан байна.

ХАБЭА-н шаардлага нь хүний эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой заавал мөрдөх хэмжээ тул Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу техникийн зохицуулалтаар зохицуулах шаардлагатай. Нөгөө талаас аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг хуулиар нарийвчлан тогтоох нь тохиромжгүй тул ерөнхий шаардлагыг хуульд зааж, нарийвчилсан шаардлагыг техникийн зохицуулалтаар тогтоох нь зүйтэй байна.

Хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөлийн шаардлагыг стандартаар тогтооно гэж заасан хэдий ч ажилтан ажлын байранд зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн тоос, шуугиан, хорт бодист өртөх нь эрүүл ахуйн шаардлага зөрчигдөж, МШӨ-нөөр өвчлөх эрсдэлт нөхцөл үүсдэг. Иймд ажил олгогч нь хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулж, өртөлтийг зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бууруулж, ажилтнаа хамгаалах шаардлагатай. Гэвч одоогийн хуулиар энэхүү зохицуулалт тусгагдаагүй байна.

Эрүүл мэндийн үзлэг

Хуулийн 14 дүгээр зүйлээр ажилтны эрүүл мэндийн үзлэгийн асуудлыг зохицуулж байна. Үндсэн хуулийн 16.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 120.1-д заасны дагуу ажилтны эрүүл мэндийн үзлэг нь ажил хөдөлмөр эрхлэгч иргэн нь ажил хөдөлмөртэй холбоотой өвчнөөр өвчлөх, хөдөлмөрийн чадвар алдахаас урьдчилан сэргийлэхэд чиглэх ёстой. Түүнчлэн ажилтны эрүүл мэндийн байдал нь зарим эрсдэлтэй ажил хөдөлмөр эрхлэхэд хязгаарлалт болдог тул төрөлжсөн мэргэшлийн эмч “ажил мэргэжлийн тохироо”-г үнэлэх зайлшгүй шаардлага тулгардаг.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд ажилтны эрүүл мэндийн үзлэгийн асуудлыг зохицуулахдаа “эрсдэлтэй ажилтнуудад ажил хөдөлмөртэй холбоотой өвчнөөс сэргийлэх, ажил мэргэжлийн тохироог үнэлэх” асуудлыг тодорхой заагаагүй. Үүнтэй холбоотойгоор практикт аж ахуйн нэгжүүд ажилтны эрүүл мэндийн үзлэгийг хөдөлмөрийн нөхцөл, эрсдэлийн түвшнээс хамааран төлөвлөдөггүй, ердийн өвчний илрүүлэг оношилгоо хэлбэрээр зохион байгуулж байна. Энэ нь ажил хөдөлмөртэй холбоотой өвчнийг эрт илрүүлэх, оношлох, хөдөлмөрийн чадвар алдуулахаас урьдчилан сэргийлэхэд үр нөлөөгүй байна.

Хуулийн 14.1-д “Ажил олгогч нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу үйлдвэрлэл, ажил, үйлчилгээтэй холбоотой, зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт ажилтныг хамруулна” гэж заасныг агуулга, нэр томъёоны хувьд сайжруулах шаардлагатай байна.

²² Damiran Naransukh, Frank AL. Mongolia: Failure of Total Banning of Asbestos. Ann Glob Health. 2023 Aug 2;89(1):50. doi: 10.5334/aogh.4035. PMID: 37547483; PMCID: PMC10402788.

“...үйлдвэрлэл, ажил, үйлчилгээтэй холбоотой, зайлшгүй шаардлагатай...” эрүүл мэндийн үзлэг хийхээр зохицуулсан нь ямар салбар, ажил мэргэжил эрхлэх хүмүүст зориулагдсан нь тодорхойгүй байна. Мэргэжлийн сурах бичиг, мэргэжлийн удирдамжид ажил хөдөлмөртэй холбоотой өвчин үүсгэх эрсдэлтэй хөдөлмөрийн нөхцөлтэй, аюулгүй ажиллагааны өндөр эрсдэлтэй ажил хийх хүнийг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, “хөдөлмөрийн нөхцөл нь эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлөх, эрүүл мэндийн байдлаас шалтгаалан ажлын байранд өөрийн болон бусдын аюулгүй байдалд эрсдэл учруулах, бие бялдрын хувьд ажлаа хийж чадах эсэхэд нь ” дүгнэлт гаргах зорилгоор хийнэ гэж заасан байдаг ²³ ²⁴. Гэвч хуулийн заалт энэ агуулгыг тодорхой илэрхийлээгүй байна.

Эрүүл мэндийн салбарт ердийн хүн амын дунд хийгдэж буй үзлэг, эрт илрүүлгээс ялгах, төөрөгдөл үүсгэхгүйн тулд олон улсын жишгээр “Хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг” гэсэн нэр томъёог хэрэглэх нь оновчтой юм. Практикт аж ахуйн нэгж, байгууллага ажилтны эрүүл мэндийн үзлэгийг хөдөлмөрийн нөхцөл, эрсдэлийн түвшнээс хамааран төлөвлөдөггүй ба ердийн өвчний эрт илрүүлэг оношилгоо хэлбэрээр зохион байгуулж байна. Энэ нь ажил хөдөлмөртэй холбоотой өвчнийг эрт илрүүлэх, оношлох, хөдөлмөрийн чадвар алдуулахаас урьдчилан сэргийлэхэд үр нөлөөгүй, цаашлаад Монгол Улсад мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бүртгэх, мэдээлэх, статистик бүртгэл хөгжихөд сөргөөр нөлөөлж байна.

Хуульд шинэ ажилтныг ажилд авахаас өмнө хийх эрүүл мэндийн үзлэгийг “урьдчилсан” гэж нэрлэсэн нь оновчгүй байна. Мэргэжлийн ном сурах бичиг, удирдамжид үүнийг “ажилд орохоос өмнөх эрүүл мэндийн үзлэг” (pre-employment medical examination) гэж нэрлэдэг ²⁵.

Хуулийн 14.4-т заасны дагуу эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үүрэг зөвхөн ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулах журмыг батлахаар хязгаарлагдаж байна. Хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг нь эрүүл мэндийн байгууллагад хийгддэг эмнэлгийн бөгөөд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ тул дараах хуулиудын дагуу эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хамаарах асуудалд харьяалагдаж байна.

- Эрүүл мэндийн тухай хуулийн 13.2. “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа хамаарна”;
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 3.1.1. “эмнэлгийн тусламж, үйлчилгээ” гэж өвчин эмгэг, гэмтэл бэртэл, хүний биеийн үйл ажиллагааны алдагдлыг орчин үеийн болон уламжлалт анагаах ухаанд тулгуурлан оношлох, эмчлэх, сувилах, хөнгөвчлөх, сэргээн засах цогц үйл ажиллагааг”;
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль 5.1. “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь дараах төрөлтэй байна... 5.1.3.хөдөлмөрийн эрүүл мэнд”;

²³ German Social Accident Insurance, Guidelines for Occupational Medical Examinations. Prophylaxis in Occupational Medicine, 2007

²⁴ John Hobson, Julia Smedley, Fitness for Work: The Medical Aspects, 6th edition, 2019

²⁵ German Social Accident Insurance, Guidelines for Occupational Medical Examinations. Prophylaxis in Occupational Medicine, 2007

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд хөдөлмөрийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний асуудлыг эрүүл мэндийн салбарын хууль тогтоомжтой уялдуулаагүйгээс эрүүл мэндийн байгууллагуудад МШӨ-ний үзлэг оношилгоо хийгддэггүй, статистик бүртгэл байхгүй, мэргэжлийн хүний нөөцийн хомсдолд орсон зэрэг асуудлыг үүсгэж байна. Түүнчлэн үйлдвэр, уурхай эмнэлгийн тусгай зөвшөөрөлгүйгээр, хяналтгүй эмнэлгийн үйл ажиллагаа явуулж байна.

Эрсдэлтэй нөхцөлд ажилладаг ажилтнуудад хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг хийснээр мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт илрүүлэх зорилготой. Одоо ХНХС, ЭМС-ын 2023 оны А/152, А/388 дугаар тушаалаар баталсан МШӨ-ний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг тогтоосон жагсаалт мөрдөгдөж байна. Энэ тушаал нь хөдөлмөрийн чадвар нэгэнт алдсан ажилтанд нийгмийн даатгалаас тэтгэвэр олгоход зориулагдсан. Харин хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэгээр илрүүлж оношилсон МШӨ-ний тохиолдлыг бүртгэх, улмаар хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн жагсаалт байхгүй.

Хуульд эрсдэлтэй хөдөлмөрийн нөхцөлд ажилладаг ажилтны эрүүл мэндийн тандалтыг цогцоор авч үзэж, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт илрүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалтаас сэргийлэх, ажилтанд эрүүл мэндийн байдалд тохирсон ажил хөдөлмөр эрхлэх эрхээ эдлэх боломж олгоход чиглэсэн зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл

Хуулийн 15 дугаар зүйлээр ажилтныг ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах асуудлыг зохицуулж байна. Хуулийн үр нөлөөг улам сайжруулахын тулд ажил олгогч ажилтанд ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг олгохоос өмнө ажлын байран дахь осол, өвчин үүсгэж болзошгүй аюулыг арилгах илүү үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагыг тавих нь зүйтэй.

Ажил олгогч ажлын байран дахь аюулыг арилгах эх үүсвэр, орлуулах, агааржуулалт, тусгаарлалт, удирдлага зохион байгуулалт зэрэг дэс дараатай арга хэмжээгээр аюул, эрсдэлийг арилгах, бууруулах боломжийг нэн тэргүүнд анхаарч, хэрэгжүүлэх ёстой. Эдгээр арга хэмжээ нь аюулыг арилгах боломжгүй тохиолдолд эцсийн хамгаалах арга хэмжээний сонголт нь ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл юм.

Ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийн сонголтыг хийхдээ ажлын байран дахь аюултай хүчин зүйлсийн шинж чанар, өртөлтийн түвшин, ажлын орчны нөхцөл, бусад хамгаалах хэрэгслийн хэрэглээ зэргийг харгалзан үзэх шаардлагатай.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон мэргэжлийн сургалт

Хуулийн 17 дугаар зүйлээр “ажил олгогч”, “ажилтан”, “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн” гэсэн 3 түвшинд зориулсан сургалтыг зохицуулж байна. Ажил олгогч, ажилтанд зориулсан сургалтыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмаар нарийвчлан зохицуулах заалт хэрэгжиж байна. ХАБЭА-н мэргэжилтний сургалтыг Боловсролын тухай хууль тогтоомжоор зохицуулах заалттай.

Хуулийн 17.6-д заасан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэнд “хөдөлмөрийн аюулгүй байдлын мэргэжилтэн”, “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжилтэн”, “хөдөлмөрийн эрүүл ахуйч”, “хөдөлмөрийн эрүүл мэнд судлаач эмч”, “хөдөлмөрийн эрүүл мэндийн сувилагч”, “эргономикийн мэргэжилтэн” зэрэг хамаарна. Гэвч хуулийн 27.4-т инженер, техникийн болон эрүүл ахуйн боловсролтой хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан гэсэн нэр томъёог тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл хуульд ХАБЭА-н мэргэжилтэн болон асуудал хариуцсан ажилтан гэсэн хоёр нэршил хэрэглэгдэж байна.

ХНХС-ын 2023 оны А/173 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт явуулах болон шалгалт авах журам”-аар ажил олгогч, ажилтан, ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан, сургагч багш бэлтгэх сургалтын асуудлыг зохицуулж байгаа нь хуулийн 17.1-д заасан “ажил хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтан болон ажил олгогчийн сургалт”-ын асуудлын хүрээнээс хэтэрсэн байна.²⁶

2024 оны 10 дугаар сарын байдлаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн бүртгэж гэрчилгээ олгосон 120 сургалтын төвийг 21,757 хүн 7-14 хоногийн сургалтаар ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтнаар төгсөөд байна²⁷. 2024 оны байдлаар АШУУИС, ШУТИС, Техник технологийн дээд сургууль, Хөдөлмөрийн харилцааны дээд сургуулиудад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжилтэн, Хөдөлмөрийн эрүүл ахуйч, Мэргэжлээс шалтгаалсан өвчний эмч, Эрүүл ахуйч зэрэг мэргэжилтнийг 4 жилийн бакалаврын хөтөлбөрөөр бэлтгэж байна.²⁸

Хуулийн 17.6 болон 27.4-т заасан ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан болон ХАБЭА-н мэргэжилтэн нэршлийг хянаж нягтлах нь сургалт, мэргэжлийн хүний нөөцийн бодлогод ач холбогдолтой байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тогтолцоо

Хуулийн 19.1-д “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцах тогтолцоо нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний харьяа мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллага, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороо, салбар хороо болон аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл, аймаг, сум, нийслэл, дүүрэг, хорооны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, хяналтын байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөл, ажилтнаас бүрдэнэ” гэж тодорхойлсон.

ОУХБ-ын 187 дугаар конвенцод “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний тогтолцоо гэж урьдчилан тогтоосон хугацаанд хүрэх зорилтууд, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний бодлого, хөтөлбөрийн

²⁶ ХНХС-ын 2023 оны А/173 тоот тушаал, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17048054797081>

²⁷ ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны мэдээлэл, <https://new.tender.gov.mn/mn/osh/certificate>

²⁸ Э.Эрдэнэчимэг, Хөдөлмөрийн эрүүл мэндийн мэргэжлийн хүний нөөц, эрдэм шинжилгээ илтгэл, 2024.

хэрэгжилтийн үндсэн суурь тогтолцоог бүрдүүлж буй дэд бүтцийг хэлнэ” гэж тодорхойлсон.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд үндэсний тогтолцоог ХАБЭА-н асуудал хариуцсан байгууллагын тогтолцоо хэлбэрээр тодорхойлсон ба бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшинд хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний хэрэгжилтийн түвшинд мэргэжлээс шалтгаалсан өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллага ажиллахаар хуульчилсан. Мөн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналтын байгууллага хяналт тавьж ажиллаж байна.

Үндэсний хороо, салбар хороо, орон нутгийн зөвлөл нь ХАБЭА-н хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтэд ажил олгогч, ажилтны төлөөлөл, салбарын яамд, нутгийн захиргааны байгууллагын оролцоог хангах, дэмжлэг авах үүрэг гүйцэтгэж байна.

Аж ахуйн нэгж, байгууллага нь хууль тогтоомжоор тогтоосон ажилтны аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах ажил олгогчийн үүргээ биелүүлэх, ХАБЭА-н зөвлөлөөр дамжуулан ажилтны оролцоог хангах хэлбэрээр үндэсний тогтолцоонд оролцож байна.

ОУХБ-ын 187 дугаар конвенцод заасан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тогтолцооны хүрээнд хэрэгждэг үйл ажиллагаа дараах байдлаар тодорхойлогдож байна. Үүнд:

- а) **ХАБЭМ-ийн асуудлаар ажилладаг үндэсний гурван талт зөвлөлдөх байгууллага буюу үндэсний хороо.** Хуулийн 23.1-д заасны дагуу төрийн захиргааны байгууллага, ажил олгогчийн болон ажилтны эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөл бүхий тэнцүү тооны гишүүдээс бүрдсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Үндэсний хороо, салбар хороо, аймаг, дүүргийн зөвлөл;
- б) **ХАБЭМ-ийн мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээ.** Хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.6-д Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага “үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын талаарх тайланг гаргах, хөдөлмөрийн хортой, аюултай нөхцөл бүхий ажлын байрны мэдээллийн сан бүрдүүлэх, холбогдох газар, олон нийтэд мэдээлэх”, 25.1.4-т “аймаг, сум, нийслэл, дүүрэг, хорооны ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан “үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх”, 33.2.2, 33.31, 33.3.7, 33.4.4-т “хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын байцаагч нарын ХАБЭМ-ийн зөвлөгөө өгөх эрх” зэрэг зохицуулалтыг тус тус заасан.

Хуульд ХАБЭМ-ийн мэдээлэл, зөвлөгөө өгөх асуудлыг олон нийтэд өгөх асуудлыг ХНХЯ хариуцахаар заасан ч зохицуулалтын хувьд оновчгүйгээс хангалттай хэрэгжихгүй байна. ХНХЯ-ны харъяа ХАБЭМТ тодорхой хэмжээгээр мэдээлэл, зөвлөгөө түгээн ажилладаг ч хүртээмж нь хангалтгүй байна. Аймаг, сум, нийслэл, дүүрэг, хорооны түвшинд ХАБЭМ-ийн зөвлөгөө, мэдээлэл өгөх асуудал практикт хангалтгүй, хариуцах эзэнгүй байна. Хяналтын байцаагч нар ихэнх тохиолдолд тэдний хяналтад хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагад зөвлөгөө өгдөг. ХАБЭМ-ийн мэдээлэл, зөвлөгөө нь ихэнхдээ компанит ажлын хүрээнд, гадны төсөл хөтөлбөр эсвэл мэргэжлийн холбоо, сайн дурын үйл ажиллагааны хүрээнд

тогтмол бус байдлаар хийгдэж байна. Практикт ХАБЭМ-ийн зөвлөгөө, мэдээллийн хүртээмж хангалтгүй.

Хуульд заасны дагуу хортой, аюултай нөхцөл бүхий ажлын байрны мэдээллийн санг бий болгоогүй тул холбогдох газар, олон нийтэд мэдээлэх боломжгүй байна. Үндэсний тогтолцооны хүрээнд "ХАБЭМ-ийн мэдээлэл, зөвлөгөөний үйлчилгээ"-г бий болгохын тулд:

- a) ХАБЭМ-ийн мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээний хариуцах талыг үндэсний тогтолцоонд тодорхой заах. Ялангуяа албан бус хөдөлмөр эрхлэгч, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч нарт чиглэсэн мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээг бий болгоход онцгой анхаарах;
 - b) Мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээнд мэргэжлийн холбоо, сайн дурын байгууллага, үйлдвэрчний эвлэл, ажил олгогчдын холбоо зэргийн оролцоог ашиглах асуудлыг анхаарах;
 - c) ОУХБ-ын 155-р конвенцын 11.е-д заасны дагуу "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төлөв байдал" эмхэтгэлийг жил тутам хэвлүүлж, ХАБЭМ-ийн бодлогын төлөвлөлт, хэрэгжилтэд ашиглах.
- c) **ХАБЭМ-ийн сургалт.** Хуулийн 17.1-д "Ажил, хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтан болон ажил олгогч нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу ХАБЭА-н сургалтад хамрагдаж мэдлэг, дадлагатай болсон байна", 17.6-д "ХАБЭА-н чиглэлийн мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэх харилцааг Боловсролын тухай, Дээд боловсролын тухай хуулийн дагуу зохицуулна" гэж тус тус заасан.
- d) **Хөдөлмөрийн эрүүл мэндийн үйлчилгээний талаар хуульд тусгайлсан заалт байхгүй.** Хуулийн 31 дүгээр зүйлд "Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ" буюу хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжлийн үйлчилгээ, 14 дүгээр зүйлд "Эрүүл мэндийн үзлэг" буюу хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэгийн асуудал, 30 дугаар зүйлд "Мэргэжлээс шалтгаалах өвчин, түүнтэй холбогдсон хөдөлмөр зохицуулалт"-ын талаар тус тус заасан.
- Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг ХНХС-ын 2023 оны А/155 дугаар тушаалаар баталсан журмын дагуу Үндэсний итгэмжлэлийн төвөөс итгэмжлэлтэй 7 байгууллага хийж байна. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээнд тогтмол хамрагдвал зохих эрсдэл өндөртэй 14 мянга орчим аж ахуйн нэгж, байгууллагын 1.4% нь хамрагддаг. Ажилтны эрүүл мэндийн үзлэгийг Эрүүл мэндийн сайдын 2014 оны А/340 дугаар тушаалаар баталсан Эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийн журмын дагуу зохион байгуулж байна. Ажилтны эрүүл мэндийн үзлэгийг хөдөлмөрийн нөхцөлөөс хамааруулан зохион байгуулдаг 4 эмнэлэг байна. Бусад эмнэлгүүдэд ажилтны эрүүл мэндийн үзлэгийг ердийн өвчний илрүүлэг хэлбэрээр хийж байна.
- ХЭМ-ийн тусламж, үйлчилгээний зохицуулалтыг дараах чиглэлээр шинэчлэн сайжруулах:
- a. Эрсдэлтэй ажлын байранд ажиллагчдын эрүүл мэндийн үзлэг, тандалтыг хөдөлмөрийн нөхцөл, эрсдэлийн түвшнээс хамааруулан хийх, шаардлагагүй зардал, ачааллаас ажил олгогчийг чөлөөлөх, үзлэгийн чанарыг сайжруулах;
 - b. Ажилтны эрүүл мэндийн үзлэгтэй холбогдуулан хувь хүний мэдээллийн нууцлал, түүнийг хадгалах, ашиглах асуудал;

- c. МШӨ-ний оношилгоо, хөдөлмөрийн чадвар алдалтыг магадлан тогтооход ажилтны хөдөлмөрийн нөхцөл, эрсдэлийн түвшнийг харгалзан үзэх;
 - d. ХЭМ-ийн тусламж, үйлчилгээ ХЭМ-ийн чиглэлээр мэргэшсэн мэргэжлийн эмч, сувилагч, хөдөлмөрийн эрүүл ахуйчаар гүйцэтгүүлэх;
- e) **ХАБЭМ-ийн судалгаа.** Хуулийн 21.1.7-д Засгийн газрын бүрэн эрхэд "хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх судалгаа, шинжилгээг холбогдох байгууллагаар хийлгэх" гэж заасан энэ үүргийг хариуцах тал тодорхойгүй.

Үндэсний тогтолцооны хүрээнд "ХАБЭМ-ийн судалгаа"-г хийдэг байх заалтыг бүрэн хангахын тулд:

- a. Үндэсний тогтолцоонд ХАБЭМ-ийн судалгааны асуудал хариуцах талыг тодорхой болгох;
 - b. ХАБЭМ-ийн чиглэлийн судалгааны санхүүжилтийг тодорхой болгох;
 - c. ХАБЭМ-ийн судалгааны нөөц чадавх тодорхой хэмжээгээр их дээд сургуулиудыг энэ асуудалд татан оролцуулах нь зүйтэй.
- f) **Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тоо мэдээ цуглуулах, дүн шинжилгээ хийх механизм.** Хуулийн 6 дугаар бүлгээр "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлого, тэдгээрийг судалж бүртгэх" асуудлыг зохицуулсан. Засгийн газрын 2015 оны 269 дугаар тогтоолоор баталсан дүрмийн дагуу Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх үйл ажиллагаа хэрэгжиж байна. ҮОХХ-ын бүртгэлийг онлайн хэлбэрээр цуглуулж, Үндэсний статистикт мэдээлэгдэж байна. Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бүртгэх, мэдээлэх асуудлыг ХНХС-ын 2015 оны А/234 тоот тушаалаар баталсан журмын дагуу зохицуулдаг ч зөвхөн МШӨ-нөөр хөдөлмөрийн чадвар алдсан тохиолдлыг бүртгэдэг. Эрүүл мэндийн хугацаат үзлэгээр эрт илрүүлсэн тохиолдлуудыг бүртгэх, Үндэсний статистикт нэгтгэх асуудал хийгдэхгүй байна. ҮОМШӨ-ний тоо, статистикт дүн шинжилгээ хийх механизм хангалттай бүрдээгүй, ОУХБ-ын аргачлалыг ашигладаггүй.

Үндэсний тогтолцооны хүрээнд ҮОМШӨ-ний тоо мэдээ цуглуулах, дүн шинжилгээ хийх механизм"-ыг бий болгох заалтыг бүрэн хангахын тулд:

- a. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчлэлээр хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг, тандалт, бүртгэл, мэдээллийн асуудлыг тодорхой зохицуулах;
 - b. МШӨ-ний эрт илрүүлэх ХЭМ-ийн үзлэг тандалт зохион байгуулах чадавх бүхий эмнэлгийн тоог нэмэгдүүлэх, ХЭМ судлаач эмчийг бэлтгэх;
 - c. Хурц хордлогын тохиолдлыг судлан бүртгэх аргачлалыг үйлдвэрлэлийн ослоос ялгаатай байдлаар боловсруулах;
 - d. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тоо мэдээ цуглуулах, дүн шинжилгээ хийхэд ОУХБ-ын аргачлалыг ашиглах боломжийг судлах.
- g) **Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал.** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-т ажилтан "үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд хамрагдах" эрхийг, 28.4-т "Эрсдэлийн түвшин их ажлын байранд ажиллаж байгаа ажилтныг амь нас, эрүүл мэндийн даатгалд тухайн ажилтны 36 ба түүнээс дээш сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээгээр заавал даатгуулах" ажил олгогчийн үүргийг заасан. Түүнчлэн ҮОМШӨ-ний даатгалын асуудал

нийгмийн даатгалын хууль тогтоомжоор зохицуулагдаж байна. Хуулийн 26.1-д ХАБЭА-н урьдчилан сэргийлэх арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг "үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас зарцуулах хөрөнгө,..." -нөөс бүрдэх талаар заасан ч хэдий сургалт, сурталчилгааны үйл ажиллагаагаар хязгаарлагдаж байна.

h) **Бичил, жижиг, дунд бизнес, албан бус эдийн засгийн ХАБЭМ-ийн нөхцөлийг** дэвшилттэйгээр сайжруулах талаар хууль тогтоомжид ямар нэг зохицуулалтгүй байна. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай болон бусад хуульд эрсдэл өндөртэй, жижиг, дунд хөдөлмөр эрхлэгч, албан бус салбарт ажиллагчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн зохицуулалтыг бий болгох хэрэгцээ байна. Тухайлбал:

- ХАБЭМ-ийн эрсдэл өндөртэй, жижиг дунд хөдөлмөр эрхлэгч, албан бус хөдөлмөр эрхлэгчдийн (цахим) бүртгэлийг нэвтрүүлж, эрсдэлийг үнэлэх, бууруулах, ҮОМШӨ-нөөс урьдчилан сэргийлэх, ХАБЭМ-ийн сайн туршлагыг нэвтрүүлэхэд дэмжлэг, тусалцаа үзүүлж, зөвлөгөө өгөх;
- ХАБЭМ-ийн төвийг аймаг эсвэл бүс, дүүрэг, нийслэлд байгуулах, зардлыг бүхэлд нь эсвэл тодорхой хувийг ҮОМШӨ-ний даатгалын сангаас санхүүжүүлэх (төр-хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар);
- Жижиг, дунд хөдөлмөр эрхлэгч, албан бус салбарынханд зориулсан ХАБЭМ-ийн аутсорсинг үйлчилгээ үзүүлэгчдийг дэмжих, үйлчилгээний чанар, хүртээмжид хяналт тавих, төлбөрийг нь ҮОМШӨДС-гаас хэсэгчлэн эсвэл бүтэн төлөх;
- Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг ҮОМШӨДС-гаас санхүүжүүлэх;
- Ажилтны хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэгийн зардлыг ЭМДС-гаас гаргах.

Үндэсний хэмжээнд ХАБЭМ-ийн бодлогын хэрэгжилтийг голлон хариуцаж ажиллах мэргэжлийн түвшний байгууллага нь хуулийн 22.1.9-д заасан мэргэжлээс шалтгаалсан өвчин, хөдөлмөрийн нөхцөл хариуцсан байгууллагаар хязгаарлагдаж байна. Уг байгууллагын үйл ажиллагаа нь мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ба үйлдвэрлэлийн ослын асуудлыг хамрахгүй байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд үндэсний тогтолцоог зохих агуулга, хамрах хүрээг дахин тодорхойлж, бүрэлдэхүүнд нь аймаг эсвэл бүсийн түвшинд ХАБЭМ-ийн бодлогын хэрэгжилтийг хариуцах мэргэжлийн байгууллага болон хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний байгууллага, хөдөлмөрийн эрүүл ахуйн лаборатори, хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг, тандалт хийдэг эмнэлэг, ХАБЭМ-ийн мэргэжлийн үйлчилгээний байгууллага, ХАБЭМ-ийн мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургууль, ХАБЭА-н ажилтан бэлтгэх сургалтын төв зэргийг багтааж, үүрэг, хариуцлагыг тодорхойлох нь зүйтэй.

Засаг захиргааны нэгжийн түвшинд ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны чиг, үүрэг

Хуулийн 25 дугаар зүйлд аймаг, сум, нийслэл, дүүрэг, хорооны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтны чиг үүргийг тодорхойлсон

нь засаг захиргааны нэгжийн түвшинд ҮОМШӨ-ний урьдчилан сэргийлэлтийг хэрэгжүүлэх, статистик, мэдээллийн сан бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой байна.

ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан нь ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжлийн байгууллагатай ямар харилцаатай ажиллах талаар хуульд зохицуулагдаагүй байна.

Орхон, Дархан-Уул, Өмнөговь, Дундговь зэрэг уурхай үйлдвэрлэл төвлөрсөн, эрсдэлтэй ажлын байр ихтэй засаг захиргааны нэгжид ХАБЭМ-ийн тусламж үйлчилгээ үзүүлэх дэд бүтцийг дэмжих зохицуулалт шаардлагатай эсэхийг тодорхойлох нь зүйтэй.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн санхүүжилт

Хуулийн 26 дугаар зүйлээр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого боловсруулах, хэрэгжилтийг хангах, ажлын байранд хэрэгжих арга хэмжээний санхүүжилтийг тодорхойлсон. ҮОМШӨ-ний даатгалын асуудалтай холбоотойгоор нийгмийн даатгалын хууль тогтоомж нь ХАБЭА-н санхүүжилтийг зохицуулахад оролцож байна.

Хуулийн 26.1-д зааснаар ХАБЭА-н урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсөв нь байгууллага, иргэний хандив, зээл, тусламж, ҮОМШӨ-ний даатгалын сангаар санхүүжүүлэх зохицуулалттай байна. Үүнээс улсын төсөв болон ҮОМШӨ-ний даатгалын сан тогтвортой санхүүжилтийн эх үүсвэр ба бусад нь тогтмол бус.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т зааснаар “Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төлбөр нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн тухайн жилийн шимтгэлийн орлогын 2 хувиас багагүй байна” гэж заасан. Гэвч хуульд уг сангаас зарцуулах зардлын санхүүжилт нь:

- Даатгалын үйл ажиллагаа, хууль тогтоомжтой холбоотой мэдээлэл, зөвлөгөө өгөх сургалт, сурталчилгаа;
- Даатгуулагч, ажил олгогчид зориулсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт;
- ХАБЭА-н урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлсэн, шинэ техник, технологи, инновац нэвтрүүлсэн ажил олгогчийн шилдэг туршлага, ололт, амжилтыг олон нийтэд сурталчлах;
- ҮОМШӨ-ний чиглэлээр хийх тандан судалгаа, эрсдэлийн болон хяналт шинжилгээ, үнэлгээнд зарцуулагдахаар хязгаарлагдсан.

Тиймээс ҮОМШӨ-ний урьдчилан сэргийлэлтийг дэмжихэд чиглэсэн үндэсний түвшний ХАБЭА-н урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон ажил олгогч, ажилтанд зориулсан урьдчилан сэргийлэлтийн үйлчилгээг санхүүжүүлэхэд ҮОМШӨ-ний сангийн санхүүжилт хангалтгүй байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийг ажлын байрны эрсдэлийн түвшнээс хамааруулан цалин хөлсний орлогын 0.5, 1.5, 2.5 хувиар тооцох зохицуулалттай. Уг зохицуулалт нь ХАБЭМ-ийн бодит эрсдэлийн түвшин, ҮОМШӨ-ний тохиолдолд суурилагагүй бөгөөд ажил мэргэжлийн төрлөөс хамаарч эрсдэлийн түвшинг шууд тооцож байна.

Хуулийн 28.4-т "Эрсдэлийн түвшин их ажлын байранд ажиллаж байгаа ажилтныг амь нас, эрүүл мэндийн даатгалд тухайн ажилтны 36 ба түүнээс дээш сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээгээр заавал даатгуулна" гэж заасан байдаг."Ажилтны амь нас, эрүүл мэндийн даатгалын хураамжийг ажил олгогч хариуцах бөгөөд ажилтныг амь нас, эрүүл мэндийн даатгалд даатгуулсан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 125 дугаар зүйлд заасан нөхөн төлбөрийг ажил олгогч олгохгүй байх үндэслэл болохгүй", 26.5.7-д "ажилтныг амь нас, эрүүл мэндийн даатгалд хамруулах" тухай заалтын дагуу ажил олгогч нар хувийн даатгалын компаниар ажилтнаа даатгуулдаг. Гэвч уг нэмэлт даатгалаас ҮОМШӨ-нөөс урьдчилан сэргийлэх зориулалтаар ажил олгогч, ажилтанд үзүүлэх даатгалын үйлчилгээ, санхүүжилт нь тодорхой зохицуулалтгүй байна.

Хуулийн 26.4-т заасны дагуу ажил олгогч нь өөрийн байгууллагад хэрэгжүүлэх ХАБЭА-н урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг бүрэн санхүүжүүлэх тогтолцоотой. Хуулийн 26.2-т "төсвийн байгууллага нь тухайн жилийн батлагдсан төсвийн 0.5 хувиас, аж ахуйн нэгж, байгууллага эрсдэлийн түшингээс хамааран үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тус тус зарцуулна" гэж заасан.

Аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд ХАБ-ын эрсдэлийн үнэлгээ, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ, ажлын байрны эрүүл ахуйн хэмжилт мониторинг, ажилтны эрүүл мэндийн үзлэг, ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, сургалт зэрэг олон үйл ажиллагаанд зардал төлөвлөх шаардлагатай болдог. Хуулийн 26.2-т заасны дагуу хэрэгжилтийн хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагуудын ХАБЭА-н урьдчилан сэргийлэх санхүүжилтийг ерөнхийд нь төлөвлөдөг тул хуулийн дагуу зайлшгүй хэрэгжүүлэх зарим үйл ажиллагаандаа зардал төлөвлөхгүй байх асуудал түгээмэл тохиолдож байна.

Хуулийн 18.1, 28.4-т заасны дагуу ажил олгогч ҮОМШӨ-ний даатгал, амь нас, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлж байгаа хэдий ч урьдчилан сэргийлэлтийн үйл ажиллагаанд зориулсан санхүүгийн дэмжлэг даатгалаас авах зохицуулалт байхгүй. Осол, өвчлөлийн тохиолдолд даатгуулагчид тэтгэвэр, тэтгэмж олгох зохицуулалт хэрэгжиж байна.

Хуульд төрөөс хэрэгжүүлж буй үндэсний хэмжээний ХАБЭА-н бодлого, хөтөлбөрийн санхүүжилтийг тодорхой зохицуулаагүй тул ихэнхдээ гадаадын хандив, тусламжаар эдгээр арга хэмжээг санхүүжүүлж байна. ҮОМШӨ-нөөс урьдчилан сэргийлэх зорилготой ХАБЭА-н стандарт, техникийн зохицуулалтыг боловсруулах, шинэчлэх, түүний хэрэглээг дэмжих, аж ахуйн нэгж, байгууллагад аюулгүй ажиллагааны эрсдэлийн үнэлгээ, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт оношлон илрүүлж, хөдөлмөрийн чадвар алдахаас урьдчилан сэргийлэх зэрэгт ҮОМШӨ-ний даатгалын санхүүжилт ашиглагдахгүй байна.

Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зохион байгуулалт ба ажил олгогчийн эрх, үүрэг

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль нь албан салбар буюу дунд, том хэмжээтэй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд ХАБЭА-н

шаардлагыг хангуулахад чиглэсэн бөгөөд албан бус салбар, жижиг, дунд үйлдвэрлэл, хувиараа хөдөлмөр эрхлэгч нарт чиглэсэн зохицуулалт байхгүй байна.

Хуулийн 27 дугаар зүйлд аж ахуйн, нэгж байгууллагын ХАБЭА-н зохион байгуулалтад тавигдах шаардлага, 28 дугаар зүйлд ХАБЭА-н талаар ажил олгогчийн эрх, үүргийг тодорхойлсон. Ажилтнаа эрүүл, аюулгүй ажлын байраар хангахын тулд ХАБЭА-н үйл ажиллагааг үр нөлөөтэй зохион байгуулж, удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх нь ажил олгогчийн үүрэг юм. Тиймээс хуулийн 27, 28 дугаар зүйлийн зохицуулалт харилцан уялдаатай байх шаардлагатай юм.

ОУХБ-аас гаргасан ХАБЭМ-ийн удирдлагын тогтолцоо, ХАБЭМ-ийн чанарын удирдлагын тогтолцооны ISO 45001 стандартад аж ахуйн нэгж, байгууллагын ХАБЭМ-ийн удирдлагын тогтолцоо нь дараах үндсэн бүрэлдэхүүнтэй байхыг зөвлөдөг^{29 30}. Үүнд:

1. Бодлого, дүрэм, журам боловсруулж, мөрдөх, тасралтгүй сайруулах;
2. Ажил олгогчийн манлайлал, ажилтны оролцоо;
3. ХАБЭМ-ийн үйл ажиллагааны төлөвлөлт;
4. Ажлын байранд аюулыг таньж илрүүлэх, эрсдэлийг үнэлэх, арилгах, бууруулах хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэх;
5. Хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалт, мониторинг;
6. ҮОМШӨ-ний тохиолдол гарсан үед хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, дүн шинжилгээ;
7. Хууль тогтоомжийн нийцлийг хангах;
8. ХАБЭМ-ийн гүйцэтгэлийн үнэлгээ, тасралтгүй сайжруулалт;
9. Онцгой үеийн бэлэн байдал ба хариу арга хэмжээ;
10. ХАБЭМ-ийн сургалт, чадамжийн үнэлгээ;
11. Удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх шаардлагатай мэргэжилтэн, санхүүжилт, материаллаг нөөц;
12. Баримт бичиг хөтлөлт багтана.

ХАБЭА-н удирдлагын тогтолцооны шаардлага нь албан бус салбар, хувиараа хөдөлмөр эрхлэгч, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч нарт илүү энгийн загвараар хэрэгжих нь зүйтэй байна.

Аж ахуйн нэгж, байгууллагын ХАБЭА-н удирдлагын тогтолцоонд тавигдах ерөнхий шаардлагыг хуулийн 27.2, 27.3-т ХАБЭА-н асуудал хариуцсан бүтэц, ажилтан, зөвлөлийн чиг үүрэг гэсэн агуулгаар дараах бүрэлдэхүүнтэйгээр тодорхойлсон. Үүнд:

- 27.3.1. ХАБЭА-н бодлого, төлөвлөгөөг боловсруулж, шаардлагатай дүрэм, журмыг шинэчлэн баталж, хэрэгжүүлэх;
- 27.3.2. ХАБЭА-н удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, хэрэгжилт, үр дүнд хяналт тавих;
- 27.3.3. ХАБЭА-н хууль тогтоомжийн шаардлага, стандарт, салбарын болон аж ахуйн нэгж, байгууллагын мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журмын хэрэгжилтийн байдалд үзлэг, шалгалт хийлгэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах;

²⁹ ILO, Occupational Safety and Health Management System, 2016

³⁰ ISO 45001:2018, Occupational Safety and Health Management Systems- Requirements with Guidance for Use

- 27.3.4. ХАБЭА-н сургалтын хэрэгцээг тодорхойлох, төлөвлөх, хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах, үр дүнг тооцох, тайлагнах;
- 27.3.5. Ажлын нөхцөл, мэргэжлийн онцлогт тохирсон тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг ажилтанд олгох, норм, чанар, зохистой хэрэглээнд хяналт тавих;
- 27.3.6. ХАБЭА-н хууль тогтоомжийн шаардлага, стандарт, дүрэм, журмыг зөрчсөн албан тушаалтан, ажилтанд хариуцлага хүлээлгэх саналаа ажил олгогчид гаргах;
- 27.3.7. хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

Хуулийн 28.1.4, 28.1.5-д ажил олгогч нь ажлын байранд эрсдэлийн үнэлгээ хийх, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх үүргийг тодорхойлсон байдаг. Гэхдээ эрсдэлийн үнэлгээ, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээгээр ажилтны эрүүл мэнд, амь насанд аюул учруулахуй нөхцөл байдал үүссэн нь тогтоогдсон бол түүнийг эрх бүхий байгууллагад мэдээлэх, залруулах арга хэмжээг хэрэгжүүлэх асуудал зохицуулалтгүй байна.

Ажлын байрны агаар дахь хорт бодисыг хэмжихэд тавих ерөнхий шаардлага, зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 4990:2023 стандартын 3.17-д ажилтны амь насанд эгшин зуур аюул учруулах, эрүүл мэндэд эргэшгүй сөрөг нөлөө үүсгэх эсвэл аюултай орчноос өөрийгөө аврах, чадварыг нь алдагдуулж хурц хордлогод хүргэх агаар дахь тоос, хорт бодисын өртөлтийн түвшинг **амь нас, эрүүл мэндэд нэн аюултай өртөлт** гэж тодорхойлсон. Түүнчлэн ажилтан өдөр бүр өртөхөд эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлж МШӨ үүсгэх ажлын байрны сөрөг хүчин зүйлсийн өртөлтийн **зөвшөөрөгдөх дээд хэмжээг** хөдөлмөрийн эрүүл ахуйн стандартаар тогтоосон. Эрсдэлийн үнэлгээ, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээгээр ажилтан аюултай болон зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн аюултай хүчин зүйлсэд өртөж байгаа нь тогтоогдвол, ажилтны эрүүл мэндийг хамгаалах зорилгоор ажил зогсоох, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, үр дүнг нь эрх бүхий (хяналтын) байгууллагад мэдээлэх зохицуулалт шаардлагатай.

Хуульд заасан аж ахуйн нэгж, байгууллагын ХАБЭА-н зохион байгуулалтад тавигдах шаардлагыг ХАБЭА-н талаарх ажил олгогчийн эрх, үүрэгтэй уялдуулах, олон улсын сайн туршлагатай харьцуулан дахин хянах нь зүйтэй.

Хуулийн 27.4-т “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтнаар инженер, техникийн болон эрүүл ахуйн боловсролтой, мэргэшсэн хүнийг ажиллуулна” гэж заасны хүрээнд ажлын байранд тавигдах шаардлага, чиг үүрэг болон их дээд сургууль, түр сургалтаар бэлтгэж буй хүний нөөцийн ялгаа, заагийг тодорхой болгох шаардлагатай байна.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлого, тэдгээрийг судалж бүртгэх

Хуулийн 29 дүгээр зүйлээр ҮОХХ-ийн үед авах арга хэмжээ, бүртгэл, мэдээлэлтэй холбоотой харилцааг зохицуулсан. Хуульд үйлдвэрлэлийн осол болон хурц хордлогын тохиолдлыг ижил зохицуулалтаар судлан, бүртгэж, мэдээлэхээр заасан. ҮОХХ-ыг судлан бүртгэх, мэдээлэх асуудлыг Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолоор нарийвчлан зохицуулж байна.

Химийн бодисоор үүсгэгдсэн хордлого болон механик хүчин зүйлээр үүсгэгдсэн ослын шинж чанар нь өөр тул осол, хурц хордлогын шалтгааныг судлан бүртгэх, мэдээлэх үйл явц нь ялгаатай байх шаардлага тулгарч байна.

Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бүртгэх, мэдээлэх асуудлыг хуульд тодорхой заагаагүй бөгөөд эрүүл мэнд болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтарсан тушаалаар батлахаар зохицуулсан.

МШӨ-нийг илрүүлэх, оношлох, бүртгэх, мэдээлэх, статистик сан үүсгэхэд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хүлээх үүрэг, оролцоог хуульд тодорхойлоогүй байна. Үүнтэй холбоотой практикт эрүүл мэндийн байгууллага дээр хийгдэж буй ажилтны эрүүл мэндийн үзлэгээр МШӨ-нийг илрүүлэх, оношлох үйл ажиллагааг орхигдуулж, МШӨ-ний статистик бүртгэл хангалтгүй байна.

Хуулийн 30.1-д “Мэргэжлээс шалтгаалах өвчний жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална” гэж заасны дагуу ХНХС, ЭМС-ын 2023 оны А/152, А/388 дугаар хамтарсан тушаалаар баталсан МШӨ-ний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг тогтоосон жагсаалт мөрдөгдөж байна. Энэ жагсаалт нь МШӨ-нөөр хөдөлмөрийн чадвар алдсан ажилтанд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн хүрээнд тэтгэвэр олгоход чиглэгдсэн. МШӨ-ний тохиолдлыг хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэгээр эрт илрүүлж, бүртгэх, улмаар хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэхэд уг жагсаалтыг ашиглах боломжгүй байна.

Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ

Хуулийн 28.1.5-д ажил олгогчийг ажлын байрандаа хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх үүрэг хүлээлгэсэн. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ нь ажилтан ажлын байрандаа өртөх хортой, аюултай хүчин зүйлсийн өртөлтийг хэмжсэний үндсэн дээр мэргэжлээс шалтгаалсан өвчний эрсдэлийг үнэлж, хөдөлмөрийн нөхцөлийн ангиллыг тодорхойлдог хөндлөнгийн үнэлгээ юм. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ нь Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой бөгөөд ажилтны ажлын цаг, цалин хөлсний нэмэгдэл, ээлжийн амралтын хугацаа, тэтгэвэрт гарах насыг тодорхойлоход ашиглагдаж байна.

Хуулийн 31.1-д “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг стандартын асуудал эрхэлсэн байгууллагын итгэмжлэл бүхий мэргэжлийн байгууллага батлагдсан журмын дагуу хийнэ” гэж заасан. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийн хүрээнд стандартын асуудал эрхэлсэн байгууллага итгэмжлэлийн асуудал хариуцахгүй болсон ба бие даасан итгэмжлэлийн асуудал эрхэлсэн байгууллага байгуулагдсан.

Хуулийн 31.2-т “Ажил олгогч нь ажлын байр шинээр бий болгох болон тухайн ажлын байрны үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, нөхцөл өөрчлөгдөх бүрт химийн хорт болон аюултай бодис агуулсан түүхий эд, материал ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа бол жилд нэгээс доошгүй удаа ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг тус тус хийлгэнэ” гэж заасан.

2021 оны байдлаар бүртгэлтэй 180 мянган аж ахуйн нэгж, байгууллагын 10 мянга нь эрчим хүч, уул уурхай, барилга зэрэг эрсдэл өндөртэй салбарт үйл ажиллагаа явуулж байна. 2023 оны байдлаар 210 аж ахуйн нэгж, байгууллага хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээнд хамрагдсан байна³¹. Түүнчлэн ХАБЭМТ-ийн мэдээллээр сүүлийн жилүүдэд МШӨ-ний шинэ тохиолдлын тоо нэмэгдэх хандлагатай байна. 2010-2012 онд жилд дунджаар 45 шинэ тохиолдол бүртгэгдэж байсан бол 2021-2023 онд жилд дунджаар 78 болж нэмэгдсэн³². Эдгээр тоо баримт нь ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний талаарх хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгож хэрэгжилтийг хангахад анхаарах шаардлагатай илтгэж байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих

Хуулийн 32.1-д зааснаар ХАБЭА-н хууль тогтоомжид тавих хяналтыг Улсын их хурал, Засгийн газар, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга, хяналтын алба, ажилтны төлөөллийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага хэрэгжүүлэх зохицуулалттай.

2022 онд Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт орж мэргэжлийн хяналтын байгууллагын харьяанд байсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын чиг үүрэг хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад шилжин ирсэн.

Хуулийн 33.1-д “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих төрийн захиргааны хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу эрх олгосон хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч гүйцэтгэнэ” гэж заасан.

Хөдөлмөрийн тухай хуулийн 162 дугаар зүйлийн 162.1-д “хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч хөдөлмөрийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг хэрэгжүүлнэ” гэж заасан.

Өөрөөр хэлбэл хөдөлмөрийн хяналтын байцаагч Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавихаас гадна Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2, 33.4 дэх хэсэгт заасан хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналтыг хавсран гүйцэтгэж байна.

Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын байцаагч Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3, 33.4 дэх хэсэгт заасан хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтыг гүйцэтгэж байна.

Хуульд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих төрийн хяналтыг хяналтын байцаагчийн бүрэн эрхийн хүрээнд тодорхойлсон ба тогтолцооны хэлбэрээр тодорхойлоогүй байна.

³¹ А.Цэнгэлмаа, Хөдөлмөрийн эрүүл ахуйн 2024 бага хурал:Хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ, Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ, 2024 он

³² Д.Нарансүх, Хөдөлмөрийн эрүүл ахуйн 2024 бага хурал: Мэргэжлээс шалтгаалсан өвчний бүртгэл, мэдээллийн тогтолцоо илтгэл, 2024 он

2022 оноос өмнө мэргэжлийн хяналтын байгууллага төрийн хяналт шалгалтын нэгдсэн тогтолцооноос салбарын яамддаа шилжсэн ч ХАБЭА-н хяналтын асуудлыг тогтолцооны түвшинд зохицуулсан хууль эрх зүйн зохицуулалт бий болоогүй байна.

Хуулийн 35 дугаар зүйлийн зохицуулалтаар аж ахуйн нэгж, байгууллагын ХАБЭА-н дотоод хяналтын асуудал нь хуулийн 27 дугаар зүйлд заасан ХАБЭА-н зохион байгуулалт, удирдлагын тогтолцоонд хамаарах асуудал юм.

Хуулийн 35.1-д “Ажил олгогч нь үйлдвэрлэлийн цех, тасаг, хэсэг, ажлын байр бүрд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, нийтлэг шаардлага, стандартын хэрэгжилт, ажлын байран дахь эрсдэлийн үнэлгээний дагуу авагдсан арга хэмжээний биелэлтэд дотоодын хяналт тавина” гэж заасан. Ажлын байранд ажилтнуудад осол, өвчлөлийн эрсдэл үүсгэх эрүүл мэндийн болон аюулгүй ажиллагааны хүчин зүйлсийг илрүүлэх, тогтмол хэмжиж хяналт тавих, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний дагуу хэрэгжих шаардлагатай арга хэмжээнд хяналт тавих дотоод хяналтын асуудлууд зохицуулагдаагүй байна.

Хуулийн 28.1.4-т заасан “ажлын байранд учирч болзошгүй аюулыг илрүүлэх, тогтоох, үнэлэх, бууруулах, арилгах зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийх” гэсэн ажил олгогчийн үүрэг нь аж ахуйн, нэгж байгууллагын дотоод хяналтад ч хамааралтай асуудал юм.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГО

2.1 Гол зорилго, зорилт

2.1.1 ХАБЭА-н тухай хуулийг ОУХБ-ын конвенцод нийцүүлэх чиглэлээр:

- Монгол Улсын нэгдэн орсон ОУХБ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай 155 дугаар конвенц, Уурхай дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай 176 дугаар конвенц, Барилгын салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай 167 дугаар конвенцод нийцүүлэх;
- Монгол Улсын нэгдэн ороогүй байгаа ОУХБ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг дэмжих суурь тогтолцооны тухай 187 дугаар конвенц, Хөдөлмөрийн мэндийн үйлчилгээний талаарх 161 дүгээр конвенцод нийцүүлэх.

2.1.2 ХАБЭА-н тухай хууль болон бусад хуулийн уялдааг хангах чиглэлээр:

- Хууль анх 2008 онд батлагдсанаас хойш хэрэгжсэн бусад хуулийн шинэчлэлтэй нийцүүлэн дараах чиглэлээр шинэчлэн сайжруулах шаардлагатай байна. Үүнд:
 - Ажлын байранд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэм хэмжээний зохицуулалтыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуультай уялдуулах;
 - Ажилтныг аюулгүй, хэвийн нөхцөлтэй ажлын байраар хангах ажил олгогчийн эрх, үүргийг хангуулах, хөдөлмөрийн харилцааны асуудалд ХАБЭА-н хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор Хөдөлмөрийн тухай хуультай уялдуулах;

- Ажилтны эрүүл мэндийн үзлэг, тандалт, МШӨ-ний илрүүлэг, бүртгэл, мэдээллийн талаарх зохицуулалтыг Эрүүл мэндийн тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуультай уялдуулах;
- ҮОМШӨ-ний даатгал болон өндөр эрсдэлтэй ажлын байранд ажилладаг ажилтнуудыг хамруулдаг амь нас, эрүүл мэндийн даатгал, ХАБЭА-н урьдчилан сэргийлэх арга хэмжээний санхүүжилтийн талаарх зохицуулалт болон Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуультай уялдуулах;

2.1.3 Ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлд тавигдах шаардлагын талаарх зохицуулалтыг сайжруулах:

- Заавал мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэм хэмжээг техникийн зохицуулалтаар тогтоож мөрдүүлэх, нөхцөл байдалдаа тохируулан сонгон хэрэглэх шаардлагыг стандартаар тогтоох зохицуулалтыг бий болгох;
- ХАБЭА-н стандарт, техникийн зохицуулалтын байнгын шинэчлэл, сайжруулалтыг хариуцах байгууллага, эрх үүргийг тодорхой болгох;
- Ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлд тавигдах шаардлагад шинээр бий болсон дараах шинэ нөхцөлийг тусгах:
 - Ил уурхайн ажлын байранд тавигдах шаардлага;
 - Далд уурхайн ажлын байранд тавигдах шаардлага;
 - Хязгаарлагдмал орчинд ажиллах үед тавигдах шаардлага;
 - Хавдар үүсгэдэг, үр удамд нөлөөлдөг, нөхөн үржихүйд сөрөг нөлөөтэй хорт бодистой харьцан ажиллахад тавигдах шаардлага;
 - Хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөлийн хэмжилт мониторингд тавигдах шаардлага.

2.1.4 Эрүүл мэндийн үзлэгийн талаарх зохицуулалтыг сайжруулах чиглэлээр:

- Эрүүл мэндийн үзлэгийн зохицуулалтыг “Хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг, тандалт” болгон сайжруулж, эрсдэлтэй ажлын байранд шинэ ажилтан ажилд авахаас өмнө болон дараа нь хийх эрүүл мэндийн үзлэгийг хөдөлмөрийн нөхцөлөөс хамааруулан зохион байгуулах, ажилтны эрүүл мэндийн үнэлгээ, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн зохицуулалтыг сайжруулах;
- Хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг, тандалтын хэрэгжилтэд эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын чиг үүргийг тодорхой болгож, эрүүл мэндийн байгууллагуудад хийгдэх хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг, мэргэжлээс шалтгаалсан өвчний эрт илрүүлэг, оношилгоо, бүртгэл, мэдээллийн зохион байгуулалтын зохицуулалтыг сайжруулах;
- Хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэгийн зохион байгуулалттай холбоотой хөдөлмөрийн эрүүл мэнд судлаач, эмчид тавигдах шаардлага, ажилтны хувийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдал, ажил олгогч, үзлэг хийх

эмнэлгийн хүлээх үүрэг, ёс зүйн асуудлын талаарх зохицуулалтыг Эрүүл мэндийн хууль тогтоомжтой нийцүүлэн зохицуулах.

2.1.5 Мэргэшсэн, чадварлаг мэргэжилтнээр салбарын хүний нөөцийг бүрдүүлэх чиглэлээр:

- ХАБЭА-н ажилтан болон ХАБЭМ-ийн мэргэжилтний тодорхойлолтыг нэмж оруулах;
- ХАБЭМ-ийн мэргэжилтэн гэдэгт их дээд сургуулийг “Хөдөлмөрийн аюулгүй байдлын мэргэжилтэн”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжилтэн”, “Хөдөлмөрийн эрүүл ахуйч”, “Хөдөлмөрийн эрүүл мэнд судлаач эмч”, “Хөдөлмөрийн эрүүл мэндийн сувилагч” мэргэжлээр төгссөн мэргэжилтэн хамаарахыг заах;
- ХАБЭА-н ажилтан гэдэгт ажлын туршлага, түр сургалтаар ХАБЭА-н мэдлэг, ур чадварыг эзэмшсэн, мэргэжлийн чадамжаа баталгаажуулсан, аж ахуйн нэгж, байгууллагад энэ чиглэлээр ажиллаж буй ажилтан хамаарахыг заах;
- ХАБЭМ-ийн мэргэжилтнүүд мэргэжлийн нийгэмлэг, холбоодын гишүүнчлэл, сургалт, мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаанд тогтмол хамрагдан мэдлэг, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх, мэргэжлийн чадамжаа баталгаажуулах асуудлыг дэмжих зохицуулалт нэмэх.

2.1.6 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний тогтолцоо, санхүүжилтийг сайжруулах чиглэлээр:

- Хуульд ХАБЭА-н асуудал хариуцсан байгууллагыг тогтолцоо байдлаар тодорхойлсныг ХАБЭМ-ийн үндэсний тогтолцоо болгон сайжруулж, ҮОМШӨ-ний даатгал, төрийн хяналт, урьдчилан сэргийлэлт, сургалт, зөвлөгөө, хөдөлмөрийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч мэргэжлийн байгууллагууд, ХАБЭМ-ийн мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулийг нэмэх, шинэчлэх;
- ХАБЭМ-ийн үндэсний тогтолцоог урьдчилан сэргийлэлт, ҮОМШӨ-ний даатгал, төрийн хяналтын нэгдмэл тогтолцоо болгох зохицуулалтыг бий болгох;
- Засаг захиргааны нэгжийн түвшинд ХАБЭМ-ийн асуудал хариуцсан мэргэжилтэн ажиллуулж, ХАБЭМ-ийн асуудал хариуцсан мэргэжлийн байгууллагатай уялдан ажиллах байдлаар зохицуулалтыг сайжруулах;
- ХАБЭМ-ийн асуудал хариуцсан байгууллагын чиг үүргийг урьдчилан сэргийлэлт, хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалт, МШӨ-ний оношилгоо, ХАБЭМ-ийн сургалт, судалгаа, лавлагаа лаборатори, хөдөлмөрийн хяналт, ҮОМШӨ-ний даатгалын чиг үүрэгтэйгээр тодорхойлох.

2.1.7 Урьдчилан сэргийлэлтэд чиглэсэн ҮОМШӨ-ний даатгалын зохицуулалтыг бий болгох чиглэлээр:

- ҮОМШӨ-ний даатгалыг ХАБЭМ-ийн тогтолцоонд нэгдмэл хэлбэрээр хөгжүүлэх зохицуулалтыг бий болгох;
- Урьдчилан сэргийлэлтэд чиглэсэн ҮОМШӨ-ний даатгалыг хөгжүүлэх зохицуулалтыг бий болгож, ажлын байрны эрсдэлийн түвшинд суурилан даатгалын шимтгэлийг тооцох, ҮОМШӨ-ний эрсдэлийг бууруулах,

арилгах зорилгоор урьдчилан сэргийлэх үйлчилгээг даатгалаас санхүүжүүлэх зохицуулалтыг бий болгох;

- Өндөр эрсдэлтэй салбарын ажилтнуудын даатгуулдаг амь нас, эрүүл мэндийн нэмэлт даатгалыг ҮОМШӨ-ний эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглүүлэх, даатгуулагчид олгох үйлчилгээг тодорхой болгох;
- ҮОМШӨ-ний даатгалаас даатгуулагчид олгох урьдчилан сэргийлэлт, сэргээн засах тусламж үйлчилгээний нэр төрлийг тодорхой болгох;
- ҮОМШӨ-ний тохиолдлын үед ажилтанд үзүүлэх шаардлагатай эмнэлгийн яаралтай тусламж, эмчилгээ, сэргээн засах тусламж, үйлчилгээний зардлыг ажил олгогчоос бус ҮОМШӨ-ний даатгал, өндөр өртөгтэй эмчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээний зардал, эд хөрөнгийн хохирлыг нас, эрүүл мэндийн нэмэлт даатгалаас санхүүжүүлэх зохицуулалтыг бий болгох.

2.1.8 Аж ахуйн нэгж, байгууллагын ХАБЭА-н зохион байгуулалт болон ажил олгогчийн эрх үүргийн уялдааг хангах чиглэлээр:

- Аж ахуйн, нэгж байгууллагын ХАБЭМ-ийн зохион байгуулалтад тавигдах шаардлага болон ХАБЭМ-ийн асуудлаар ажил олгогчийн эрх, үүргийн талаарх зохицуулалтуудыг нь харилцан уялдаатай болгох;
- Аж ахуйн, нэгж байгууллагын ХАБЭМ-ийн зохион байгуулалтад тавигдах шаардлагыг шинэчлэн сайжруулах;
- Албан бус салбар, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч нарыг ҮОМШӨ-нөөс урьдчилан сэргийлэх зохицуулалтыг бий болгох;
- Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний үр дүнг ХАБЭМ-ийн асуудал хариуцсан байгууллагад мэдээлэх, эрсдэл, аюулыг арилгах арга хэмжээний үр дүнг эргэн мэдээлэх байдлаар ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах механизмыг бий болгох.

2.1.9 ҮОМШӨ-ний бүртгэл, мэдээлэл, статистикийг боловсронгуй болгох чиглэлээр:

- Мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогыг бүртгэх, шалтгааныг судлан тогтоох, мэдээлэхэд эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын чиг үүргийг тодорхой болгож, зохицуулалт, уялдааг сайжруулах;
- Хөдөлмөрийн эрүүл мэндийн хугацаат үзлэгээр илрүүлсэн МШӨ-ний тохиолдлыг бүртгэх, онош баталгаажуулах, мэдээлэх зохицуулалтыг бий болгох;
- Осолд дөхсөн тохиолдлыг бүртгэх, судлах, мэдээлэх зохицуулалтыг шинээр бий болгож, үйлдвэрлэлийн ослыг бүртгэх, судлах, мэдээлэх системтэй уялдуулан сайжруулах;
- ҮОМШӨ-ний бүртгэл, мэдээлэл, хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох үйл явцыг ажилтанд төвөггүйгээр түргэн шуурхай хийж, даатгалын нэгдсэн үйлчилгээ авах боломжоор хангасан зохицуулалтыг бий болгох.

2.1.10 Ажлын байрны хөдөлмөрийн хэвийн нөхцөлөөр хангах ажилтны эрхийг баталгаажуулах:

- Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх мэргэжлийн байгууллага, мэргэжилтэнд тавигдах шаардлагыг тодорхой болгох;
- Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээгээр тогтоосон хэвийн бус нөхцөлтэй ажлын байрыг ХАБЭМ-ийн асуудал хариуцсан байгууллагад мэдээлэх, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих зохицуулалтыг нэмэх.

2.1.11 Хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг ХАБЭМ-ийн урьдчилан сэргийлэлттэй уялдсан, нэгдмэл хэлбэрээр хэрэгжүүлэх:

- Хяналтыг ХАБЭМ-ийн асуудал хариуцсан байгууллагын харьяанд нэгдмэл байдлаар хэрэгжүүлэх.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАР, ЭЭРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

3.1. Асуудлыг зохицуулах хувилбарууд

3.1.1 “Тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах:

Тандалт судалгааны хүрээнд тодорхойлсон ХАБЭА-н чиглэлээр тулгамдаж буй асуудлууд нь одоогийн хуулийн зохицуулалт хангалтгүйгээс шалтгаалсан тул “тэг” хувилбар нь оновчгүй юм.

3.1.2 Хэвлэл мэдээлэл болон бусад хэрэгслийг ашиглан олон нийтэд хандсан ухуулах сурталчилгааны ажил өрнүүлэх:

Энэ хувилбарыг сонговол ажлын байрны аюул, эрсдэлийн талаарх олон нийт, ажил олгогч, ажилтнуудын мэдлэг, хандлагыг өөрчилж болох үндэсний тогтолцоо, хөтөлбөрийн санхүүжилт, ҮОМШӨ-ний бүртгэл мэдээлэл, ХЭМ-ийн үзлэг, тандалт зэрэг тогтолцооны шинжтэй асуудалд дорвитой өөрчлөлт гарахгүй тул дангаараа асуудлыг шийдвэрлэх боломжгүй юм.

3.1.3 Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх:

Шийдвэрлэхийг зорьж буй ХАБЭА-н асуудлууд нь татвар, хураамжийн бодлого, зөвшөөрөл, лиценз, квот олгохтой холбоогүй тул уг хувилбараар шийдвэрлэх боломжгүй юм.

3.1.4 Төрөөс санхүүгийн интервенц хийх:

Уг аргаар ХАБЭА-н тулгамдсан асуудлыг шийдвэрлэх боломжгүй.

3.1.5 Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх:

Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ, ХАБЭМ-ийн мэргэжилтний сургалт, эрүүл мэндийн үзлэг зэрэг урьдчилан сэргийлэлтийн үйл ажиллагааг энэ хувилбараар шийдэж болно. ХАБЭА-н үндэсний тогтолцоо, удирдлага зохион байгуулалт, ҮОМШӨ-ний даатгалын үр нөлөө, санхүүжилттэй холбоотой асуудлыг

төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх зарчмаар шийдвэрлэх боломжгүй.

3.1.6 Захиргааны шийдвэр гаргах:

Захиргааны акт, захиргааны хэм хэмжээний актаар зарим асуудлыг шийдвэрлэж болох ч бүхэлд нь шийдэх боломжгүй.

3.1.7. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах:

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах замаар дээрх тулгамдсан асуудлыг зохицуулах зохицуулалтыг бий болгож, шийдвэрлэх бүрэн боломжтой.

Дээрх хувилбаруудыг харьцуулан тулгамдсан асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй байдлаар үнэлэхэд нягталж, “тэг”, хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулах сурталчилгааны ажил өрнүүлэх, зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх, төрөөс санхүүгийн интервенц хийх, төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх хувилбарууд үр дүнгүй байна.

Иймд асуудлыг захиргааны шийдвэр гаргах, хууль тогтоомжийн төслийг боловсруулах хувилбарын үр нөлөөг нарийвчлан тооцохоор шийдвэрлэв.

3.2 Зохицуулалтын хувилбаруудын зэрэг болон сөрөг талын харьцуулалт

3.2.1 Зорилгод хүрэх байдлын харьцуулалт

Захиргааны шийдвэр гаргах, хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбаруудыг зорилгод хүрэх байдлаар нь харьцуулан дараах хүснэгтээр үзүүлэв.

Зорилгод хүрэх байдлын харьцуулалт

Хүснэгт 2

Д/д	Зорилго	Сонгосон хувилбар	
		Захиргааны шийдвэр гаргах	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах
1	ХАБЭА-н тухай хуулийг ОУХБ-ын конвенцод нийцүүлэх	Захиргааны шийдвэр гаргах замаар МУ-ын хууль тогтоомжийг олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэх боломжгүй.	Олон улсын гэрээ, конвенцын шаардлага, нөхцөлийг тусгасан тодорхой зохицуулалтыг хуульд оруулах замаар шийдвэрлэнэ.
2	ХАБЭА-н тухай хууль болон бусад хуулийн уялдааг хангах	Захиргааны шийдвэрээр хууль хоорондын уялдааг хангах боломжгүй.	ХАБЭА-н тухай болон бусад хуульд зохих нэмэлт, өөрчлөлтийг оруулах байдлаар хуулийн уялдааг хангана.
3	Ажлын байранд тавигдах ХАБЭА-н нөхцөлд тавигдах шаардлагын талаарх	Ажлын байрны ХАБЭА-н нөхцөлд тавигдах дэлгэрэнгүй шаардлагыг дан ганц захиргааны актаар	Өнөөгийн хуульд заасан ажлын байрны ХАБЭА-н нөхцөлд тавигдах үндсэн шаардлагыг тогтоож, техникийн зохицуулалт,

	зохицуулалтыг сайжруулах	тогтоож, мөрдүүлэх боломжгүй. Өнөөгийн хуульд ХАБЭА-н үндсэн шаардлагыг тогтоосон тул захиргааны акт хуулийн энэ заалтаас давж зохицуулах боломжгүй юм.	стандартаар нарийвчлан зохицуулах хуулийн үндэслэлийг бий болгох шаардлагатай. Цаг үеийн өөрчлөлттэй нийцүүлэн стандарт, техникийн зохицуулалтын шинэчлэлийг тогтмол хэрэгжүүлэх зохицуулалтыг хуулиар тогтоох шаардлагатай.
4	Эрүүл мэндийн үзлэгийн талаарх зохицуулалтыг сайжруулах	ХЭМ-ийн үзлэг, тандалтын асуудал нь хөдөлмөр, эрүүл мэндийн салбарын хуулиар зохицуулагддаг тул хуулиас давж захиргааны актаар зохицуулах боломжгүй.	ХЭМ-ийн үзлэг, тандалтын зорилго, зохион байгуулалтад тавигдах шаардлага, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын чиг үүргийг хуулиар зохицуулах нь ажиллагчдын дунд МШӨ-нийг эрт илрүүлэх, бүртгэл, мэдээллийг сайжруулах, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх боломжийг олгоно.
5	Мэргэшсэн, чадварлаг мэргэжилтнээр салбарын хүний нөөцийг бүрдүүлэх	Хуульд ХАБЭА-н мэргэжилтэн болон инженер техникийн мэргэжилтэй ХАБЭА-н ажилтан гэсэн зөрүүтэй ойлголт байдаг ба үүнийг захиргааны актаар зохицуулах оролдлогууд үр дүнд хүрээгүй.	ХАБЭА-н ажилтан, мэргэжилтний тодорхойлолтыг хуульд оруулж, МУ-д нэн яаралтай ХАБЭМ-ийн мэргэжилтнүүдийг бэлтгэх, чадамжийг нь баталгаажуулах, мэргэжлийн холбоодын үүрэг, оролцоог тодорхой болгосон зохицуулалтыг бий болгох шаардлагатай.
6	ХАБЭМ-ийн тогтолцоог сайжруулах	Үндэсний тогтолцоог захиргааны актаар тодорхойлж, зохицуулах боломжгүй.	Өнөөгийн хуульд заасан ХАБЭА-н асуудал хариуцсан байгууллагын тогтолцоог Үндэсний тогтолцоо болгон дахин тодорхойлж, үүнд хамаарах талууд, тэдгээрийн чиг үүргийг

			тодорхой болгох шаардлагатай.
7	Урьдчилан сэргийлэлтэд чиглэсэн ҮОМШӨ-ний даатгалын зохицуулалтыг бий болгох	ҮОМШӨ-ний даатгалын асуудлыг хуулиар тогтоодог тул захиргааны актаар шийдвэрлэх боломжгүй.	ХАБЭА-н урьдчилан сэргийлэх болон зарим асуудлыг ҮОМШӨ-ний даатгалын сангаас санхүүжүүлэх зохицуулалтыг бий болгосноор асуудлыг шийдвэрлэнэ.
8	Аж ахуйн нэгж, байгууллагын ХАБЭА-н зохион байгуулалт болон ажил олгогчийн эрх, үүргийн уялдааг хангах	Уг асуудлыг ХАБЭА-н тухай хуулиар зохицуулсан тул захиргааны актаар зохицуулбал хуулийн заалттай зөрчилдөнө.	Хуульд заасан зохицуулалтыг хянаж, олон улсын гэрээ, конвенцод заасан шаардлагад нийцүүлэн сайжруулах байдлаар асуудлыг шийдвэрлэх боломжтой.
9	ҮОМШӨ-ний бүртгэл, мэдээлэл, статистикийг боловсронгуй болгох	Уг асуудлыг ХАБЭА-н хууль болон захиргааны актаар зохицуулдаг. Иймд захиргааны акт дангаараа асуудлыг шийдвэрлэж чадахгүй.	ҮО болон осол дөхсөн тохиолдлыг бүртгэх, мэдээлэх, МШӨ болон хурц хордлогыг бүртгэн, мэдээлэх зохицуулалтыг хуульд зааж, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүргийг тодорхой болгох байдлаар асуудлыг шийдвэрлэнэ.
10	Ажлын байрны хөдөлмөрийн хэвийн нөхцөлөөр хангах ажилтны эрхийг баталгаажуулах	Уг асуудал ХАБЭА-н тухай хуулиас гадна Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хуулиар зохицуулагддаг тул захиргааны актаар шийдвэрлэх боломжгүй.	Хуульд хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлтэй байгууллагуудын мэдээллийг ХАБЭМ-ийн асуудал хариуцсан байгууллага бүртгэж, нөхцөлийг сайжруулах арга хэмжээнд хяналт тавих зохицуулалт бий болсоноор асуудал шийдвэрлэх боломжтой.
11	Хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг ХАБЭМ-ийн урьдчилан сэргийлэлттэй уялдсан, нэгдмэл	Захиргааны актаар зохицуулах боломжгүй.	ХАБЭМ-ийн асуудал хариуцсан байгууллагын чиг үүрэгт ХАБЭА-н хяналтыг оруулах зохицуулалт хийснээр, илүү нэгдмэл тогтолцоо

хэлбэрээр хэрэгжүүлэх	бүрдэж, асуудлыг шийдвэрлэнэ.
-----------------------	-------------------------------

3.2.2 Зардал, үр өгөөжийн харьцаа болон үр дүнгийн харьцуулалт

ХАБЭА-н урьдчилан сэргийлэх болон зарим асуудлыг ҮОМШӨ-ний даатгалын сангаас санхүүжүүлэх зохицуулалтыг бий болгосноор захиргааны шийдвэр гаргах, хэрэгжүүлэх төрийн байгууллагуудад зардал үүсгэнэ. Ажил олгогч, хувийн хэвшлийн байгууллагуудын өнөөгийн ХАБЭА-н тухай хуулиар хүлээсэн үүрэг хүлээж, зардал төлөвлөж, зарцуулах зохицуулалттай. Үүн дээр нэмж зардал гарахгүй. ҮОМШӨ-ний даатгалыг урьдчилан сэргийлэх арга хэмжээтэй уялдуулсан зохицуулалттай болсноор аж ахуйн нэгж, байгууллага, ажил олгогч нарын ХАБЭА-н урьдчилан сэргийлэх арга хэмжээ, түүний зардалд санхүүгийн дэмжлэг үзүүлэх эерэг нөлөөтэй.

Зардал, үр өгөөжийн харьцаа болон үр дүнгийн харьцуулалт

Хүснэгт 3

Д/д	Хувилбар	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Захиргааны шийдвэр гаргах	Тодорхой зардал гарна. Асуудлыг үүсгэж буй үндсэн шалтгааныг шийдвэрлэж чадахгүй.	Үр дүнгүй
2	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Зардал гарах боловч уг хувилбар нь асуудлыг үүсгэж буй шалтгааныг шийдвэрлэх боломжтой.	Үр дүнтэй

3.3 Хамгийн үр дүнтэй хувилбарын тухай

Сонгосон хувилбаруудыг зорилгод хүрэх байдлаар нь харьцуулан судалж, ажилтан, ажил олгогчдын төлөөлөл, ХАБЭМ-ийн мэргэжилтнүүд, асуудал хариуцсан төрийн байгууллагын санал, дүгнэлт, өмнө нь хийгдсэн судалгааны зөвлөмжид үндэслэн “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар” хамгийн үр дүнтэй нь гэж тодорхойлогдов.

ХАБЭМ-ийн салбарын хөгжлийн чиг хандлага, олон улсын гэрээ, конвенцын шаардлагад нийцүүлэн **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай** хууль нэртэй шинэчилсэн найруулгын төслийг бэлтгэж, ажил, хөдөлмөр эрхлэгч хүний эрүүл мэнд, аюулгүй байдлыг ажлын байрны сөрөг хүчин зүйлсээс хамгаалах, ҮОМШӨ-нөөс урьдчилан сэргийлэхэд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зохицуулалтыг тусгана. Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл дараах бүтэцтэй боловсруулагдана. Үүнд:

- Нийтлэг үндэслэл
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлага
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний тогтолцоо
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэлт
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний бүртгэл, мэдээлэл, хөдөлмөр зохицуулалт, сэргээн засах тусламж үйлчилгээ

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, маргаан шийдвэрлэх

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨ

4.1 Хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

4.1.1 Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Тандан судалгааны явцад сонгосон “Хуулийн төсөл боловсруулах” зохицуулалтын хувилбарын хүрээнд хүний эрхэд сөрөг нөлөө үзүүлэхгүй бөгөөд олон улсын гэрээ, конвенц, зөвлөмжид нийцүүлэн боловсруулна. Хууль нь Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон хөдөлмөрийн аятай таатай нөхцөлөөр хангагдах иргэн хүний эрхийг хамгаалахад чиглэсэн.

4.1.2 Эдийн засагт үзүүлэх нөлөө

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь дотоод болон гадаадын аж ахуйн нэгж, байгууллагад эдийн засгийн сөрөг нөлөө үзүүлэхгүй. Урьдчилан сэргийлэлтэд суурилсан ҮОМШӨ-ний даатгалын зохицуулалтыг бий болгосноор ажил олгогч, даатгуулагчид ХАБЭМ-ийн урьдчилан сэргийлэлт, ХЭМ-ийн тусламж үйлчилгээ авахад санхүүгийн дэмжлэг авах эерэг нөлөөтэй.

4.1.3 Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Хуулийн төсөл боловсруулах нь эрүүл, аюулгүй ажлын байрыг бий болгоход ажилтан, ажил олгогч, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн байгууллагын эрх, үүргийг тодорхой болгож ажил, хөдөлмөр эрхлэгч хүн амын дундаж наслалт, амьдралын чанарт эергээр нөлөөлнө.

4.1.4 Байгаль орчинд үзүүлэх нөлөө

Сонгосон хувилбараас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө байхгүй. Хуулийн шинэчилсэн зохицуулалтын хүрээнд уул уурхай, зам тээврийн салбарын ажлын байруудад тоосжилт, шуугианыг бууруулахад тавигдах шаардлага сайжирснаар байгаль орчныг хамгаалахад эерэг нөлөөтэй.

4.2 Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдсэн олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх талаар

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдсэн олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулна.

Хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, бүрэн гүйцэд зохицуулах үүднээс шинэчилсэн найруулгын төсөлтэй уялдуулан Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэрэгцээ шаардлагыг тандан судлахад ХАБЭА-н хууль тогтоомжийн хүрээнд дараах асуудал тулгарч байна:

- ХАБЭА-н тухай хуулийг ОУХБ-ын конвенцод нийцүүлэх;
- ХАБЭА-н тухай хууль болон бусад хуулийн уялдааг хангах;
- Ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлд тавигдах шаардлагыг сайжруулах;
- Эрүүл мэндийн үзлэгийн талаарх зохицуулалтыг сайжруулах;
- Мэргэшсэн, чадварлаг мэргэжилтнээр салбарын хүний нөөцийг бүрдүүлэх;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тогтолцоог сайжруулах;
- ҮОМШӨ-ний даатгалыг урьдчилан сэргийлэлтэд суурилсан зарчмаар хөгжүүлэх;
- Аж ахуйн нэгж, байгууллагын ХАБЭА-н зохион байгуулалт болон ажил олгогчийн эрх, үүргийн уялдааг хангах;
- ҮОМШӨ-ний бүртгэл, мэдээлэл, статистикийг боловсронгуй болгох;
- Ажлын байрны хөдөлмөрийн хэвийн нөхцөлөөр хангах ажилтны эрхийг баталгаажуулах;
- Хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг ХАБЭМ-ийн урьдчилан сэргийлэлттэй уялдсан, нэгдмэл хэлбэрээр хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлыг “тэг”, “хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулах сурталчилгааны ажил өрнүүлэх”, “зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх”, “төрөөс санхүүгийн интервенц хийх”, “төрийн бус байгууллага”, “хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх”, “захиргааны шийдвэр гаргах”, “хууль тогтоомжийн төсөл боловсруулах” хувилбаруудыг харьцуулан үнэлэхэд хамгийн үр дүнтэй нь **“хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар”** байна.

Тандан судалгаагаар захиргааны шийдвэр гаргах болон хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг нарийвчлан харьцуулж үзсэн бөгөөд хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарын хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг дэлгэрэнгүй судлав.

Хүний эрхэд үзүүлэх үр нөлөөний хувьд энэ талаарх олон улсын конвенцод нийцсэн ба хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулахгүй, жендерийн эрх тэгш байдлыг хангана.

Эдийн засагт үзүүлэх үр нөлөөний хувьд уг хувилбар нь аж ахуйн нэгж, байгууллагад эдийн засгийн нэмэлт ачаалал үүсгэхгүй. ҮОМШӨ-ний урьдчилан сэргийлэлтэд даатгалаас тодорхой санхүүгийн дэмжлэг үзүүлэх эерэг нөлөө бүхий зохицуулалттай болно.

Нийгэмд үзүүлэх үр нөлөөллийн хувьд сөрөг нөлөө байхгүй бөгөөд ажил, хөдөлмөр эрхлэгчдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зохицуулалтыг сайжруулснаар хүн амын дундаж наслалт, амьдралын чанарт эерэг нөлөөтэй.

Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө байхгүй ба уул уурхай, зам, барилга зэрэг гадна байрлах ажлын байруудад тоосжилт, агаарын бохирдлыг бууруулж, байгаль орчныг хамгаалахад эерэг нөлөөтэй зохицуулалт хуульд тусгана.

Энэхүү тандан судалгаагаар тодорхойлсон үндсэн 12 асуудал болон бусад холбогдох асуудлыг шийдвэрлэхийн тулд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн зүйл, заалтын 50-аас илүү хувь нь өөрчлөгдөхөөр байгаа тул тус хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах нь зүйтэй гэж дүгнэж байна.

ЗУРГАА. ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

1. ОУХБ-ын конвенц

Монгол Улс 2024 оны байдлаар ОУХБ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай 155 дугаар суурь конвенц, ОУХБ-ын Барилгын салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай 167 дугаар конвенц, ОУХБ-ын Уул уурхай дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай 176 дугаар конвенц зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай ОУХБ-ын гурван конвенцод нэгдэн оржээ.

Монгол Улс ОУХБ-ын 155 дугаар конвенцод 1998 онд нэгдэн орсноос хойш Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай бие даасан хуультай болж, ажлын байран дахь аюултай хүчин зүйлсээс ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр ахиц дэвшлүүд гарч, засгийн газар, ажил олгогч, ажилтны төлөөллийг багтаасан удирдлагын тогтолцоо бий болж, ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн нөхцөл сайжирсан байна. Түүнчлэн эдийн засгийн салбарын хөгжилтэй холбоотойгоор ХАБЭМ-ийн өндөр эрсдэлтэй уул уурхай, барилгын салбар дахь хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай ОУХБ-ын 167, 176 дугаар конвенцод 2015, 2020 онд тус тус нэгдэн орсон байна.

Монгол Улсад засгийн газар, ажил олгогч, ажилтны (нийгмийн түншлэгч талуудын) төлөөллийн оролцоо бүхий ХАБЭМ-ийн тогтолцоог бий болгон хөгжүүлсээр байгаа ч салбарын хууль эрх зүй, бодлого, мэргэжлийн хүний нөөц, мэргэжлийн үйлчилгээний дэд бүтэц, хяналтыг улам сайжруулах хэрэгцээ шаардлага тулгарч байна.

ОУХБ-аас баталсан ХАБЭМ-ийн талаарх хоёр суурь конвенцын нэг болох ОУХБ-ын ХАБЭМ-ийг дэмжих суурь тогтолцооны тухай 187 дугаар конвенцод манай улс нэгдэн ороогүй. Гэхдээ 155 дугаар конвенцын хэрэгжилтийн хүрээнд 187 дугаар конвенцоор тогтоосон үндэсний түвшинд ХАБЭМ-ийн тогтолцоог улам бэхжүүлэх замаар ажиллагчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалахад чиглэсэн хэм хэмжээг мөрдөх үүрэг хүлээдэг. 187 дугаар конвенцын нийцлийг бүрэн хангах чиглэлээр:

- Жижиг, дунд үйлдвэрлэл, албан бус эдийн засгийн ХАБЭМ-ийн нөхцөлийг дэвшилттэйгээр сайжруулахад дэмжлэг үзүүлэх механизм бүхий зохицуулалт бий болгох чиглэлээр;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний тогтолцоог дахин тодорхойлж, ХАБЭМ-ийн урьдчилан сэргийлэх үйлчилгээ үзүүлэгч, ХЭМ-ийн тусламж үйлчилгээ үзүүлэгч, ХАБЭМ-ийн мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээ, ХАБЭМ-ийн судалгааг хариуцсан талуудыг үндэсний тогтолцоонд тодорхой зааж, санхүүжилтийг тодорхой болгох, мэргэжлийн чадварлаг хүний нөөцийг бэлтгэхэд чиглэсэн зохицуулалтыг бий болгох;

- ҮОМШӨ-ний бүртгэл, мэдээллийн талаарх зохицуулалтыг боловсронгуй болгож сайжруулах;
- Хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг, тандалт, МШӨ-ний эрт илрүүлэг, оношилгооны зохион байгуулалт, ХЭМ-ийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллага, мэргэжилтэнд тавигдах шаардлагыг тодорхой болгох хэрэгцээ тодорхойлогдов.

2. Бусад улсын туршлага

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчлэлтэй холбоотой тулгамдаж буй асуудлаар Их Британи, Сингапур, Малайз улсын хуулийн зохицуулалтыг харьцуулан судлав. Их Британи, Малайз, Сингапур, Монгол Улсын ХАБЭА-н талаарх хууль тогтоомжийг харьцуулан судлахад, эдгээр улсын хууль эрх зүйн тогтолцоо, эдийн засгийн хөгжил, соёлын онцлогоос хамааран нийтлэг болон ялгаатай талууд ажиглагддаг.

Их Британи:

Их Британийн ажлын байрны аюулгүй байдлыг зохицуулдаг үндсэн хууль нь 1974 оны "Эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай" хууль юм.³³ Энэхүү хууль ажил олгогч нь ажилтан болон тэдний үйл ажиллагаанд өртөж буй бусад хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй байдал, сайн сайхан байдлыг хангах үүрэг хүлээдэг. Хуулийн хэрэгжилтийг "Эрүүл мэнд, аюулгүй байдлын гүйцэтгэх газар гэх байгууллага хариуцаж ажиллаж, зөвлөн туслах үйлчилгээ, хяналт шалгалтыг явуулдаг.

- **Эрүүл мэнд, аюулгүй байдлын агентлаг** нь Их Британид хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, хяналт тавих үндсэн байгууллага юм. Уг агентлаг нь 1974 оны "Эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай" хуулиар байгуулагдсан бөгөөд дараах үндсэн чиг үүрэгтэйгээр байгуулагдсан байна:
 - **Хуулийн хэрэгжилтийг хянах:** Ажлын байрны хяналт хийж, хууль, дүрэм, стандартыг мөрдөж байгаа эсэхийг шалгадаг. Зөрчил илэрсэн тохиолдолд сайжруулах мэдэгдэл гаргах, үйл ажиллагааг зогсоох, эсвэл торгууль, эрүүгийн хариуцлага ногдуулах эрхтэй.
 - **Зөвлөмж, удирдамж өгөх:** Ажил олгогч, ажилтанд зориулсан практик удирдамж, зөвлөмжийг гаргаж, эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудлаар мэдээлэл, зөвлөгөө өгдөг.
 - **Судалгаа, шинжилгээ хийх:** Эрүүл мэнд, аюулгүй байдлын агентлаг нь хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой судалгаа, шинжилгээ хийж, бодлого боловсруулахад шаардлагатай мэдээлэл цуглуулдаг.
 - **Сургалт, сурталчилгаа явуулах:** Ажилтан болон ажил олгогчийн мэдлэг, ойлголтыг сайжруулахын тулд сургалт зохион байгуулах, сурталчилгаа явуулах ажлыг хариуцдаг.
 - **Стандарт тогтоох:** Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлын стандарт, шаардлагыг боловсруулж, мөрдүүлэхэд анхаардаг.

³³ UK, Health and Safety at Work Act, 1974 <http://www.legislation.gov.uk/ukpga/1974/37/contents>

- **Хяналт шалгалт хийх:** Эрүүл мэнд, аюулгүй байдлын агентлаг нь ажлын байранд хяналт шалгалт хийж, аюулгүй байдлын нөхцөл байдалд үнэлгээ өгдөг. Хэрэв ноцтой зөрчил илэрвэл сайжруулах эсвэл үйл ажиллагааг зогсоох мэдэгдэл гаргадаг.
- **Шийтгэл хүлээлгэх:** Хууль зөрчсөн байгууллагад торгууль ногдуулах, үйл ажиллагааг зогсоох, эрүүгийн хариуцлага хүлээлгэх зэрэг арга хэмжээг авах эрхтэй. Зорилго нь ажилчдын аюулгүй байдлыг хангаж, осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэгддэг.
- Эрүүл мэнд, аюулгүй байдлын агентлаг нь хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг дээшлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж, ажилчдын сайн сайхан байдлыг хангахад ихээхэн хувь нэмэр оруулдаг.
- **Талуудын ерөнхий үүрэг:** Ажлын байранд аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг хангуулахад зөвхөн ажилтан, ажил олгогчоос гадна ажлын орчинд байгаа бусад хүмүүс, орчны агаар тоос, хорт бодис ялгаруулах үйл ажиллагаа эрхлэгч, үйлдвэрлэлд хэрэглэгдэг бараа материал үйлдвэрлэгч нарын үүргийг тусгайлан заасан. Мөн ажлын байранд эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зориулалтаар хэрэглэдэг хэрэглэгдэхүүнийг зориулалтын бусаар, буруу хэрэглэхийг хориглосон зохицуулалттай.
- **Хөдөлмөрийн эрүүл мэндийн үйлчилгээг эмнэлгийн мэргэжилтэн дараах байдлаар үзүүлэхээр зохицуулсан нь ажилчдын эрүүл мэнд, сайн сайхан байдлыг хангахад урьдчилан сэргийлэх эмнэлгийн хяналт, мэргэжлийн зөвлөгөөгөөр дамжуулан чухал үүрэг гүйцэтгэдэг.**
 - **Зөвлөгөө, тусламж:** Ажлын байран дахь эрүүл мэндийн эрсдэлтэй холбоотой үүсэх өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн зөвлөмж арга хэмжээ, удирдамжийг ажил олгогч болон ажилтнуудад санал болгох;
 - **Эмнэлгийн тандалт:** Аюултай хөдөлмөрийн нөхцөлд өртдөг ажилтнуудын эрүүл мэндэд үзлэг хийх, эрсдэлийн үнэлгээ хийж эрүүл мэндийн эрсдэлийн стандартын шаардлага хангаж хуулийн хэрэгжилтийг хангаж буй эсэхэд хяналт тавих;
 - **Зохицуулах байгууллагуудыг дэмжих:** Хөдөлмөрийн эрүүл мэндийн үйлчилгээний хүрээнд эмнэлгийн мэргэжилтнүүд нь Эрүүл мэнд, аюулгүй байдлын агентлагт эрүүл мэндийн зохицуулалтыг боловсруулах, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх;
 - **Ажлын байртай холбоотой эрүүл мэндийн асуудлыг судлах:** Ажлын холбогдолтой өвчлөлийн тохиолдлыг судалж, шаардлагатай эрүүл мэндийн арга хэмжээг зөвлөдөг.
- **Хувиараа хөдөлмөр эрхлэгчид ажил, хөдөлмөр эрхлэхдээ өөрийн болон бусдын эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл учруулахгүй байх үүрэг хариуцлагыг заасан. Үүнд:**
 - **Бусдад аюул учруулахгүй байх үүрэг:** Хувиараа хөдөлмөр эрхлэгч хүн ажил хийхдээ бусдад аюул учруулахгүй байх бүх арга хэмжээг авах ёстой. Үүнд үйлчлүүлэгч, зочин, олон нийтэд осол, эрсдэл үүсгэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;

- **Өндөр эрсдэлтэй ажлын үед мөрдөх журам:** Хувиараа хөдөлмөр эрхлэгч хүн барилга, хөдөө аж ахуй гэх мэт өндөр эрсдэлтэй салбарт ажилладаг бол ажил олгогчид тавигдах эрүүл мэнд, аюулгүй байдлын бүх шаардлагыг нэгэн адил дагаж мөрдөх;
- **Эрсдэлийн үнэлгээ:** Хувиараа хөдөлмөр эрхлэгч хүн ажлынхаа эрсдэлийг үнэлж, боломжит аюулыг илрүүлэн, эрсдэлийг үр дүнтэй удирдах арга хэмжээг хэрэгжүүлэх;
- **Аюулгүй ажиллагааны дадал, сургалт:** Хувиараа хөдөлмөр эрхлэгч хүмүүс бусдад ажил олгогч биш ч гэсэн аюулгүй ажиллагааны дадлыг баримталж, хэрэв ажил нь аюултай үйл ажиллагаатай холбоотой бол шаардлагатай сургалтад хамрагдах.

Малайз:

Малайзын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хууль нь 1994 онд батлагдсан юм.³⁴ 2024 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон.

Хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр тус хууль бүх ажлын байрыг хамрах хүрээгээ өргөжүүлж, ажил олгогчдод шинэ үүрэг хариуцлага ногдуулан, зөрчилд тавих торгуулийг нэмэгдүүлсэн. Одоо ажил олгогчид эрсдэлийн үнэлгээ хийх, яаралтай тусламжийн журам боловсруулах, тав ба түүнээс дээш ажилтантай ажлын байранд аюулгүй байдал, эрүүл ахуйн зохицуулагч томилох үүрэгтэй болсон. Хуулийн хэрэгжилтийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн газар нь хариуцдаг.

- **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн газар 1994 онд** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн дагуу байгуулагдсан бөгөөд ажлын байранд аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах дараах үндсэн үүрэгтэй төрийн байгууллага юм. Үүнд:
 - ХАБЭМ-ийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, бусад хууль, дүрэм, стандартыг хэрэгжүүлэх, мөрдүүлэх;
 - Ажлын байранд төрийн хяналт, шалгалт явуулж, аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаж буй эсэхийг шалгах;
 - Аюултай бодис, тоног төхөөрөмж ашиглах, үйлдвэрлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл, лиценз олгох;
 - Ажил олгогч, ажилчдад аюулгүй ажиллагааны талаар сургалт зохион байгуулах, мэдээлэл, зөвлөгөө өгөх;
 - Ажлын байрны осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгаан, нөхцөлийг судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ боловсруулах.
- **Талуудын үүрэг.** Хуульд ажил олгогч аюулгүй ажлын орчин бүрдүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх, ажилчдыг аюулгүй ажиллагааны талаар сургаж, мэдээллээр хангах, тав ба түүнээс дээш ажилтантай ажлын байранд аюулгүй байдлын зохицуулагч

³⁴ Laws of Malaysia Act 514, Occupational Safety and Health Act, 1994

<https://legal.usm.my/ihocadownload/laws/Occupational%20Safety%20and%20Health%20Act%20-%20Act%20514.pdf>

томилох үүрэгтэй. Ажилчид өөрийн болон бусдын аюулгүй байдалд анхаарч, ажил олгогчийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг дагаж мөрдөх;

- **Хөдөлмөрийн эрүүл мэндийн дараах шаардлагыг голчлон ХАБЭМ-ийн тухай хууль болон холбогдох дүрэм, журмаар зохицуулдаг:**
 1. **Эмнэлгийн тандалт.** Ажил олгогч аюултай бодист өртдөг болон өндөр эрсдэлтэй орчинд ажиллаж буй ажилтнаа тогтмол эмнэлгийн тандалтад хамруулах үүрэгтэй. Үүнд ажлын холбогдолтой өвчлөлийн эхэн үеийн шинж тэмдгийг илрүүлэх эрүүл мэндийн үнэлгээ багтдаг. 2000 оны ажлын байран дахь аюултай химийн бодис ашиглалт, өртөлтийн стандартаар эмнэлгийн тандалтын нарийвчилсан асуудлыг зохицуулдаг.
 2. **Хөдөлмөрийн эрүүл мэндийн үйлчилгээ.** Ажил олгогч ажилтны эрүүл мэндийг хянах, дэмжих хөдөлмөрийн эрүүл мэндийн иж бүрэн үйлчилгээг хэрэгжүүлэхийг зөвлөдөг. 2005 оны Хөдөлмөрийн эрүүл мэндийн үйлчилгээний удирдамж нь эрүүл мэндийн үнэлгээ хийх, ажлын байрны эрсдэлийг үнэлэх, эрүүл мэндийн боловсрол олгох харилцааг зохицуулсан.
 3. **Хөдөлмөрийн эрүүл мэндийн эмч томилох.** Эрүүл мэндийн өндөр эрсдэлтэй ажлын байранд ажил олгогч эмнэлгийн тандалт хийх, эрүүл мэндийн асуудлаар зөвлөгөө өгөх үүрэг бүхий хөдөлмөрийн эрүүл мэндийн мэргэшсэн эмчийг томилох үүрэгтэй. Эдгээр эмч нар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн газарт бүртгэлтэй байна.
 4. **Мэргэжлээс шалтгаалсан өвчний тайлагнал.** Ажил олгогч ажлын холбогдолтой өвчин, хордлого тохиолдсон тохиолдолд ХАБЭМ-ийн газарт мэдэгдэх үүрэгтэй.
- **Хувиараа хөдөлмөр эрхлэгч хүн ХАБЭМ-ийн талаарх дараах үүргийг хүлээдэг. Үүнд:**
 - Өөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор ажлын үйл ажиллагааны явцад бүх боломжит арга хэмжээг авах үүрэгтэй. Ажлын байрны ойролцоох зочид, үйлчлүүлэгч, бусад хүмүүс, олон нийтэд аюул учруулахгүйгээр зохион байгуулах;
 - **Аюулгүй ажиллах нөхцөлийг хангах:** Ажлын орчныг аюулгүй байлгах, тоног төхөөрөмжийн зохистой байдлыг хангах, аюултай бодисыг аюулгүйгээр ашиглах;
 - **Мэдээлэл, сургалтаар хангагдах:** Хувиараа хөдөлмөр эрхлэгчид өөрийн ажлаа аюулгүй явуулах мэдлэг, сургалтад хамрагдсан байх;
 - **Хууль тогтоомжийг дагаж мөрдөх:** Тэдний ажлын үйл ажиллагаанд хамаарах ХАБЭМ-ийн бодлогыг хэрэгжүүлэх, мөрдөх.

Сингапур:

Сингапурын "Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" хууль нь гүйцэтгэлд суурилсан хандлагыг баримталж, аюулыг эх үүсвэр дээр нь бууруулах,

ажил олгогчийн өөрийн зохицуулалтыг дэмжихэд чиглэдэг.³⁵ Энэхүү хууль нь оролцогч талуудад ажлын байранд аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах боломжит арга хэмжээг авахыг шаарддаг. Үүнд эрсдэлийн үнэлгээ хийх, хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэх, тогтмол аюулгүй байдлын хяналт хийх зэрэг орно.

- **Гүйцэтгэлд суурилсан хандлага:** Ажлын байрны аюулгүй байдлыг хангах үүрэг хариуцлага нь ажил олгогч, ажилтан, холбогдох бүх талуудад ногдож, аюулыг эх үүсвэр дээр нь бууруулахад чиглэсэн.
- **Ажил олгогчийн үүрэг:**
 - Ажил олгогч ажлын байран дахь эрсдэлийг тодорхойлж, үнэлгээ хийх, эрсдэлээс хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх;
 - Ажилчдыг аюулгүй ажиллагааны талаар сургаж, мэдээллээр хангах;
 - Аюулгүй байдлыг хариуцсан ажилтан томилох.
- **Ажилтны үүрэг:**
 - Ажилтан ажлын байран дахь аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг дагаж мөрдөх;
 - Өөрийн болон бусдын аюулгүй байдалд анхаарч, ажил олгогчтой хамтран ажиллах.
- **Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон гэрээт ажилчдын үүрэг:**
 - Өөрөө болон бусдын аюулгүй байдлыг хангах үүрэг хүлээх;
 - Ажлын байранд үйл ажиллагаагаа бусдад аюул учруулахгүйгээр зохион байгуулах.

Хяналт:

- Хөдөлмөрийн яам нь хуулийн хэрэгжилтийг хариуцаж, ажлын байранд хяналт шалгалт явуулдаг. Тэд эрсдэлийн үнэлгээ хийх, аюулгүй ажиллагааны журмыг дагаж мөрдөхийг шаардаж, зөрчил гаргасан тохиолдолд торгууль, шийтгэл оногдуулдаг.
- Аюултай нөхцөл байдал, ослын талаар мэдэгдэл хүлээн авч, цаг алдалгүй арга хэмжээ авдаг.

Хөдөлмөрийн эрүүл мэндийн шаардлага:

- **Эмнэлгийн тандалт, үзлэг:** Өндөр эрсдэлтэй ажлын байранд ажилтныг тогтмол эрүүл мэндийн үзлэгт хамруулах үүрэгтэй.
- **Хөдөлмөрийн эрүүл мэндийн үйлчилгээ:** Эрсдэлтэй орчинд ажиллаж буй ажилтанд зориулсан хөдөлмөрийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхийг дэмждэг.
- **Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг тайлагнах:** Ажил олгогч ажлын холбогдолтой өвчин, гэмтлийг Хөдөлмөрийн яаманд тайлагнах үүрэгтэй.

Хувиараа хөдөлмөр эрхлэгчийн үүрэг:

- Өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах;
- Ажлын байранд аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, зааварчилгааг мөрдөх.

Харьцуулсан дүгнэлт:

Их Британи, Малайз, Сингапур улсууд өргөн хүрээтэй, нарийвчилсан зохицуулалт бүхий ХАБЭМ-ийн хуультай бол Монгол Улсын хууль тогтоомж нь

³⁵ Singapore Statutes Online, Workplace Safety and Health Act 2006, <https://sso.agc.gov.sg/Act/WSHA2006>

хөгжиж буй эдийн засаг, ажлын орчны олон төрлөөс шалтгаалан хөгжлийн шатандаа байна.

Их Британи, Сингапур улсууд гүйцэтгэлд суурилсан зарчмыг баримталж, эрсдэлийн үнэлгээнд суурилан ажлын байрны аюул, эрсдэлийг арилгах зохицуулалттай. Малайзын сүүлийн үеийн нэмэлт, өөрчлөлтүүд нь илүү цогц, хатуу зохицуулалтын хүрээг бий болгож байна. Монгол Улс ХАБЭА-н стандартыг тогтоож, хяналт шалгалтаар дамжуулан мөрдүүлэхэд анхаарч байна.

Хуулийн хэрэгжилтийг хариуцах байгууллага нь Их Британид ХАБЭМ-ийн агентлаг, Малайзд ХАБЭМ-ийн газар, Сингапур улсад Хөдөлмөрийн яам нь бөгөөд хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, мэргэжлийн зөвлөн туслах үйлчилгээ, стандарт, удирдамж боловсруулах, судалгаа шинжилгээ хийх, сургалт сурталчилгаа хийх, ажилтай холбоотой осол, өвчлөлийг бүртгэх нийтлэг чиг үүрэгтэй байна. Монгол Улсад ХАБЭМ-ийн хуулийн хэрэгжилтийг хариуцан ажиллах байгууллагыг ойлгомжтой тодорхойлоогүй. Зөвхөн хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлээс шалтгаалсан өвчний асуудал хариуцсан байгууллага байх талаар ерөнхий заасан.

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль 2008 онд батлагдсанаар өмнө нь Хөдөлмөрийн тухай хуулийн нэг бүлгээр зохицуулдаг байсан ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой харилцааг бие даасан хуулиар зохицуулдаг болж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага, зохион байгуулалт, хяналт, ажил олгогч, ажилтны үүрэг, хариуцлага, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, түүний санхүүжилт зэрэг нийтлэг шаардлагуудыг бий болгосон зэрэг дэвшил гарсан. Гэвч ҮОМШӨ-ний урьдчилан сэргийлэлт хангалтгүй, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн урьдчилан сэргийлэлтийн үр нөлөөг улам сайжруулан боловсронгуй болгож шинэчлэх хэрэгцээ, шаардлага тулгарч байна.

Үүнд үндэслэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах замаар асуудлыг цогцоор нь шийдвэрлэх боломжтой гэж дүгнэн дараах зөвлөмжийг боловсруулав. Үүнд:

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах;
2. ХАБЭМ-ийн хууль тогтоомжийн зохицуулалтыг олон улсын конвенцын хэм хэмжээнд нийцүүлэн сайжруулах;
3. ҮОМШӨ-ний урьдчилан сэргийлэлтийг үндэсний түвшинд илүү үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд ХАБЭМ-ийн үндэсний тогтолцоог шинээр тодорхойлж, ХАБЭМ-ийн асуудал хариуцсан байгууллагын чиг үүрэгт төрийн хяналт шалгалт, ҮОМШӨ-ний даатгалын асуудлыг багтааж, статус, үүргийг нь тодорхой болгох;
4. Ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлд тавих шаардлага, түүнийг тогтоох стандарт, техникийн зохицуулалтын талаарх зохицуулалтыг сайжруулах;
5. МШӨ-ний эрт илрүүлэг, оношилгоо, бүртгэл, мэдээлэл, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэлтийг сайжруулахын тулд

- хөдөлмөрийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ зохицуулалтыг сайжруулж, боловсронгуй болгох;
6. Салбарын мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бий болгохын тулд ХАБЭМ-ийн мэргэжилтэнд тавигдах шаардлагыг тодорхой болгож, мэргэжлийн холбоодын оролцоог дэмжих;
 7. ХАБЭМ-ийн үр дүнтэй удирдлага, зохион байгуулалтыг нэвтрүүлэхийн тулд аж ахуйн нэгж, байгууллагын ХАБЭМ-ийн зохион байгуулалтад тавигдах шаардлагыг сайжруулах;
 8. Албан бус салбарын хөдөлмөр эрхлэгчдийн үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх зохицуулалтыг бий болгох;
 9. ҮОМШӨ-ний бүртгэл, мэдээлэл, статистик, судалгааны талаарх зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. Монгол Улсын Үндсэн хууль;
2. Хөдөлмөрийн тухай хууль, 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр;
3. Хөдөлмөрийн тухай хууль, 1999 оны 5 дугаар сарын 14-ны өдөр;
4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 оны 5 дугаар сарын 22-ны өдөр;
5. Стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, 2017 он;
6. Нийгмийн даатгалын ерөнхий хууль, 2023 он;
7. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль, 2024 он;
8. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын бүртгэл мэдээллийн систем, <http://om.inspection.gov.mn>;
9. Нийгмийн даатгалын бүртгэлийн мэдээлэл, 2024 он;
10. ХНХЯ, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2021 он;
11. Монгол Улсын Хөдөлмөр зах зээлийн дунд хугацааны эрэлт, нийлүүлэлтийн таамаглал, 2024 он;
12. О.Алтансүх, Анагаах ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл: Монгол Улс дахь Зэсийн хүдэр баяжуулах үйлдвэрийн хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөл, ажиллагсдын мэргэжлээс шалтгаалсан өвчин, түүний дарамтын судалгаа, 2023 он;
13. ХНХЯ, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний нийгэм, эдийн засгийн нөлөөллийн судалгаа, 2020 он;
14. ОУХБ-ын конвенцын жагсаалт <https://normlex.ilo.org/dyn/normlex/en/f?p=NORMLEXPUB:12000:0::NO::> ;
15. ХНХЯ, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг дэмжих тогтолцооны тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 187 дугаар конвенцыг Монгол Улсын хууль тогтоомжтой харьцуулсан үнэлгээ, 2023 он;
16. ОУХБ, ХАБЭМ-ийн нэвтэрхий толь, <https://www.iloencyclopaedia.org/part-iv-66769/occupational-hygiene-47504> ;

17. ОУХБ, ХАБЭМ-ийн нэвтэрхий толь, <https://www.iloencyclopaedia.org/part-ii-44366/occupational-health-services>;
18. Д.Нарансүх, Хөдөлмөрийн эрүүл ахуй сурах бичиг, 2022 он;
19. Eurostat Statistics Explained, [https://ec.europa.eu/eurostat/statistics-explained/index.php?title=Glossary:Carcinogenic_mutagenic_and_reprotoxic_\(CMR\)](https://ec.europa.eu/eurostat/statistics-explained/index.php?title=Glossary:Carcinogenic_mutagenic_and_reprotoxic_(CMR)) ;
20. Agents Classified by the IARC Monographs, Volumes 1–136, <https://monographs.iarc.who.int/agents-classified-by-the-iarc/>;
21. Химийн хорт болон аюултай бодис <https://legalinfo.mn/mn/detail/526>;
22. Damiran Naransukh, Frank AL. Mongolia: Failure of Total Banning of Asbestos. Ann Glob Health. 2023 Aug 2;89(1):50. doi: 10.5334/aogh.4035. PMID: 37547483; PMCID: PMC10402788. ;
23. German Social Accident Insurance, Guidelines for Occupational Medical Examinations. Prophylaxis in Occupational Medicine, 2007;
24. John Hobson, Julia Smedley, Fitness for Work: The Medical Aspects, 6th edition, 2019;
25. German Social Accident Insurance, Guidelines for Occupational Medical Examinations. Prophylaxis in Occupational Medicine, 2007;
26. ХНХС-ын 2023 оны А/173 тоот тушаал, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17048054797081>;
27. ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны мэдээлэл, <https://new.tender.gov.mn/mn/osh/certificate>;
28. Э.Эрдэнэчимэг, Хөдөлмөрийн эрүүл мэндийн мэргэжлийн хүний нөөц, эрдэм шинжилгээ илтгэл, 2024;
29. А.Цэнгэлмаа, Хөдөлмөрийн эрүүл ахуйн 2024 бага хурал:Хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ, Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ, 2024 он;
30. Д.Нарансүх, Хөдөлмөрийн эрүүл ахуйн 2024 бага хурал: Мэргэжлээс шалтгаалсан өвчний бүртгэл, мэдээллийн тогтолцоо илтгэл, 2024 он.

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 4

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх		
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Үгүй	-
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Үгүй	-
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг	Үгүй	-

	сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх		
	1.2.Оролцоог хангах		
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	-
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн		
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	-
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Үгүй	
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Үгүй	-
3. Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	

	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Үгүй	
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Үгүй	
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Үгүй	
4. Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	
5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 5

Үзүүлэх үр нөлөө		Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	-
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	-	сөрөг нөлөө байхгүй
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	-	-
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	-	Үгүй	-

болон тогтвортой байдал	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх	-	Үгүй	-
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	-	Үгүй	-
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	-	Үгүй	-
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	-	Үгүй	-
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм		сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	-	Үгүй	-
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	-	Үгүй	-
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	-	Үгүй	-
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	-	Үгүй	-
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	-	Үгүй	-
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	-	Үгүй	-
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	-	Үгүй	-

6.Инновац болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	-	-
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	-	-
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	-
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	-	-
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	-	Үгүй	-
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм		сөрөг нөлөө байхгүй
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	-	Үгүй	-
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	-
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	хамааралгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	-
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	-	Үгүй	-
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	-	-
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	-

	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	-	-
	10.3.Инфляц нэмэгдэх эсэх	-	Үгүй	-
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	тийм	-	-

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 6

Үзүүлэх үр		Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	-	Үгүй	-
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	-	Үгүй	-
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	-
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	-	Үгүй	-
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	-	Үгүй	-
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	тийм	-	-
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	-	Үгүй	-
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	-	Үгүй	-
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	-	Үгүй	-
	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	-	Үгүй	-

3. Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.2. Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	-	Үгүй	-
	3.3. Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	-	Үгүй	-
4. Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1. Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	-	Үгүй	-
	4.2. Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	-	Үгүй	-
	4.3. Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	-	Үгүй	-
	4.4. Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	-	Үгүй	-
	4.5. Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	-	Үгүй	-
5. Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1. Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	тийм	-	зэрэг нөлөө үзүүлнэ
	5.2. Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	-
	5.3. Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	тийм	-	зэрэг нөлөө үзүүлнэ
6. Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1. Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	-	Үгүй	-
	6.2. Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	-	Үгүй	-

	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	-	үгүй	-
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	-	үгүй	-
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	-	үгүй	-
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	-	үгүй	-
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	-	үгүй	-
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	-	үгүй	-
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	-	үгүй	-
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	-	үгүй	-
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	-	үгүй	-
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	-	үгүй	-

Хүснэгт 7

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр		Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	-	үгүй	-

2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	-	үгүй	-
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	-	үгүй	-
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	-	үгүй	-
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	-	үгүй	-
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	-	-	хамааралгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	-	-	хамааралгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	-	-	хамааралгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	-	-	хамааралгүй
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	-	үгүй	-
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	-	үгүй	-
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	-	үгүй	-
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	-	үгүй	-
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	-	үгүй	-
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	-	үгүй	-
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	-	үгүй	-
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	-	үгүй	-

7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	-	үгүй	-
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	-	үгүй	-

_____оо_____



**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ**

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ
ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН ТӨСЛИЙН ҮР
НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ТАЙЛАН**

**Улаанбаатар хот
2025 он**

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ
ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН
ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ТАЙЛАН**

Гарчиг

НЭГ. Ерөнхий зүйл

ХОЁР. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон байдал

ГУРАВ. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоосон байдал

ДӨРӨВ. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн байдал

4.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

4.2.“Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

4.3.“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

4.4. “Зардал тооцох” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

4.5.“Харилцан уялдааг шалгах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

ТАВ. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал

5.1. Баримтжуулалт

5.2. Дүгнэлт

5.3. Зөвлөмж

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн /цаашид “ХТТХ” гэх/ 12.1.2 дахь хэсэгт заасан аргачлалын дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсны үндсэн дээр хуулийн төслийг шинэчлэн боловсруулах хувилбарыг сонгон авч, хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн сайдтай 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдөр хамтран баталсан.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлагдсан үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулсан бөгөөд тус хуулийн төсөл батлагдан хэрэгжсэнээр хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд ямар үр дагавар, үр нөлөө үзүүлэхийг тооцох, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, харилцан уялдааг тогтоох, хуулийн төслийг ойлгомжтой, хүлээн зөвшөөрөгдөх, практикт хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилгоор Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1.3 дахь заалтад заасан аргачлалын дагуу үр нөлөөний үнэлгээг боловсрууллаа.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөний үнэлгээг дараах үе шаттайгаар хийлээ.

1. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх;
4. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ

Засгийн газрын 2016 оны 159 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д заасны дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгохдоо хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан доорх 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Ойлгомжтой байдал;
3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал;
4. Зардал тооцох;
5. Харилцан уялдаа.

“Зорилгод хүрэх байдал”: Хуулийн төсөлд туссан зүйлүүд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэж чадах эсэх; хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх; хуулийн төслөөр тавьсан зорилгод хүрч чадах эсэхийг тооцох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон.

“Ойлгомжтой байдал”:Хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн /ажил олгогч, ажилтан, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, орон нутгийн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн байгууллага/ хувьд ойлгомжтой байгаа эсэх; хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай эсэх; агуулга, хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгомжтой эсэхийг тогтоох зорилгоор энэ шалгуур үзүүлэлтийг сонголоо.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал”:Хуулийн үр дагаварт шууд хамаарах субъектүүд /ажилтан ажил олгогч, аж ахуй, нэгж байгууллага, Монгол Улсын Засгийн газар/ уг хуулийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх эсэхийг үнэлэх зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон.

“Зардал тооцох”:Хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор иргэн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээдэд нэмэлт зардал гарах эсэхийг үнэлэх зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонголоо.

“Харилцан уялдаа”: Хуулийн төслийн зүйлүүд бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой нийцэж байгаа, эсхүл зөрчилдөж байгаа эсэхэд үнэлгээ хийх шаардлагатай гэж үзэж тус шалгуур үзүүлэлтийг сонгосон.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо.

Хүснэгт 1

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 1 дүгээр зүйл.	Хуулийн төслийн 1 дүгээр зүйл тавьсан зорилгод хүрэх боломжтой байдлаар томъёологдож чадсан эсэх, хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцэж байгаа эсэхийг шалгах.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг бүхэлд нь хамруулах.	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1.1 дэх заалтад заасан аргачлалын 5 дугаар бүлэгт нийцсэн эсэхийг шалгах.
4	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хуулийн төслийг бүхэлд нь хамруулах.	Хуулийг хэрэгжүүлэх байгууллага /Монгол Улсын Засгийн газар/, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, ажил

			олгогч, ажилтан/ хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх боломжтой эсэхийг шалгах.
5	Зардал тооцох	Хуулийн төслийг бүхэлд нь хамруулах.	Хуулийн төсөл батлагдан хэрэгжсэнээр улсын төсвөөс нэмэлт хөрөнгө шаардах эсэх; иргэн, хуулийн этгээд нэмэлт зардал гарах эсэхийг шалгах.
6	Харилцан уялдаа	Хуулийн төслийг бүхэлд нь хамруулах.	“Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын 4.10-д заасан шаардлага, шалгуурыг хангасан эсэхийг шалгах.

ДӨРӨВ. УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Энэ тайлангийн 3 дугаар бүлэгт сонгосон хэсгүүдэд дээрх шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд дараах байдлаар үнэлгээ хийлээ.

4.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль анх 2008 онд батлагдсан бөгөөд үүнээс өмнө Хөдөлмөрийн тухай хуулийн нэг бүлгээр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй(ХАБЭА)-н талаарх харилцааг зохицуулж байсан¹. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль нь ажил, хөдөлмөр эрхлэгч хүнийг ажлын байрны аюултай, хортой хүчин зүйлсээс хамгаалж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин(ҮОМШӨ)-нөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн. Уг хууль хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага, зохион байгуулалт, хяналт, ажил олгогч, ажилтны үүрэг, хариуцлага, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, түүний санхүүжилт зэрэг нийтлэг шаардлагыг тусгасан 9 бүлэг, 37 зүйлтэй².

Монгол Улс Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай 155 дугаар конвенцод нэгдсэн тул Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжоо уг конвенцтой нийцүүлэх үүрэг олон улсад хүлээсэн.

Сүүлийн жилүүдэд Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль (2017 он), Хөдөлмөрийн тухай хууль (2021 он),

¹ Хөдөлмөрийн тухай хууль, 1999 оны 5 дугаар сарын 14-ны өдөр

² Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 оны 5 дугаар сарын 22-ны өдөр

Төрийн хяналт шалгалтын тухай хууль (2022 он), Нийгмийн даатгалын багц хууль (2023 он), Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль (2024 он) зэрэг хуулиудад шинэчлэгдсэн нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтэд нөлөө үзүүлэх болсон.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад хүний эрүүл мэнд, аюулгүй байдлыг зохицуулах заавал мөрдөх норматив хэмжээг техникийн зохицуулалтаар батлах, стандарт нь сайн дурын үндсэн дээр сонгон хэрэглэх зохицуулалттай болсон³.

Хөдөлмөрийн тухай хуульд “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй”-н асуудлыг олон улсын жишгээр “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд” гэж нэрлэж, ажилтныг хөдөлмөрийн хэвийн нөхцөлөөр хангах ажил олгогчийг үүргийг илүү тодорхой болгосон⁴.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчлэлээр YOMШӨ-ний даатгалын шимтгэлийг салбараар нь бус ажлын байрны эрсдэлээс хамаарч ялгаатай тогтоох дэвшил гарсан. Гэвч YOMШӨ-ний даатгалын сангаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээг санхүүжүүлэх боломж хязгаарлагдмал хэвээр байна.⁵

2024 онд батлагдсан Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуульд хөдөлмөрийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нийгмийн эрүүл мэндийн тусламж үйл ажиллагаанд хамаарна гэж заасан ч ажилтны эрүүл мэндийн үзлэг, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг оношлох, бүртгэх, мэдээлэх, хөдөлмөрийн чадвар алдалтаас сэргийлэх, ажил мэргэжлийн тохироог үнэлэх зэрэг асуудлын зохицуулалтад дэвшил гараагүй ба энэ арга хэмжээнд эрүүл мэндийн салбарын оролцоо сул байсаар байна.⁶

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг шинэчлэн боловсруулах хэрэгцээ шаардлагыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу урьдчилан тандан судалсны үндсэн дээр хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах дараах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон байна. Үүнд:

1. Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаарх конвенцууд нь “Occupational Safety and Health” буюу “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд” гэсэн өргөн агуулгаар тодорхойлогдож, бусад улс орнууд ч “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд” гэсэн нэршлээр хуулиа батлан мөрдөж байна. Мөн Хөдөлмөрийн тухай хуулийн 2021 оны шинэчилсэн найруулгаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг олон

³ Стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, 2017 он

⁴ Хөдөлмөрийн тухай хууль, 2021 он

⁵ Нийгмийн даатгалын ерөнхий хууль, 2023

⁶ Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль, 2024

улсын жишгээр “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд” гэж нэрлэж, ажилтныг хөдөлмөрийн хэвийн нөхцөлөөр хангах ажил олгогчийн үүргийг тодорхой болгон хуульчилсан. Иймд хуулийн нэршлийн хувьд олон улсын хэм хэмжээ, шаардлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулах хуулийн төслийн нэрийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хууль гэж томъёолно.

2. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй бүтээн байгуулалтын томоохон төслүүд, эдийн засгийн өсөлтийн улмаас ажиллах хүчний эрэлт 2035 онд 19.1 хувиар, үүнээс эрсдэл өндөртэй уул уурхай, олборлолтын салбарт 32.5, боловсруулах үйлдвэрт 63.3, барилгын салбарт 55.9 мянган хүнээр нэмэгдэх төлөвтэйг хөдөлмөрийн зах зээлийн таамаглалаар тодорхойлжээ.

Манай улсын нийт хүн амын 39 хувь нь ажиллах хүч бөгөөд ажил хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн 41 хувь (521 мянган хүн) нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин үүсэх эрсдэлтэй салбарт ажиллаж байна.

Улсын хэмжээнд 1972-2024 онд 10359 хүн мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан ба сүүлийн 5 жилд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын 2125 тохиолдол бүртгэгдэж, 275 хүн нас барсан байна.

Хөдөлмөрийн эрүүл мэндийн зохицуулах харилцаа, агуулга нь хөдөлмөрийн эрүүл ахуйн асуудлаас өргөн хүрээтэй тул ажилтны эрүүл мэндийн үзлэг, тандалт, ажил мэргэжлийн тохироо, сэргээн засах тусламж үйлчилгээний талаарх зохицуулалтыг олон улсын конвенц, хэм хэмжээнд нийцүүлэн сайжруулж, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт илрүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх үр нөлөөг нэмэгдүүлэх шаардлага үүсэж байна.

3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний тогтолцоо нэгдмэл биш, санхүүжилтийн эх үүсвэр, мэргэжлийн байгууллага, асуудал хариуцсан мэргэжилтний чиг үүрэг, салбар дундын уялдаа холбоог нарийвчлан тодорхойлоогүй, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, албан бус салбарт ажиллагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал зохицуулалтгүйгээс хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Манай яамнаас олон улсын системийн инженерчлэлийн аргачлалыг ашиглан салбарын хуулиуддаа системийн шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд хийсэн шинжилгээгээр хуулийн зорилгыг хүрэх үр дүнд үндэслэн тодорхойлж, оролцогч талуудын эрх, үүргийг ангилах, хэмжиж болохуйц үр дүн, эргэх холбоог сайжруулан боловсруулахыг зөвлөж, хуулийн системийн хэв шинжүүдийг 60.7 хувь бүрдүүлсэн гэж үзсэн байна.

4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндэд тавигдах шаардлагыг тодорхой болгож, өндөрт ажиллах аюулгүй ажиллагаа, хязгаарлагдмал орчин, хими, биологи, эргономик, нийгэм-сэтгэл зүйн хүчин зүйлс зэрэгт тавих шаардлагыг шинээр зохицуулах хэрэгцээ үүсээд байна.

5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үйл ажиллагааны үндсэн зарчим нь осол, өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгддэг. Одоогоор үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоо бүрдээгүй, даатгалын сангаас ажил олгогч, даатгуулагчид үзүүлэх үйлчилгээ хомс байна. Иймд ажил хөдөлмөртэй холбоотойгоор үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, уг үйл ажиллагааг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалтай уялдуулах шаардлагатай юм.

Хуулийн тандан судалгаа болон хуулийн үзэл баримтлалд туссан зорилгод тулгуурлан боловсруулсан хуулийн төслийн зохицуулалт бүрд дүн шинжилгээ хийхэд тухайн зохицуулалт, арга хэмжээ нь зорилгод хүрэх боломжтой гэж дүгнэж байна.

4.2. “Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1.1 дэх заалтад заасан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ын Хоёрдугаар бүлэг “Хуулийн төсөл боловсруулахад тавигдах нийтлэг шаардлага”-т заасан шаардлагыг дараах байдлаар хангаж байна.

Хүснэгт 2

Хуулийн төслийн эх бичвэрийн асуулгад тавигдах шаардлага		
1	Монгол Улсын үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Уг шаардлагыг хангасан.
2	Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Уг шаардлагыг хангасан.
3	Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
4	Зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх.	Уг шаардлагыг хангасан.
5	Хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх	Уг шаардлагыг хангасан.
Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавигдах шаардлага		
6	Хуулийн төслийн үг хэллэг өгүүлбэрийг хэл зүйн, найруулга, өгүүлбэр зүйн монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн	Уг шаардлагыг хангасан.

	хоёрдмол утгагүй, товч тодорхой, ойлгоход хялбар	
7	Бичвэр нь үндсэн агуулгаас хоёрдогч ач холбогдол бүхий ерөнхийгөөс тусгай руу, нийтлэг журмаас тусгай руу гэсэн хэлбэртэй байна	Уг шаардлагыг хангасан.
Хуулийн төслийн эх бичвэрт хэрэглэх арга ажиллагаа		
8	1.Нэр томьёо хэрэглэх 2.Хуулийн төслийн үг хэллэг сонгох 3.Товчлол хийх 4.Эшлэл хийх	Уг шаардлагыг хангасан.
Хуулийн төслийн эх бичвэрийг компьютерт боловсруулахад тавих шаардлага		
9	Эх бичвэрийг компьютерт боловсруулахад холбогдох эрх зүйн баримт бичиг баримталсан эсэх	Хуулийн төслийг боловсруулахад Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, Стандартчилал, хэмжил зүйн үндэсний Зөвлөлийн 2021 оны “Баримт бичгийн стандарт MNS 5140-1:2021”-ыг баримталсан болно.

4.3. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлэх субъект нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам болон хуульд заасан бодлогын арга хэмжээний үр шимийг хүртэгсэд юм.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого, хууль эрх зүйн талаар хийсэн судалгаануудаас гарсан зөвлөмжийн дагуу^{7, 8} Монгол Улсын нэгдэн орсон ОУХБ-ын конвенцод нийцүүлэн хуулийн шинэчилсэн найруулгын төслийг “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай” гэж нэрлэж хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөрийн эрүүл ахуйн асуудлаас гадна ажилтны эрүүл мэндийн үзлэг, тандалт, ажил мэргэжлийн тохироо, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан иргэнд зориулсан сэргээн засах эмчилгээ зэрэг хөдөлмөрийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний асуудлыг зохицуулахаар тусгаж, хуулийн төсөл батлагдсанаар иргэдийн хууль ёсны эрх ашиг хөндөгдөхгүй.

⁷ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг шинэчлэх хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандалт судалгаа, 2024 он

⁸ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг дэмжих тогтолцооны тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 187 дугаар конвенцыг Монгол Улсын хууль тогтоомжтой харьцуулсан үнэлгээ, 2023 он

4.4. “Зардлыг тооцох” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хуулийн төсөл батлагдаж хэрэгжсэнээр дотоод болон гадаадын аж ахуйн нэгж, байгууллагад нийгэм, эдийн засаг, эрх зүйн сөрөг үр дагавар үүсэхгүй.

Хууль батлагдсанаар ажил, хөдөлмөр эрхлэхтэй холбоотой ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан, хяналт, цахимжилт, салбар дундын уялдаа, мэргэжлийн холбоо, оролцогч талуудын чиг үүргийг оновчтой тодорхойлж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үйлчилгээг өргөжүүлснээр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний тогтолцоо бий болно гэж үзэж байна.

Урьдчилан сэргийлэлтэд суурилсан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын зохицуулалтыг бий болгосноор ажил олгогч, даатгуулагчид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэлт, хөдөлмөрийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болон санхүүгийн дэмжлэг авах эерэг нөлөөтэй.

Мөн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн байгууллагын эрх, үүргийг тодорхой болгосноор ажилтан эрүүл, аюулгүй ажлын байраар хангагдах нөхцөл бүрдэж, ажил, хөдөлмөр эрхлэгч хүн амын дундаж наслалт, амьдралын чанарт эерэг нөлөө үзүүлнэ.

Хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан аливаа заалт байхгүй бөгөөд хууль хэрэгжсэнээр ажлын байранд ажилтан, иргэний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, эрүүл, аюулгүй байр, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулахад дэвшил гарна гэж үзэж байна. Иргэн, хуулийн этгээдэд ямар нэгэн нэмэлт хөрөнгийн дарамт үүсэхгүй болно.

4.5. “Харилцан уялдааг шалгах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараах стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог бүхэлд нь шалгахыг зорилоо.

Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль болон бусад холбогдох хуульд нийцсэн эсэхийг шалгалаа.

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурын дагуу үнэллээ:

Асуулт 1:Хуулийн төслийн зохицуулалт тухай хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх?

Хариулт: Тийм.

Асуулт 2. Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх?

Хариулт: Тийм.

Дүн шинжилгээ: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль⁹, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. гэж хуульд заасан ерөнхий байдлаар тодорхойлсон.

Асуулт 3. Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хууль тогтоомжийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх?

Хариулт: Тийм

Дүн шинжилгээ: Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт тусгагдсан нэр томъёо нь хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн чиглэлийн бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа болно.

Асуулт 4: Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хууль тогтоомжийн зүйл, заалттай нийцэж байгаа эсэх?

Хариулт: Тийм

Дүн шинжилгээ: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зүйл, заалтууд өөр хоорондоо зөрчилгүй байгаа бөгөөд Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн зүйл, заалттай зөрчилдөөгүй болно.

Асуулт 5: Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хууль тогтоомжийн заалттай давхардсан эсэх?

Хариулт: Үгүй.

Дүн шинжилгээ: Хуулийн төслийн зүйл, заалтууд өөр хоорондоо давхардаагүй байгаа бөгөөд Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн зүйл, заалттай давхардаагүй байна.

⁹Монгол Улсын Үндсэн хууль –“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

Асуулт 6: Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх?

Хариулт: Тийм

Дүн шинжилгээ: Хуулийн төслийн гуравдугаар бүлгийн нэг, хоёрдугаар дэд бүлгээр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний тогтолцоо болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн байгууллагын чиг үүрэг, эрх, үүрэг болон бүх шатны Засаг дарга нарын эрх, үүргийг мөн аж ахуйн нэгж, байгууллагын бүтэц зохион байгуулалт, ажил олгогч, ажилтан, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний эрх үүргийг, тодорхой зааж өгсөн.

Асуулт 7. Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх?

Хариулт: Үгүй.

Дүн шинжилгээ: Хуулийн төслөөр зохицуулах шаардлагатай бүх харилцааг зохицуулсан бөгөөд орхигдуулсан зохицуулалт байхгүй гэж үзэж байна.

Асуулт 8.Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;

Хариулт: Үгүй.

Дүн шинжилгээ: Хуулийн төслийн 27, 28 дугаар зүйлээр ХАБЭМ-ийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллага, орон нутгийн хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг, мөн хуулийн 37 дүгээр зүйлд бүх шатны Засаг дарга нарын эрх, үүргийг тодорхой зааж өгсөн болно.

Асуулт 9.Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;

Харилт: Тийм

Дүн шинжилгээ: Хуулийн төслийн 3 дугаар бүлгийн 30 дугаар зүйлд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжлийн холбоодын чиг үүргийг тодорхой тусгаж, хуулийн 30.1.6 дахь заалтад төрийн байгууллагын зарим чиг үүргийг хууль тогтоомж болон гэрээний үндсэн дээр гүйцэтгэх гэж заасан.

Асуулт 10: Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх?

Хариулт:Үгүй

Асуулт 11: Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх?

Хариулт: Үгүй. /Хуулийн төсөлд тусгай зөвшөөрлийн зохицуулалт байхгүй болно./

Асуулт 12: Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх?

Хариулт: Үгүй.

Асуулт 13: Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх?

Хариулт: Тийм

Дүн шинжилгээ: Хуулийн төслийн үйлчлэх хүрээг хөдөлмөрийн тухай хуулийн 3.6 дахь хэсэгтэй уялдуулах тодорхойлж, энэ хуулийн 3 дугаар зүйлд тодорхой заасан. Мөн хуулийн төсөлд үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, эрүүл мэндийн байдал, гадаад төрх, хөгжлийн бэрхшээл, нийгмийн гарал, нийгмийн болон гэрлэлтийн байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, улс төрийн үзэл бодлоор ялгаварлаагүй болно.

Асуулт 14: Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх?

Хариулт: Үгүй.

Асуулт 15: Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх?

Хариулт: Үгүй.

Асуулт 16: Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх?

Хариулт: Тийм

Дүн шинжилгээ: Хуулийн төслийн 7 дугаар бүлгийн 61, 62 дугаар зүйлд хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага болон маргаан шийдвэрлэх асуудлыг тодорхой тусгасан.

ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

5.1.Баримтжуулалт

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд дараах баримт бичиг, мэдээлэл, тоо баримтыг ашиглалаа.

1. Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд;

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хүрээнд гарсан дүрэм, журам болон бусад холбогдох тогтоол, шийдвэр, стандартууд;

3. Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1.2-т заасан аргачлалын дагуу хийсэн хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан;

4. Олон улсын байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн 155 дугаар конвенцын тайлан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг дэмжих тогтолцооны тухай 187 дугаар конвенцод хийсэн харьцуулалтын үнэлгээний тайлан;

5. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын цахим <http://om.inspection.gov.mn/> бүртгэлийн мэдээлэл;

6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр гарсан бусад судалгаа, тайлан;

7. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтран баталсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал;

8. Батлагдсан үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулсан хуулийн төсөл, танилцуулга.

5.2. Дүгнэлт

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлд нийцэж байгаа бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1.1 дэх хэсэгт заасан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ын Хоёрдугаар бүлэг “Хуулийн төсөл боловсруулахад тавих нийтлэг шаардлага”-т заасныг бүрэн хангаж байна гэж үзэж байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн харилцан уялдааг хангах шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1.3-т заасан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын 4.10-т заасан 16 асуултад хариулах байдлаар шалгахад “харилцан уялдаа”-г бүрэн хангаж байна гэж үзсэн.

5.3. Зөвлөмж

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2, 25.1.4. дэх заалтыг тус тус үндэслэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиар зохицуулж байсан харилцааг өргөжүүлж, нийгэм, эдийн засагт гарч байгаа шинэ өөрчлөлт, чиг хандлагатай уялдуулан хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдах хуулийн төслүүдийг УИХ-аар хэлэлцүүлж, батлагдсаны дараа хуулийн хүрээнд холбогдох дүрэм, журмыг шинээр батлуулах шаардлага үүсэж байна.

_____ооо_____



**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ**

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ
ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

2025 ОН

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ХАБЭА – Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

ААНБ – Аж ахуйн нэгж, байгууллага

ҮСХ – Үндэсний статистикийн хороо

ҮОМШӨ – Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин

ХАБЭМ - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд

ҮОХХ – Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого

ХЧТА – Хөдөлмөрийн чадвар түр алдсан

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

НЭГ.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.” гэж заасны дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/ батлагдсан нөхцөлд хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Хуулийн төслийн зорилго нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний бодлого, зарчмыг тодорхойлох, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдлага, хяналтын тогтолцоог бүрдүүлэх, ажилтан, хөдөлмөр эрхлэгч хүний эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг хангах, ажил хөдөлмөртэй холбоотой осол, бэртэл, өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэж байна.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход доор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан. Үүнд:

- иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
- хуулийн төсөлд шинээр тусгагдсан, зардал үүсгэх заалтын зардлыг тооцох;
- бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

Энэхүү тайлан нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хамаарах иргэн, хуулийн этгээд болон төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, бууруулах талаар санал боловсруулахад чиглэгдэх болно.

ХОЁР. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Хуулийн этгээдийн зардлыг тооцоходоо аргачлалын 2.1-д заасны дагуу

- 1) Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 2) Зардлыг тооцох;
- 3) Тоон үзүүлэлтийг тооцох;
- 4) Нийт зардлын дүнг тооцож гаргах;
- 5) Хялбарчлах боломжийг шалгах;

б)Нэмэлт зардлыг тооцох үе шатаар хуульд заасан үүргээ гүйцэтгэхтэй холбогдон гарах мөнгөн зардлыг тооцсон.

2.1 ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ ТОГТООХ

Ажил олгогчийн гүйцэтгэх үүрэг

Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоохдоо хуулийн үйлчлэлд хамрагдах аж ахуйн нэгж, байгууллагад үүрэг хүлээлгэсэн зүйл, заалтыг үндэслэсэн болно.

Энэ хэсэгт хуулийн төслөөр хуулийн этгээдэд үүрэг оногдуулсан болон зардлыг хариуцахаар тусгасан зохицуулалтууд нь тухайн байгууллагад хэдий хэр ачаалал, зардал үүсгэх магадлалтайг тооцоолох зорилготой.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаар ажил олгогчийн хүлээх дараах үүргийг зааж өгсөн байна.

Хүснэгт 1. ХАБЭМ-ийн талаар ажил олгогчийн хүлээх үүрэг

Хуулийн төсөлд тусгасан холбогдох зохицуулалт	Үүрэг
34 дүгээр зүйл	<p>34.1.Ажлын байрны аюултай хүчин зүйлээс ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, ажил, хөдөлмөртэй холбоотой осол, бэртэл, гэмтэл, өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг хангах, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч шууд хариуцна.</p> <p>34.2.10 хүртэл ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь энэ хуулийн 34.1-д заасан үүргийг хэрэгжүүлэхэд үйл ажиллагааны онцлог, ажлын байрны эрсдэлийн түвшнээс хамаарч хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлыг ажил олгогч өөрөө хариуцах эсхүл аль нэг ажилтнаар хавсран эсхүл гэрээгээр гүйцэтгүүлнэ.</p> <p>34.3.Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь энэ хуулийн 34.1-д заасан үүргийг хэрэгжүүлэхэд байгууллагын үйл ажиллагааны онцлог, ажлын байрны эрсдэлийн түвшин, ажилтны тоог харгалзан дараах байдлаар зохион байгуулна:</p> <p>34.3.1.11-50 хүртэл ажилтантай бол хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлыг аль нэг ажилтнаар хавсран гүйцэтгүүлэх, эсхүл орон тооны ажилтан эсхүл гэрээгээр гүйцэтгүүлэх;</p> <p>34.3.2.51-200 хүртэл ажилтантай бол орон тооны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн ажилтантай байх, хөдөлмөрийн эрүүл ахуйч, мэргэжлээс шалтгаалсан өвчний эмчийг орон тоогоор эсхүл гэрээгээр ажиллуулж болно;</p> <p>34.3.3.201-500 хүртэл ажилтантай бол хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан бүтэцтэй байх, хөдөлмөрийн эрүүл ахуйч, мэргэжлээс шалтгаалсан өвчний эмчийг орон тоогоор эсхүл гэрээгээр ажиллуулах;</p>

	34.3.4.501 ба түүнээс дээш ажилтантай бол хөдөлмөрийн аюулгүй байдал болон хөдөлмөрийн эрүүл мэндийн нэгж бүхий хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан бүтэц ажиллуулах.
40 дүгээр зүйл	<p>40.2.Ажил олгогч нь дараах нийтлэг үүрэгтэй байна:</p> <p>40.2.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлага хангасан ажлын байрны нөхцөлийг бүрдүүлэх инженер технологи, удирдлага зохион байгуулалт, хувь хүнд чиглэсэн арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлэх удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх;</p> <p>40.2.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг хангуулах, ажил хөдөлмөртэй холбоотой осол, бэртэл, гэмтэл, өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах зардлыг баталж, зарцуулах;</p> <p>40.2.3.үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад хүний амь нас, эрүүл мэндэд аюултай нөхцөл үүссэн тохиолдолд уг үйл ажиллагааг яаралтай зогсоож, аюулыг шуурхай арилгах;</p> <p>40.2.4.ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийг үнэлэх, бууруулах, арилгах, уг үйл ажиллагаанд удирдах ажилтан, ажилтны төлөөллийг томилж ажиллуулах;</p> <p>40.2.5.эрсдэлтэй ажлын байранд аюулыг анхааруулах, хориглох, сануулах, заах тэмдэг, санамж байрлуулах, аюулыг тусгаарлах хаалт, хашилт, дохиоллын систем байршуулж, тэмдэглэгээ хийх;</p> <p>40.2.6.ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх;</p> <p>40.2.7.ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөл болон ажилтны хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэгт үндэслэн хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалтыг зохион байгуулах;</p> <p>40.2.8.ажил олгогчид зориулсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдах;</p> <p>40.2.9.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдаж, шаардлагатай мэдлэг, дадлыг эзэмшсэн, шалгалтад тэнцсэн, аюулгүй ажиллах зааварчилгаа авсан, шаардлагатай бол хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан ажилтнаар ажил үүрэг гүйцэтгүүлэх;</p> <p>40.2.10.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, аюултай тохиолдлын талаар тэмдэглэл, бусад шаардлагатай мэдээллийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдлагын цахим системд илгээх;</p> <p>40.2.11.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан ажилтанд хууль тогтоомжийн дагуу нөхөн төлбөр олгох.</p> <p>40.2.12.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий этгээдийг ажлын байранд саадгүй нэвтрүүлэх, албан шаардлага, албан даалгаврыг биелүүлэх;</p> <p>40.2.13.хууль тогтоомжид заасан бусад.</p> <p>40.3.Захиалагч, ерөнхий болон туслан гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг хангах урьдчилан сэргийлэх арга хэмжээ, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас ажилтанд учирсан хохирлыг нөхөн төлөх, амь нас, эрүүл мэндийн даатгалд хамруулах зэрэгт зайлшгүй шаардагдах хөрөнгө, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаар харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгана. Хэрэв гэрээнд энэ талаар тусгаагүй бол хуулиар</p>

	хүлээсэн үүргээ биелүүлээгүй гэм буруутай тал нь учирсан хохирол, гэм хорыг ажилтны өмнө хариуцна.
--	--

Амь нас, эрүүл мэндийн даатгалын байгууллагаас хариуцах зардал

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах нөхөх төлбөр, зардлыг ажилтны амь нас, эрүүл мэндийн даатгалаас хариуцахаар тусгасан байна.

Хүснэгт 2. Ажилтны амь нас, эрүүл мэндийн даатгалаас зардлыг хариуцах зохицуулалт

Хуулийн төсөлд тусгасан холбогдох зохицуулалт	Хариуцах зардал
53.3 дахь хэсэг	53.3.Ажилтны амь нас, эрүүл мэндийн даатгалын байгууллага нь даатгуулагчид дараах зардлыг олгоно: 53.3.1.үйлдвэрлэлийн осолд орсон хүнд үзүүлэх эмнэлгийн яаралтай тусламж, ослын газраас эмнэлэг хүргэх болон эмчилгээний зардал; 53.3.2.хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээхтэй холбоотой протез, ортопед, сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний зардлын үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох жишиг зардлаас давсан хэсэг; 53.3.3.гэрээгээр тохиролцсон бусад.

2.2 ЗАРДЛЫН ТООЦОО

2.2.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан ажилтан, бүтэц ажиллуулах зардал

Үндэсний статистикийн хорооны 2024 оны 04 дүгээр улирлын мэдээгээр 108,378 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эдгээрийн 93,453 нь 1-9 ажилтантай, 6,806 нь 10-19 ажилтантай, 5,194 нь 20-49 ажилтантай, 2,925 нь 50-аас дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага байна.

Хүснэгт 3. Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо

Ажилчдын тооны бүлэг	2024-IV	Эзлэх хувь
1-9	93,453	86%
10-19	6,806	6%
20-49	5,194	5%
50-аас дээш	2,925	3%
Бүгд	108,378	100%

Хүснэгт 4. Ажиллагчдын сарын дундаж цалин (мян.төгрөг)

Ажилчдын тооны бүлэг	2024 он
Бүгд	2,332.4
1-9	1,410.7
10-49	1,964.0
50-99	2,163.9
100-199	2,436.7
200-аас дээш	2,997.2

Эх үүсвэр. Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 5. ХАБЭМ-ийн асуудал хариуцсан ажилтан, бүтэц ажиллуулах зардлын тооцоо

Ажилчдын тооны бүлэг	ХАБЭМ-ийн асуудал хариуцсан ажилтан бүтэц ажиллуулах	Ажиллагчдын сарын дундаж цалин, мян.төгрөг	Холбогдох зардал, жилээр, мян.төгрөг		Тайлбар
1-10 ажилтантай	Захирал, ажил олгогч өөрөө хариуцах эсхүл аль нэг ажилтнаар хавсран эсхүл гэрээгээр гүйцэтгүүлэх	1,410.70	-	6,771.4	Захирал, ажил олгогч өөрөө ХАБЭМ-ийн асуудлыг хариуцан ажиллах тохиолдолд зардал гарахгүй бөгөөд аль нэг ажилтнаар хавсран гүйцэтгүүлэхэд тухайн ажилтанд 40%-ийн нэмэгдэл олгоход жилд 6,771.4 мянган төгрөгийн цалин хөлсний зардал гарна.
11-50 ажилтантай	Аль нэг ажилтнаар хавсран гүйцэтгүүлэх, эсхүл орон тооны ажилтан ажиллуулах эсхүл гэрээгээр гүйцэтгүүлэх	1,964.00	9,427.2	23,568.0	Аль нэг ажилтнаар хавсран гүйцэтгүүлэхэд тухайн ажилтанд 40%-ийн нэмэгдэл олгоход жилд 9,427.2 мянган төгрөгийн цалин хөлсний зардал гарна. Харин орон тооны ажилтан ажиллуулахад жилд дунджаар 23,568.0 мянган төгрөгийн цалин хөлсний зардал гарахаар байна.
51-200 ажилтантай	ХАБЭМ-ийн ажилтантай байх	2,300.30	27,603.6		ХАБЭМ-ийн ажилтны цалин хөлсөнд жилд дунджаар 27,603.6 мянган төгрөгийн зардал гарахаар байна.
201-500 ажилтантай	ХАБЭМ хариуцсан бүтэцтэй байх, хөдөлмөрийн эрүүл ахуйч, хөдөлмөрийн	2,997.20	107,899.2		ХАБЭМ хариуцсан 3 хүний орон тоотой бүтэц ажиллуулахад цалин хөлсний зардалд жилд дунджаар 107,899.2 мянган

	эрүүл мэндийн эмчийг орон тоогоор эсхүл гэрээгээр ажиллуулах;			төгрөгийн зардал гарахаар байна.
501-ээс дээш ажилтантай	ХАБЭМ-ийн нэгж бүхий хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан бүтэц ажиллуулах.	2,997.20	179,832.0	ХАБЭМ-ийн нэгж бүхий 5 хүний орон тоотой бүтэц ажиллуулахад цалин хөлсний зардалд жилд дунджаар 179,832.0 мянган төгрөгийн зардал гарахаар байна.

Дээрх тооцооллоос харахад 1-10 ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагын хувьд тухайн ААНБ-ын захирал буюу ажил олгогч өөрөө ХАБЭМ-ийн асуудлыг хариуцан ажиллах тохиолдолд тухайн байгууллагад цалин хөлсний нэмэлт зардал үүсэхгүй бөгөөд аль нэг ажилтнаар хавсран гүйцэтгүүлэх тохиолдолд жилд дунджаар 6,771.4 мянган төгрөгийн цалин хөлсний зардал гарахаар гарна.

11-50 ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагын хувьд аль нэг ажилтнаар хавсран гүйцэтгүүлэх тохиолдолд жилд дунджаар 9,427.2 мянган төгрөгийн цалин хөлсний зардал, орон тооны ажилтан ажиллуулах тохиолдолд жилд дунджаар 23,568.0 мянган төгрөгийн цалин хөлсний зардал гарахаар байна.

51-200 ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагын хувьд ХАБЭМ-ийн ажилтны цалин хөлсөнд жилд дунджаар 27,603.6 мянган төгрөгийн зардал гарч байна.

51-200 ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагын хувьд ХАБЭМ-ийн асуудал хариуцсан бүтэц (дунджаар 3 хүний орон тоотой) ажиллуулахад цалин хөлсний зардалд жилд дунджаар 107,899.2 мянган төгрөгийг зарцуулахаар байна.

501-ээс дээш ажилтантай аж ахуйн нэгж байгууллагын хувьд ХАБЭМ-ийн нэгж бүхий бүтэц (дунджаар 5 хүний орон тоотой) ажиллуулахад цалин хөлсний зардалд жилд дунджаар 179,832.0 мянган төгрөгийн зардал гарахаар байна.

2.2.2 ХАБЭМ-ийн талаар ажил олгогчийн хүлээх нийтлэг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардал

Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал нь тухайн байгууллагын үйл ажиллагааны төрөл, хэмжээ, ажилтны тоо, эрсдэлийн түвшнээс хамааран харилцан адилгүй байдаг бөгөөд ажил олгогчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлэхэд дараах зардлууд гарч байна.

ХАБЭА-н арга хэмжээний дундаж зардлын бүрдэл:

1. Тэмдэг, тэмдэглэгээ, хувийн хамгаалах хэрэгслийн зардал
 - Анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ, ажилчдын ажлын хувцас, хамгаалалтын малгай, нүдний шил, амны хаалт гэх мэт.
2. Сургалтын зардал
 - Нийт ажилтны сургалт, шинээр ажилд орох ажилтанд зориулсан сургалт, ажил олгогч, удирдах ажилтны сургалт
3. Ажлын байрны аюулгүй байдлыг хангах зардал
 - Дуу чимээ, агаарын чанар, гэрэлтүүлэг гэх мэт.
4. Ажилтны эрүүл мэндийн үзлэгийн зардал
 - Урьдчилан сэргийлэх, хугацаат үзлэг гэх мэт.
5. Даатгалын зардал
 - ҮОМШӨ-ний даатгал, амь нас, эрүүл мэндийн даатгал

Хүснэгт 6. 50 ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагын ХАБЭМ-ийн арга хэмжээний зардлын тооцоо (жилд)

Хуулийн төсөл дэх холбогдох зохицуулалт	Зардлын төрөл	Зардал (мян.төг)	Тайлбар
18.1.Ажил олгогч нь ажлын байрны аюул, эрсдэлийг инженер технологи, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээгээр бүрэн арилгах эсхүл бууруулах боломжгүй тохиолдолд стандартын шаардлага хангасан ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгслийг ажилтанд олгож, зохистой хэрэглээнд хяналт тавина.	Тэмдэг, тэмдэглэгээ, хувийн хамгаалах хэрэгслийн зардал	12,700.0	Анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ, ажлын байрны онцлогоос хамааран ажлын хувцас, дуулга, бээлий, маск гэх мэт.
49.1.Ажил олгогч, удирдах албан тушаалтан, ажилтан, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад жил бүр хамрагдаж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай мэдлэг, дадалтай болсон байна	Сургалтын зардал	3,500.0	Нийт ажилтны сургалт, шинээр ажилд орох ажилтанд зориулсан сургалт, ажил олгогч, удирдах ажилтны сургалт
38.1.3.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх; 38.1.5.ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх	Эрсдэлийн үнэлгээ, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний зардал	5,000.0	Тоос, дуу чимээ, гэрэлтүүлэг гэх мэт
Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18.1.Ажил олгогч болон энэ хуулийн 7.2, 7.3, 7.4, 7.5-д заасан даатгуулагч дараах хувь	Даатгалын зардал	5,892.0	ҮСХ-ны 2024 оны мэдээгээр 10-49 ажилтантай ААНБ-ын ажиллагчдын дундаж

хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө: 3.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал: 0.5, 1.5, 2.5			цалин 1,964.0 мянган төгрөг байгаа бөгөөд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18.1-д заасны дагуу 0.5 хувиар шимтгэл төлөхөөр тооцов. Нэг ажилтны шимтгэлд сард дунджаар 9,820 төгрөг төлнө.
	Нийт		27,092.0

300 ажилтантай байгууллагын хувьд дунджаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн арга хэмжээнд дараах зардал гарахаар байна. Энэхүү тооцоо нь ердийн үйлдвэрлэлийн салбарт хамаарах бөгөөд эрсдэлийн түвшин дунд зэрэг гэж үзсэн болно.

Хүснэгт 7. 300 ажилтантай байгууллагын ХАБЭМ-ийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын тооцоо (жилд)

Хуулийн төсөл дэх холбогдох зохицуулалт	Зардлын төрөл	Зардал (мян.төг)	Тайлбар
18.1.Ажил олгогч нь ажлын байрны аюул, эрсдэлийг инженер технологи, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээгээр бүрэн арилгах эсхүл бууруулах боломжгүй тохиолдолд стандартын шаардлага хангасан ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгслийг ажилтанд олгож, зохистой хэрэглээнд хяналт тавина	Тэмдэг, тэмдэглэгээ, хувийн хамгаалах хэрэгслийн зардал	157,800.0	Анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ, ажлын байрны онцлогоос хамааран ажлын хувцас, дуулга, бээлий, маск гэх мэт.
49.1.Ажил олгогч, удирдах албан тушаалтан, ажилтан, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад жил бүр хамрагдаж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай мэдлэг, дадалтай болсон байна	Сургалтын зардал	15,400.0	Нийт ажилтны сургалт, шинээр ажилд орох ажилтанд зориулсан сургалт, ажил олгогч, удирдах ажилтны сургалт
38.1.3.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;	Эрсдэлийн үнэлгээ, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний зардал	10,000.0	Тоос, дуу чимээ, гэрэлтүүлэг гэх мэт

38.1.5.ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх			
40.2.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлага хангасан ажлын байрны нөхцөлийг бүрдүүлэх инженер технологи, удирдлага зохион байгуулалт, хувь хүнд чиглэсэн арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлэх удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх	ХАБЭМ-ийн удирдлага, стандарт хэрэгжилт	30,000.0	Дотоод аудит, зөвлөгөө, программ хангамж гэх мэт
Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18.1.Ажил олгогч болон энэ хуулийн 7.2, 7.3, 7.4, 7.5-д заасан даатгуулагч дараах хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө: 3.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал: 0.5, 1.5, 2.5	Даатгалын зардал	161,848.8	ҮСХ-ны 2024 оны мэдээгээр 200-аас дээш ажилтантай ААНБ-ын ажиллагчдын дундаж цалин 2,997.2 мянган төгрөг байна. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18.1-д заасны дагуу 1.5 хувиар шимтгэл төлөхөөр тооцоход нэг ажилтны шимтгэлд сард дунджаар 44,958 төгрөг төлнө.
	Нийт		375,048.8

Хүснэгт 8. 300 ажилтантай барилгын компанийн ХАБЭМ-ийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын тооцоо (жилд)

Хуулийн төсөл дэх холбогдох зохицуулалт	Зардлын төрөл	Зардал (мян.төг)	Тайлбар
18.1.Ажил олгогч нь ажлын байрны аюул, эрсдэлийг инженер технологи, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээгээр бүрэн арилгах эсхүл бууруулах боломжгүй тохиолдолд стандартын шаардлага хангасан ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгслийг ажилтанд олгож,	Тэмдэг, тэмдэглэгээ, хувийн хамгаалах хэрэгслийн зардал	157,800.0	Анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ, ажлын байрны онцлогоос хамааран ажлын хувцас, дуулга, бээлий, маск гэх мэт.

зохистой хэрэглээнд хяналт тавина.			
49.1.Ажил олгогч, удирдах албан тушаалтан, ажилтан, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад жил бүр хамрагдаж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай мэдлэг, дадалтай болсон байна	Сургалтын зардал	15,400.0	Нийт ажилтны сургалт, шинээр ажилд орох ажилтанд зориулсан сургалт, ажил олгогч, удирдах ажилтны сургалт, эрсдэлтэй ажлын байрны сургалт
47.3.Өндөр эрсдэлтэй ажилд шинээр орох болон хөдөлмөрийн нөхцөл нь солигдож байгаа ажилтныг хөдөлмөрийн эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулна.	Эрүүл мэндийн үзлэгийн зардал	45,000.0	Жилд 1 удаа хийлгэх
38.1.3.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх; 38.1.5.ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх	Эрсдэлийн үнэлгээ, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний зардал	10,000.0	Тоос, дуу чимээ, гэрэлтүүлэг гэх мэт
40.2.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлага хангасан ажлын байрны нөхцөлийг бүрдүүлэх инженер технологи, удирдлага зохион байгуулалт, хувь хүнд чиглэсэн арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлэх удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх	ХАБЭМ-ийн удирдлага, стандартын хэрэгжилт	30,000.0	Дотоод аудит, зөвлөгөө, мэдээлэл өгөх, программ хангамж гэх мэт
20.1.3.хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажил үүрэг гүйцэтгэдэг ажилтныг эрүүл ахуйн шаардлага хангасан, шим тэжээллэг хүнсний бүтээгдэхүүн, хоолоор үнэгүй хангах	Хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, хоолоор хангах	225.0	Сүү, сүүн бүтээгдэхүүн гэх мэт.
Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18.1.Ажил олгогч болон энэ хуулийн 7.2, 7.3, 7.4, 7.5-д заасан даатгуулагч дараах хувь	Даатгалын зардал	269,748.0	ҮСХ-ны 2024 оны мэдээгээр 200-аас дээш ажилтантай ААНБ-ын ажиллагчдын дундаж цалин 2,997.2 мянган

хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө: 3.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал: 0.5, 1.5, 2.5			төгрөг байна. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18.1-д заасны дагуу 2.5 хувиар шимтгэл төлөхөөр тооцоход нэг ажилтны шимтгэлд сард дунджаар 74,930 төгрөг төлнө.
53.1.Эрсдэл өндөртэй ажлын байранд ажиллаж байгаа ажилтныг амь нас, эрүүл мэндийн даатгалд даатгуулна. Амь нас, эрүүл мэндийн нэмэлт даатгалын хураамжийг ажил олгогч хариуцна.	Даатгалын зардал	350,022.6	Эрсдэл өндөртэй ажлын байранд ажиллаж буй нэг ажилтны амь нас, эрүүл мэндийн даатгалд (дунджаар 2 хувь) ажил олгогч жилд дунджаар 2,334.0 мянган төгрөгийн даатгалын хураамж төлөхөөр байна.
	Нийт		878,195.6

Эрсдэл өндөртэй томоохон уул уурхайн компаниудын хувьд үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 2.7-3.4 хувийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн холбогдох арга хэмжээнд зарцуулж байна.

Дүгнэлт: Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн зардал нь тухайн байгууллагын үйл ажиллагааны төрөл, хэмжээ, ажилтны тоо, эрсдэлийн түвшнээс хамааран харилцан адилгүй байх бөгөөд ХАБЭМ-ийн нэг ажилтны цалин хөлсөнд жилд дунджаар 27,603.6 мянган төгрөг, ХАБЭМ-ийн талаар ажил олгогчийн хүлээх нийтлэг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор жижиг аж ахуйн нэгжийн хувьд жилд дунджаар 27,092.0 мянган төгрөг, томоохон аж ахуйн нэгж, байгууллагын хувьд эрсдэлийн түвшнээс хамааран дунджаар 375,048.8 мянга ба үүнээс дээш хэмжээний хөрөнгийг зарцуулж байна.

2.3 НЭМЭЛТ ЗАРДЛЫН ТООЦОО

Энэ хэсэгт одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх хүрээнд гарч буй зардлыг хамааруулахгүйгээр хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар хуулийн этгээдэд нэмэлт зардал үүсгэж болох зохицуулалтыг сонгож зардлын тооцоог гаргасан болно.

2.3.1 Ажил олгогчид үүсэх нэмэлт зардал

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26.2-т “Төсвийн байгууллага нь тухайн жилийн батлагдсан төсвийн **0.5 хувиас**, аж ахуйн нэгж, байгууллага эрсдэлийн түвшнээс хамааран **үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын**

1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тус тус зарцуулна.” гэж заасан.

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн хүрээнд дээрх төсөвлөсөн зардлыг дараах арга хэмжээнд зарцуулж байна. Үүнд:

1. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, сурталчилгаа,
2. ажилтныг эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт хамруулах,
3. ажилтныг сувилах, хөдөлмөрийн чадвар алдалтыг нөхөн сэргээх,
4. ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл,
5. ажлын байр, үйлдвэрлэлийн орчны аюул, эрсдэлгүй байдлыг хангах,
6. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бүтэц, ажилтан, зөвлөлийн чиг үүрэгт хамаарах үйл ажиллагаа
7. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх бусад арга
8. ажилтныг амь нас, эрүүл мэндийн даатгалд хамруулах;

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дээр дурдсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн арга хэмжээнд зарцуулах төсвийн **хувь хэмжээг хэвээр тусгасан байна.**

Мөн уг зардлыг одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд заасан ажилтныг эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт хамруулах, ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах, ажилтныг амь нас, эрүүл мэндийн даатгалд даатгуулах зэрэг арга хэмжээнд мөн адил зарцуулахаар хуулийн төсөлд тусгасан байна.

Мөн хуулийн төсөлд “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх бусад арга хэмжээ” гэснийг илүү тодорхой болгож дараах байдлаар авч үзсэн байна. Үүнд:

- ажлын байранд эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийг арилгах, бууруулах урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээг тодорхойлох үнэлгээ, судалгаа хийх;
- ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилт, шинжилгээ хийх, хэмжилтийн багаж хэрэгсэл худалдан авах, шалгалт тохируулга хийлгэх;
- ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх;
- хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг, тандалт;
- ажилтанд ажлын байранд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх;

Дээрх байдлаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээг задлан, нарийн тодорхойлж өгсөн нь дээр дурдсан “Төсвийн байгууллага нь тухайн жилийн батлагдсан төсвийн **0.5 хувиас**, аж ахуйн нэгж, байгууллага эрсдэлийн түшингээс хамааран **үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тус тус зарцуулна.”** гэсэн хүрээнд

багтаж байгаа тул аж ахуйн нэгж, байгууллагын хувьд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний нийт зардалд өөрчлөлт гарахгүй буюу нэмэлт зардал гарахааргүй байна.

Харин хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ажил олгогч ажилтныг амь нас, эрүүл мэндийн даатгалд даатгуулснаар даатгалын байгууллагаас тодорхой зардлуудыг хариуцах буюу ажил олгогчид ирэх эрсдэл, ачааллыг бууруулах тодорхой зохицуулалтууд тусгагдсан байна.

Ажилтны амь нас, эрүүл мэндийн даатгалын байгууллагаас хариуцах зардал

Монгол улсад хөдөлмөр эрхэлж буй нийт ажилтны 17 хувь буюу 224.0 мянган ажилтан өндөр эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа бөгөөд эдгээрийн ихэнх нь уул уурхай, барилга, зам, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байна.

Сүүлийн 5 жилийн хугацаанд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын нийт 2125 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд үүний 275 буюу 13 хувь нь үхэлд хүргэсэн, 1850 буюу 87.0 хувь нь үхэлд хүргээгүй буюу гэмтсэн, хордсон ослын тохиолдолд хамаарч байна.

Хүснэгт 9. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдлын тоо

Он	Бүртгэгдсэн ҮОХХ-ын тоо	Ослын хэлбэр	
		Үхэлд хүргэсэн (нас барсан)	Үхэлд хүргээгүй (гэмтсэн, хордсон)
2020	354	40	313
2021	256	34	223
2022	395	57	338
2023	408	57	351
2024	712	87	625
Нийт	2125	275	1850

Эх үүсвэр: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Хөдөлмөрийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.1.2-т үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас ажилтан нас барсан бол үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд даатгуулсан эсэхийг үл харгалзан **ажил олгогч** ажилтны нэг сарын дундаж цалин хөлсийг 36 дахин нэмэгдүүлсэн нөхөн төлбөрийг түүний гэр бүлд нэг удаа олгохоор заасан.

Хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 53.1-д “эрсдэл өндөртэй ажлын байранд ажиллаж байгаа ажилтныг амь нас, эрүүл мэндийн даатгалд даатгуулна” гэж, мөн хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 40.2.11-д “үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан ажилтанд хууль тогтоомжийн дагуу нөхөн төлбөр олгох” гэж тус тус заасан байна. Түүнчлэн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд даатгуулагчийг хөдөлмөрийн эрүүл мэндийн хугацаат үзлэг хийх, үйлдвэрлэлийн осолд орсон хүнд үзүүлэх эмнэлгийн яаралтай тусламж, ослын газраас эмнэлэг хүргэх болон эмчилгээний зардал,

хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээхтэй холбоотой протез, ортопед, сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний зардлын үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох жишиг зардлаас давсан хэсэг зэргийн зардлыг даатгалын байгууллагаас хариуцахаар тусгасан байна.

Эдгээр эрсдэл өндөртэй ажлын байранд ажиллаж буй нэг ажилтны амь нас, эрүүл мэндийн даатгалд (дунджаар 2 хувь) ажил олгогч жилд дунджаар 2,334.0 мянган төгрөгийн даатгалын хураамж төлөхөөр байна. Тооцооллыг Хүснэгт 10-т харуулав.

Хүснэгт 10. Эрсдэл өндөртэй ажлын байранд ажиллаж буй нэг ажилтны амь нас, эрүүл мэндийн даатгалын хураамжийн зардал

Эрсдэл өндөртэй салбар	Сарын дундаж цалин, мян.төг	Даатгалын үнэлгээ, мян.төг	Нэг ажилтны даатгалын хураамжийн зардал (2%)
Уул уурхай, олборлолт	5402.8	194,500.8	3,890,016.0
Боловсруулах үйлдвэрлэл	2385.2	85,867.2	1,717,344.0
Барилга	2303.4	82,922.4	1,658,448.0
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	2872.4	103,406.4	2,068,128.0
Дундаж	3240.95	116,674.2	2,333,484.0

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсаны дагуу эрсдэл өндөртэй ажлын байранд ажиллаж буй ажилтныг амь нас, эрүүл мэндийн даатгалд хамруулснаар тухайн даатгуулагч ажилтан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас амь насаа алдсан, үйлдвэрлэлийн осолд орсон тохиолдолд ажил олгогчоос хариуцах нөхөн төлбөр, эмнэлгийн яаралтай тусламж, ослын газраас эмнэлэг хүргэх болон эмчилгээний зардал зэргийг даатгалын байгууллагаас хариуцах бөгөөд уг хэмжээгээр ажил олгогчид үүсэх эрсдэл, зардал буурахаар байна. Холбогдох тооцооллыг Хүснэгт 11-д харуулав.

Хүснэгт 11. Ажилтны амь нас, эрүүл мэндийн даатгалын байгууллагаас хариуцах зардлын тооцоо

Хуулийн төсөлд тусгагдсан заалт	Нэг даатгуулагч ажилтанд гарах зардал, дунджаар	Нийт зардал, жилд (мян.төгрөг)	Тайлбар
53.4.2.даатгуулагч үйлдвэрлэлийн осолд өртсөн, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр өвчилсөн эсхүл нас барсан бол Хөдөлмөрийн тухай хуулийн 125.1-д заасан нөхөн төлбөрийг ажилтан эсхүл ажилтны ар гэрт олгох	116,674,200	10,150,655	2024 оны байдлаар нийт 87 хүн ҮОХХ-ын улмаас нас барсан байна.

53.4.1.ажил олгогч, даатгуулагчид чиглэсэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний урьдчилан сэргийлэлт болон эрүүл мэндийн үйлчилгээний зардал	300,000	72,000,000	Улсын хэмжээнд ойролцоогоор 240,000 эрсдэлтэй ажлын байр бүртгэгдсэн байна.
53.3.1.үйлдвэрлэлийн осолд орсон хүнд үзүүлэх эмнэлгийн яаралтай тусламж, ослын газраас эмнэлэг хүргэх болон эмчилгээний зардал	3,000,000	2,136,000	2024 онд нийт 712 үйлдвэрлэлийн осол, хурц хордлого бүртгэгдсэн.
53.3.2.хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээхтэй холбоотой протез, ортопед, сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний зардлын үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох жишиг зардлаас давсан хэсэг	2,000,000	1,000,000	2024 оны байдлаар хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээхтэй холбоотой протез, ортопед, сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний зардлын үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас төлбөр авсан 1714 хүн байна.
Нийт		85,286,655	

Дүгнэлт: Хуулийн төсөл батлагдсанаар ажил олгогчийн зүгээс хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах нийт зардлын хувьд өөрчлөлт гарахгүй. Харин эрсдэл өндөртэй ажлын байранд ажилладаг ажилтан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас амь насаа алдсан тохиолдолд ажил олгогч хариуцах нөхөн төлбөр, ажилтныг эрүүл мэндийн хугацаат үзлэгт хамруулах зэрэг арга хэмжээний зардлыг даатгалын байгууллагаас хариуцахаар байна. Тухайлбал ажил олгогч ажилтныг амь нас, эрүүл мэндийн даатгалд хамруулснаар нэг даатгуулагч ажилтны дундаж нөхөн төлбөрийн зардал болох 116,674.2 мянган төгрөгийг амь нас, эрүүл мэндийн даатгалын байгууллагаас хариуцан төлнө. Ингэснээр даатгалын байгууллагаас даатгуулагч ажилтанд үзүүлэх үйлчилгээний нэр, төрлийг тодорхой болгож, улмаар ажил олгогчийн эрсдэл, ачааллыг бууруулж байна.

2.2.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан бүтэц болон ажилтан, зөвлөл ажиллуулах

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27.2-т “Ажил олгогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог,

ажлын байрны эрсдэлийн түвшин, ажилтны тоог харгалзан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан **бүтэц болон ажилтан, зөвлөл ажиллуулна.**” гэж заасан. Мөн Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалаар “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл байгуулах, орон тооны ажилтан ажиллуулах норматив”-ыг баталсан.

Уг тушаалын 1-ийн а/-д “Үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага 50-иас 100 хүртэл ажилтантай тохиолдолд нэг ба түүнээс дээш орон тооны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтантай, 100-аас дээш ажилтантай тохиолдолд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэцтэй байна.” гэж, г/-д “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 4.1.3, 4.1.6-д заасан аж ахуйн нэгж, байгууллага нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц болон ажилтан ажиллуулах орон тоонд хүрээгүй тохиолдолд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг мэргэшсэн байгууллага, ажилтнаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.” гэж тус тус заасан.

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тухайн аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны тооноос хамааран хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлыг захирал /эзэн/, ажил олгогч өөрөө хариуцах эсхүл аль нэг ажилтнаар хавсран гүйцэтгүүлэх, орон тооны ажилтан ажиллуулах, хариуцсан бүтэцтэй байхаар тусгасан байна.

Үндэсний статистикийн хорооны 2024 оны 4 дүгээр улирлын мэдээгээр Монгол улсад нийт 108,378 ААНБ үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эдгээрийн 93,453 нь буюу 86 хувь нь 1-9 ажилтантай ААНБ байна. Эдгээр ААНБ-ын хувьд захирал, ажил олгогч өөрөө ХАБЭМ-ийн асуудлыг хариуцан ажиллах тохиолдолд ямар нэгэн нэмэлт зардал гарахгүй бөгөөд аль нэг ажилтнаар хавсран гүйцэтгүүлэхэд тохиолдолд жилд дунджаар 6,771.4 мянган төгрөгийн цалин хөлсний зардал гарна.

Мөн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 11-50 ажилтантай ААНБ нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлыг аль нэг ажилтнаар хавсран гүйцэтгүүлэх, эсхүл орон тооны ажилтан ажиллуулах эсхүл гэрээгээр гүйцэтгүүлэхээр заасан. Үндэсний статистикийн хорооны 2024 оны 4 дүгээр улирлын мэдээгээр уг хүрээнд хамаарах ААНБ 12,000 буюу нийт Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын 11 хувийг эзэлж байна. Эдгээр ААНБ-ын хувьд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлыг аль нэг ажилтнаар хавсран гүйцэтгүүлэхэд жилд 9,427.2 мянган төгрөгийн, орон тооны ажилтан ажиллуулахад жилд 23,568.0 мянган төгрөгийн цалин хөлсний зардал гарахаар байна.

Харин хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 100-200 хүртэл ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагын хувьд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэцтэй бус орон тооны ажилтантай байхаар байна. Иймд дээр дурдсан хүрээнд хамаарах ажил олгогчийн хувьд нэг ажилтны цалин хөлсний зардалд жилд дунджаар 27,603.6 мянган төгрөгийн цалин хөлсний зардлын хэмнэлт үүсэхээр байна. Тооцооллыг Хүснэгт 12-т харуулав.

Хүснэгт 12. 100-200 хүртэл ажилтантай үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн орон тооны ажилтан ажиллуулахтай холбогдох гарах зардлын тооцоо, жилээр

Хуулийн төсөлд тусгагдсан заалт	Ажилтны тоо	Дундаж цалин, мян.төг	Нийт зардал, жилээр, мян.төгрөг
34.3.2.51-200 хүртэл ажилтантай бол орон тооны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн ажилтантай байх, хөдөлмөрийн эрүүл ахуйч, мэргэжлээс шалтгаалсан өвчний эмчийг орон тоогоор эсхүл гэрээгээр ажиллуулж болно	1	2,300.3	27,603.6

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

200-аас дээш ажилтантай ААНБ-ын хувьд одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн адил хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан бүтэцтэй байхаар байгаа бөгөөд эдгээр ААНБ-ын хувьд нэмэлт зардал үүсэхгүй байна.

Дүгнэлт: Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын 86 хувь буюу 1-9 ажилтантай 93,453 ААНБ-ын хувьд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг аль нэг ажилтнаар хавсран гүйцэтгүүлэх эсвэл ажил олгогч өөрөө хариуцан ажиллахаар байгаа тул уг хүрээнд хамаарах ажил олгогчдын хувьд нэмэлт зардал үүсэхгүй. Харин 11-50 ажилтантай 12,000 ААНБ-ын хувьд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлыг аль нэг ажилтнаар хавсран гүйцэтгүүлэхэд жилд 9,427.2 мянган төгрөгийн, орон тооны ажилтан ажиллуулахад жилд 23,568.0 мянган төгрөгийн цалин хөлсний зардал гарахаар байна.

ГУРАВ.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДАЛ

Төрийн байгууллагын зардлыг тооцохдоо аргачлалын 4.1-д заасны дагуу

- 1) байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох;
- 2) ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;
- 3) гарах зардлыг урьдчилан тооцох;
- 4) зардлыг нэгтгэн тооцох;
- 5) хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах үе шатаар хуульд заасан үүргээ гүйцэтгэхтэй холбогдон гарах мөнгөн зардлыг тооцсон.

3.1 ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ БУЮУ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭГ ТОДОРХОЙЛОХ

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас ажил хөдөлмөр эрхэлж байгаа даатгуулагч иргэнд үзүүлэх үйлчилгээ, даатгуулагч, ажил олгогчид үзүүлэх урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан иргэнд зориулсан үйлчилгээ зэргийн зардлыг санхүүжүүлэхээр тусгасан байна.

Хүснэгт 13. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх арга хэмжээ

Хуулийн төсөлд тусгасан холбогдох зохицуулалт	Санхүүжүүлэх арга хэмжээ
Хуулийн төслийн 50.4 дахь хэсэг	50.4.Удирдлагын цахим системийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг хангахтай холбоотой үйл ажиллагааны зардлыг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлнэ.
Хуулийн төслийн 51.1 дэх хэсэг	51.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн арга хэмжээ болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үндэсний түвшинд хэрэгжүүлэх санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ: 51.1.1.улсын болон орон нутгийн төсөв; 51.1.2.гадаад, дотоодын иргэн, хуулийн этгээдийн хандив; 51.1.3.гадаадын зээл, тусламж; 51.1.4.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас зарцуулах хөрөнгө;
Хуулийн төслийн 52.3 дахь хэсэг	52.3.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 13.1-т заасны дагуу санхүүжүүлнэ.
Хуулийн төслийн 53.3 дахь хэсэг	53.3.2.хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээхтэй холбоотой протез, ортопед, сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний зардлын үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох жишиг зардлаас давсан хэсэг;
Хуулийн төслийн 56.5 дахь хэсэг	56.5.Энэ хуулийн 56.4-т заасан сэргээн засах тусламж, үйлчилгээний зардлыг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлнэ.

3.2 ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН САНГААС ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

Одоогийн хүчин төгөлдөр хууль тогтоомжийн хүрээнд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөртэй холбоотой харилцааг Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулиар зохицуулж байгаа бөгөөд

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд тодорхой зохицуулалтууд байхгүй байна.

Үндэсний статистикийн хорооны мэдээгээр 2023 онд тус сангийн орлого нь 282.7 тэрбум төгрөг, зарлага нь 54.2 тэрбум төгрөг, 2024 онд сангийн орлого 345.0 тэрбум төгрөг, зарлага нь 48.1 тэрбум төгрөг байна. ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого, зарлагын мэдээг Хүснэгт 14-т харуулав.

Тус сангийн орлого, зарлагын мэдээнээс харахад 2024 оны байдлаар нийт сангийн орлогын 14.0 хувийг зарцуулж байна.

Хүснэгт 14. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн орлого, зарлагын мэдээ /сая төгрөг/

ҮОМШӨ-ний даатгалын сан	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого	147,845.7	171,211.5	210,956.8	145,482.4	129,237.8	208,836.2	282,706.0	345,027.4	353,907
ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага	46,027.8	46,820.0	52,854.1	34,227.2	34,415.8	40,656.7	54,133.6	48,110.8	52,049.6
Зарлагын хувь	31.1%	27.3%	25.1%	23.5%	26.6%	19.5%	19.1%	14.0%	14.7%

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2023 онд баталж, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж байна. Тус хуулийн 13.2-т “Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төлбөр нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн тухайн жилийн шимтгэлийн орлогын 2 хувиас багагүй байна.” гэж заасан.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2025 оны орлого 353.0 тэрбум төгрөг байгаа бөгөөд дээрх хуульд заасан хувь хэмжээгээр тооцоход урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төлбөрт хамгийн багадаа 7.1 тэрбум төгрөгийг төсөвлөхөөр байна.

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох, хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах, ажил олгогчийн шилдэг туршлага, ололт, амжилтыг олон нийтэд сурталчлах зэрэг арга хэмжээг санхүүжүүлж байна.

2024 оны жилийн эцсийн байдлаар 6.7 мянган даатгуулагчид хөдөлмөрийн чадвар алдсан, тэжээгчээ алдсан, ХЧТА, хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, рашаан сувиллын зардалд ҮОМШӨ-ний даатгалын сангаас 48.1

тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна. Харин 2025 онд 52.1 тэрбум төгрөгийн зарцуулсан байна.

Хүснэгт 15. ҮОМШӨ-ний тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн /мян.хүн, тэрбум.төг/

№	Тэтгэвэр, тэтгэмжийн төрөл	2022 он		2023 он		2024 он	
		Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн
1	Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр	3.5	27.5	3.5	31.8	3.4	37.5
2	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	0.5	3.4	0.5	4.0	0.4	4.8
3	ХЧТА-ны тэтгэмж	1.2	1.3	1.5	1.8	1.2	2.6
4	Хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр	0.01	0.01	0.01	0.01	0.01	0.02
5	Рашаан сувиллын зардал	2.0	1.1	1.9	1.0	1.7	1.3
6	Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал	-	1.1	-	1.1	-	0.25
7	Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчдын тэтгэврийн даатгалын шимтгэл	-	1.5	-	1.8	-	1.6
8	Олон нийтэд чиглэсэн, сурталчилгаа, зөвлөн туслах үйлчилгээ	-	-	-	-	-	0.06
	Нийт	7.2	36.0	7.4	41.5	6.7	48.1

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 1362 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд заасан үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан ажлын байр нэмэгдэхгүй. Харин шинээр гарах зардлыг энэхүү тооцооллын 3.3 дугаар хэсэгт тусгав.

3.3 ШИНЭЭР ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас дараах нэмэлт зардал тусгасныг тооцоолов.

Хүснэгт 16. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын мэдээллийн санг ашиглах, хадгалах, хамгаалахтай холбогдох зардал

№	Хуулийн төсөлд тусгагдсан заалт	Зардлын төрөл	Тоо ширхэг	Зардал /мян.төг/
1	50.4.Удирдлагын цахим системийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг хангахтай холбоотой үйл ажиллагааны зардлыг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс	Ашиглалт, хадгалалт, хамгаалалт	-	20,000

	шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлнэ.		
Нийт			20,000.0

Удирдлагын цахим системийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг хангахтай холбоотой үйл ажиллагааны зардлыг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэхэд 20 сая төгрөг гарахаар байна.

Хүснэгт 17. Шинээр ажилд орох даатгуулагчийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн 44.2-т заасан хөдөлмөрийн эрүүл мэндийн урьдчилсан үзлэгийн тооцоо

№	Хуулийн төсөлд тусгагдсан заалт	Эрсдэлтэй ажлын байранд шинээр ажилд орох хүний тоо	Нэгж зардал /мян.төгрөг/	Зардал /мян.төг/
1	52.3.шинээр ажилд орох даатгуулагчийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн 44.2-т заасан хөдөлмөрийн эрүүл мэндийн урьдчилсан үзлэг	39720	200	7,854,000
Нийт				7,854,000

2025 онд шинээр даатгуулсан 112200 даатгуулагчдаас өмнөх жилүүдийн дунджаар тооцон 35% нь эрсдэлтэй ажлын байранд ажиллахад гарах зардлыг тооцоолоход 7.8 тэрбум төгрөг гарахаар байна.

Хүснэгт 18. Мэргэжлээс шалтгаалсан өвчний онош баталгаажуулах, хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоохтой холбоотой эмнэлгийн үзлэг, шинжилгээний зардал

№	Хуулийн төсөлд тусгагдсан заалт	ХЧА онош баталгаажуулах хүний тоо	Нэгж зардал /мян.төгрөг/	Зардал /мян.төг/
1	Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль: 14.1.1.мэргэжлээс шалтгаалсан өвчний онош баталгаажуулах, хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоохтой холбоотой эмнэлгийн үзлэг, шинжилгээний	2196	300	658,800
Нийт				658,800

Хөдөлмөрийн чадварын онош баталгаажуулах хүний тоог сүүлийн 2 жилийн дунджаар авч, шинжилгээний зардлыг 300,000 төгрөгөөр тооцоход 658,8 сая төгрөг гарахаар байна.

Хүснэгт 19. Хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгаан, онош баталгаажуулахтай холбоотой хөдөлмөрийн нөхцөлийг судлан тогтоох хэмжилт, лабораторийн шинжилгээний зардал

№	Хуулийн төсөлд тусгагдсан заалт	ХЧА онош баталгаажуулах хүний тоо	Нэгж зардал /мян.төгрөг/	Зардал /мян.төг/
1	Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль: 14.1.2.хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгаан, онош баталгаажуулахтай холбоотой хөдөлмөрийн нөхцөлийг судлан тогтоох хэмжилт, лабораторийн шинжилгээний	2196	500	1,098,000
Нийт				1,098,000

Хөдөлмөрийн чадварын онош баталгаажуулах хүний тоог сүүлийн 2 жилийн дунджаар авч, хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгаан, онош баталгаажуулахтай холбоотой хөдөлмөрийн нөхцөлийг судлан тогтоох хэмжилт, лабораторийн шинжилгээний зардлыг 500,000 төгрөгөөр тооцоход 1,1 тэрбум төгрөг гарахаар байна.

Хүснэгт 20. Хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагчид үзүүлэх хөдөлмөрийн сэргээн засах үйлчилгээний зардал

№	Хуулийн төсөлд тусгагдсан заалт	Сэргээн засах үйлчилгээнд хамрагдах хүний тоо	Нэгж зардал /мян.төгрөг/	Зардал /мян.төг/
1	Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль:	4237	650	2,754,050

	14.1.6.хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагчид үзүүлэх хөдөлмөрийн сэргээн засах үйлчилгээний			
2	Сэргээн засах сувиллын зардал	2237	1320	2,952,840
Нийт				5,706,890

2024, 2025 онуудын сэргээн засах үйлчилгээнд хамрагдсан хүнийг дунджаар авч, нэгж зардлыг 650,000 төгрөгөөр тооцоход 2.7 тэрбум төгрөг сэргээн засах үйлчилгээнд гарахаар байна. Харин сэргээн засах сувиллын зардалд сувилалд хамрагдах хүний тоог нэг хүний хоногийн 110,000 төгрөгийг ҮОМШӨ-ний даатгалын сангаас олгох өдрийн дээд хоног 12 хоногоор тооцоход 2.9 тэрбум төгрөг гарахаар байна.

Хүснэгт 21. Даатгуулагчийн хөдөлмөрийн чадварыг хадгалах, сэргээн засах иж бүрэн төлөвлөгөө боловсруулах, эмчилгээний, сувилгааны хэрэгцээг тодорхойлох, үр дүнг хянахад чиглэсэн эмнэлгийн хяналтын үзлэг, шинжилгээний зардал

№	Хуулийн төсөлд тусгагдсан заалт	Хяналтын үзлэгт хамрагдах даатгуулагчийн тоо	Нэгж зардал /мян.төгрөг/	Зардал /мян.төг/
1	Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль: 14.1.7.даатгуулагчийн хөдөлмөрийн чадварыг хадгалах, сэргээн засах төлөвлөгөө боловсруулах, эмчилгээ, сувилгааны хэрэгцээг тодорхойлох, үр дүнг хянахад чиглэсэн эмнэлгийн хяналтын үзлэг, шинжилгээний	4237	320	1,355,840
Нийт				1,355,840

2025 онд МШӨ-ний оношоор бүртгэгдсэн 4237 даатгуулагчийг 160,000 төгрөгөөр жилд 2 удаа эмнэлгийн хяналтын үзлэгт хамруулахад 1,3 тэрбум төгрөг гарахаар байна.

Хүснэгт 22. Ажил олгогчид олгох хөнгөлөлтийн зардал

№	Хуулийн төсөлд тусгагдсан заалт	Хөдөлмөрийн нөхцөлөө сайжруулсан ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх ажил олгогчийн тоо	Нэгж зардал /мян.төгрөг/	Зардал /мян.төг/
1	15.2.Энэ хуулийн 15.1.1-д заасан шимтгэлийн хөнгөлөлтийг дараах нөхцөлийг 3 жил дараалан хангасан ажил олгогчийн сүүлийн жилд төлсөн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн 15 хүртэлх хувиар тооцож, ажил олгогчид 3 жил тутамд нэг удаа, хөдөлмөрийн нөхцөлөө сайжруулсан ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэсэн зардлын 20 хүртэл хувийг нэг удаа тус тус үзүүлнэ	122	6000	732,000
Нийт				732,000

Жилд дунджаар 244 байгууллага хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэдэг ба үйлчилгээний дундаж төлбөр 30 сая төгрөг байна. Эдгээр байгууллагуудын 50 хувь нь нөхцөлөө сайжруулна гэж үзэн 20 хувийн хөнгөлөлт үзүүлэхээр тооцоолоход 732,0 сая төгрөг гарахаар байна.

Дээрх байдлаар тооцоход хуулийн төсөлд тусгагдсан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх даатгуулагч ажилтан, ажил олгогчид зориулсан арга хэмжээний хүрээнд Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас жилд дунджаар 17.4 тэрбум төгрөгийн нэмэлт зардал гарахаар байна.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2025 оны орлого, зарлагын мэдээнээс харахад тус сангийн орлого 353.9 тэрбум төгрөг, зарлага нь 52.1 тэрбум төгрөг буюу 14.7 хувийг зарцуулж байгаа бөгөөд дээр дурдсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нэмэлт арга хэмжээг сангаас санхүүжүүлснээр сангийн зарлага нийт орлогын 19.6 хувь болохоор байна.

Дүгнэлт: Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2025 оны орлого, зарлагын мэдээнээс харахад тус сангийн орлого 353.9 тэрбум төгрөг, зарлага нь 52.1 тэрбум төгрөг байна. Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан даатгуулагч, ажил олгогч болон даатгуулагч

ажилтанд үзүүлэх арга хэмжээ нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд чиглэгдэж байгаа бөгөөд хуулийн төсөл батлагдсанаар санд ойролцоогоор 17.4 тэрбум төгрөгийн нэмэлт зардал үүсэхээр байна.

ДӨРӨВ, ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Иргэнд үүсэх зардлыг тооцохдоо аргачлалын 3.1-д заасны дагуу

- 1) иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 2) цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох;
- 3) тоон үзүүлэлтийг тогтоох;
- 4) нийт дүнг тооцож гаргах;
- 5) хялбарчлах боломжийг шалгах үе шатаар тооцлоо.

4.1 ИРГЭНИЙ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ ТОГТООХ

Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн

Хүснэгт 23. Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний гүйцэтгэх үүрэг

Хуулийн төсөлд тусгасан холбогдох зохицуулалт	Үүрэг
41.2 дэх Хэсэг	<p>41.2.Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн дараах үүрэгтэй байна:</p> <p>41.2.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг хангаж өөрийн болон бусдын эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл учруулахгүй байх;</p> <p>41.2.2.ажил, хөдөлмөрийн онцлогт нийцсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан байх;</p> <p>41.2.3.ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийх;</p> <p>41.2.4.тухайн салбарт тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг мөрдөх;</p> <p>41.2.5.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд даатгуулах;</p> <p>41.2.6.хууль тогтоомжид заасан бусад.</p>

Дээрх байдлаар хуулийн төсөлд тусгагдсаны дагуу хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн дараах 6 үндсэн үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. **Өөрийн болон бусдын эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл учруулахгүй байх**
 - ХАБЭМ-ийн шаардлагыг хангаж ажиллах.
2. **Сургалтад хамрагдсан байх**

- Ажил, мэргэжлийн онцлогт тохирсон ХАБЭМ-ийн сургалтад хамрагдсан байх.
- 3. Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийх**
 - Өөрийн ажлын орчныг үнэлж, эрсдэлийг тодорхойлох.
- 4. Салбарын стандартыг мөрдөх**
 - Тухайн ажиллаж буй салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг дагаж мөрдөх.
- 5. Даатгалд хамрагдах**
 - Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд хамрагдах.
- 6. Бусад хууль тогтоомжоор тогтоосон үүрэг**
 - Бусад холбогдох хуулиар тогтоосон нэмэлт үүргүүдийг биелүүлэх.

Дээр дурдсан үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэнд дунджаар дараах зардал гарахаар байна.

Хүснэгт 24. Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллахтай холбоотой зардлын тооцоо

№	Үүрэг/Үйл ажиллагаа	Зардлын төрөл	Дундаж зардал, төгрөг	Тайлбар
1	Хувийн хамгаалах хэрэгслээр хангах	Хувцас, хэрэгслийн зардал	200,000	Бээлий, амны хаалт, ажлын хувцас
2	ХАБЭМ-ийн сургалтад хамрагдах	Сургалтын төлбөр	150,000	Жилд 1 удаа хамрагдах
3	Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийх	Үнэлгээ хийх	500,000	Мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн тохиолдолд төлбөртэй.
4	Салбарын стандартыг дагаж мөрдөх	Шинэчлэл, зохицуулалт хийх	1,000,000	Цахилгааны хамгаалалт, агааржуулалт, гэрэлтүүлэг
5	Даатгалд хамрагдах	ҮОМШӨ-ний даатгалын шимтгэл	95,040	Сайн дурын шимтгэлийн хувь 13.5 хувь
6	Хууль, дүрэм мөрдөхөд шаардагдах зардал	Зөвлөгөө, бичиг баримт бүрдүүлэлт	100,000	Бичиг баримт бүрдүүлэх
Нийт			2,045,040	

4.2 НЭМЭЛТ ЗАРДЛЫН ТООЦОО

Хуулийн төслийн 38.2-т “Ажилтан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн арга хэмжээний аливаа зардлыг хариуцахгүй” гэж заасан бөгөөд уг зохицуулалтаар ажилтанд үүсэх зардал байхгүй байна.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний хувьд одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд заасны дагуу өөрийн ажиллагчдын аюулгүй, эрүүл ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, галын аюулаас урьдчилан сэргийлэх болон гал унтраах дүрэм, журам, стандартыг хангаж ажиллах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдаж мэдлэг, дадлагатай болсон байх зэрэг үүргийг хүлээж байна.

Харин хуулийн төсөлд хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд хамрагдах үүрэг хүлээсэн байна. Өөрөөр хэлбэл хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18.3-т заасны дагуу үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд 1.0 хувиар шимтгэл төлнө. Үндэсний статистикийн хорооны 2023 оны жилийн эцсийн мэдээгээр хөдөө, аж ахуйн бус салбарт албан бус хөдөлмөр эрхлэгч 194,451 иргэн байна. ҮОМШӨ-ний даатгалын сангийн 2024 оны мэдээгээр тус санд 171,332 сайн дураар даатгуулагч шимтгэл төлж байна.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 792,000 төгрөгөөс тооцоход нэг хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн жилд 95,040 төгрөгийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэл төлөхөөр байна. Тооцоог Хүснэгт 25-т харуулав.

Хүснэгт 25. Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн зардал, жилд

Хуулийн заалт	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, сард, төгрөг	Шимтгэлийн хувь хэмжээ	Шимтгэлийн зардал, жилд, төгрөг
41.2.5.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд даатгуулах;	792,000	1.0	95,040

Дүгнэлт: Хуулийн төслийн 35.2-т “Ажилтан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн арга хэмжээний аливаа зардлыг хариуцахгүй” гэж заасан бөгөөд уг зохицуулалтаар ажилтанд үүсэх зардал байхгүй. Харин нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэнд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд хамрагдахтай холбоотой зардал үүсэхээр байна.

ТАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн, 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн хүрээнд хамрагдах

иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ыг удирдлага болгон зардлын тооцоог гаргалаа.

Аргачлалын 1 дүгээр зүйлийн 1.5-д заасан журмын дагуу зардлыг төрийн байгууллагын зардал, хуулийн этгээдийн зардал, иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцоход ажилтанд зардал үүсгэх зохицуулалт тусгагдаагүй байна. Харин хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн жилд 95,040 төгрөгийн ҮОМШӨ-ний даатгалын шимтгэл төлөхөөр байна.

Төрийн байгууллагад үүсэх зардлын хувьд Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд тодорхой зардал гарахаар байна. Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан даатгуулагч ажил олгогч болон даатгуулагч ажилтанд үзүүлэх эдгээр арга хэмжээ нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдэж байгаа бөгөөд хуулийн төсөл батлагдсанаар ҮОМШӨ-ний даатгалын санд ойролцоогоор 17.4 тэрбум төгрөгийн нэмэлт зардал үүсэхээр байгаа бөгөөд энэхүү зардал нь даатгуулагч ажил олгогчийг эрсдэлээс хамгаалах, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх, даатгуулагч ажилтны эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдэж байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон Олон улсын хөдөлмөрийн байгууллагын судалгаагаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд оруулсан 1 ам.долларын зардал нь 4-6 ам.долларын үр ашиг өгдөг байна. Мөн Япон, Герман, Канад зэрэг орнууд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээг өндөр төвшинд хэрэгжүүлснээр үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний түвшинг 20-50 хувиар бууруулсан байна.

Иймд дээр дурдсан зардал нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийг хэрэгжүүлэх, ялангуяа ажил, хөдөлмөртэй холбоотой осол, бэртэл, өвчнөөс урьдчилан сэргийлэх, ажилтны эрүүл мэндийг хамгаалахад зайлшгүй чухал тул хялбаршуулах, үүргийг нэгтгэн бууруулах боломжгүй гэж дүгнэв.



МОНГОЛ УЛСЫН
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛДЫН САЙД

Нэгдсэн үндэстний гудамж 5,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 15 53, Факс: 32 66 34,
Цахим шуудан: info@mlsp.gov.mn
Цахим хуудас: www.mlsp.gov.mn

2026.03.09 № 01/708

танай _____ -ны № _____ -Т

Санал авах тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдуулан боловсруулсан Зөрчлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд Хууль тогтоомжийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэгт заасны дагуу санал авахаар холбогдох материалыг хүргүүлж байна. Үүнд:

1. Хуулийн төсөл
2. Хуулийн төслийн үзэл баримтлал
3. Хуулийн төслийн танилцуулга
4. Дагалдаж нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох материалтай танилцаж саналаа ирүүлнэ үү.

Хавсралт хуудастай

Хүндэтгэсэн,



Т.АУБАКИР



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР**

Хуульчдын гудамж 15/1, Бага тойруу, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 08 55, Факс: (976-51) 26 37 39,
Цахим шуудан: gro@prosecutor.mn,
Цахим хуудас: www.prosecutor.mn

2026.04.15 № 2/1579

танай 2026.03.09 ны № 01/708-т

**МОНГОЛ УЛСЫН ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД
Т.АУБАКИР ТАНАА**


Таны 2026 оны 03 дугаар сарын 9-ний өдрийн 01/708 дугаартай албан бичгийн дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдан боловсруулсан Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй танилцаад, гаргасан саналыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 2-хуудас.

**УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН
ОРЛОГЧ, ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН
ШАДАР ЗӨВЛӨХ М.ЧИНБАТ**

D:\2026\БТХШҮХ\45moom.docx

15013402539



Улсын ерөнхий прокурорын газрын
2026 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн
...2/1574 дугаартай албан бичгийн хавсралт

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ГАРГАСАН САНАЛ

№	Зүйл, хэсэг, заалт	Гаргасан санал			Саналын үндэслэл, хэрэгцээ, шаардлага
		Өөрчлөх	Нэмэх	Хасах	
0	1	2	3	4	5
1.	Төслийн 1 дүгээр зүйл. 10.15 дугаар зүйлийн 9 дэх хэсэг. 9.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн тухайн зөрчлийг давтан үйлдсэн бол торгуулийн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлж торгоно.			Бүхэлд нь хасах	Зөрчлийн тухай хуульд зөрчлийг давтан үйлдэх, торгох шийтгэлийн хэмжээг нэмэгдүүлж оногдуулах гэсэн хууль зүйн ойлголт байхгүй. Зөрчлийн тухай хуулийн 3.4 дүгээр зүйлд торгох шийтгэл оногдуулах үндэслэл, журмыг, 3.8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт хуулийн этгээд хууль, захиргааны хэм хэмжээний актаар тогтоосон журмыг байнга, эсхүл ноцтой зөрчсөн тохиолдолд эрх хасах шийтгэлийг үндсэн шийтгэл дээр нэмж оногдуулахаар хуульчилсан. Төсөл зааснаар, зөрчлийг давтан үйлдсэн тохиолдолд торгох шийтгэлийн хэмжээг нэмэгдүүлж оногдуулах нь Зөрчлийн тухай хуульд заасан нийтлэг журамд нийцэхгүйн зэрэгцээ зөрчлийн шинж чанар, давтамжаас шалтгаалан эрх хасах нэмэгдэл шийтгэл оногдуулах зохицуулалттай зөрчилдөхөөр байна.
2.	10.15 дугаар зүйлийн 10 дахь хэсэг.		"10. Үйлдвэрлэлийн осол, аюултай тохиолдлыг судлан бүртгэх, акт үйлдэх орон тооны байнгын комиссыг байгуулж		Хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 54 дүгээр зүйлд ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, аюултай тохиолдол гарах бүрд техникийн зохицуулалтын дагуу судлан бүртгэх орон тооны бус комиссыг байгуулах, комисс нь 72 цагийн дотор судлан бүртгэж, акт үйлдэх зохицуулалтыг тусгасан.

			<p>ажиллуулаагүй, эсхүл хуульд заасан хугацаанд акт үйлдэж, хяналтын улсын байцаагчид хүргүүлээгүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно." гэж нэмэх.</p>		<p>Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх комисс байгуулах, акт үйлдэх ажиллагаа нь осолд өртсөн ажилтан Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж авах эрх хэрэгжих үндсэн нөхцөл болдог.</p> <p>Ажил олгогчийн зүгээс үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх комиссыг байгуулдаггүй, комисс актыг хуульд заасан хугацаанд гаргадаггүй зэрэг эс үйлдлээс шалтгаалан, ажилтан Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох эмчилгээний зардал, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, тахир дутуугийн тэтгэвэр зэрэг нийгмийн хамгааллын үйлчилгээг авч чадахгүй нөхцөл байдалд хүрч, ноцтой хохирол учрах тохиолдол гардаг.</p> <p>Иймд хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн дээрх үйлдлийг зөрчилд тооцох зохицуулалтыг төсөлд нэмэх.</p>
--	--	--	---	--	---



**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ**

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙГ ОЛОН НИЙТЭЭР
ХЭЛЭЛЦҮҮЛСЭН ТУХАЙ ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2026 он

**Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн
шинэчилсэн найруулгын төслийг олон нийтээр
хэлэлцүүлсэн тухай тайлан**

Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан хууль санаачлагчаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах үүрэг бүхий техникийн ажлын хэсгийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 27-ний өдрийн А/21 дүгээр тушаалаар баталж, хуулийн төслийг боловсруулсан.

Мөн хуулийн төслийг эцэслэн боловсруулж, хэлэлцүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг нийгмийн түншлэгч талууд болон эрдэмтэн, судлаачдын өргөтгөсөн бүрэлдэхүүнтэй Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 04 дүгээр сарын 10-ний өдрийн А/88 дугаар тушаалаар байгуулан ажилласан.

Хуулийн төслийг боловсруулах хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, хуулийн хэрэгцээ шаардлагын урьдчилан тандан судалсан судалгаа, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ болон холбогдох зардлын тооцоолол, хуулийн төслийг дагаж нэмэлт, өөрчлөлт орох хуулийн төслийг боловсруулсан. Эдгээр судалгааг төрийн болон төрийн бус байгууллага, хөдөлмөр, нийгмийн түншлэгч талуудад танилцуулах уулзалт зохион байгуулсан.

Хуулийн төслийг боловсруулах явцад 2025 оны 3 дугаар сараас 11 дүгээр сарын хооронд 11 удаагийн уулзалт, хэлэлцүүлгийг Улаанбаатар хотод аймагт зохион байгуулж, мэргэжлийн холбоод, салбарын мэргэжилтэн, аж ахуйн нэгж байгууллагын төлөөллийг хамруулан, саналыг тусган ажилласан. Түүнчлэн 2025 оны 9-12 дугаар сард Баян-Өлгий, Төв аймаг, Налайх, Багануур дүүрэгт зохион байгуулсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн цогц аян”-ны хүрээнд тухайн засаг захиргааны харьяалалтай аж ахуйн нэгж, байгууллагын удирдах ажилтнуудад хуулийн төслийг танилцуулан, хэлэлцүүлэг хийсэн.

2025 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр зохион байгуулсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аяны нээлтийн арга хэмжээний үеэр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хувилбарыг хөдөлмөр, нийгмийн түншлэлийн талууд болон олон нийтэд танилцуулав. Арга хэмжээнд 400 гаруй хүн оролцов.



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН АЯНЫ НЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭ	
09:30-09:35	ХАНДИТ УРСГАМЫН ГАНЦЛАГЧИЙН ХАМТРАН
09:30-09:35	МОНГОЛЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН АЯНЫ НЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭ
09:30-09:40	ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН АЯНЫ НЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭ
09:40-09:50	ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН АЯНЫ НЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭ
09:50-10:00	ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН АЯНЫ НЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭ
10:00-10:10	ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН АЯНЫ НЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭ
10:10-10:20	ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН АЯНЫ НЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭ
10:20-10:30	ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН АЯНЫ НЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭ
10:30-10:40	ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН АЯНЫ НЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭ
10:40-10:50	ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН АЯНЫ НЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭ
10:50-11:00	ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН АЯНЫ НЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭ
11:00-11:10	ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН АЯНЫ НЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭ
11:10-11:20	ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН АЯНЫ НЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭ
11:20-11:30	ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН АЯНЫ НЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭ
11:30-11:40	ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН АЯНЫ НЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭ
11:40-11:50	ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН АЯНЫ НЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭ
11:50-12:00	ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН АЯНЫ НЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭ

2025.04.02 “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аяны нээлтийн арга хэмжээ”

Эрчим хүчний яамтай хамтран 2025 оны 04 дүгээр сарын 04-ны өдөр зохион байгуулсан “**Эрчим хүчний салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чуулган**”-д ГБХНХЯ-наас хуулийн төслийн танилцуулга хийж, панел хэлэлцүүлэгт оролцов. Энэ чуулганд эрчим хүчний салбарын удирдах ажилтан, ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтэн зэрэг 120 гаруй төлөөлөл хүн оролцож хуулийн төсөлд саналаа ирүүлсэн.



2025.04.04 “Эрчим хүчний салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чуулган”

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээлээр “**Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний чуулган**”-ыг 2025 оны 05 дугаар сарын 02-

ны өдөр “ХАБЭМ-ийн Үндэсний тогтолцоог бэхжүүлж” урианд зохион байгуулж, 800 гаруй хүнийг хамруулав. Чуулганаар хуулийн төслийг олон нийтэд танилцуулж, панел хэлэлцүүлэг хийж, цахимаар /QR/ санал авч ажилласан.



“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний чуулган” 2025.05.02

Эрдэс баялаг, аж үйлдвэрийн яамтай хамтран уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн төлөөлөл 50 гаруй хүнийг хамруулсан хуулийн төслийн хэлэлцүүлгийг 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулав.



Уул уурхайн салбарын төлөөллийн дунд зохион байгуулсан хуулийн төслийн хэлэлцүүлэг

Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр “Албан бус салбарт ажиллагчдад зориулсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрх зүйн шинэчлэл, хэлэлцүүлэг”-ыг зохион байгуулж Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг төслийг танилцуулан, ажлын байран дахь осол, өвчлөлөөс сэргийлэх сургалтыг зохион байгуулж ажилласан. Арга хэмжээнд Улаанбаатар хотын төвийн дүүргийн хувиараа хөдөлмөр эрхлэгч 40 гаруй хүн оролцов.



“Албан бус салбарт ажиллагчдад зориулсан ХАБЭА-н эрх зүйн шинэчлэл хэлэлцүүлэг” 2025.05.23

Хуулийн төслийг танилцуулах хэлэлцүүлэх уулзалтад Налайх дүүрэгт 50, Багануур дүүрэгт 60, Баян-Өлгий аймагт 150, Төв аймагт 70 гаруй хүн оролцов.



Налайх дүүрэг 2025.09.09

Баян-Өлгий аймаг 2025.10.05



Төв аймаг 2025.12.10

Багануур дүүрэг 2025.11.10

Аймаг, дүүрэгт хийсэн хуулийн төслийг хэлэлцүүлэх уулзалт

Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтран хуулийн төслийг танилцуулах уулзалт, хэлэлцүүлгийг 2025 оны 05 дугаар сараас 2026 оны 02

дугаар сарын 03-ны өдрийн хооронд 4 удаа зохион байгуулав. 2026 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн зохион байгуулсан хэлэлцүүлэгт МҮЭХ-ийн Ерөнхийлөгч Э.Тамир, Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Одонтунгалаг, УИХ-ын гишүүн С.Эрдэнэбат нар оролцов.

2025 оны 12 дугаар сарын 22-ны өдөр МҮЭХ-ны гэрээт өмгөөлөгч нарт хуулийн төслийг танилцуулах уулзалт, хэлэлцүүлэгт ажлын хэсгээс оролцов.



Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтран зохион байгуулсан хуулийн төслийн хэлэлцүүлэг 2026.02.03

Багануур, Налайх дүүрэг, Баян-Өлгий аймаг харьяалалтай мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, хөдөлмөрийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, сэргээн засах эмчилгээний чанар, хүртээмжийг шийдвэрлэх талаар асуудлаар саналыг нь хүлээн авч хуулийн төсөлд тусган ажиллав.

Багануур дүүргийн ахмад настан, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр хөдөлмөрийн чадвар алдсан иргэн Б.Эрдэнэчимэг өндөр насны тэтгэвэрт шилжсэнээр эрүүл мэндийн хяналтын үзлэг, сэргээн засах тусламж, үйлчилгээнд хамрагдах боломжгүй болсон тул энэ асуудлыг анхаарах өргөдлийг Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд гаргасан. Энэ асуудлыг судалж, хуулийн төсөлд зохих зохицуулалтыг оруулсан.



Налайх дүүргийн харьяа мэргэжлээс шалтгаалсан өвчтэй иргэдийн төлөөлөлтэй хийсэн уулзалт 2025.09.09


Олон нийт, мэргэжлийн байгууллага, холбоод, яамдаас ирсэн саналын дагуу хуулийн төсөлд зохих засвар, шинэчлэлийг оруулж, хуулийн төслийн сүүлийн хувилбарыг олон нийтээр хэлэлцүүлэх хэлэлцүүлгийг 2026 оны 2 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулав. Хэлэлцүүлэгт яамд, аж ахуйн нэгж, байгууллага, үйлдвэрчний эвлэл, мэргэжлийн холбоодын төлөөлөл 80 гаруй хүн оролцож, саналаа илэрхийлэв.



Хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлэг 2026.02.12

Хуулийн төслийн хэлэлцүүлгийг нийт 6 удаа зохион байгуулж, төрийн болон төрийн бус 30 гаруй байгууллагаас санал авах албан бичгийг хүргүүлсэн бөгөөд, 100 гаруй иргэдээс /утсаар болон цахимаар, бичгээр/ ирүүлсэн саналыг судалж, хуулийн төсөлд тусгасан.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн эхний хувилбарт санал авахаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны (<https://mlsp.gov.mn/content/detail/3737>) цахим хуудсанд 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр байршуулан иргэд, олон нийтээс санал авсан. Холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, иргэд, олон нийтээс ирүүлсэн саналыг тусган дахин боловсруулалт хийж мөн яамны (<https://mlsp.gov.mn/content/detail/3939>) цахим хуудсанд 2026 оны 02 дугаар сарын 05-ны өдөр байршуулсан.



Мөн Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу дээрх цахим хуудсанд холбогдох судалгаа болон хуулийн төслийг байршуулан иргэд, олон нийт, сонирхлын бүлэг, мэргэжлийн холбоодын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, хуулийн төслийн хэрэгцээ шаардлагын тандан судалгаа болон хуулийн төслийг танилцуулан саналыг авч, зарим эрсдэл өндөртэй салбарын төлөөллүүдтэй ажлын хэсгийн гишүүд биечлэн уулзалт зохион байгуулан санал солилцсон.

Тухайлбал; Уул уурхай, барилга, зам тээвэр, эрчим хүчний салбар болон Нийгмийн даатгалын ерөнхий газар, Стандарт хэмжил зүйн газар, Санхүүгийн зохицуулах хороо, Арилжааны даатгалын байгууллага, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын байгууллагын төлөөллүүдтэй ажлын хэсгийн гишүүд уулзалт зохион байгуулан хуулийн төсөлд санал авч, харилцан мэдээлэл солилцсон.



Мөн 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 01/3857 тоот албан бичгээр Засгийн газрын гишүүд, төрийн захиргааны төв байгууллага болон мэргэжлийн холбоод, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим зэрэг байгууллагаас санал авсан.


Түүнчлэн хуулийг төсөл, үзэл баримтлал, танилцуулгыг англи хэл дээр орчуулан Олон улсын хөдөлмөрийн байгууллагад хүргүүлж зөвлөмж авч, хуулийн төсөлд зөвлөмжийн дагуу тусган ажилласан.

Одоо мөрдөгдөж буй Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн төслийн харьцуулалтын дүн шинжилгээг хийж, хөдөлмөр, нийгмийн түншлэгч талуудад танилцуулсан.

_____о0о_____

ЦАХИМ ХУУДСАНД БАЙРШУУЛСАН МЭДЭЭЛЭЛ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн эхний хувилбарт санал авахаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны (<https://mlsp.gov.mn/content/detail/3737>) цахим хуудсанд 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр байршуулан иргэд, олон нийтээс санал авсан. Холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, иргэд, олон нийтээс ирүүлсэн саналыг тусган дахин боловсруулалт хийж мөн яамны (<https://mlsp.gov.mn/content/detail/3939>) цахим хуудсанд 2026 оны 02 дугаар сарын 05-ны өдөр байршуулсан.



Мөн Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу дээрх цахим хуудсанд холбогдох судалгаа болон хуулийн төслийг байршуулан иргэд, олон нийт, сонирхлын бүлэг, мэргэжлийн холбоодын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, хуулийн төслийн хэрэгцээ шаардлагын тандан судалгаа болон хуулийн төслийг танилцуулан саналыг авч, зарим эрсдэл өндөртэй салбарын төлөөллүүдтэй ажлын хэсгийн гишүүд биечлэн уулзалт зохион байгуулан санал солилцсон.

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭСЭН НАЙРУУЛГЫН
ТӨСӨЛД ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГА, ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЬБЕГ**

№	Байгууллагын нэр	Ирсэн санал	Саналыг тусгасан байдал
1	Нийгмийн даатгалын ерөнхий газар 2025.12.22 01/3380	Төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус газрын холбогдох албан тушаалтнууд ажиллаж, хуулийн төсөлд тусгах саналыг хуулийн төсөлд бүрэн тусгагдсан байна.	Саналгүй.
2	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	Санал ирүүлээгүй.	
3	МУ-ын ерөнхий прокурорын газар 2026.04.15 2/1579	Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд: Хуулийн төслийн 10.15 дугаар зүйлийн 9 дэх хэсгийн "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн тухайн зөрчлийг давтан үйлдсэн бол торгуулийн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлж торгоно." гэснийг бүхэлд нь хасах	Саналыг тусгав.
4	МУ-ын дээд шүүх	Үйлдвэрлэлийн осол, аюултай тохиолдлыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссыг байгуулж ажиллуулаагүй эсхүл хуульд заасан хугацаанд акт үйлдэж, хяналтын улсын байцаагчид хүргүүлээгүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно." гэж нэмэх	Саналыг тусгав.
5	МУ-ын дээд шүүх	Тусгайлан өгөх саналгүй.	
	Санхүүгийн зохицуулах хороо	Хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.1.1-т заасан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний тогтолцооны	Саналыг тусгав.

<p>2025.12.19 01/4579</p>	<p>бүрэлдэхүүн хэсгүүдийг жагсаалт хэлбэрээр, ойлгомжтой тусгах;</p> <p>Хуулийн төслийн 37 дугаар зүйлийн 37.2-т заасан ажил олгогчийн нийтлэг үүргийн жагсаалтад "Энэ хуулийн 50 дугаар зүйлд заасан даатгалд заавал даатгуулах;" гэсэн зохицуулалт бүхий заалтыг нэмэх;</p> <p>Хуулийн төслийн 37 дугаар зүйлийн 37.3-т заасан "амь нас" гэснийг "гэнэтийн осол" гэж өөрчлөх;</p> <p>Хуулийн төслийн 47 дугаар зүйлийн 47.1.1-47.1.4-т заасан "бүртгэл" гэснийг тодорхой тусгах; Тайлбар: Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тохиолдол, аюултай тохиолдол (хаана, хэзээ, ямар хүчин зүйлийн улмаас зэрэг), эдгээртэй холбоотой гарсан хохирол, зардал зэрэг олон төрлийн мэдээллийг эдгээр бүртгэлд агуулах нь зүйтэй байна. Хэдийгээр хуулийн төслийн 47 дугаар зүйлийн 47.5-д заасан журмаар удирдлагын цахим системд төвлөрүүлэх мэдээллийн жагсаалтыг гаргахаар тодорхой болно гэж ойлгож болох ч ажил олгогч, даатгуулагч, ажилтны бүртгэл гэхээр тэдгээрийн нэрс агуулсан бүртгэл гэж ойлгогдохуйц хоёрдмол утгыг бий болгох эрсдэлтэй байна.</p> <p>Хуулийн төслийн 47 дугаар зүйлийн 47.1.5-д заасан "хяналт шалгалт" гэснийг илүү тодорхой болгох буюу удирдлагын цахим системд хяналт шалгалтын ямар арга хэмжээг оруулахыг тодруулах, эсвэл "хяналт шалгалттай холбогдох энэ хуулийн 47.5-д заасан журамд тусгагдсан мэдээлэл" гэж тусгах;</p>	<p>Хуулийн төслийн Гуравдугаар бүлэг бүхэлдээ ХАБЭМ-ийн үндэсний тогтолцоо, түүнд хамаарах талуудын талаар нарийвчлан зохицуулсан.</p> <p>Саналыг тусгав. Хуулийн төслийн 53.1-д даатгуулна гэсэн нь заавал даатгуулах агуулгыг илэрхийлнэ.</p> <p>Хуулийн төслийн 40.3 дахь хэсгийг Хөдөлмөрийн тухай хуульд 120.1-д ажил олгогч ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах зохих арга хэмжээг хэрэгжүүлэх талаар зохицуулсан тул уг нэршилтэй нийцүүлсэн.</p> <p>Саналыг тусгав. Хуулийн төслийн 47.5 дахь хэсгийг хассан. Хуулийн төслийн 50 дугаар зүйлд заасан ХАБЭМ-тэй холбоотой тоо, мэдээ бүртгэлүүд хамаарна. Цахим систем хөгжүүлэхэд бүртгэлд орох мэдээллийг Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нарийвчлан тодорхойлно.</p> <p>Саналыг тусгав. Хуулийн төслийн 50.1.5-д тусгасан.</p>
-------------------------------	--	--

<p>Саналыг тусгав.</p> <p>Хуулийн төслийн 53 дугаар зүйлд Амь нас, эрүүл мэндийн даатгалын мэдээлэл, нөхөн төлбөрийн асуудлыг тусгасан.</p>	<p>Хуулийн төсөлд дараах агуулга бүхий 47.1.6, 47.1.7 дахь заалтыг нэмэх; "47.1.6.энэ хуулийн 50 дугаар зүйлд заасан даатгалын мэдээлэл; 47.1.7. Хөдөлмөрийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.1-д заасны дагуу олгосон нөхөн төлбөрийн мэдээлэл;" Тайлбар: Ажилтны эрүүл мэндийн даатгалын мэдээллэийн буюу даатгуулсан аж ахуй нэгжүүд, даатгалын хураамж, даатгалын тохиолдол, даатгалтай холбогдуулан гарсан хохирол, даатгагчаас олгосон нөхөн төлбөрийн мэдээллэийг авах нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс үүдэлтэйгээр ажилтан, ажил олгогчид учирсан эрсдэл, нийт зардал, хохирлын талаарх бүрэн мэдээллэийн сан үүсэх, цаашид учирч болзошгүй хохирлыг таамаглахад чухал ач холбогдолтой.</p>
<p>Саналыг тусгав.</p> <p>Хуулийн төслийн 47.5 дахь хэсгийг хассан.</p>	<p>Хуулийн төслийн 47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсгийг дараах агуулгаар өөрчлөх; "47.5. Удирдлагын цахим системд ирүүлэх мэдээллэйн төрөл, тэдгээрт тавигдах шаардлага, мэдээлэл ирүүлэх байгууллагын жагсаалт, тэдгээрийн эрх, үүрэг, мэдээлэл ирүүлэх хугацаа, мэдээлэл харилцан солилцох үйл ажиллагаа, мэдээллэйн аюулгүй байдалд хяналт тавих, мэдээллэйн хадгалалт, хамгаалалт, холбогдох бусад харилцааг зохицуулсан Удирдлагын цахим системийг бүрдүүлэх, ашиглах, хяналт тавих журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална." Тайлбар: Хэд хэдэн этгээдээс олон төрлийн нарийвчилсан мэдээлэл авах шаардлагатай тул хуулийн хүрээнд мэдээлэл цуглуулах эрх, үүргээ тодорхой тусгах шаардлагатай гэж үзэв.</p>
<p>Саналыг тусгав.</p> <p>Хуулийн төслийн 53 дугаар зүйлд агуулгын хувьд тусгасан.</p>	<p>Хуулийн төслийн 50 дугаар зүйлийг дараах агуулгаар өөрчлөн найруулах: "50 дугаар зүйл. Ажилтны гэнэтийн осол, эрүүл мэндийн даатгал 50.1.Эрсдэл өндөртэй ажлын байранд ажиллаж байгаа ажилтныг гэнэтийн осол, эрүүл мэндийн даатгалд заавал даатгуулна. Ажилтны гэнэтийн осол, эрүүл мэндийн даатгалын хураамжийг ажил олгогч хариуцна.</p>

	<p>50.2. Энэ хуулийн 50.1 дэх хэсэгт заасан даатгал нь дараах эрсдэлийг хамарсан байна:</p> <p>50.2.1 даатгуулагч үйлдвэрлэлийн осолд орсон тохиолдолд ослын газраас эмнэлэг хүргэх болон эмнэлгийн яаралтай тусламж, эмчилгээний зардлын үйлдвэрлэлийн осол, мэргэжлэх шалтгаалсан өвчний болон эрүүл мэндийн даатгалын сангаас олгох жишиг зардлаас давсан хэсэг;</p> <p>50.2.2 хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээхтэй холбоотой протез, ортопед сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний зардлын үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох жишиг зардлаас давсан хэсэг,</p> <p>50.2.3. хууль тогтоомжид заасан болон гэрээгээр тохиролцсон бусад</p> <p>50.3.1. Хөдөлмөрийн тухай хуулийн 125.1-д заасны дагуу ажил олгогчоос олгох нөхөн төлбөрийн зардал,</p> <p>50.3.2. ажил олгогч, ажилтанд чиглэсэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний урьдчилан сэргийлэлт болон эрүүл мэндийн үйлчилгээний зардал.</p> <p>50.4. Ажилтны гэнэтийн осол, эрүүл мэндийн даатгалын хураамжийг удирдлагын цахим системд үндэслэн, эсхүл ажлын байранд хийсэн эрсдэлийн үнэлгээнээс хамааруулан холбогдох хууль тогтоомжийн дагуу тогтооно." гэх</p>
Саналыг тусгав.	<p>Дагаж гарах хуулийн төсөлд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд: Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дараах агуулга бүхий заалтыг нэмэх: "Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 19.1 дэх хэсгийг "Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд оролцож байгаа хуулийн этгээд олон нийт, гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлагын даатгалд заавал даатгуулна." гэсэн агуулгаар өөрчлөн найруулах;</p> <p>Тайлбар: Дээрх хуулийн 19.1-д Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд оролцож байгаа хуулийн</p>

		<p>этгээд нь Үйл ажиллагааны эрсдэл, Иргэний амь нас, эрүүл мэндийг заавал даатгуулахаар тусгасан.</p> <p>Өндөр эрсдэлтэй ажлын байранд ажиллаж буй ажилтныг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн дагуу заавал даатгах тул энэ хуульд тусгайлан зааж өгч, хуулийн давхардал үүсгэх шаардлагагүй. Мөн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд оролцож байгаа хуулийн этгээд бүр өндөр эрсдэлтэй байхгүй тул эдгээр этгээд ажилтны амь нас, эрүүл мэндийг даатгах харилцааг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиар зохицуулах нь тохиромжтой байна.</p> <p>Харин үйл ажиллагааны эрсдэл нь хуулийн этгээдийн бүхий л үйл ажиллагааг хамарсан өргөн хүрээний ойлголт тул зөвхөн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд оролцож байгаа хуулийн этгээдийн үйл ажиллагааны улмаас олон нийт, гуравдагч этгээдэд учирч болзошгүй хохирлыг нөхөн төлөх зорилгоор тэдгээрийн өмнө хүлээх хариуцлагын даатгалд заавал даатгуулахаар тусгах нь зүйтэй юм. 2024 оны 1 дүгээр сард болсон "Дүнжингарав худалдааны төв"-ийн ойролцоо болсон осол, ослын улмаас олон нийтэд учирсан хохирол, хохирлыг барагдуулах үйл явц нь энэ төрлийн даатгал зайлшгүй шаардлагатай байгааг илтгэж байгаа билээ.</p>	
6	<p>Стандарт, хэмжил зүйн газар 2025.12.22 01/1375</p>	<p>Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт "Стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллага хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн стандартыг шинээр боловсруулах, шинэчлэх, хүчингүй болгоход хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал авна." гэж заасны "...хүчингүй болгоход..." гэсэн агуулгыг хасах саналыг хүргүүлж байна.</p>	<p>Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ҮОМШӨ-өөс урьдчилан сэргийлэхэд мөрдөгдөж буй стандартыг шинэчлэх, шинээр боловсруулах, хүчингүй болгох талаар саналаа өгснөөр холбогдох ХАБЭА-н салбарын стандартуудад хууль тогтоомжийн нийцлийг хангах, хэрэгжилтийг дэмжих, хяналт тавихад чухал ач холбогдолтой.</p>
7	<p>Үндэсний статистикийн газар 2025.12.19 01/907</p>	<p>1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 7, 9, 11 дүгээр зүйлийн тайлбаруудыг 4 дүгээр зүйлд дурдсан нэр томъёоны тодорхойлолтод оруулах;</p>	<p>Хууль тогтоомжийн тухай хуульд нийүүлэн боловсруулж, энэ тайлбар нь зөвхөн тухайн зүйл, заалтад хэрэглэгддэг нэр томъёоны тайлбар юм.</p>

		<p>2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 49 дүгээр зүйлийн 49.3-д "үйлдвэрчдийн" гэснийг "үйлдвэрлэлийн" гэх;</p> <p>3. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийн "2.1.5. "хордлого" гэж Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн тайлбарт заасныг" гэснийг "2.1.5. "хордлого" гэж Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн тодорхойлолтод заасныг" гэх.</p>	<p>Саналыг тусгав.</p> <p>Хууль тогтоомжийн тухай хуульд нийүүүлэн боловсруулж, энэ тайлбар нь зөвхөн тухайн зүйл, заалтад хэрэглэгддэг нэр томъёоны тайлбар юм.</p>
8	<p>МАОЭНХ 2026.03.24 02/014</p>	<p>Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллаж тодорхой саналыг тусгасан.</p>	<p>Саналыг тусгав.</p>
9	<p>МУХАУТ 2026.03.24 02/212</p>	<p>Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллаж тодорхой саналыг тусгасан.</p>	<p>Саналыг тусгав.</p>
10	<p>Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо</p>	<p>"1.3 дугаар зүйл. Энэ хуулиар дараах этгээдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн харилцааг зохицуулна" гэх</p> <p>"1.4-д хязгаарлагдмал орчны тодорхойлолт, хэвийн бус нөхцөл, хурц хордлого нэр тодорхойлолтыг нэмэх</p> <p>"4.1.2."ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ" гэж хөдөлмөрлөх явцад хүний ажил үүргээ гүйцэтгэх чадвар, эрүүл мэндэд дагнасан буюу хамссан байдлаар нөлөөлөх ажлын байрны хими, физик, биологи, эргономик, нийгэм, сэтгэл зүйн серег хүчин зүйлийн өртөлтийг стандартын дагуу хэмжиж, зөвшөөрөгдөх хэмжээтэй харьцуулан дүгнэх үйл ажиллагааг" гэж найруулах</p>	<p>Саналыг тусгав.</p> <p>Хязгаарлагдмал орчны тодорхойлолтыг аюулгүй ажиллагааны бусад асуудлын адилаар стандарт, техникийн зохицуулалтаар тодорхойлох нь зүйтэй.</p> <p>Хуулийн төслийн 4.1.3-д хөдөлмөрийн хэвийн нөхцөлийг тодорхойлсон. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний MNS 5080 стандарт хөдөлмөрийн нөхцөлийн ангиллыг нарийвчлан тодорхойлсон. Саналыг тусгаж хуулийн төслийн 11 дүгээр зүйлд "хордлого" гэсэн тайлбарыг нэмсэн.</p>

	<p>“6.3. Салбарын яам, агентлаг ХАБЭМ-ийн техникийн зохицуулалтыг боловсруулах, шинэчлэх, хүчингүй болгоход хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас дүгнэлт гаргуулна”</p> <p>”7 дугаар бүлэг. Үйлдвэрлэлийн орчин, барилга байгууламж болон үндсэн, суурин тоног төхөөрөмж, хэрэгслийг эзэмших, ашиглахад тавих шаардлагад “”үйлчилгээний барилга байгууламж” гэж нэмэх</p> <p>”8.1.Үйлдвэрлэлийн зориулалттай, хүний эрүүл мэндэд аюул учруулж болох машин механизм, тоног төхөөрөмжийн талаар ажил олгогч, ИРГЭН, хуулийн этгээд нь дараах шаардлагыг хангасан байна” гэх</p> <p>”9.1.Өргөх байгууламжийг эзэмшигч, ашиглагч ИРГЭН, хуулийн этгээд нь өргөх байгууламжийн бүрэн бүтэн байдлыг хангаж, ослоос урьдчилан сэргийлэх үүрэгтэй.</p> <p>18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт “Ажил олгогч нь ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгслийн нэр, төрөл бүрийн жагсаалтыг баталж, “ажиллагсдын саналын дагуу” мөрдүүлнэ.</p> <p>Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг худалдан авахдаа ажиллагсдын төлөөллийг оруулна.” гэж нэмэх;</p> <p>17.1.Үйлдвэрлэл, үйлчилгээний барилга байгууламж, тоног төхөөрөмж, ажлын байрны зохион байгуулалт, багаж, хэрэгсэл, бараа материалын савлагаа, жин, хөдөлмөрлөх үеийн ажилтны биеийн байрлал, олон давтагдах үйлдэл бүхий ажил, ажлын нэг үйлдлийн үргэлжлэх хугацаа нь урт болон богино хугацаанд</p>	<p>Саналыг агуулгын хувьд тусгаж “6.3.Стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллага хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн стандартыг шинээр боловсруулах, шинэчлэх, хүчингүй болгоход хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал авна.” гэж найруулсан.</p> <p>Барилга байгууламж гэдэгт бүх төрлийн барилга хамаарна.</p> <p>Саналыг тусгав. “”...ажил олгогч, хүн, хуулийн этгээд ...”</p> <p>Саналыг тусгав. “”...ашиглагч, хүн, хуулийн этгээд ...”</p> <p>Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн шаардлагыг стандартаар тусгайлан тогтоодог. Хуулийн төслийн 35-д заасны дагуу байгууллагын ХАБЭМ-ийн зөвлөл ажилтны оролцоог хангах боломжтой.</p> <p>Хуулийн төслийн 35-д заасны дагуу байгууллагын ХАБЭМ-ийн зөвлөл ажилтны оролцоог ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн чанар, хэрэглээнд хяналт тавихад хангана.</p> <p>Саналыг тусгав.</p>
--	---	---

	<p>ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх шаардлагыг хангасан байна.</p>	
Саналыг тусгав.	<p>18.2 Ажил олгогч нь ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгслийг сонгохдоо ажлын байран дахь аюултай, хортой хүчин зүйлсийн шинж чанар, өртөлтийн түвшин, Эрсдэлийн зэрэг хөдөлмөрийн нөхцөл, бусад хамгаалах хэрэгсэлтэй хамт хэрэглэх байдлыг харгалзана.</p>	
Саналыг тусгав.	<p>18.6. Ажил олгогч эсхүл ажилтан нь ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгслийн аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн шаардлага хангаж байгаа эсэхэд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулж болно. Мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах бол ажил олгогч зардлыг хариуцна.</p>	
Саналыг тусгав.	<p>19.1 Дэх хэсэгт "ажил үүргийн хуваарилалт, ... "сайн сайхан" байдалд нөлөөлж ..." гэдгээс сайн сайхан гэдгийг хасах саналтай байна. Учир нь сайн сайхан гэдэг нь ойлгомжгүй, хийсвэр бөгөөд хууль нь тодорхой, шууд үгийн утгаар ойлгогдог зарчимтай тул хасах;</p>	
Саналыг тусгаж 20 дугаар зүйлийг дахин найруулав. Хор саармагжуулах хор судлаач эмчийн хийдэг эмчилгээ тул нэршлийг зөв болгож хүнсний "шим тэжээллэг хүнсний бүтээгдэхүүн" тусгав.	<p>Шинэ 20.6 Химийн хорт болон аюултай бодистой орчинд эсхүл харьцан ажилладаг ажлын байранд ажиллагсдад хор саармагжуулах сүү, тусгайлан төхөөрөмжилсөн хувцас солих өрөө, түр амрах байраар хангах</p>	
Хуулийн төслийн 11 дугаар зүйлд "хордлого" гэдэгт химийн хорт болон цацраг идэвхт бодисын нөлөөгөөр цочмог хэлбэрээр богино хугацаанд хордохыг ойлгоно гэж тайлбарласан. Мөн 11.4.Химийн хорт болон аюултай бодис, цацраг идэвхт бодисын хэрэглээтэй холбоотой осол, хордлого гарсан тохиолдолд үйлдвэрлэлийн ослын нэгэн адил судлан бүртгэнэ.	<p>Хуулийн төслийн 22.1.7, 23.1.1, 23.1.2, 24.4.2, 25.2.4, 26.1.2, 26.1.8, 27.1.1, 28.2.6, 45.1, 48.1-дэх заалтуудад тус тус хурц хордлого гэж нэмэх</p>	
Хуулийн төслийн 24.1.7-д Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх, 26.4.Үндэсний хороо	<p>22.1.7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний хорооны саналыг үндэслэн үйлдвэрлэлийн осол, хурц хордлого,</p>	

	<p>мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөж, санхүүжилтийг шийдвэрлүүлэх;</p>	<p>нь дараах бүрэн эрхийг ХАБЭМ-ийн асуудлаар төрийн бодлого боловсруулах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлаар санал, зөвлөмж гаргах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, үр дүнтэй танилцах, олон улсын хөдөлмөрийн байгууллагын холбогдох конвенцод нэгдэн орох асуудлаар санал, зөвлөмж боловсруулах, нийгмийн түншлэлийн талуудын түвшинд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлаар төр, ажил олгогч, ажилтны төлөөллийн хооронд харилцан ойлголцол, хамтын ажиллагааг дэмжих, мэргэжил арга зүйгээр хангах гэж зохицуулсан.</p>
<p>24.2. Үндэсний хорооны дүрэм, бүрэлдэхүүнийг талуудын саналыг үндэслэн Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны дарга, салбар хорооны дүрмийг Үндэсний хорооны дарга тус тус батална.</p>	<p>24.4.5 ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг баталгаажуулах гэж шинээр нэмэх</p>	<p>Саналыг тусгав.</p>
		<p>Хуулийн төслийн 30.1.3-д ХАБЭМ-ийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний мэргэжлийн байгууллагын чиг үүрэгт "ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг хэмжих, үнэлэх, химийн бодисын хордлогын шалтгааныг судлан тогтоох, дүгнэлт, зөвлөмж гаргах" гэж тусгасан. Хуулийн төслийн дагуу ХАБЭМ-ийн үндэсний хороо 26.4.2. үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, үр дүнтэй танилцах; 26.4.4. нийгмийн түншлэлийн талуудын түвшинд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлаар төр, ажил олгогч, ажилтны төлөөллийн хооронд харилцан ойлголцол,</p>

		<p>хамтын ажиллагааг дэмжих, мэргэжил арга зүйгээр хангах, бусад чиг үүрэгтэй</p> <p>Хуулийн төслийн 29.1-д аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг харьяа засаг захиргааны нэгжид хангуулах чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гэж зохицуулсан. Сумын засаг дарга сум болон багийн ХАБЭМ-ийн чиглэлээр үүрэг хүлээнэ.</p> <p>Саналыг тусгав.</p> <p>Саналыг тусгаж хуулийн төслийн 34.1-д Ажлын байрны аюултай хүчин зүйлээс ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, ажил, хөдөлмөртэй холбоотой осол, бэртэл, гэмтэл, өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг хангах, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч шууд хариуцна гэж найруулав.</p> <p>Хуулийн төслийн хэлэлцүүлэг, мэргэжлийн байгууллага олон нийтээс ирсэн саналд үндэслэн тухай заалтыг хасаж, 4.1.19-д “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн ажилтан” гэж аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хууль тогтоомж, шаардлагын дагуу зохион байгуулах мэдлэг, чадамж бүхий хүнийг” гэж найруулан тусгасан.</p>
<p>27 дугаар зүйл. Бүх шатны засаг даргын бүрэн эрх, үүрэг /багийн засаг дарга орох шаардлагатай тул бүх шатны гэж өөрчлөх/</p>	<p>31.2.2.11-50 хүртэл ажилтантай үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлыг аль нэг ажилтнаар хавсран гүйцэтгүүлэх, эсхүл орон тооны ажилтан ажиллуулах эсхүл гэрээгээр гүйцэтгүүлэх;</p> <p>31.1.Ажлын байрны аюултай хүчин зүйлээс ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, ажил, хөдөлмөртэй холбоотой осол, бэртэл, гэмтэл, өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг хангах, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээд, ажил олгогч шууд хариуцна.</p>	
<p>31.4.Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан ажилтан нь тухайн чиглэлээр их, дээд сургууль төгссөн эсхүл мэргэжлийн холбоогоор ЦОГЦ ЧАДАМЖАА-ыг тодорхой заах баталгаажуулсан байна.</p>	<p>31.4.Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан ажилтан нь тухайн чиглэлээр их, дээд сургууль төгссөн эсхүл мэргэжлийн холбоогоор ЦОГЦ ЧАДАМЖАА-ыг тодорхой заах баталгаажуулсан байна.</p>	

	<p>31.5.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан ажилтны цогц чадамж, мэргэшлийн түвшнийг үнэлэх, баталгаажуулах, мэргэшлийн зэрэг олгох нийтлэг журмыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний хорооны саналыг үндэслэн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална</p> <p>32 дугаар зүйл. шинэ заалт: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг хөдөлмөрийн хуульд заасан хэмжээгээр цалин түүнтэй адилтгах орлогоор урамшуулах журмыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний хорооны саналыг үндэслэн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>35.1. Төсвийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага эрсдэлийн түвшнээс хамааран жил тутамд үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг дараах арга хэмжээнд зарцуулна:</p>	<p>23.Хууль дагалдан гарах дүрэм, журмыг цөөлөх хүрээнд уг заалтыг хассан.</p> <p>Саналыг зарчмын хувьд тусгаж, хуулийн төслийн 35.3-д Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнд ажил олгогч болон ажилтнаас сонгогдсон төлөөлөл ажиллана. Орон тооны бус зөвлөлийн гишүүдэд урамшуулал олгож болно” гэж найруулсан.</p> <p>Хуулийн төслийн 38.1-д Аж ахуйн нэгж, байгууллага эрсдэлийн түвшнээс хамааран үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг хангуулах... гэж найруулсан.</p> <p>Саналыг зарчмын хувьд тусгаж, хуулийн төслийн 40.2.7-д ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөл болон ажилтны хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэгт үндэслэн хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалтыг зохион байгуулах гэж найруулсан.</p> <p>Хуулийн төслийн 43.1-д саналыг зарчмын хувьд тусгав. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу стандарт нь сонгон хэрэглэх, техникийн зохицуулалт нь заавал мөрдөх зохицуулалттай.</p> <p>Саналыг тусгаж, хуулийн төслийн 53 дугаар зүйлээр ажилтны амь нас, эрүүл мэндийн даатгалын асуудлыг зохицуулсан</p>
	<p>35.1.6.хөдөлмөрийн эрүүл мэндийн нарийвчилсан үзлэг, тандалт;</p>	
	<p>40.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн техникийн зохицуулалт, стандарт нь ажлын байранд ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд заавал мөрдөх шаардлагыг тогтооно.</p>	
	<p>Ажилтан даатгуулах эрхтэй боловч даатгалаас нөхөн төлбөр авах эрхийг олгоогүй тул 36 дугаар зүйлийн 36.1.2 дахь хэсэгт "гэтгэмж авах" гэж нэмэх;</p>	

	<p>37.4 Өндөр болон ноцтой эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа ажилтныг амь нас, эрүүл мэндийн даатгалд тухайн ажилтны 36 ба түүнээс дээш сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээгээр заавал даатгуулна. Ажилтны амь нас, эрүүл мэндийн даатгалын хураамжийг ажил олгогч хариуцна.</p> <p>46.5.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн сургалт зохион байгуулах журмыг ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ САНАЛЫГ ҮНДЭСЛЭН хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн сурагч, хүүхдэд осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх мэдлэг, дадал олгох сургалтыг ХАБ-ын мэргэжлийн инженер, ахлах болон мэргэжлийн холбоо, сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулна.</p> <p>48.2.Аймаг, нийслэл, дүүргийн түвшинд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн арга хэмжээнд шаардагдах төсвийг ХУУЛЬД ЗААСАН ХЭМЖЭЭГЭЭР тухайн засаг захиргааны нэгжийн Засаг дарга Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулан, зарцуулна.</p> <p>Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа түр болон алдсан даатгуулагчид Хөдөлмөрийн тухай хуулийн 125 дугаар зүйлд заасан нэг удаагийн тэтгэмжийг энэхүү заалтын дагуу олгохгүй байх хуулийн зөрчил бий болж байгаа тул 49 дүгээр зүйлийн 49.5 дахь хэсэг "Үйлдвэрлэлийн осол,... хөдөлмөрийн чадвараа түр болон алдсан даатгуулагчид..." гэж нэмэх</p> <p>55.1.4. ажлын байр, үйлдвэрлэлийн орчинд ажилтан болон хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулах нөхцөл үүссэн тохиолдолд тухайн ажил, үйлчилгээ, үйл ажиллагааг түр зогсоох, аюулгүй байдлыг хангуулах;55 дугаар зүйл. ҮО- болон шалгалт хийх үед Улсын байцаагч тухайн байгууллагын ХАБЭА-</p>	<p>Саналыг тусгаж, хуулийн төслийн 53.1-д Эрсдэл өндөртэй ажлын байранд ажиллаж байгаа ажилтныг амь нас, эрүүл мэндийн даатгалд даатгуулна. Амь нас, эрүүл мэндийн нэмэлт даатгалын хураамжийг ажил олгогч хариуцна гэж найруулсан.</p> <p>Хууль дагалдан гарах дүрэм, журмыг цөөлөх хүрээнд уг заалтыг хассан.</p> <p>Саналыг зарчмын хувьд тусгаж хуулийн төслийн 49.3, 49.4 -д шинэ зохицуулалт нэмсэн.</p> <p>Саналыг тусгаж, хуулийн төслийн 28 дугаар зүйлээр зохицуулсан</p> <p>Саналыг зарчмын хувьд тусгаж, хуулийн төслийн 52, 53 дугаар зүйлээр даатгалтай холбоотой харилцааг зохицуулсан.</p> <p>Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар тусгайлан зохицуулсан.</p>
--	--	--

	<p>н хуулийн нийцэлд мэргэшсэн байгууллагаар үнэлгээ хийлгэж шийдвэр гаргадаг байх</p> <p>57.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн АЖИЛТНЫ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХЯНАЛТ гэж найруулах</p> <p>36. 57.1.6.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар болон хөдөлмөрийн нөхцөлийг дордуулсан, ажилтны эрүүл мэнд, амь насыг хамгаалах үүргээ биелүүлэхгүй байгаа албан тушаалтанд ШААРДЛАГА ТАВИХ, хариуцлага хүлээлгэх, хамтарсан хяналт шалгалт хийх саналаа холбогдох байгууллагад тавих.</p>	<p>Саналыг зарчмын хувьд тусгаж, хуулийн төслийн 61 дүгээр бүлгийг Ажилтны төлөөллийн байгууллагын хяналт гэж найруулсан.</p> <p>Саналыг зарчмын хувьд тусгаж, хуулийн төслийн 61.1.6-д "хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар болон хөдөлмөрийн нөхцөлийг дордуулсан, ажилтны эрүүл мэнд, амь насыг хамгаалах үүргээ биелүүлэхгүй байгаа албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, хамтарсан хяналт шалгалт хийх саналаа холбогдох байгууллагад тавих." гэж найруулсан.</p>
<p>11 ЭМ ЖИ ЭЛ үнэт цаасны холбоо</p>	<p>1. 39.1.Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэлт нь төрийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагаанаас гадна ажилчдын төлөөлөх холбоо, эвсэл зэргийг хамруулах саналтай байна.</p> <p>2. 39.1 дэх заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах "... Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэлт нь ажил, мэндийг хамгаалахад чиглэж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төрийн захиргааны хяналттай нэгдмэл, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллага, мэргэжлийн холбоотой харилцан уялдаатайгаар салбар дундын хамтын ажиллагаа, идэвхтэй оролцоонд суурилан хэрэгжинэ."</p> <p>3. 36.1.4.Ажилтан ажил, үүргээ биелүүлэх явцад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хэм хэмжээ зөрчигдөөд амь нас, эрүүл мэндэд нь аюултай нөхцөл бий болоод ажил үүргээ гүйцэтгэхээ больсон тохиолдолд тухайн ажилтны эдлэх халамж, хууль ёсны эрх ашиг хөндөгдөхгүй байх саналтай байна.</p>	<p>Саналыг тусгаж, хуулийн төслийн 3, 4 дүгээр бүлгийг шинээр найруулав.</p> <p>2.Хуулийн төслийн 42.1 уг саналтай зарчмын хувьд нийцсэн.</p> <p>Хуулийн төслийн 39.1.4--д ажилтан "ажил, үүргээ биелүүлэх явцад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хэм хэмжээ зөрчигдсэн болон амь нас, эрүүл мэндэд нь аюултай нөхцөл бий болсон тохиолдолд</p>

		<p>ажлаа зогсоож, энэ талаар ажил олгогчид мэдэгдэх" эрхтэй гэж зохицуулсан.</p> <p>Хуулийн төслийн 54.3-д "Ажил олгогч нь өөрийн зардлаар үйлдвэрлэлийн осолд өртсөн хүн, ажилтанд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх, ослын газраас эмнэлэгт хүргэх, эмчилгээ, үзлэг, шинжилгээг хийлгэх арга хэмжээг нэн даруй авна..." гэж зохицуулсан.</p>	<p>ажлаа зогсоож, энэ талаар ажил олгогчид мэдэгдэх" эрхтэй гэж зохицуулсан.</p> <p>Хуулийн төслийн 54.3-д "Ажил олгогч нь өөрийн зардлаар үйлдвэрлэлийн осолд өртсөн хүн, ажилтанд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх, ослын газраас эмнэлэгт хүргэх, эмчилгээ, үзлэг, шинжилгээг хийлгэх арга хэмжээг нэн даруй авна..." гэж зохицуулсан.</p>
12	Эм си эс ХХК	<p>4.37.2-д нэмэлтээр .ажил олгогч нь тухайн ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндэд учирч болох эрсдэлийг урьдаас мэдэж буй учир ажил олгогчид шаардлагатай тохиолдолд арга хэмжээ авч, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх тухай үүрэг хүлээлгэх саналтай байна.</p> <p>1. Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд заасан "ажлын байрны хөдөлмөрийн хэвийн нөхцөл", "ажил, хөдөлмөртэй холбоотой бэртэл гэмтэл, өвчин", "аюултай осолд дөхсөн тохиолдол", "аюултай осолд дөхсөн тохиолдол", "ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгсэл", "үйлдвэрийн осол" нэр томъёог найруулах</p> <p>2. "Хязгаарлагдмал орчин" гэж хүн нэвтэрч ажил гүйцэтгэх хангалттай хэмжээтэй боловч орж гарах гарц хялбар биш, жижиг давчуу хязгаарлагдмал, байнгын ажиллах зориулалтгүй, хүчилтөрөгч дутагдах, хорт хий хуримтлагдах эрсдэлтэй орчныг;</p> <p>3. 7.3. Үйлдвэрлэлийн барилга байгууламжийн зураг төсөл нь тухайн барилга байгууламжийн ашиглалтын явцад ажилтны аюулгүй байдал, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх шаардлагыг хангана.</p> <p>4. 4 зүйлд заасан "Үйлдвэрлэлийн орчин" гэж ажилтныг, ойр орчмын оршин суугч, зорчин явагч хүнийг осол, гэмтэл, бэртлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зайлшгүй шаардлагатай үйлдвэр, үйлчилгээний талбай, гадна орчныг ойлгоно гэж нэмэх</p> <p>5. 8.1.2. машин механизм, тоног төхөөрөмжийг ажиллуулах, засвар үйлчилгээ хийх үед мөрдөх ашиглалт, аюулгүй ажиллагааны заавар, техникийн паспорттай байх, техникийн паспорт цахим хэлбэрээр байж болно.</p>	<p>Зарчмын хувьд саналыг хүлээн авч, нэр томъёоны тодорхойлолтыг найруулгыг хянасан.</p> <p>Хязгаарлагдмал орчны тодорхойлолтыг аюулгүй ажиллагааны бусад асуудлын адилаар стандарт, техникийн зохицуулалтаар тодорхойлох нь зүйтэй.</p> <p>Саналыг тусгав.</p> <p>Хуулийн төслийн 7 дугаар зүйлд "Үйлдвэрлэлийн орчин" гэсэн тайлбарыг нэмсэн.</p> <p>Хуулиар нийтлэг шаардлагыг тогтоосон, тусгайлан "техникийн паспорт цахим" гэж заах шаардлагагүй.</p>

	<p>6. Өргөх байгууламжийг эзэмшигч, ашиглагч хүн, хуулийн этгээд нь “Ачаа өргөх краныг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-г үйл ажиллагаандаа дагаж мөрдөх үүрэгтэй.”</p> <p>7. 9 зүйлд заасан “Өргөх байгууламж” гэдэгт босоо болон хэвтээ чиглэлд хүн, ачаа өргөх, тээвэрлэх зориулалт бүхий суурин болон хөдөлгөөнт тоног төхөөрөмжийг ойлгоно гэ</p> <p>8. “Хүнд даацын автомашины тэвш, вагонд чингэлэг ачиж буулгах хөдөлгөөнт дугуйт ачигч, буулгагч” гэсэн шаардлагатай гэж үзвэл нэмэлтээр оруулах</p> <p>9. цацраг идэвхт бодистой харьцах шаардлагыг нэмж оруулах</p> <p>10. 11.1.4 заалтаас “тухайн ажилтны өртөлтийг үнэлсэн хэмжилтийн дүн, хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг, тандалт болон урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн тайланг жил бүр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн цахим удирдлагын системд жил бүр илгээх” гэдгийг хасах</p> <p>11. 11.2. Ажил олгогч нь стандартаар тогтоосон зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн химийн хорт ба аюултай бодисын өртөлт бүхий ажлын байранд ажилтныг ажиллуулахыг хориглоно.</p> <p>12. 13 дугаар зүйлд хязгаарлагдмал орчинд тавих шаардлагаар хэт товч байгаа үүнийг зохицуулах холбогдох дүрэм, журам байхгүй тул дэлгэрүүлж зохицуулах Зохицуулалтын агуулгыг дэлгэрүүлж тусгах</p> <p>13. 13.2-д Хязгаарлагдмал орчинд ажил, үйлчилгээ явуулах үед ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэлийг үнэлж, арилгах эсхүл хяналтад авах арга хэмжээг ажил олгогч хэрэгжүүлнэ. Ажил олгогч нь дотооддоо хязгаарлагдмал орчинд ажиллах журмыг баталж хэрэгжүүлэн ажиллана.</p> <p>14. 14.1.4 заалтаас үйлдвэрлэлийн ослын тохиолдолд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, мөрдөх гэснээс төлөвлөгөөг хасаж, журам гэж нэмэх</p>	<p>Салбарын зохицуулалтаар зохицуулагдах. Энэ хуулийн төсөл нийтлэг шаардлагыг тогтоосон.</p> <p>Хуулийн төслийн 9 дүгээр зүйлд нэмсэн тайлбартай нийцсэн.</p> <p>Салбарын дүрэм, журам, стандартаар зохицуулагдах асуудал. Энэ хуулийн төсөл нийтлэг шаардлагыг тогтоосон.</p> <p>Саналыг хуулийн төслийн 11 дүгээр зүйлд тусгав.</p> <p>Энэ хуулиар тогтоосон ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, эрсдэлийг үнэлэх, эрүүл мэндийн үзлэгт хамруулах, цахим системээр дамжуулан тайлагнах ажил олгогчийн үүргийг химийн бодис дээр тусгайлан зохицуулсан тул зайлшгүй байх шаардлагатай</p> <p>Саналыг тусгав.</p> <p>Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагааны шаардлагыг техникийн зохицуулалтаар тусгайлан зохицуулна.</p> <p>Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагааны техникийн зохицуулалтаар тусгайлан зохицуулсан.</p> <p>Осол дахин гарахаас сэргийлэхийн тулд урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулан мөрдөх шаардлага тавигдана.</p>
--	--	--

	<p>15. 23.1.4. Хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэгийг аймаг, дүүргийн эрх бүхий байгууллагын гаргасан шаардлагыг хангасан чадамж бүхий эрүүл мэндийн байгууллага зохион байгуулах, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг илрүүлэх</p> <p>16. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллага нь ямар байгууллага байх, хаанаас байгуулагдах, эрх зүйн статус нь юу байхыг тодорхойлох, чиг үүрэг нь энэхүү хууль болон бусад хууль тогтоомжоор заасан бусад байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаатай давхацсан байгааг харьцуулан хянаж, өөрчлөлт оруулах, давхцалыг арилгах.</p> <p>17. Эрсдэлийн өндөр, дунд, бага гэсэн гурван төрлийн түвшнээс хамааран үйл ажиллагааны зарцуулалтыг ялгаатай болгох</p> <p>18. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжилтэн нь ямар эрх бүхий субъект байх, хаанаас томилогдох, эрх авах, хаана хэнд харьяалагдахыг тодорхой тусгах.</p> <p>19. 30.1.4. Мэргэшлийн зэргээ баталгаажуулах, Мэргэжилтэн нь мэргэшлийн зэргийн нэмэгдэл авч болно гэж нэмэх</p> <p>20. Хуулийн бүтэц, зохион байгуулалтын хувьд бүлэг, дэд бүлэг, хэсэг, дэд хэсэг гэх зэрэг нэгжүүд нь шаталсан зохион байгуулалттай, логик дараалалтай байх нь хууль тогтоомжийн хэрэглээ, ойлгомжтой байдал, хэрэгжилтэд чухал ач холбогдолтой. Тухайлбал, хэрэв хуулийн агуулгад “Нэгдүгээр дэд бүлэг” гэж дугаарласан бол энэхүү дэд бүлэг нь “Нэгдүгээр бүлгийн” бүрэлдэхүүнд багтах.</p> <p>21. 31.2.1. 10 хүртэл ажилтантай, эрсдэлийн түвшин бага гэж үнэлэгдсэн аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлыг захирал, ажил олгогч өөрөө хариуцах эсхүл аль нэг ажилтнаар хавсран эсхүл гэрээгээр гүйцэтгүүлэх;</p>	<p>Хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэгийг хувийн болон төрийн бүх байгууллага хийнэ. Эрх бүхий эрүүл мэндийн байгууллага гэдгийг тогтоох, бүртгэх нь нэмэлт зөвшөөрлийн процессыг бий болгох тул саналыг тусгах боломжгүй.</p> <p>Гуравдугаар бүлгээр тодорхой зохицуулсан.</p> <p>ХАБЭМ-ийн эрсдэлийн үнэлгээ нь батлагдсан стандарт, аргачлалын дагуу хийгдэж, эрсдэлийн түвшнийг тогтоох тул хуульд оруулах шаардлагагүй</p> <p>Хуулийн төслийн 4.1.18-д ХАБЭМ-ийн мэргэжилтний тодорхойлолтыг тусгасан.</p> <p>Хуулийн төслийн 33.1.4-д саналыг тусгав.</p> <p>Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулсан</p> <p>Эрсдэлийн түвшин болон ажилтны тоо хамааралгүй тул уг саналыг тусгах боломжгүй</p>
--	--	---

	<p>22. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжилтэн нь ямар эрх бүхий субъект байх, хаанаас томилогдох, эрх авах, хаана хэнд харьяалагдахыг тодорхой тусгах.</p> <p>23. 31.2.3. 51-200 хүртэл ажилтантай үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь орон тооны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн ажилтантай байх бөгөөд өндөр эрсдэлтэй салбарт ажиллаж буй тохиолдолд хөдөлмөрийн эрүүл ахуйч эсвэл хөдөлмөрийн эрүүл мэндийн эмчийг орон тоогоор эсхүл гэрээгээр ажиллуулж болно;</p> <p>24. 31.4-ийг " Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан ажилтан нь тухайн чиглэлээр, эсхүл бусад чиглэлээр их, дээд сургууль төгссөн бөгөөд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн чиглэлээр сургалтад хамрагдсан, эсхүл мэргэжлийн холбоогоор цогц чадамжаа баталгаажуулсан байна. "</p> <p>25. нэгжийн удирдлага нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын хэрэгцээг тодорхойлж, зохион байгуулах, өдөр тутмын зааварчилгаа өгөх чиг үүргийг хэрэгжүүлэх талаар заалт нэмэх</p> <p>26. 33.1.8-ийг " ажлын байран дахь аюултай хүчин зүйл, ажлын орчны нөхцөл, онцлогт тохирсон Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний зөвлөмжийн дагуу ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгслийг сонгож түүний нэр, төрөл бүхий жагсаалт боловсруулж, ажил олгогчоор батлуулах, түүний чанар, зохистой хэрэглээнд хяналт тавих" гэж найруулах</p> <p>27. 36.2.5. Ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу зохистой хэрэглэх. Хэрэв зориулалтын дагуу зүй зохистой хэрэглээгүй, өөрийн буруутай үйлдлээс шалтгаалж ашиглах боломжгүй, эсхүл алга болгосон тохиолдолд ажил</p>	<p>Хуулийн төслийн 30.1.13-д ХАБЭМ-ийн төрийн үйлчилгээний байгууллага "хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжилтний цогц чадамж, мэргэшлийн түвшнийг үнэлж, зөвшөөрүүлэх, мэргэшлийн зэрэг олгох шалгуур үзүүлэлтийг тогтоох" гэж заасан</p> <p>Эрсдэлийн үнэлгээ хийхгүйгээр аж ахуйн нэгж байгууллагыг салбараас хамааруулан ХАБЭМ-ийн бүтэц, ажилтны асуудлыг механикаар шууд зохицуулах учир дутагдалтай. Энэ заалт нь үйл ажиллагааны чиглэл, ажилтны тоо, эрсдэлээс хамаарсан илүү уяан хатан заалт</p> <p>Хуулийн төсөл боловсруулах явцад талуудын саналыг үндэслэн энэ заалтыг хасаж, 4.1.18. 4.1.19-д ХАБЭМ-ийн мэргэжилтэн, ажилтан гэсэн тодорхойлолтыг нэмсэн</p> <p>Хуулийн төсөлд 37 дугаар зүйлийн заалттай агуулгын хувьд нийцсэн</p> <p>Ажлын тусгай хувцас хамгаалах хэрэгсэл нь аюулгүй байдал, эрүүл мэндийн аюул аль алианаас нь хамгаалахад чиглэсэн тул тусгайлан хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ гэж заах боломжгүй</p> <p>Хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулах боломжтой тул хуульд энэ саналыг тусгах шаардлагагүй</p>
--	--	---

	<p>олгогчтой байгуулсан эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээний дагуу хариуцлага хүлээнэ.</p> <p>28. 38.2-д заасан хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн асуудлыг хасах</p> <p>29. 41.3, 42.7, 43.3, 42.2-д заасан ХАБЭМ-ийн удирдлагын цахим систем тайлан, мэдээ оруулах заалтыг хасах</p> <p>30. "Ажил олгогч нь ажлын байр шинээр бий болгох болон тухайн ажлын байрны үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, нөхцөл өөрчлөгдөх бүрд, химийн хорт болон аюултай бодис агуулсан түүхий эд, материал ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа бол жилд нэгээс доошгүй удаа ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгэнэ" гэж нэмэх</p> <p>31. 44.1.-ийг "Ажил олгогч нь хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилт эсхүл ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний дүнд үндэслэн ажилтнуудаа хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэгт хамруулна" гэж найруулах</p> <p>32. 46.5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэснийг хасах</p> <p>33. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас гаргах зардалтай холбоотой асуудлыг Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлтөөр оруулах.</p> <p>34. 49.7, 50.1, 51.2, 54.5-д заасан амь нас эрүүл мэндийн даатгалд даатгуулах, аюултай тохиолдлыг бүртгэн мэдээлэх, мэргэжлээс шалтгаалах өвчнийг бүртгэх, мэдээлэх, ХАБЭМ-ийн төрийн хяналт шалгалтыг урьдчилан мэдэгдэхгүйгээр хийх зохицуулалтуудыг хасах</p>	<p>Хуулийн зорилго нь ажил хөдөлмөр эрхэлдэг бүх хүний эрүүл мэнд, аюулгүй байдлыг ажлын байрны эрсдэлээс хамгаалахад чиглэдэг, МУ олон улсын гэрээ конвенцын дагуу хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн ХАБЭМ-ийн асуудлыг зохицуулах үүрэгтэй тул саналыг хүлээн авах боломжгүй.</p> <p>Хууль эрх зүйн шинэчлэлийн хүрээнд ХАБЭМ-ийн цахим систем зайлшгүй шаардлагатай.</p> <p>Жил бүр хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэн гэснийг жилд 1-ээс доошгүй хийнэ гэж найруулах нь бодит амьдралд хэрэгждэггүй, ажил олгогчид зардлын дарамт үүсгэх заалт болно.</p> <p>Энэ нь агуулгын хувьд төслийн 47.2-д тусгагдсан. Жагсаалт гаргаснаар ЭМ-ийн үзлэг оруулах шаардлагагүй ажилтнуудад үзлэг хийж шаардлагагүй ачаалал, зардлыг бууруулах ажил олгогч заалт.</p> <p>Энэ заалт хасагдсан.</p> <p>Дагаж нэмэлт өөрчлөлт орох хуулиар зохицуулсан.</p> <p>Ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах, одоогийн хуулийн зохицуулалтаас дордуулах эрсдэлтэй тул саналыг хүлээн авах боломжгүй.</p>
--	--	---

13	<p>“Номин констракшн” ХХК-ний хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтсийн дарга Н.Очирбат</p>	<p>1. 12.1. Энэ хуулийн 3.1-д заасан этгээд нь галын аюулгүй байдлын тухай хууль, тогтоомж, дүрэм, журам, стандартыг хангаж ажиллах үүрэг хүлээнэ.</p> <p>2. 14.1.Ажилтан, хувиараа хөдөлмөр эрхлэгч нь гадаргуунуудын түвшний зөрүүтэй ба өндөрт гарч хийх аливаа ажлыг гүйцэтгэхэд ажил олгогч нь дараах шаардлагыг хангана:</p> <p>3. 28.1-“... хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн сургалтын байгууллага,” гэж найруулах</p> <p>4. 29.1.3.тухайн чиглэлийн мэргэжилтэнд тавигдах мэргэжлийн цогц чадамж, мэргэшлийн зэргийг үнэлэх, баталгаажуулах;</p> <p>5. “34.1.5. Өөрийн харьяалах нэгжийн нийт ажилтанд өгөх аюулгүй ажиллагааны сургалт болон зааварчилгааны хэрэгцээг тодорхойлж, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, өдөр тутмын аюулгүй ажиллагааны зааварчилгаа, ажлын байрны анхан шатны зааварчилгаа, ээлжит бус давтан зааварчилгааг өгч, технологийн аюулгүй ажиллагааны сургалтуудыг зохион байгуулах, мэдлэгийг үнэлэх, давтан сургаж мэдлэгийг бататгах ажлыг зохион байгуулна.” гэсэн заалтыг нэмж оруулъя.</p> <p>6. 35.1.7.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, зааварчилгаа, сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, орчныг бүрдүүлэх.</p> <p>7. 36.2.9. Гүйцэтгэх ажил болон ажлын байранд үүсдэг бодит ба үүсэж болзошгүй аюулуудыг илрүүлэх, эрсдэлийг үнэлж, болзошгүй хохирлоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг үнэлэх ажилд заавал оролцох.</p> <p>8. 37.2.4.ажлын байранд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийг үнэлэх, бууруулах, арилгах үйл ажиллагаанд шат шатны албан удирдах албан тушаалтан, ажилтны төлөөллийг томилж ажиллуулах</p> <p>9. 37.2.5.эрсдэлтэй ажлын байранд аюулыг анхааруулах, хориглох, сануулах, заах тэмдэг, үзүүлэн санамж, аюулыг</p>
Саналыг тусгав.		Саналыг тусгав.
Саналыг тусгав.		Саналыг тусгав.
Сургалтын байгууллагаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлууд заагдах тул энэ нэршил нь илүү оновчтой.		Сургалтын байгууллагаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлууд заагдах тул энэ нэршил нь илүү оновчтой.
Хуулийн төслийн 32.1.3-д тухайн чиглэлийн мэргэжилтэнд тавигдах мэргэжлийн цогц чадамж, мэргэшлийн зэргийг үнэлэх, хүлээн зөвшөөрөх гэж найруулан тусгав.		Хуулийн төслийн 37.1.5 -д өөрийн харьяалах нэгжийн нийт ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын хэрэгцээг тодорхойлох, сургалт зохион байгуулах, мэдлэг, дадлыг үнэлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа өгөх саналыг тусгав.
Саналыг тусгав.		Саналыг тусгав.
Саналыг тусгав.		Саналыг тусгав.
Саналыг тусгав.		Саналыг тусгав.
Саналыг тусгав.		Саналыг тусгав.

14	Монголын барилгачдын нэгдсэн холбоо	<p>тусгаарлах хаалт, хашилт, дохиоллын системийг байрлуулж, тэмдэглэгээ хийх;</p> <p>10. 37.2.9. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн сургалтад хамрагдаж, шалгалт өгч, аюулгүй ажиллахад шаардлагатай мэдлэг, дадлыг эзэмшсэн эсэхээ нотолсон, зааварчилгаа авсан, эрүүл мэндийн үзлэгээр тэнцсэн ажилтнаар ажил үүрэг гүйцэтгүүлэх;</p> <p>11. 45.3.Ажлын байран дахь аюулыг арилгаж ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор аюулыг устгах, нөлөөллийг бууруулах, инженерийн, захиргааны, соён гэгээрүүлэх, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл олгох зэрэг хяналтын бүхий л шатны арга хэмжээнээс оновчтойг нь сонгож эсвэл хослуулан хэрэгжүүлнэ.</p> <p>46.3.Бүх их, дээд, мэргэжлийн боловсролын сургууль нь оюутан, суралцагчид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдлэг, дадал олгосон байна.</p>	<p>Саналыг тусгав.</p> <p>ХАБЭМ-ийн эрсдэлийн удирдлагыг дэс дараатай хэрэгжүүлэх 48 дугаар зүйлд тусгасан нь энэ саналтай агуулгын хувьд нийцэж байна.</p> <p>Хуулийн төслийн 49.3-д тусгав.</p>
	<p>6.1.Хөдөлмөрлөх явцад хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, ажил, хөдөлмөртэй холбоотой бэртэл гэмтэл, өвчнөөс урьдчилан сэргийлэхэд мөрдөгдөх шаардлага, хэм хэмжээг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомж, Олон улсад нийтлэг хэрэглэгдэж буй техникийн зохицуулалт, стандартаар тогтооно. Эдийн засаг, техникийн хувьд Монгол Улсад хэрэгжих боломжгүй стандарт, шаардлагыг тогтоохыг хориглоно.</p> <p>6.3.Стандартын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн стандартыг шинээр боловсруулах, шинэчлэх, хүчингүй болгоход хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас дүгнэлт гаргуулна. Тус дүгнэлт гаргахад мэргэжлийн ажилтан, олон нийтээс санал асуулга авсан, туршсан, судалгаа, шинжилгээнээс гарсан үр дүнд суурилсан эсэхийг харгалзан үзнэ.</p>	<p>Хуулийн төсөлд агуулгын хувьд туссан. Стандартын талаарх нийтлэг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний тухай хуулиар зохицуулагддаг.</p> <p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн стандарт нь ажлын байранд осол, өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд мөрддөг зөвшөөрөгдөх дээд хэмжээ, аюулгүй ажиллагааны шаардлага зэргийг тогтоодог тул асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага энэ асуудлыг нэгдсэн бодлогоор хангах зайлшгүй шаардлагатай. Стандарт боловсруулахад холбогдох хуулийн дагуу олон нийтийн хэлэлцүүлэг, санал авдаг тул</p>	

		<p>энэ хуулиар энэ асуудлыг давхардуулан зохицуулах шаардлагагүй.</p>
	<p>Дор дурдсан заалт нь Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулж буй учраас 19.2-т заасан хэсгийг хасах. 19.2.Ажил олгогч нь Хөдөлмөрийн тухай хуулийн 6,7 дугаар зүйлд заасан ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхалтаас ангид орчин бүрдүүлж, ажлын байран дахь дарамт, хүчирхийллээс урьдчилан сэргийлнэ.</p> <p>31.1.Ажлын байрны аюултай хүчин зүйлээс ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, ажил, хөдөлмөртэй холбоотой осол, бэртэл, гэмтэл, өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг хангах, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал, ажил олгогч шууд хариуцна. Ажилтан нь энэ хуулийн 36.2 дугаарын 36.2.1, 36.2.5, 36.2.8 дах хэсэгт заасныг зөрчсөнөөс үүссэн хор уршиг, эрсдэлийг ажил олгогч үл хариуцна.</p> <p>40.3.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн стандартыг шинээр боловсруулах, шинэчлэх асуудлыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллага хариуцна.</p> <p>40.3.1.Тус стандартыг боловсруулахдаа бодит нөхцөл байдалд хэрхэн хэрэгжүүлэх, олон улсын нийтлэг жишиг стандартад тохирсон эсэх, практикт үүсэж буй хүндрэл, бэрхшээлтэй эсэх, бодитой хэрэгжихүйц эсэх талаар мэргэжлийн холбоо, байгууллага, олон нийтээс санал, судалгаа авч үр дүнд суурилах зарчмыг баримтална.</p> <p>49.8. Ажилтны амь нас, эрүүл мэндийн даатгалын байгууллага нь даатгуулагчид дараах нөхөн төлбөр, зардлыг хэний буруутайгаас үл шалтгаалан шууд олгоно:</p>	<p>Хуулийн төслийн 19 дүгээр зүйл ажлын байрны нийгэм, сэтгэл зүй асуудлыг зохицуулсан бөгөөд Хөдөлмөрийн тухай хуультай давхардаагүй.</p> <p>Саналыг тусгав.</p> <p>Саналыг тусгав.</p> <p>Стандарт боловсруулахад мөрдөгдөх зохицуулалт нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний тухай хуулиар зохицуулагдана.</p> <p>Саналыг тусгав.</p> <p>Саналыг тусгав.</p>
15	Сейфти Грийн Зон” ХХК Ч.ЧИНЗОРИГ	Саналыг тусгав.

	<p>2.Хуулийн төслийн 2 дугаар бүлэгт заасан шаардлага тус бүрийн суурь шаардлагыг нарийвчлан тодорхойлж тусгах, тухайлбал үйлдвэрлэлийн орчинд тавих суурь шаардлага, барилгын ажлаас бусад тохиолдолд барилга байгууламж нь хууль тогтоомж, стандарт, техникийн зохицуулалт, норм дүрмийн дагуу баригдаж улсын комисс хүлээн авсан байх зэрэг шаардлагыг тодорхой тусгах.</p>	Саналыг тусгав.
<p>16 Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын ахлах байцаагчаар ажиллаж байсан, одоо өндөр насны тэтгэвэрт буй. 3.Мөнхтуул</p>	<p>Төслийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь заалт “10 ба түүнээс дээш ажилтантай хүн, хуулийн этгээд үйл ажиллагааны онцлог, ажилтны тооноос хамааран хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлыг аль нэг ажилтнаар хавсран гүйцэтгүүлэх эсхүл орон тооны ажилтан ажиллуулах эсхүл гэрээгээр гүйцэтгүүлж болно.” гэсэн нь 31.2 дахь заалтуудтай давхардсан заалт байгаа тул хасах;</p>	Хуулийн төслийн 34.3-д илүү тодорхой болгон дахин найруулсан.
	<p>Төслийн 31 дүгээр зүйлийн 31.4.” Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан ажилтан нь тухайн чиглэлээр их, дээд сургууль төгссөн эсхүл мэргэжлийн холбоогоор цогц чадамжаа баталгаажуулсан байна” гэсний “тухайн чиглэлээр их дээд сургууль төгссөн” гэсэн нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн чиглэлээр гэж ойлгох уу, хэрэв тийм бол аж ахуйн нэгж байгууллагад ажиллаж байгаа хөдөлмөрийн аюулгүй байдлын асуудал хариуцсан ажилтнууд ихэнх нь энэ шаардлагыг хангахгүй болох тул одоо мөрдөж байгаа хуульд заасан инженерийн чиглэлээр гэсэн заалтыг хэвээр үлдээх саналтай байна</p>	Уг заалтыг хасаж 4.1.18, 4.1.19-д ХАБЭМ-ийн мэргэжилтэн, ажилтны тодорхойлолтыг нэмсэн.
	<p>Төслийн 28 дугаар зүйлийн 28.2.3-т “ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний байгууллага энэ хуулийн 43 дугаар зүйлд заасан шаардлагын дагуу хэмжилт шинжилгээнд үндэслэн ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг үнэлж, мэргэжлээс шалтгаалсан өвчний эрсдэлийг арилгах, бууруулах зөвлөмжийг ажил олгогч, ажилтан, холбогдох талд өгөх” гэсний 43 дугаар зүйл нь “Хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилт”-ийн асуудал байх ба ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний байгууллага нь зөвхөн энэ хуулийн 43</p>	Саналыг тусгав.

<p>дугаар зүйлд заасан шаардлагын дагуу үнэлгээ хийхээр заасан байна. Төслийн 42 дугаар зүйл нь “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ” -ний шаардлагыг тусад нь заасан байх тул төслийн 42 дугаар зүйлийн “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ” -ний шаардлагаас холбогдох заалтыг нэмж тусгахаар өөрчлөн найруулах;</p>	
<p>Төслийн 50 дугаар зүйлийн 50.6 дахь заалт гэж байхгүй байгаа тул 50.1 дэх заалтад “Ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол гарсан тохиолдолд энэ хуулийн 50.6”...гэснийг 50.5 гэж засах;</p> <p>Төслийн 51 дүгээр зүйлд мэргэжлээс шалтгаалсан өвчний хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох, бүртгэх, мэдээлэх, статистик мэдээллийн сан бүрдүүлэх журамтай байх эсэх, хэрэв журам байх бол журмыг ямар субъект батлах талаар заалт оруулах;</p>	<p>Саналыг тусгав.</p> <p>Эрүүл мэндийн болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас журам гаргахаар зохицуулсан.</p>
<p>Төслийн 58 дугаар зүйлийн 58.1-д заасан “Хөндлөнгийн хяналт”-ыг төслийн 26 дугаар зүйлийн 26.1.11-д зааснаар зөвхөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллага хийх үү, ямар эрх зүйн актаар хяналт хийх, тусгайлсан журам гарах эсэхийг тодруулах;</p>	<p>Саналыг тусгав.</p> <p>Хуулийн төсөлд 58.1-д Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих төрийн захиргааны хяналтыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, орон нутагт хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ гэж найруулсан.</p>
<p>Төслийн 58 дугаар зүйлийн 58.1-д заасан “Итгэмжлэлийн асуудал хариуцсан байгууллагаас итгэмжлэгдсэн байгууллага нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн дараах асуудлаар хөндлөнгийн хяналт хийж болно” гэвэл одоогийн байдлаар MNS ISO/IEC 17020:2013 Хяналтын ажил эрхэлдэг төрөл бүрийн байгууллагын ажиллагаанд тавих шаардлага” стандартын хүрээнд Үндэсний итгэмжлэлийн төвөөс итгэмжлэгдсэн байгууллагууд техникийн хяналтын үйл ажиллагаа явуулж байгаа. Энэ байгууллагуудын явуулж байгаа үйл ажиллагааг хөндлөнгийн хяналт гэж ойлгох уу, хэрэв тэгж ойлгох бол өргөх механизм, үл эвдэх сорил, өндөр хүчдэл зэрэг аюулгүй ажиллагаатай холбоотой чиглэлүүд энэ хяналтад</p>	<p>Саналыг тусгав. Хуулийн төслийн 62.1-д Итгэмжлэлийн асуудал хариуцсан байгууллагаас итгэмжлэгдсэн байгууллага итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтод заасны дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн дараах хөндлөнгийн хяналтыг ажил олгогч, ажилтны хүсэлтээр хийж болно гэж найруулав</p>

		хамаарах уу. Энэ заалтыг заавал оруулахаар бол Төслийн 53 дугаар зүйлийн 53.2.4-т заасан "хөндлөнгийн хяналт"-ыг "техникийн хяналт" гэж өөрчлөн найруулах, төслийн 58 дугаар зүйлийн 58.1-д заасан асуудалд аюулгүй ажиллагааны чиглэлийг нэмж оруулах;	
17	ХАБЭА-н Үндэсний сургагч багш ХАБЭА-н магистрант А.Еркин	ХАБЭМ-ийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 33 дугаар зүйлийн 33.1.7-т тусгагдсан хэсгээс Өдөр тутмын зааварчилгаа өгөх гэсэн өгүүлбэрийг хасах	Саналыг тусгав.
18	Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлаач эмч, АУ-ны доктор, Д.Хишигтогтох	Мэргэжлийн тохироо нь ажилтны эрүүл мэнд тухайн ажлын байранд ажиллаж хөдөлмөрлөхөд нийцэж байгаа эсэхийг тодорхойлох Цаашилбал ХЧА-ын эмнэлзүй болон шинжилгээнүүдийг үндэслэл болдог тул ажил хөдөлмөрийн тохироо гэдэг нэршлээр явах	Саналыг тусгаж хуулийн төслийн 47.2-д ажил, хөдөлмөрийн тохироо гэсний г ажил, мэргэжлийн тохироо гэж найруулав.
19	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Сувилахуйн сургууль	ХАБЭМ-ийн мэргэжилтэн гэдэгт ямар ажил мэргэжлүүд багтахыг зааж оруулах нь зүйтэй гэсэн санал өгч байна.	Саналыг тусгав. 4.1.18-д ХАБЭМ-ийн мэргэжилтний тодорхойлолт, 25 дугаар зүйлд хөдөлмөрийн эрүүл мэндийн мэргэжилтний тодорхойлолтыг нэмэв.
20	Монголын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нийгэмлэгийг төлөөлөл Довдонбалжир	31.2.1. "нийгмийн эрүүл мэндийн сувилагч болон, хөдөлмөрийн эрүүл мэндийн сувилагч" гэж нэмж тугтах 34-р зүйлийн заалт бүр "Хөдөлмөрийн эрүүл мэндийн олон мэргэжлийн баг" гэж нэмж тусгах	хөдөлмөрийн эрүүл мэндийн сувилагчийн талаар 25 дугаар зүйлд нэмэв Хуулиар зохицуулах шаардлагагүй
21	Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг	ХАБЭА-н тухай хуульд заасны дагуу 0.5 хувийг сангийн яамнаас олголт хийгдэхгүй байгаа асуудлыг шийдвэрлэх Малчид хувиараа бизнес эрхлэгчид чиглэсэн ХАБЭА-н сургалтыг сайжруулах шаардлагатай байна. ХАБЭА-н ажилтнуудыг мэргэжлийн зэрэгтэй болгож, цалин урамшуулал шаталсан тогтолцоотой болгох	Хуулийн төслийн 38.1-д тусгав. Хуулийн төслийн 41 дүгээр зүйлд хувиар хөдөлмөр эрхлэгч, 49 дүгээр зүйл ХАБЭА-н сургалтын талаар зохицуулсан Хуулийн төслийн 33.1.4-д мэргэшлийн зэргээ баталгаажуулах, мэргэшлийн зэргийн нэмэгдэл авах гэж зохицуулсан
21	Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг	Эрүүл мэндийн салбарт ХАБЭА-н дутмаг хүрэлцээгүй, эмч, эмнэлгийн ажилтнуудын 500 гаруй ажилтан хариуцан ажиллаж	Хуулийн ХАБЭМ-ийн нийтлэг зохицуулалтыг тодорхойлсон ба салбар бүр энэ хуульд

		байгаа эрүүл мэндийн салбарт чиглэсэн арга хэмжээ зохицуулалтыг ХАБЭА-н тухай хуульд оруулж өгөөрэй	нийцүүлэн салбарын ХАБЭМ-ийн асуудлыг зохицуулна.
22	Монголын тээвэр холбоо газрын тосны ажилтны үйлдвэрчний эвлэлийн дарга Болдсайхан	Мэргэшсэн ХАБЭА-н ажилтнуудын шагнал урамшуулал асуудлыг хуульд тусгах	Хуулийн төслийн 33.1.4-д мэргэшлийн зэргээ баталгаажуулах, мэргэшлийн зэргийн нэмэгдэл авах гэж зохицуулсан.
23	Хөдөлмөр үйлчилгээний О.Одончимэг	Хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналтыг тогтолцооны эрх үүргийг оруулах	Хуулийн төслийн 6 дугаар бүлгээр энэ асуудлыг зохицуулсан.
24	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар Б.Дулмаа	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчийн авах арга хэмжээнд ЗТХуулийн 10.15-ыг нэмж өгөх.	Хяналтын байцаагч зөрчлийн болон төрийн хяналт шалгалтын тухай хууль тогтоомжийн мөрдөж ажиллана.
25	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар Д.Сосорбурам	Аймгуудын Нэгдсэн эмнэлэг дээр МШӨ-ний талаар анхан шатны үзлэг хийх, зөвлөгөө өгөх кабинет байгуулах талаар хуульд оруулах	Хуулийн төслийн 31.2.5-д "хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг зохион байгуулах эрүүл мэндийн байгууллага нь хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэн хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг, тандалт хийх, ажилтны ажил, мэргэжлийн тохироог үнэлэх, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт илрүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, хөдөлмөр зохицуулалтын асуудлаар ажилтан, ажил олгогчид зөвлөх," гэж заасан ба зөвхөн аймгийн эмнэлгээр хязгаарлаагүй.
26	БГД Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс Л.Эрдэнэбат	Хөдөлмөрийн хяналт бол төрийн хяналт. Иймд хөндлөнгийн хяналт гэж байх ёсгүй. Нийгмийн даатгалын тогтолцоо, ҮОМШӨ даатгалын сангийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээн дээрх сангаас санхүүжүүлэх. Цахим системийг илүү боловсронгуй болгох	Хөндлөнгийн хяналт ажил олгогч хэрэгцээндээ суурилан сайн дураараа хийлгэдэг мэргэжлийн үйлчилгээ бөгөөд төрийн хяналт шалгалтыг орлохгүй. Дагаж нэмэлт өөрчлөлт орох хуульд энэ холбогдох нэмэлт өөрчлөлийг хийхээр төсөл боловсруулсан. Саналыг тусгав.

27	УБТЗ ХНН, Зорчигчийн вагон депо Ц.Батдэлгэр	Аюулгүй байдал хариуцагч ажилтны хамаарах хүрээ, хариуцан ажиллах ажилтны тоог тусгах Эрүүл ахуйчийг заавал ажиллуулах	34 дүгээр зүйлд зарчмын хувьд туссан.
28	ИНУТ ТӨХХК Х. Гансүх	Амь насны даатгал, эрүүл мэндийн даатгалын нөхцөл, нөхөн төлбөрийн хэмжээний доод түшиг тодорхой зааж өгөх	34 дүгээр зүйлд зарчмын хувьд туссан.
29	Баянхонгор АОЭХ Жигмэд Дуламсүрэн	Малчдын ХАБЭМ талаар тусгайлан авч үзэх	Хуулийн төслийн 53 дугаар зүйлийн дагуу даатгалын гэрээгээр зохицуулагдан. Хуулийн төслийн 41 дүгээр зүйлд хувиар хөдөлмөр эрхлэгчдийн ХАБЭМ-ийн сургалтын талаар зохицуулсан.
30	Тэсо пропертис групп Д.Цэрэннадмид	Урьдчилан сэргийлэх ажлыг сайн хэрэгжүүлсэн АО-ыг урамшуулах зохицуулалт хийх Малчдын бүртгэлийг тусгайлан авч үзэх хоршоогоор дамжуулан бүртгэл хөтлөх	ҮОМШӨ-ий даатгалын талаар хууль тогтоомжид урамшууллын заалтыг шинээр нэмсэн.
31	МОШПА ТББ Сүрэн Давааням	Цахимжилтын хүрээнд онлайн болон зайнаас зааварчилга өгөх, авахтай холбоотой зохицуулалтыг заавал оруулах Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг олон улсын ISO 45001 стандартын үзэл баримтлалд нийцүүлэх Ажил олгогчийн үүргийг ISO 45001-д заасны дагуу тодорхой болгох Эрсдэлийн менежментийн тогтолцоог ISO 45001-д нийцүүлэх Ажилтны оролцоог нэмэгдүүлэх (ISO 45001-д заасан "ажилтны идэвхтэй оролцоо" зарчимтай нийцүүлэх) Ажлын байрны эрүүл мэнд, сэтгэл зүйг хамгаалах (ISO 45001-д заасан "ажилтны эрүүл мэндийг хамгаалах" үзэл баримтлалд нийцүүлэх)	хуулийн хэрэгжилтийн хүрээний арга хэмжээгээр хийх боломжтой. хуулийн хэрэгжилтийн хүрээний арга хэмжээгээр хийх боломжтой
32	Таван Богд Нура ХХК Б.Уртнасан	"Ажил олгогч нь ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдлын стандартад нийцсэн мэргэшил эзэмшүүлэх, сургалт зохион байгуулах, ажил мэргэшлийн стандартад тусгагдсан ХАБЭА-н шаардлагыг биелүүлэх хяналт тавих үүрэгтэй." Хор саармагжуулах бүтээгдэхүүн олгох талаар нарийн тусгаж, шаардлагатай бол яг ямар ямар нөхцөлд ажилтнуудад өгөх талаар тодорхой тусгах	Энэ хуулиар нийтлэг мөрдөх ХАБЭМ-ийн шаардлагыг тогтоосон бөгөөд ажил олгогч олон улсын сайн туршлагыг сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлж болно. Хуулиар тухайлан энэ стандартыг иш татах нь ISO стандартын зөвлөгөө, баталгаажуулалтын байгууллагуудыг ашиг сонирхлын зөрчил үүсгэх, ажил олгогчид шаардлагагүй зардал, дарамт болох эрсдэлтэй.
			Хуулийн хэрэгжилтийн хүрээний арга хэмжээгээр шийдвэрлэх боломжтой.
			Хуулийн төслийн 20 дугаар зүйлд хүнсний бүтээгдэхүүн гэдгээр зохицуулсан.

		Хөдөлмөрийн хортой нөхцөл, хэвийн бус нөхцөлийг мэргэжлийн байгууллагаар тодорхойлуулаад хэвийн гэж үнэлгээ гарахад ажилтнууд сайдын эрт тэтгэвэрт гарах ажлын байрны жагсаалтаар бол хэвийн бус нөхцөлд орж байна гэж маргадаг. Тиймээс хуульд мэргэжлийн байгууллагаар үнэлгээ хийлгээд хэвийн хэвийн бус гээд үнэлэгдсэн бол энэ үнэлгээний дүгнэлт нь 1-д явна гэдэг зохицуулалт тодорхой заах	Хуулийн зарчим урьдчилан сэргийлэлтэд суурилсан үндэсний тогтолцоог бэхжүүлэх зорилготой буюу саналтай зарчмын хувьд нийцэж байна.	
33	ЧД-ийн А.Оюунтүлхүүр	ХХҮХ	Төрийн үйлчилгээний байгууллагад харьяалагддаг хөдөлмөрийн хяналтын тогтолцоог ахисан түвшинд хэрэгжүүлэх, тогтолцооны шинэчлэл хийж хуульд өөрчлөлт оруулах. Хуулийн шинэчлэлийн төслийн ажлын хэсэгт хяналт шалгалтыг хэрэгжүүлэгч байцаагч нараас ажлын хэсэгт оруулах ХАБЭА-н санхүүжилтийг заавал тусгаж, зарцуулалтыг зориулалтын дагуу хийж хэрэгжүүлэх, хандлагыг өөрчлөх ҮОХХ-ыг судлан бүртгэх цахим системд холбож төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах ХАБЭМ ийн мэдлэг олгож буй сургалтын төвүүдийг чанаржуул, аттестатчилах, хуулийн хүрээнд үүрэг хариуцлагыг нь тодруулж тусгаж өгөх ҮОМШӨ- ийг судлан бүртгэх платформ хөгжүүлэлт хийх, осол гэмтэл гарахад маш яаралтай цахим программд мэдээлдэг, үүнийг хуулиар үүрэгжүүлэх Бүртгэл мэдээллийн Цахим программ хөгжүүлэлт хийх	Саналыг тусгав. Саналыг тусгав. Саналыг тусгав. Саналыг тусгав. Хуулийн хэрэгжилтийн хүрээний арга хэмжээгээр шийдвэрлэх боломжтой. Хуулийн хэрэгжилтийн хүрээний арга хэмжээгээр шийдвэрлэх боломжтой. Хуулийн хэрэгжилтийн хүрээний арга хэмжээгээр шийдвэрлэх боломжтой. Саналыг тусгав. 6 дугаар бүлгээр зохицуулсан.
35	Энержи Ресурс М.Пүрэвдорж	ХХК	1.ХАБЭА-н хэрэгжилтийг зөвхөн ХАБЭА-н инженер хариуцах бус, удирдлагын бүх түвшинд үүрэг, оролцоог хуульчлах, үнэлгээ, хяналтад хамруулах (ISO 45001-ийн 5.1 заалтад нийцсэн байдлаар).	Энэ хуулиар нийтлэг мөрдөх ХАБЭМ-ийн шаардлагыг тогтоосон бөгөөд ажил олгогч олон улсын сайн туршлагыг сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлж болно. Хуулиар тухайлан энэ стандартыг иш татах нь ISO стандартын зөвлөгөө, баталгаажуулалтын байгууллагуудыг ашиг сонирхлын

			<p>зөрчилүүсгэх, ажил олгогчид шаардлагагүй зардал, дарамт болох эрсдэлтэй хуулийн хэрэгжилтийн хүрээний арга хэмжээгээр хийх боломжтой</p> <p>Саналыг тусгав.</p> <p>Саналыг тусгав.</p> <p>Саналыг тусгав.</p> <p>Саналыг тусгав.</p> <p>Саналыг тусгав.</p> <p>Саналыг тусгав.</p> <p>Саналыг тусгав.</p> <p>Хуулийн хэрэгжилтийн хүрээний арга хэмжээгээр шийдвэрлэх боломжтой.</p> <p>Саналыг тусгав.</p> <p>Саналыг тусгав.</p>
36	Хаанхулд Групп Б.Мянганбанзрагч	ХХК	<p>2.Мэргэжлийн хяналт, ААН-ын мэдээлэл уялдсан байх нөхцөл бүрдүүлэх.</p> <p>1.Барилгын архитектурын зураг төсөл боловсруулахад ХАБЭА-н мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авч баталгаажуулах.</p> <p>2.Барилгын бригад, хувь хүмүүсээр ажил гүйцэтгэсэн тохиолдолд ХАБЭА-г ерөнхий гүйцэтгэгч тал хариуцах.</p> <p>3.Хувь хүн ажил үйлчилгээг барилгын бригадаар ажил гүйцэтгүүлбэл тухайн гүйцэтгэгч тал ХАБЭА-г хариуцах</p> <p>4.Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх заалтыг тодорхой болгох.</p> <p>5.ХАБЭА-н нийт ажилтны сургалт бусад сургалтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгэдэг болгохыг хуульд оруулах.</p> <p>6.Төрийн байгууллага, Ажил олгогч эздийн холбоо, Үйлдвэрчний эвлэл зэрэг байгууллагуудыг сургалт хийдгийг болиулах. Эдгээр байгууллагууд нь өөрийн давуу эрхийг ашиглан үйл ажиллагаа явуулдаг.</p>
37	Барловорлд ХХК	Монголиа	<p>1.Ажил мэргэжлийн тохироог бүх урьдчилсан болон хугацаат үзлэг хийж байгаа эмнэлгүүд бүгд хийдэг байх.</p> <p>2.Ажилтны сэтгэлзүйн эрүүл мэндийн үзлэгийг тогтмолжуулж, сэтгэлзүй тогтворгүй ажилтныг мөн адил илүү аюулгүй ажлын байранд шилжүүлж тухайн ажилтныг болон бусдын эрүүл мэнд, амь насыг хамгаалахаар байна.</p> <p>3.ҮО дээр яг ямар төрлийн гэмтлийг бүртгэх нь тодорхойгүй байдаг. Тохиолдол бүрд Улсын байцаагчаас зөвлөгөө авч, тэдний туршлагаас шийдэж байгаа нь учир дутагдалтай байдаг. Ажил руу ирэх ажлаас буцах зам дах бэртэл гэмтлийг илүү зааглаж өгмөөр байна. Ажилтан компанийн бус тээврийн хэрэгслээр зорчиж байгаа тохиолдолд энэ нь ажил олгогчийн эрсдэлийн хяналтаас гадуур болж байгаа тул дан ажилд ирэх, буцах зам гэдэг нь амьдрал дээр асуудлууд үүсгэж байна. Тэгэхээр компанийн тээврийн хэрэгслээр явбал компани хариуцлагаа хүлээхэд асуудал алга.</p>
			<p>54 дүгээр зүйлээр үйлдвэрлэлийн ослын бүртгэл, мэдээллийг зохицуулалтыг нарийвчилсан.</p>

	<p>4.Хор саармагжуулах бүтээгдэхүүн үнэхээр үр дүн өгдөггүй гэж боддог. Үүний оронд ажил олгогч хөдөлмөрийн хортой нөхцөлд ажилладаг ажилтнуудаа жилд нэг удаа 7 хоногийн сувилалд явуулдаг байвал илүү үр дүнтэй байхаар санагддаг.</p> <p>5.MNS 4969:2000 өдөр тутмын зааварчилгааны дэвтрийг бөглөхөд асуудал үүсдэг. Дуудлагаар хөдөө явж ажилладаг ажилтнууд уг зааварчилгааг стандартын дагуу бөглөх боломжгүй байдаг. Ажил болгонд хэсгийн мастер, удирдах ажилтан хамт яваад байдаггүй учраас зааварчилга өгч чаддаггүй. Үүнийг цахимжуулах шаардлага үүсэж байна.</p>	<p>Энэ зохицуулалтыг хассан. Урьдчилан сэргийлэлт, сэргээн засах зохицуулалтыг тусгасан.</p>
<p>38</p> <p>Боловсролын ерөнхий газар Г.Олонбаяр</p>	<p>Хөдөлмөрийн гэрээний нөхцөлд ХАБЭА-н асуудлыг 2 талын /ажил олгогч, ажилтан/ чиг үүрэгт заавал тусгадаг болгох.Хөдөлмөрийн тухай хууль дахь хөдөлмөрийн гэрээний нөхцөлд дээрх чиглэлээр нэмэлт заалт оруулж уялдуулах.</p>	<p>Хуулийн хэрэгжилтийн хүрээний арга хэмжээгээр шийдвэрлэх боломжтой.</p> <p>Одоогийн хууль тогтоомжоор хөдөлмөрийн гэрээнд тусдаг асуудал юм.</p> <p>Одоогийн хууль тогтоомжоор хөдөлмөрийн гэрээнд тусдаг асуудал юм.</p>
<p>39</p> <p>Хувиараа бизнес эрхлэгч С.Цогбадрах</p>	<p>ХАБЭА-н тухай хуулийн 17.1 заалтад батлагдсан журмын дагуу ХАБЭА-н мэргэжлийн сургалтын байгууллагын сургалтад хамрагдсан байх гэж оруулж өгөх, 17.4-д мөн адил ХАБЭА-н сургалтыг жилд 2-оос доошгүй удаа мэргэжлийн сургалтын байгууллагаар зохион байгуулж гэж оруулж өгөх.</p> <p>27.3.4-т хөтөлбөр боловсруулах сургалт зохион байгуулах гэдэг үгийг хасах</p>	<p>хуулийн хэрэгжилтийн хүрээний арга хэмжээгээр шийдвэрлэх боломжтой.</p> <p>ХАБЭМ-ийн асуудал хариуцсан ажилтан хөтөлбөрийн дагуу сургалт хийх нь сургалтыг чанартай хийхэд хэрэгтэй.</p> <p>хуулийн хэрэгжилтийн хүрээний арга хэмжээгээр шийдвэрлэх боломжтой.</p> <p>Саналыг тусгав.</p>
<p>40</p> <p>Премиум Г.Хасбаатар</p> <p>корпароци</p>	<p>ХАБЭА-н сургалтыг зөвхөн мэргэжлийн багш бүхий сургалтын байгууллагаар л оруулж байхаар зохицуулж өгөх.</p> <p>Хуульд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” ISO45001:2018-д “Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал” нэрлэдэг. Хууль нь эрх зүйн үндсэн бичиг баримт учир нэр томъёо нь хуулиа 42 дагасан байх. Нэр томъёог тодорхой болгох. ХАБЭА юу ХЭМАБ уу?</p> <p>“Эрсдэлийн түвшин их ажлын байр” а.Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээгээр тогтоогдсон б.Ажлын байрны эрсдэлийн үнэлгээгээр тогтоогдсон в.2023 оны А221 тоот тушаалд дурдагдсан ажлын байр гэх мэтээр тодорхой дурдаж өгөх.</p>	<p>Эрсдэлийн үнэлгээгээр тогтоох зохицуулалт төсөлд туссан.</p>

41	МСМ Групп · ХХК Ц.Бат-Оргил	<p>3.1.11."тусгай хувцас" 3.1.12."нэг бүрийн хамгаалах хэрэгсэл" 3.1.13."хамтын хамгаалах хэрэгсэл" MNS4920:2015 стандартаар: Нийтийн хамгаалах хэрэгсэл , Тусгай хамгаалах хэрэгсэл- эдгээрийг нэг мөр ангилал, тодорхойлолтоо гаргах</p> <p>Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгэж ажлын байрны нөхцөлийг тодорхойлохоор А211 тоот тушаалтай таардаггүй. Тэгэхээр А211 тоот тушаалаа барих уу? Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний үр дүнг барих уу нэг тийш нь тодорхой болгох</p> <p>Эрүүл мэндийн үзлэг хийж буй эмнэлгүүдэд хяналт тавих энэ талаар тусгаж оруулах</p> <p>26.2.Төсвийн байгууллага нь тухайн жилийн батлагдсан төсвийн 0.5 хувиас, аж ахуйн нэгж, байгууллага эрсдэлийн түвшнээс хамааран үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тус тус зарцуулна.Байгууллагын эрсдэлийн түвшинг хэрхэн тогтоохыг тусгах</p>	<p>хуулийн хэрэгжилтийн хүрээний арга хэмжээгээр шийдвэрлэх боломжтой.</p> <p>хуулийн хэрэгжилтийн хүрээний арга хэмжээгээр шийдвэрлэх боломжтой.</p> <p>хуулийн хэрэгжилтийн хүрээний арга хэмжээгээр шийдвэрлэх боломжтой.</p>
42	МСМ Групп · ХХК Ц.Бат-Оргил	<p>Компаниас гаргаж өгсөн тээврийн хэрэгсэлд зорчсоноос бусад нөхцөлд ажилдаа ирэх, буцах үед осолд өртсөн бол ҮО осолд тооцоггүй байх. Учир нь компани ажлын байрны эрсдэлийг хянаж чадна. Харин бусад орчны нөхцөлийг үргэлж хянаж чадахгүй шүү дээ. Амралтын байр мөн адил хамаарна...Зөвхөн ажлын байранд, ажил үүрэг гүйцэтгэх үеийн ослыг тооцдог болох.</p> <p>Ажил олгогч, удирдах ажилтны сургалтыг жил бүр хийх шаардлагагүй гэж бодож байна. Нэг л зүйлээ давтаад байдаг тул 2 жилд 1 удаа зохион байгуулах.</p> <p>Хөдөө аж ахуйн салбарын хөдөлмөр эрхлэгчдэд тэдний хөдөлмөрийн аюулгүй байдалд онцгой анхаарах, хуульд оруулах. Тооцоо судалгаа гаргаж дүгнэлт хийх, ХАБ-ыг хуульд тусгаж хамгаалах, урьдчилан сэргийлэх, даатгалд хамруулах, ойлголт таниулга нөлөөллийг жил бүр сурталчлах сургалтад</p>	<p>54 дүгээр зүйлээр үйлдвэрлэлийн ослын бүртгэл, мэдээллийг зохицуулалтыг нарийвчилсан.</p> <p>Саналыг тусгав.</p> <p>Агуулгын хувьд хуулийн төсөлд туссан. Хуулийн хэрэгжилтээр шийдвэрлэх боломжтой.</p>

		хамруулах. Жишээ нь хятад мотоцикл, ахуйн газ хэрэглээ, тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг хангахад чиглүүлэх.	
43	Технотех инженеринг ХХК Д.Эрдэнэбаатар	Барилгын салбарт бригад гээд ажил гүйцэтгэдэг бүлэг хүмүүст ХАБ-н тал дээр хариуцлага хүлээхгүй хуулийн этгээд биш гээд бултаад яваад байгаа. Энэ хүмүүс дээр ямар нэгэн хуулийн зохицуулалт заалт оруулж өгнө үү?	Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн ХАБЭМ-ийн эрх, үүргээр зохицуулсан.
44	ХХҮГ Доржпүрэв Батхуяг	ТХШТХ-д заасан байдаг Төрийн захиргааны хяналт буюу хөдөлмөрийн хяналт хараат бус бие даасан байх нөхцөлийг тусгах.	Агуулгын хувьд хуульд туссан.
45	Гал сэнтий ХХК, Э. Ариунтунгалаг	ХАБЭА- н ажилтнуудын цалин, мэргэжлийн зэргийг тусгах	Хуулийн төслийн 33.1.4-д мэргэшлийн зэргээ баталгаажуулах, мэргэшлийн зэргийн нэмэгдэл авах гэж зохицуулсан.
46	Хэлт Инспекшин ХХК Б.Дөлгөөнбаяр	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/221 дугаар тушаалд хэвийн бус ажил мэргэжлийн жагсаалтад байгаа хэдий ч ХНҮ-гээр хэвийн гарч баталгаажсан ажил мэргэжлүүдэд эрх зүйн зохицуулалт бий болгох	хуулийн хэрэгжилтийн хүрээний арга хэмжээгээр шийдвэрлэх боломжтой.
47	Автотээврийн үндэсний төв Л.Энх-Амгалан	Ажил олгогч, удирдлагуудын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх заалтын тодорхой оруулж өгөх	Санал туссан.
48	Хувь хүн Дэлгэрцогт Оюундэлгэр	ХАБЭА-н тухай хуулийг Замын хөдөлгөөний тухай хууль, Боловсролын тухай хууль, ТАТХуультай уялдуулж, нэмэлт өөрчлөлтийг тэдгээр хуульд оруулах	Ач холбогдолтой хуулиудад дагаж нэмэлт өөрчлөлт хийгдэнэ.
49	ГБХНХЯ Г.Одгэрэл	Хуулийн төслийг нээлттэй байдлаар санал авах, 81, 129-р конвенцын үзэл баримтлалтай уялдуулах шаардлагатай	Саналыг тусгав.
50	Чандмань-Илч ОНӨ ХХК ДАШ ЦЭРЭНЧИМЭД	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан орон тооны ажилтан сум, аймагт байх шаардлагатай. Хавсарч ажилладаг байдлыг болиулах, хуульд тусгах	Байгууллагаас хамаарч ХАБЭМ-ийн асуудал хариуцсан ажилтан, бүтэц уян хатан байх нь зүйтэй.
51	Дархан-Уул аймгийн ҮЭ-ийн холбоо Т.Баяржаргал	ҮО-ыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын гишүүдийг урамшуулах асуудлыг тодорхой тусгах	хуулийн хэрэгжилтийн хүрээний арга хэмжээгээр шийдвэрлэх боломжтой
52	Ай мед техноложис ХХК Б.Эрдэнэчимэг	ХАБЭА ажилтныг байгууллага бүрд орон тоотой байх мөн түүнтэй зэрэгцэн ХАБЭА тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, сар эсвэл улиралдаа үнэлүүлдэг, үнэлгээнээс шалтгаалж	Саналыг тусгав.

		<p>тухайн байгууллагыг торгох эсвэл урамшуулах гэх зэрэг үйл ажиллагааг хийдэг байхаар зохицуулан бодит өөрчлөлт гарах.</p>	
53	<p>Дашваанжил групп ХХК Шагдаржав Бурмаа</p>	<p>Компанийн санхүү стандартын шаардлага хангахгүй хамгаалах хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж, бодис материал, барилгын материал авсан бол СБА-ны дарга, эрүүл мэндийн урьдчилсан үзлэгийн дүгнэлтийг харж ажлын байрны тохироо хийгээгүй, тохирохгүй ажлын байранд авсан, ажлын байрны тодорхойлолтод зааснаас бусад ажлыг гүйцэтгүүлэхэд хориг тавьж журамлаж чадаагүй бол хүний нөөцийн албаны дарга, нар, аюулгүйн зааварчилгаа өгөөгүй, хяналт тавиагүй, аюул, эрсдэлийг тооцоогүй ажилд гаргасан инженерийн албаны дарга ахлах, ажил гүйцэтгүүлэх, туслан гүйцэтгэгч авч ажиллуулах гэрээнд ХАБЭА-н заалт тусгаж өгөөгүй, хууль эрх зүйн зөв дүгнэлт хяналт хийгээгүй хуулийн зөвлөх гэрээний мэргэжилтнүүд, урьдчилсан болон давтан зааварчилгааг үр дүнгүй өгсөн бол ХАБЭА-н мэргэжилтэн хариуцлага хүлээдэг зохицуулалтыг эх хуульд нарийвчлан тусгаж өгөх</p>	<p>Саналыг тусгав.</p>
54	<p>Б.Эрдэнэчимэг</p>	<p>Мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр хөдөлмөрийн чадвар алдсан иргэн өндөр настны тэтгэвэрт шилжихээр өмнө нь авч байсан хөнгөлөлт болох сувилал, нөхөн сэргээх үйлчилгээ зэрэг хөнгөлөлт хасагдсан үүнийг хуулийн төсөлд тусгах талаар судалгаа шинжилгээнд суурилан оруулах</p>	<p>Саналыг тусгав. ҮОМШӨТТТ-ийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.</p>

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ЗӨВШӨӨРӨЛ
ОЛГОХООР ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЬЕГ**

2026.03.18

№	Яамдын нэр	Ирүүлсэн санал	Тайлбар
1	Хууль зүй, дотоод хэргийн яам 2026.03.16 01/1306	<p>1.Хуулийн төслийн 23 дугаар зүйлийн 23.1.4-т үйлдвэрлэлийн осол, аюултай тохиолдлыг судлан бүртгэх дүрэм батлах эрх олгосон зохицуулалтыг тусгажээ.</p> <p>Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална” гэж заасан.</p> <p>Үндсэн хуулийн дээрх хэм хэмжээнд нийцүүлэн Засгийн газраас шинээр боловсруулж байгаа хуулийн төсөлд холбогдох харилцааг бүрэн тусгах, хуулиас доогуур эрэмбийн актаар зарим харилцааг зохицуулахыг хязгаарлах чиглэлийг баримтлан ажиллаж байна.</p> <p>Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 206 дугаар тогтоолоор захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэх, Захиргааны ерөнхий хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах болон авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл боломжийг арилгах, бизнесийн үйл ажиллагаанд тавигдах зөвшөөрөл, бүртгэлийн ачааллыг хөнгөвчлөх, хуулиар тогтоосон хязгаарлалтаас гадуур хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг зохицуулсан дүрэм, журам, тэдгээрийн холбогдох зохицуулалтыг хүчингүй болгох, өөрчлөхийг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосон.</p> <p>Иймд дээрх дүрэмд хамаарах харилцааг хуулийн төсөлд тусгах;</p>	<p>Саналыг тусгав.</p> <p>Үйлдвэрлэлийн осол, аюултай тохиолдлыг судлан бүртгэх дүрмээр зохицуулах харилцааг хуулийн төсөлд тусгасан.</p>
		<p>2.Хуулийн төслийн 47 дугаар зүйлийн 47.6-д “Хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалт, мэргэжлээс шалтгаалсан өвчний жагсаалт болон бүртгэх, мэдээлэх журмыг хөдөлмөрийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.” гэж тусгасан байна.</p>	<p>Саналыг тусгав.</p> <p>“Хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалт, мэргэжлээс шалтгаалсан өвчний жагсаалт болон бүртгэх, мэдээлэх журам” нь хуулийн төслийн 47 дугаар зүйл, 55 дугаар зүйлийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн. Мөн Хууль тогтоомжийн тухай</p>

		<p>Хууль тогтоомжийн тухай хуулийн 27¹ дугаар зүйлийн 27¹.1.-д хуулийн төсөлд захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалт тусгахдаа хуулийн тодорхой зүйл, хэсэг, заалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх, тухайн хуулийн зорилго, зорилт, үйлчлэх хүрээнд нийцсэн байх, захиргааны хэм хэмжээний акт батлахад баримтлах тухайлсан зарчмыг тодорхойлсон байх, зорилго, зохицуулах харилцааны хүрээг тодорхой тусгасан байх, захиргааны хэм хэмжээний акт батлах байгууллага, албан тушаалтныг тодорхойлсон, тухайн этгээдийн хуульд заасан чиг үүрэгт хамааралтай байх, хуулиар тогтоосон иргэн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулаагүй байх зэрэг шаардлагыг хангасан байх шаардлагатай байна.</p> <p>Иймд дээрх эрх олгосон зохицуулалтыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 27¹ дугаар зүйлийн 27¹.1.1-д хуулийн тодорхой зүйл, хэсэг, заалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх, 27¹.1.3-т захиргааны хэм хэмжээний акт батлахад баримтлах тухайлсан зарчмыг тодорхойлсон байх гэсэн шаардлагад нийцүүлэн өөрчлөн найруулах. Жишээ нь: Хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалт, мэргэжлээс шалтгаалсан өвчний жагсаалтыг батлах болон бүртгэх, мэдээлэхэд баримтлах зарчим, жагсаалтыг баталснаар хуулийн аль зүйл, хэсэг, заалтыг хэрэгжүүлэхэд чиглэж байгаа талаар тус тус тусгах;</p> <p>3.Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1-д заасан хуулийн төслийн гарчиг, бүтцийн товёгийг ирүүлээгүй байх тул тус хуулийн төслийн бүрдүүлбэрт хавсаргах шаардлагатай байна.</p>	<p>хуулийн 27¹ дугаар зүйлийн 27¹.1-д заасан шаардлагыг хангасан.</p>
2	Сангийн яам 2026.03.16 01/1825	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах саналыг тусгасны үндсэн дээр Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7	<p>Саналыг тусгав. Хуулийн төслийн гарчиг, бүтцийн товёг хийж хуулийн төслийн бүрдүүлбэрт хавсаргав.</p>

	дахь хэсэгт заасныг үндэслэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл олгож байна.	
--	---	--

_____ ооо _____

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЬБҮГ**

№	Байгууллагын нэр	Ирсэн санал	Саналыг тусгасан байдал
1	Монгол Улсын Шадар сайд Х.Ганхуяг 2025.12.10 ЗГ-2/1000	<p>29.1.3.тухайн чиглэлийн мэргэжилтэнд тавигдах мэргэжлийн цогц чадамж мэргэшлийн зэргийг үнэлэх; гэж өөрчлөх</p> <p>Ажилтны баталгаажуулалт гэж үзвэл олон улсын стандартын байгууллагын ISO 17024 стандартад нийцүүлж баталгаажуулахыг ойлгох тул "баталгаажуулах" гэсэн үгийг хасах</p> <p>59.1.3.ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ; Заалтыг хасах</p> <p>Хуулийн 42.4 дэх хэсэгт "... Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг итгэмжлэлийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагаас итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага стандартын дагуу хийнэ..." гэж заасан боловч 59.1.3 хийж болно гэж оруулсан нь агуулгын хувьд зөрчилтэй.</p>	<p>Саналыг тусгав.</p> <p>Саналыг тусгав.</p>
2	Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд 2025.12.26 ЗГ-3/801	<p>1.Хуулийн төслийн 31 дүгээр зүйлийн 31.2-т "Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь энэ хуулийн 31.1-д заасан үүргийг хэрэгжүүлэхэд байгууллагын үйл ажиллагааны онцлог, ажлын байрны эрсдэлийн түвшин, ажилтны тоог харгалзан дараах байдлаар зохион байгуулна" гэж аж ахуй нэгж, байгууллагын хүрээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлыг хариуцах ажилтнуудыг тодорхойлсон байна. Ингэхдээ 10 хүртэл, 11-50 хүртэл, 51-200 хүртэл, 201-500 хүртэл болон 501 ба түүнээс дээш ажилтантай бол гэсэн ажилтны тооны шалгуураар зааглан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлыг хариуцах ажилтны тогтвортой болон мэргэшсэн байдлыг маш ялгаатай тусгасан байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 4 дэх хэсэгт Монгол Улсын иргэн бүр "...хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах..." эрхийг тусгасан. Энэхүү эрхийн хүрээнд ажилтан бүрийн хөдөлмөрлөх эрх болон түүний хүрээнд үүсэх эрхийг тэгш, шударгаар эдлэх боломжийг бататгасан агуулга юм. Иймд тухайн байгууллагын ажилтны тооноос хамаарахгүйгээр</p>	<p>Эрсдэл өндөртэй салбарт ажлын байранд ХАБЭА-н өдөр тутмын зааварчилгаа, сургалт, эрсдэлийн үнэлгээ, хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт, үнэлгээ, ажилтны эрүүл мэндийн үзлэг зэрэг ажлыг тогтмол зохион байгуулах шаардлагатай. Харин эрсдэл багатай (банк, санхүү, төрлийн үйлчилгээ, төсвийн байгууллага гэх зэрэг) аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгч нар ХАБЭА-н өдөр тутмын зааварчилгаа, үйл ажиллагааг өдөр тутам хэрэгжүүлэх бодит хэрэгцээ шаардлагагүй.</p>

	<p>хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлыг хариуцах ажилтны тогтвортой болон мэргэшсэн байдлыг хуулийн төслийн зорилгыг баримтлан зохицуулалт хийх шаардлагатай;</p>	<p>Иймд бүх ААНБ-д ХАБЭА-н бүтэц, орон тооны мэргэжилтэн ажиллуулахыг шаардах нь санхүүгийн олон хүний нөөцийн хувьд хүндрэлтэй, амьдрал дээр хэрэгжих боломжгүй. Хуульд туссан уг зохицуулалтыг Хөдөлмөрийн сайдын 2015 оны 114 дугаар тушаалаар ХАБЭА-н зөвлөл байгуулах, орон тооны ажилтан ажиллуулах нормативыг баталж, мөрдөн ажиллаж байна.</p>
	<p>2. Энэхүү хуулийн төслийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэгт "Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ" гэж хариуцлагын зохицуулалтыг тусгахдаа "... Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд..." гэж өөрчлөх саналтай байна.</p>	<p>Хуулийн төслийн 33 дугаар зүйлд ХАБЭМ-ийн мэргэжилтний эрх, үүргийг шинээр тодорхойлсон, мэргэшших суралцах, мэргэжлийн зэрэг хамгаалах зохицуулалтыг шинээр бий болгож, мэргэжлийн хүний нөөцийг бэхжүүлэх, дэмжих заалтыг тусгасан.</p>
<p>3</p> <p>Хууль зүй, дотоод хэргийн яам 2026.01.08 1/85</p>	<p>1.Хуулийн төслийн 24 дүгээр зүйлийн 24.2, 31 дүгээр зүйлийн 31.5, 44 дүгээр зүйлийн 44.6, 46 дугаар зүйлийн 46.5, 47 дугаар зүйлийн 47.5, 51 дүгээр зүйлийн 51.4-т тус тус холбогдох, дүрэм, журам батлах эрх олгосон зохицуулалтыг тусгажээ. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд "Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална" гэж заасан.</p>	<p>Саналыг тусгав.</p>

Үндсэн хуулийн дээрх хэм хэмжээнд нийцүүлэн Засгийн газраас шинээр боловсруулж байгаа хуулийн төсөлд холбогдох харилцааг бүрэн тусгах, хуулиас доогуур эрэмбийн актаар зарим харилцааг зохицуулахыг хязгаарлах чиглэлийг баримтлан ажиллаж байна. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 191 дүгээр захирамжаар Монгол Улсын Засгийн газар, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад хуулиар тусгайлан эрх олгогдсон зохицуулалтад дүн шинжилгээ хийж, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосон.

Мөн Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 206 дугаар тогтоолоор захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэх, Захиргааны ерөнхий хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах болон хуулиар тогтоосон хязгаарлалтаас гадуур хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл боломжийг арилгах, бизнесийн үйл ажиллагаанд тавигдах зөвшөөрөл, бүртгэлийн ачааллыг хөнгөвчлөх зорилгоор эрхлэх асуудлын хүрээнд хамаарах захиргааны хэм хэмжээний актыг хууль зүйн үндэслэлийг нягтлан шалгаж, хуулиар тогтоосон хязгаарлалтаас гадуур хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, ашиг сонирхлын зөрчил, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн шинжтэй, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг зохицуулсан дүрэм, журам, тэдгээрийн холбогдох зохицуулалтыг хүчингүй болгох, өөрчлөхийг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосон.

Иймд хуулийн төсөлд захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалт тусгахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийн 27¹ дүгээр зүйл 27^{1.1} хэсэгт заасан шаардлагад нийцүүлэх, мөн зүйлийн 27^{1.2.1}-д зааснаар "Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хуулиар тогтоосноос гадуур хязгаарлах, хариуцлага оногдуулах" асуудлаар захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгохгүй тул хуулийн төсөл Дэх журмуудад хамаарах хүний эрхийг хязгаарлах, хариуцлага тооцохтой холбогдсон харилцааг хуулийн төсөлд тусгахыг тус тус анхаарах нь зүйтэй;

	<p>2.Хуулийн төсөлд нэмэх санал:</p> <p>1.Хуулийн төслийн 3 дугаар бүлэгт Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний тогтолцоо, байгууллагуудын бүрэн эрхийн талаар тусгасан байна. Гэвч тус бүлэгт Улсын Их Хурал, Засгийн газар, аймаг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхийн талаарх зохицуулалтыг орхигдуулсан байх тул хуулийн төсөлд дээр дурдсан байгууллагуудын бүрэн эрхийн талаарх зохицуулалтыг нэмж тусгах;</p> <p>2. Хуулийн төслийн 12 дугаар зүйлд галын аюулгүй байдалд тавих шаардлагын зохицуулалтыг тусгасан байх тул хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт “Галын аюулгүй байдлын тухай хууль” гэж нэмэх</p> <p>3.Хуулийн төслийн гол зорилт нь хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд оршиж байх тул хуулийн төслийн 39 дүгээр зүйлд заасан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зохицуулалтыг нарийвчлан тусгах.</p>	<p>2.Хуулийн төсөлд нэмэх санал</p> <p>1.Саналыг тусгав.</p> <p>2.Саналыг тусгав.</p> <p>3. Саналыг тусгав.</p>
	<p>3.Хуулийн төсөлд нарийвчлан тусгаж, тодорхой болгох талаарх санал:</p> <p>1.Хуулийн төслийн 7 дугаар зүйлийг задлах буюу нарийвчлан тусгах, тухайлбал, үйлдвэрлэлийн орчинд болон барилга байгууламжид тавигдах шаардлага, 7 дугаар зүйлд заасан суурин тоног төхөөрөмж, 8 дугаар зүйлд заасан машин механизм, тоног төхөөрөмжийн ялгааг тодорхой тусгах;</p> <p>2.Хуулийн төслийн 2 дугаар бүлэгт заасан шаардлага тус бүрийн суурь шаардлагыг нарийвчлан тодорхойлж тусгах, тухайлбал үйлдвэрлэлийн орчинд тавих суурь шаардлага, барилгын ажлаас бусад тохиолдолд барилга байгууламж нь хууль тогтоомж, стандарт, техникийн зохицуулалт, норм дүрмийн дагуу баригдаж улсын комисс хүлээн авсан байх зэрэг шаардлагыг тодорхой тусгах.</p> <p>Мөн тус бүлэгт өндөр эрсдэлтэй ажлын байр, өргөх байгууламжид тавих шаардлага, өндрийн ажлын аюулгүй байдлын шаардлага гэх мэт шаардлагуудыг хязгаарлагдмал хүрээгээр тусгасан байна. Түүнчлэн уул уурхайн салбар, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн ажлын байрны шаардлагын талаар зохицуулалт тусгагдаагүй байх тул нарийвчлан,</p>	<p>3.Хуулийн төсөлд нарийвчлан тусгаж, тодорхой болгосон:</p> <p>1.Саналыг тусгав.</p> <p>2. Хуулийн төслийн 2 дугаар бүлэгт заасан салбарын онцлогоос хамаарсан ажлын байрны эрсдэлээс сэргийлэхэд тавигдсан шаардлагууд нь тухайн салбарын хууль тогтоомж, стандарт, нормоор нарийвчлан зохицуулагддаг.</p> <p>Хуулийн төсөлд ажлын байрны эрсдэл бүрээс сэргийлэхэд тавигдах бүх шаардлагыг дэлгэрэнгүй тусгах боломжгүй. Салбарын онцлогоос хамаарсан болон ажлын байрны өндөр эрсдэл бүрээс сэргийлсэн</p>

	<p>“хязгаарлагдмал орчин”, төслийн 44 дүгээр зүйлд заасан “хөдөлмөрийн тохироо” гэдэгт тус тус юуг ойлгох талаар тодорхой тусгах;</p> <p>6.Хуулийн төслийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т заасан “...хоолоор үнэгүй хангах” гэсэн нь хэрэгжих боломжтой эсэхийг дахин нягтлах;</p> <p>7.Хуулийн төслийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг нь зөвхөн ажилтны тоонд үндэслэж хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн ажилтан ажиллахаар байгааг нягталж, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөл, аюултай ажлын орчин зэргийг харгалзан нарийвчлан зааглах шаардлагатай. Тухайлбал, уул уурхай, төмөр зам зэрэг салбарт хөдөлмөрийн хэвийн нөхцөлийн зохицуулалт ижил үйлчлэхээр байгааг анхаарч, ялгамжтай зохицуулах;</p> <p>8.Хуулийн төслийн 31 дүгээр зүйлийн 31.4-т заасан эрсдэлтэй ажлын байр буюу уул уурхайн салбарт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан ажилтан нь тухайн чиглэлээр их, дээд сургууль төгссөн буюу илүү мэргэшсэн байх тухай агуулгыг нэмж тусган, өөрчлөн найруулах;</p> <p>9.Хуулийн төслийн 41 дүгээр зүйлийн 41.3-т “Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл</p>	<p>5.Саналыг тусгав.</p> <p>6. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа ХАБЭА-н тухай хуулиар 2008 оноос хойш ажил олгогч хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилтныг хоолоор үнэгүй хангах зохицуулалт хэрэгжиж байна.</p> <p>7. Хуульд туссан уг зохицуулалтыг Хөдөлмөрийн сайдын 2015 оны 114 дугаар тушаалаар ХАБЭА-н зөвлөл байгуулах, орон тооны ажилтан ажиллуулах нормативыг баталж, ААНБ-ын эрсдэлийн түвшин, ажилтны тооноос хамааран ХАБЭА-н бүтэц, ажилтан, зөвлөл ажиллуулах нормативыг зохицуулсан. Хуулийн төсөлд уг нормативыг нарийвчлан зохицуулсан. Хуульд барилга, уурхай, боловсруулах үйлдвэр, эрчим хүч, зам тээвэр зэргээр салбар бүрээр нь ялгаатай зохицуулах боломжгүй тул ажлын байрны эрсдэлээс хамаарсан байдлаар зохицуулах заалтыг 34.2-т тусгасан.</p> <p>8. Хуулийн төсөлд агуулгын хувьд тусгасан. Уг хуулийн төсөл нь ХАБЭМ-ийн нийтлэг асуудлыг зохицуулж, бүх салбарт хамаарна. Салбарын ХАБЭМ-ийн норм, дүрмээр энэ асуудлыг нарийвчлан зохицуулдаг.</p> <p>9. Саналыг тусгав.</p>
--	---	--

	<p>мэндийн эрсдэлийн үнэлгээ, түүний мөрөөр хэрэгжүүлсэн ажлын тайланг тухай бүр удирдлагын цахим системд оруулна" гэж тусгасан нь хэрэгжих боломжгүй гэж үзэж байна. Учир нь хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн нь ямар байдлаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ, түүний мөрөөр хэрэгжүүлсэн ажлын тайланг тухай бүр удирдлагын цахим системд оруулах талаар тодорхой тусгаагүй байна.</p> <p>Өөрөөр хэлбэл хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн нь тус хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.15-д ("хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ" гэж үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин үүсгэх ажлын байрны аюултай, сөрөг хүчин зүйлийг илрүүлэх, түүний эрсдэлийг стандарт аргачлалаар үнэлэх үйл явцыг) заасны дагуу үнэлгээг хийж чадах болон тухай бүр цахим системд оруулах боломжтой эсэх, тухайн иргэнийг удирдлагын цахим системд эрсдэлийн үнэлгээ, тайланг оруулж байгаа эсэхэд хяналт тавих субьект тодорхойгүй байна;</p> <p>10.Хуулийн төслийн 43 дугаар зүйлийн 43.3-т хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилтээр ажилтан нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн аюултай хүчин зүйлд өртөж байгаа нь тогтоогдвол ажил олгогч энэ талаар удирдлагын цахим системд мэдээлнэ гэж тусгажээ. Гэтэл системд мэдээлсний дараа ямар арга хэмжээ авах нь тодорхойгүй байх тул нарийвчлан тусгах;</p> <p>11.Хуулийн төсөлд тусгасан төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагын нэршлийг зөвтгөж, жигдлэх, төслийн 38 дугаар зүйлийн 38.1 болон 38.2 дахь хэсгийн байршлыг солих.</p>	<p>Цахим системд хувиараа хөдөлмөр эрхлэгч оруулах шаардлагыг хасав. Системийн шийдлийн хувьд хувиараа хөдөлмөр эрхлэгч сайн дураараа бүртгүүлэх боломжтой.</p> <p>10.Саналыг тусгав. Цахимд мэдээлсний мөрөөр яах вэ гэдгээ төсөлд тусгах хуулийн төслийн 48.1-т тусгасан.</p> <p>11.Саналыг тусгав.</p>
	<p>4.Хуулийн төсөлд өөрчлөн найруулах талаарх санал:</p> <p>1.Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын "хүндэрч даамжирсан тохиолдлыг" гэснийг "үүссэн өвчнийг" гэж өөрчлөх;</p> <p>2.Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.2., 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтад заасан "холбогдох зөвшөөрөл" гэж ямар зөвшөөрлийг хэлж байгааг тодорхой тусгах, мөн энэхүү зөвшөөрөл нь Зөвшөөрлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 1-д "Хүн, хуулийн этгээд хуулиар хориглосон,</p>	<p>4.Хуулийн төсөлд өөрчлөн найруулах талаарх санал:</p> <p>1.Саналыг тусгав.</p> <p>2.Саналыг тусгав.</p> <p>3.Саналыг тусгав.</p>

	<p>эсхүл энэ хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан тусгай болон энгийн зөвшөөрөл /цашид "зөвшөөрөл" гэх/-тэйгээр эрхлэхээс бусад төрлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн чөлөөтэй эрхэлж болно" гэж заасантай зөрчилдөхөөр байгааг анхаарч, нийцүүлэх;</p> <p>3.Хуулийн төслийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөлийг стандарт аргачлалаар хийсэн хэмжилт, үнэлгээнд үндэслэн тодорхойлно" гэж, төслийн 26 дугаар зүйлийн 26.1.5-д "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллага нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээний стандарт аргачлал батлах, ажил олгогч, ажилтан, холбогдох талд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх үүрэгтэй" гэж тус тус тусгажээ.</p> <p>Тус заалтууд нь хуулийн төслийн 40 дүгээр зүйлийн 40.3-т "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн стандартыг шинээр боловсруулах, шинэчлэх асуудлыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллага хариуцна" гэж, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д "Үндэсний стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална" гэж тус тус заасантай нийцэхгүй бөгөөд "стандарт аргачлал" гэдгийг хэрхэн ойлгож хэрэгжүүлэх нь тодорхой бус байна.</p> <p>Иймд хуулийн төслийн 15 дугаар зүйлийн 15.2, 26 дугаар зүйлийн 26.1.5 дахь заалтыг тус тус өөрчлөн найруулах.</p>	
	<p>5.Хуулийн төслөөс хасах санал:</p> <p>1.Хуулийн төслийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 дахь заалтыг Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын хууль тогтоомжтой тус тус нийцүүлэх, түүнчлэн төслийн 28 дугаар зүйлийн 28.2.1 болон 28.2.4-т заасан сургалтын байгууллагын хэрэгжүүлэх чиг үүрэг давхардаж байх тул төслийн 28.2.4 дэх заалтыг хасах;</p>	<p>5.Хуулийн төслөөс хасах санал:</p> <p>1.Боловсролын ерөнхий хуулийн "3.1.11."суралцагч" гэж боловсролын сургалтын байгууллагад албан ёсоор суралцаж байгаа хүнийг тодорхойлсон. Хуулийн төсөлд ХАБЭМ-ийн чиглэлээр ажиллаж буй их, дээд сургууль мэргэжилтнийг тухайн мэргэжлийн цогц чадамжийн</p>

	<p>2.Хуулийн төслийн 32 дугаар зүйлд аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн орон тооны бус зөвлөлийн талаар тусгасан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-т “Төсвийн байгууллагад чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоохыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна. Тухайлбал, аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн орон тооны бус зөвлөлийн чиг үүрэг нь хуулийн төслийн 33 дугаар зүйлд заасан аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан бүтэц, ажилтны чиг үүрэгтэй агуулгын хувьд давхардаж байна.</p> <p>Түүнчлэн хуулийн төслийн 32 дугаар зүйлийн 32.3-т “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнд ажил олгогч болон ажилтнаас сонгогдсон төлөөлөл ажиллана. Орон тооны бус зөвлөлийн гишүүдэд урамшуулал олгож болно” гэж тусгасан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т “Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байх тул хуулийн төслийн 32 дугаар зүйлийг бүхэлд нь хасах;</p>	<p>асуудлыг заасан. Олон улсын жишгээр мэргэжлийн холбоо нийгэмлэг нь мэргэшсэн нягтлан бодогч, мэргэшсэн инженер зэрэг олгох практик хэрэгжиж байна.</p> <p>Хуулийн төслийн 31.2.1-т их сургуулиар дээд боловсролтой ХАБЭМ-ийн мэргэжилтнийг бэлтгэх, 31.2.4-т ажил олгогч, ажилтан, хувиараа хөдөлмөр эрхлэгч нарт ҮОМШӨ-аас сэргийлэх мэдлэг, дадал олгох сургалтын асуудлын талаар зохицуулсан. Иймд зохицуулалт давцахгүй.</p> <p>2.МУ-ын нэгдсэн ОУХБ-ын 155 дугаар конвенцын дагуу үндэсний болон засаг захиргааны нэгж, аж ахуйн нэгж байгууллагын түвшний ХАБЭМ-ийн үйл ажиллагаанд ажилтны төлөөллийг оролцуулах үүрэг хүлээсэн. Үүнийг ААНБ-ын түвшинд хангах механизм нь ХАБЭМ-ийн орон тооны бус зөвлөл юм. Хуульд туссан уг зохицуулалтыг Хөдөлмөрийн сайдын 2015 оны 114 дугаар тушаалаар ХАБЭА-н зөвлөл байгуулах, орон тооны ажилтан ажиллуулах нормативыг баталж, ХАБЭА-н бүтэц, ажилтан, зөвлөл ажиллуулах нормативыг зохицуулсан. Уг зохицуулалтыг хуулийн төсөлд нэгтгэсэн.</p> <p>Хуулийн төслийн энэ заалт нь зөвхөн төрийн байгууллага биш бүх</p>
--	--	--

	<p>3. Хуулийн төслийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, 38 дугаар зүйлийн 38.2.2, 38.2.3 дахь заалт нь тус тус Иргэний хуулийн 189 дүгээр зүйлд заасан гэрээний талуудын чөлөөт байдлын зарчимд нийцэхгүй байх тул хасах.</p> <p>Энэхүү саналтай холбогдуулан дагалдан боловсруулсан Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1/10.15 дугаар зүйлийн 10.15 дугаар зүйлийн 6, 7 дахь хэсгийг тус тус хасах;</p> <p>4. Хуулийн төслийн 42 дугаар зүйлийн 42.4-т “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг итгэмжлэлийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагаас итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага стандартын дагуу хийнэ” гэж тусгасан байна.</p> <p>Энэ нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Тохирлын үнэлгээний зорилго нь бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хэрэглэгчийн эрх, ашгийг хамгаалахад оршино” гэж, 13.2-т “Тохирлын үнэлгээнд хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүнийг заавал хамруулна” гэж тус тус заасантай нийцэхгүй байх тул хасах;</p>	<p>ААНБ дагаж мөрдөхөд зориулагдсан. “Орон тооны бус зөвлөлийн гишүүдэд урамшуулал олгож болно” гэсэн нь заавал мөрдөх заалт биш юм.</p> <p>3. Уг асуудал нь Захиалагч, ерөнхий болон туслан гүйцэтгэгч гэрээний чөлөөт байдлыг алдагдуулаагүй. Энэ асуудлыг зохицуулаагүйгээс туслан гүйцэтгэгч, гэрээт байгууллагуудын ажилтнууд осолд орох эрсдэлийг үүсгэдэг. Тиймээс хуулийн төсөлд тусгах нь зүйтэй.</p> <p>4.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 4.1.4-д бүтээгдэхүүн гэж үйлдвэрлэл, үйлчилгээний явцад бий болсон үр дүн гэж тодорхойлсон. Хөдөлмөрийн нөхцөл нь үйлдвэрлэл, үйлчилгээний явцад бий болж, ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлөх ажлын орчны нөлөөлөл юм. Иймд хуулийн тодорхойлолтын дагуу хөдөлмөрийн нөхцөл нь бүтээгдэхүүнд хамаарна. Энэ үнэлгээгээр нь ажил хөдөлмөр эрхлэж буй иргэн хүний аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй ажлын орчны хүчин зүйлсийн үнэлж, дүгнэх үйл ажиллагаа.</p> <p>Энэ хуулийн дагуу 6 байгууллага итгэмжлэгдэн хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийж байна.</p> <p>5.Хуулийн төслийн 44, 45, дугаар зүйл нь УОМШӨ-ний урьдчилан</p>

	<p>үнэлгээ зэрэгт хөндлөнгийн хяналт хийхээр тусгасан нь хуулийн төслийн 41 дүгээр зүйл (хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ), 42 дугаар зүйлтэй тус тус агуулгын хувьд давхардаж байх тул хасах зэрэг болно.</p>	<p>сэргийлэх зорилгоор ажил олгогчийн хийдэг урьдчилан сэргийлэлтийн үйл ажиллагааны хэлбэрүүд юм. Эдгээр үнэлгээг ажил олгогч өөрөө хийх боломжгүй тохиолдолд сайн дурын үндсэн дээр мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн хяналт хийлгэж болно.</p>
<p>4</p> <p>Сангийн яам 2025.12.30 01/11300</p>	<p>1. Хуулийн төслийн 13 дугаар зүйлд хязгаарлагдмал орчинд тавигдах шаардлагын талаар зохицуулсан боловч "Хязгаарлагдмал орчин" гэснийг хэрхэн ойлгох нь тодорхой бус байх тул энэ талаар тодорхой тусгах;</p> <p>2. Хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт эргономик ажлын байрыг бүрдүүлэхэд шаардлагатай ажил олгогчийн үүргийг тодорхойлсон байна. "Эргономик" гэдэг нь ажлын байр, бүтээгдэхүүн, системийг ашиглаж буй этгээдэд тохируулан зохион бүтээх, зохион байгуулах үйл ажиллагаа тул тус хэсэгт ажилтан техник, хэрэгслийг зааварчилгааны дагуу ашиглаж, эрүүл мэндэд нь эрсдэл учирч болзошгүй тохиолдолд ажил олгогчид яаралтай мэдэгдэх үүрэг хүлээх талаар зохицуулалт нэмж тусгах;</p> <p>3. Хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсэгт "Ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгсэл нь стандартад нийцсэн байна" гэж заасан боловч тус стандартыг хэн батлах талаар тусгаагүй байх тул энэ талаар тодорхой тусгах;</p> <p>4. Хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан чиг үүргийг хэн хэрэгжүүлэх нь тодорхой бус байх тул тус зохицуулалтын "Ажил үүргийн хуваарилалт" гэсний өмнө "Ажил олгогч нь" гэж нэмж тусгах;</p> <p>5. Хуулийн төслийн 20 дугаар зүйлийн 20.1.3, 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэгт заасан "хөдөлмөрийн хэвийн бус нөхцөл" гэсэнд ямар нөхцөл хамаарах нь тодорхой бус байх тул тус ойлголтын тайлбарыг төсөлд тусгах;</p>	<p>Саналыг тусгав.</p> <p>Саналыг тусгав.</p> <p>Саналыг тусгав.</p> <p>Саналыг тусгав.</p> <p>Саналыг тусгав.</p> <p>Хуулийн төслийн 4.1.3-д "ажлын байрны хөдөлмөрийн хэвийн нөхцөл" гэсэн тодорхойлолтыг тусгасан. Үндсэн хуулийн 16.2.</p>

		<p>Хөдөлмөрийн тухай хуулиар ажилтан хөдөлмөрийн хэвийн нөхцөлөөр хангагдэх эрх үүргийг заасан. Хуулийн төслөөр хэвийн бус нөхцөлийг тодорхойлж, хүлээн зөвшөөрсөн агуулыг оруулахаас зайлсхийсэн.</p> <p>Хөдөлмөрийн нөхцөлийн ангилал, үнэлгээ хийхэд тавигдах шаардлагыг 2002 оноос хойш MNS 5080 стандартаар нарийвчлан тогтоосон. Уг стандарт 2023 онд шинэчлэгдэн батлагдсан.</p>
	<p>6. Хуулийн төслийн 26 дугаар зүйлийн 26.1.5 дахь заалтад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээний стандарт, аргачлал батлах чиг үүргийг тусгажээ. Тус чиг үүрэг нь Стандартчилал, техникийн зохицуулал, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсэгт заасан Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэгтэй давхцах эсэхийг нягтлах;</p>	<p>Саналыг тусгав.</p>
	<p>7. Төрийн албан хаагчийн цалин хөлс, нэмэгдлийн асуудлыг цалин хөлсний нэгдсэн бодлогын хүрээнд Төрийн албаны тухай хуулиар зохицуулах тул хуулийн төслийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалтад мэргэшлийн зэргийн нэмэгдлийн талаар зохицуулсныг хасах;</p>	<p>Энэ хуулийн төслийг улсын хэмжээнд мөрдөх тул төрийн байгууллагаас гадна хувийн хэвшлийн байгууллагад ажилладаг ХАБЭМ-ийн мэргэжилтэнд мэргэшлийн зэргийн цалин хөлсний нэмэгдэл олгох, салбарын мэргэшсэн хүний нөөцийг дэмжихэд чиглэсэн тул энэ зохицуулалт хэвээр үлдээх нь зүйтэй.</p> <p>Саналыг тусгав.</p>
	<p>8. Хуулийн төслийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт "Төсвийн байгууллага нь тухайн жилийн батлагдсан төсвийн 0.5 хувиас, ...</p>	

		доошгүй хэмжээний хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг хангуулах, ажил хөдөлмөртэй холбоотой осол, бэртэл, гэмтэл, өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсөв, зардлыг жил бүр баталж, дараах арга хэмжээнд зарцуулна." гэж заасан байна. Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэгт "Төсвийн харилцааг зөвхөн энэ хуулиар зохицуулах бөгөөд орон нутаг, салбарын үйл ажиллагаанд санхүүжилтийн эх үүсвэрийн хэмжээг хуульчлан тогтоох, түүнийг хуваарилах аливаа харилцаа үүнд нэгэн адил хамаарна." гэж заасан тул дээрх зохицуулалтаас "төсвийн байгууллага нь тухайн жилийн батлагдсан төсвийн 0.5 хувиас" гэснийг хасах зэрэг болно.	
5	Гадаад харилцааны яам 225.12.09 01/5813	Хуулийн төслийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх хэсгийг дахин найруулж, "ажилтныг" гэсний дараа "богиносгосон цагаар ажиллуулах" гэж нэмэх	Хөдөлмөрийн тухай хуулийн 85 дугаар зүйлийн 85.3-д хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилтны ажлын цагийг богиносгох асуудлыг зохицуулсан.
6	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам 2025.12.15 01/6442	Тусгайлан өгөх саналгүй.	
7	Боловсролын яам 2025.12.30 01/6447	1.Хуулийн төслийн 46.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах; "46.3.Дээд, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага нь суралцагч, иргэнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдлэг, ур чадвар, хандлагыг эзэмшүүлнэ." 2.Хуулийн төслийн 46.5-д заасан журмаар ямар харилцааг зохицуулах нь тодорхой бус байгааг анхаарч Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн томъёолох. 3.Хуулийн төсөл болон танилцуулгад Боловсролын тухай хууль гэж нэрлэснийг Боловсролын ерөнхий хууль гэж өөрчлөх.	Саналыг тусгав Саналыг тусгав. Саналыг тусгав.
8	Эрчим хүчний яам 2025.12.25	Тусгайлан өгөх саналгүй.	

<p>A/4117 Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам 225.12.30 01/3706</p>	<p>Тусгайлан өгөх саналгүй.</p>	
<p>10</p>	<p>7.3-д ...ашиглалтын явцад.. гэснийг ..барилга угсралтын ажлын явцад.. гэж өөрчлөх;</p> <p>Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Барилгын аюулгүй байдал, эрүүл ахуй”-н 1988 оны 167 дугаар конвенцод нэгдэн орсонтой холбоотойгоор 9 дүгээр зүйл Өргөх байгууламжид тавигдах шаардлага хэсэгт уг конвенцын 15 дугаар зүйлийн 1-ийн е хэсэг 2 дугаар хэсэгт заасны дагуу өргөх зөвхөн ажллагааг сургалтад хамрагдсан ажилтан удирдах, өргөх төхөөрөмжөөр хүнийг өргөх буулгах, тээвэрлэх үйлдэл хийхийг хориглосон заалт нэмж оруулах.</p> <p>10 дугаар зүйл. Уурын ба халаах зуух, даралтат сав, шугам хоолойд тавих шаардлага хэсэгт дээрх конвенцын 21 дүгээр зүйлийн 1-д заасны дагуу “зөвхөн бие бялдрын үзүүлэлтүүд нь эмнэлгийн үзлэг, шинжилгээгээр хэвийн гэж баталгаажсан ажилтан, мөн эрх бүхий этгээд үйл ажиллагааг удирдан явуулахыг зөвшөөрнө” гэж зохицуулалт нэмж оруулах;</p> <p>12.1-т ...тогтоомж... гэсний араас “техникийн зохицуулалт” гэж нэмэх;</p> <p>29.1.4-т ... үнэлэх... гэсэн боловч үнэлгээ хийх журмыг хэн боловсруулах, батлах нь тодорхойгүй байх тул хасах;</p> <p>31.4-т цогц чадамжаа баталгаажуулсан... гэж заасан нь мэргэжлийн холбоо цогц чадамж баталгаажуулна гэсэн зохицуулалт байхгүй байх тул хасах;</p>	<p>Саналыг тусгав.</p> <p>Саналыг тусгав.</p> <p>Хуулийн төслийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Энэ хуулийн 47.1-д ажилтныг хөдөлмөрийн эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгт хамруулж, ажил, мэргэжлийн тохироог тодорхойлохоор зохицуулсан”.</p> <p>Саналыг тусгав.</p> <p>Саналыг тусгав.</p> <p>Саналыг тусгав.</p>
<p>11</p> <p>Эдийн засаг, хөгжлийн яам 2026.01.27</p>	<p>Тусгайлан өгөх саналгүй.</p>	

01/225			
12	Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам	Санал ирүүлэггүй.	
13	Батлан хамгаалахын яам 2025.02.15 1а/4602	Тусгайлан өгөх саналгүй.	
14	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам 2026.02.02 01/332	1.Хуулийн төслийн 23 дугаар зүйлийн 23.1.4 дэх заалтын "... мэргэжлээс" гэсний өмнө "урьдчилан сэргийлэх" гэж нэмэх; 2.Хуулийн төслийн 30 дугаар зүйлийн 30.2.4 дэх заалтын "...нууцлалыг" гэсний дараа "холбогдох хууль, тогтоомжийн дагуу" гэж нэмэх; 3.Хуулийн төслийн 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалтын "... баталж мөрдүүлэх" гэсний дараа "эсхүл байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусган түүнийг хэрэгжилтийг хангах" гэж нэмэх; 4.Хуулийн төслийн 31 дүгээр зүйлийн 31.2-31.2.5 дахь заалт нь 31.3.10 дахь заалттай агуулгын хувьд давхцаж байх тул холбогдох заалтуудыг дахин найруулах.	Саналыг тусгав. Саналыг тусгав. Саналыг тусгав. Саналыг тусгаж, тухайн заалтыг дахин найруулав.
15	Эрүүл мэндийн яам 2026.01.28 3/444	Тусгайлан өгөх саналгүй.	
16	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам 2025.12.10 01/2802	Тусгайлан өгөх саналгүй.	
17	Зам, тээврийн яам 2026.01.28 01/455	1.Хуулийн төсөлд УИХ болон Засгийн газрын бүрэн эрх, үүргийг тусгах; 2.Хуулийн төслийн 22 дугаар зүйл. Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх, мөн хуулийн төслийн 23 дугаар зүйл Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх, мөн хуулийн төслийн 24 дүгээр зүйл	Саналыг тусгав. Саналыг тусгав.

	<p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн Үндэсний хороо, түүний бүрэн эрх, мөн хуулийн төслийн 27 дугаар зүйл Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын бүрэн эрх гэж зөвхөн бүрэн эрхийг тусгасан байх тул тухайн субъектын чиг үүргийг тусгах;</p>
<p>18</p> <p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд УБ-хотын захирагч Х.Нямбаатар 2025.06.24 01/4145</p>	<p>3.Мөн хуулийн төслийн 51 дүгээр зүйлийн 51.1-т "... энэ хуулийн 51.5" гэснийг "... энэ хуулийн 52.5" гэж зөвтгөх;</p> <p>4.Хуулийн төслийн 46 дугаар зүйлийн 46.5-д "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална" гэж сургалт зохион байгуулах асуудлыг журамлах бус тавигдах шаардлагыг хуульд тусгах.</p> <p>5.Хуулийн төслийн 19 дүгээр зүйлд "Ажлын байрны нийгэм-сэтгэл зүйн орчин" гэсэн боловч нийгэм-сэтгэл зүйн орчны сөрөг нөлөөнөөс ажилтныг хэрхэн хамгаалах, тусгах</p> <p>Төслийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:</p> <p>1.1.Энэ хуулийн зорилт нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний бодлого, зарчмыг тодорхойлж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдлага, төрийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх, ажилтан, хөдөлмөр эрхлэгч иргэнийг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг хангах, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний тохиолдлыг бууруулах, урьдчилан сэргийлэхэд оршино.</p> <p>Хуулийн зорилтод тусгагдсан "Бэртэл гэмтэл" гэх ойлголт нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод хамрагдах тул хасах. Мөн хурц хордлогыг үйлдвэрлэлийн осолд хамруулж ойлгох нь буруу юм. Иймд хуулийн нэр томъёоны тодорхойлолт хэсэгт нэмж оруулах.</p> <p>2.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Химийн хорт болон аюултай</p>
	<p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн Үндэсний хороо, түүний бүрэн эрх, мөн хуулийн төслийн 27 дугаар зүйл Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын бүрэн эрх гэж зөвхөн бүрэн эрхийг тусгасан байх тул тухайн субъектын чиг үүргийг тусгах;</p>
	<p>Саналыг тусгав.</p>
	<p>Саналыг тусгав.</p>
	<p>Хуулийн төслийн 19.1, 19.2-т тусгасан.</p>
	<p>Хуулийн төслийн 11.4-т "хордлого" гэдэгт химийн хорт болон цацрагт идэвхт бодисын нөлөөгөөр цочмог хэлбэрээр богино хугацаанд хордохыг ойлгоно." гэж тайлбарласан.</p>
	<p>Саналыг тусгав.</p>

	<p>бодисын тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.</p> <p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжид “Эрүүл ахуйн тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль”-ийг нэмэх саналтай байна.</p> <p>Эрүүл ахуйн тухай хууль нь хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулж байгаа бол Химийн хорт болон аюултай бодис тухай хуулиар химийн хорт боон аюултай бодисыг ашиглахтай холбоотой хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны нөхцөл шаардлагыг тогтоодог.</p> <p>3.1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт хамтран ажиллах, ажил гүйцэтгэх гэрээний үндсэн дээр болон бусад хэлбэрээр хөдөлмөрийн харилцаанд оролцогч ажил олгогч болон ажилтан, хувиараа хөдөлмөр эрхлэгч, иргэд хоорондын гэрээгээр ажиллагч;</p> <p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн хамрах хүрээг нарийвчлан тодорхойлж, хэнд хамаарах, хэн дагаж мөрдөх, хэрэгжүүлэхийг тодорхой, ойлгомжтой зааж өгөх хэрэгтэй. Учир нь хуулийг хэрэгжүүлээгүй, хуулиар хүлээлгэсэн үүргээ биелүүлээгүй, хууль зөрчигдсөн тохиолдолд буюу хариуцлага хүлээлгэх шатанд хүндрэл гарах болно.</p> <p>Төслийн 3.1.1-д төрийн албан хаагчид бүгд орохгүй байгаа тул тусад нь тодотгож өгөх шаардлагатай эсэхийг судлах. Мөн прокурорын болон батлан хамгаалах, зэвсэгт хүчний байгууллагуудад гарсан ослыг судлан бүртгүүлэх гэхээр хуулийн хамрах хүрээ нь манайд хамааралгүй гэж татгалзах хандлагатай гарсан талаар холбогдох хяналтын байгууллагуудаас санал гарч байсан тул төрийн тэр дундаа төрийн тусгай албан хаагчийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар хуулийн төсөлд тодорхой зохицуулах.</p> <p><u>Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай дараах заалт нэмэх:</u></p> <p>3.1.5.төрийн албан хаагч;</p> <p>3.1.6.аж ахуйн нэгж, байгууллагад үйлдвэрлэлийн дадлага хийж байгаа их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн суралцагч.</p>	<p>Саналыг тусгав.</p> <p>Хуулийн төслийн 3.1.1-д төрийн бүх албан хаагчид хамаарна.</p>	<p>Хуулийн төслийн 3 дугаар зүйлд уг асуудлыг зохицуулсан.</p>
--	--	--	--

	<p>Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай дараах заалт нэмэх:</p> <p>4.1.19. "Хөдөлмөрийн эрүүл ахуй" гэж хөдөлмөрлөх явцад хими, физик, биологийн хүчин зүйлээс шалтгаалан хүний бие махбодь, мэдрэл сэтгэхүйд өөрчлөлт орж өвчлөх, хөдөлмөрийн чадвараа түр болон бүрэн алдахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг;</p> <p>"Хөдөлмөрийн эрүүл ахуй" нь "хөдөлмөрийн эрүүл мэнд"-ийн үйл ажиллагааны урьдчилан сэргийлэх анхны суурь арга хэмжээ болдог. Иймд одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд байгаа нэр томъёог оруулах.</p> <p>4.1.20. "хурц хордлого" гэж цацраг болон биологийн идэвхт бодис, химийн хорт бодисын нөлөөгөөр хурц, цочмог хэлбэрээр богино хугацаанд хордохыг;</p> <p>Химийн бодисын хурц хордлого нь ажлын байранд гардаг тул үйлдвэрлэлийн ослын нэгэн адил судалж, бүртгэх ёстой. Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хурц хордлоготой холбоотой харилцааг орхигдуулсан байх тул "үйлдвэрлэлийн осол, хурц хордлого" гэж холбогдох бүх заалтад оруулах.</p> <p>4.1.21. "эрүүл ахуйн нөхцөл, шаардлага" гэж эрүүл ахуйн дүрэм, журам, заавар стандартад заагдсан хэм хэмжээг хангасан байхыг; Эрүүл ахуйн тухай хуультай уялдуулж оруулах.</p> <p>4.1.22. "эрүүл мэндийн эрсдэл" гэж хүний эрүүл мэндэд эрүүл ахуйн нөхцөл, шаардлага хангагдаагүйн улмаас үүсэж болзошгүй болон үүссэн сөрөг нөлөөг;</p> <p>Хуулийн төслийн 4.1.9-д заасан "өндөр эрсдэлтэй ажлын байр" гэсэнтэй уялдуулан оруулах</p> <p>4.1.23. "ахуйн байр" гэж иргэн, ажилтны хөдөлмөрлөх хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн тусгайлан төхөөрөмжилсөн хувцас солих, түр амрах, хооллох, бие засах, усанд орох, дулаацах зэрэг зориулалттай ерөө, тасалгааг;</p> <p>Ажилтныг ийм зориулалттай ахуйн байраар хангах нь тэдний эрхийг хамгаалах, эрүүл мэндийг дэмжих, ажлын байрны сөрөг хүчин зүйлийн өртөлтөөс сэргийлэх алхам болно.</p>	<p>Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, нийтлэг хэрэглэгддэг нэр тодорхойлолтыг хуулийн төсөлд ашигласан.</p> <p>Хуулийн төслийн 11.4-т "хордлого" гэдэгт химийн хорт болон цацраг идэвхт бодисын нөлөөгөөр цочмог хэлбэрээр богино хугацаанд хордохыг ойлгоно." гэж тайлбарласан.</p> <p>Хуулийн төсөлд "эрүүл ахуйн нөхцөл, шаардлага" нэр томъёо ашиглагдаагүй.</p> <p>4.1.15-д "хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ" гэсэн тодорхойлолт оруулсан.</p> <p>Хуулийн төслийн 20.1.4-д "ажилтны хөдөлмөрлөх хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн, тусгайлан төхөөрөмжилсэн хувцас солих, түр амрах, хооллох, бие засах, усанд орох, дулаацах зэрэг зориулалтын ахуйн байраар хангах" гэж тодорхойлсон.</p>
--	--	--

	<p>4.1.24. “Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдал” гэж зураг төсөл, техникийн баримт бичигт заасан нөхцөлийн дагуу тоног төхөөрөмжийг ажиллуулахад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шаардлага хангасан байхыг;</p> <p>Төслийн 8 дугаар зүйлд шаардлагыг тусгасан тул нэр томьёог нь тайлбарлах нь зүйтэй. Мөн төслийн 7.1-д энэ нэр томьёог ашигласан байна.</p> <p>4.1.25. “Үйлдвэрлэлийн орчин” гэж ажилтан, ойр орчмын оршин суугч, зорчин явагч хүнийг осол, гэмтэл, бэртлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зайлшгүй шаардлагатай үйлдвэр, үйлчилгээний талбай, гадна орчныг;</p> <p>Төслийн 7.6-д Тайлбар гэж оруулсныг дэлгэрүүлэн нэр томьёоны тайлбарт нэмэх.</p> <p>“Хөдөлмөрийн нөхцөл” гэж хөдөлмөрлөх явцад хүний ажиллах чадвар, эрүүл мэндэд дагнасан буюу хамссан байдлаар нөлөөлөх ажлын байрны болон үйлдвэрлэлийн орчныг гэж нэмж оруулах.</p> <p>“Үйлдвэрлэлийн хортой хүчин зүйл” гэж хүний эрүүл мэндэд нөлөөлж өвчлүүлэх, сэтгэхүйд өөрчлөлт оруулах, хөдөлмөрлөх чадварыг бууруулах, мэргэжлийн өвчин бий болгох уршиг бүхий үйлдвэрлэлийн хүчин зүйлийг гэж нэмж оруулах.</p> <p>“Хөдөлмөрийн аюулгүй нөхцөл” гэж ажилтанд нөлөөлөх үйлдвэрлэлийн хортой ба аюултай хүчин зүйлийн нөлөөллийн түвшин нь хөдөлмөрийн аюулгүй байдлын тогтоосон хэм хэмжээнээс хэтрээгүй байхыг гэж нэмж оруулах.</p> <p>“Ажлын байран дахь эрсдэл” гэж үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчинд хүргэж болзошгүй ажлын байрны нөхцөлийг гэж нэмж оруулах.</p> <p>“Эрсдэлийн үнэлгээ” гэж ажлын байрны эрсдэлд үнэлэлт өгөх үйл явцыг гэж нэмж оруулах.</p> <p>Өмнөх хуульд тусгагдсан байсан эдгээр нэр томьёонуудыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн төсөлд тусгаагүй байх тул нэмэх.</p> <p>Хуулийн төсөлд “үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдал” гэсэн тусгайлан нэршил ашиглагдаагүй.</p> <p>7 дугаар зүйлд Энэ зүйлд заасан “үйлдвэрлэлийн орчин” гэдэгт аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны талбай, гадна орчныг ойлгоно” гэж тайлбар оруулсан.</p> <p>Хуулийн нэр томьёог олон улсын нийтлэг нэршил, үндэсний онцлогтой нийцүүлэн ойлгомжтой болгож шинэчлэн найруулсан.</p>
	<p>4.1.4. “ажлын байрны аюултай хүчин зүйл” гэж үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод хүргэх, хүний амь нас, эрүүл мэнд, хөдөлмөрлөх</p>

	<p>чадварт сөргөөр нөлөөлж ажил, хөдөлмөртэй холбоотой гэмтэл бэртэл, өвчин, хордлого үүсгэх үр дагавар бүхий ажлын байрны хүчин зүйлийг; гэж өөрчлөх</p> <p>Хуулийн төслийн 4.1.10-тай уялдуулах</p> <p>4.1.10. “Үйлдвэрлэлийн осол” гэж хөдөлмөр эрхлэгч иргэн хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах ажлын байрны аюултай хүчин зүйлсийн үйлчлэлд өртөхийг;</p> <p>Үйлдвэрлэлийн осол зөвхөн ажлын байранд гардаггүй тул “ажлын байрны аюултай” гэдгийг хасах. Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолын 2.1.1-2.1.6 дахь заалтыг харах. Мөн ажил үүргээ гүйцэтгэж байхдаа цус харвах, зүрх зогссон тохиолдлыг үйлдвэрлэлийн осол гэж үзэх үү гээд шалгуурыг нь тодорхой болгох шаардлагатай.</p> <p>4.1.11. “хөдөлмөрийн аюулгүй байдал” гэж хөдөлмөрлөх явцад хүний эрүүл мэнд, хөдөлмөрлөх чадварт үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллийн түвшин нь эрүүл ахуйн зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрээгүй байхыг;</p> <p>“Хөдөлмөрийн аюулгүй байдал” гэдэг хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн нэр томъёоны тайлбар илүү оновчтой гэж үзэж байна.</p> <p>Аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэлийн орчин нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн стандартын шаардлагыг хангасан байна.</p> <p>Үйлдвэрлэлийн байр талбай нь холбогдох стандартаар зохицуулагдах учир стандартын гэж оруулах</p> <p>7.2. Ажил олгогч үйлдвэрлэл, үйлчилгээний барилга байгууламжийг барьж байгуулах, өргөтгөх, шинэчлэх, машин техник, тоног төхөөрөмж угсрах, суурилуулах, турших, засвар хийхдээ хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагыг хангасан байна. Ажил олгогч үйлдвэрлэлийн барилга байгууламжийг барьж байгуулах, өргөтгөх, шинэчлэх, машин техник, тоног төхөөрөмж угсрах, суурилуулах, турших, засвар хийхдээ эрсдэлийг үнэлэх, хяналт тавих комисс байгуулж ажиллуулна.</p> <p>Энэ нь яг ямар шаардлагыг хангасан байх ёстой вэ гэдэг нь тодорхойгүй байна. Барилга байгууламжийг барьж байгуулах, өргөтгөх, шинэчлэх, машин техник, тоног төхөөрөмж угсрах, суурилуулах, турших, засвар хийхэд холбогдох инженер, техникийн ажилчид хамтран хийдэг тул</p>		<p>Энэ хуулийн төслөөр бүх салбарт мөрдөгдөх ХАБЭМ-ийн нийтлэг шаардлагыг зохицуулсан бөгөөд салбарын онцлогоос хамаарсан эрсдэлийг тухайн салбарын хууль тогтоомж, норм, дүрэм, техникийн зохицуулалтаар нарийвчлан зохицуулна.</p>
--	--	--	--

	<p>тодорхой тооны гишүүнтэй комисс байгуулна. Тэдгээр хүмүүс нь тухайн төсөл/ажлын эрсдэлийн үнэлгээг хийж аюултай нөхцөл байдалд тохирсон урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсны дараа ажлаа хийж гүйцэтгэдэг.</p> <p>Ажлаа дууссаны дараа баталгаатай, найдвартай байдлыг хангаж акт үйлдэж өмчлөгч, эзэмшигчид хүлээлгэн өгнө.</p> <p>8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай дараах заалтыг нэмэх:</p> <p>8.1.4 машин механизм, тоног төхөөрөмжийг суурилуулах болон их засварын дараа ашиглалтад оруулахдаа улсын байцаагчаар хянуулж зөвшөөрөл, гэрчилгээ авсан байх.</p> <p>8 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавьж баталгаажуулах нь ажилтныг аюулгүй байдлыг хангасан тоног төхөөрөмж дээр ажиллуулж эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилготой бөгөөд Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа.MNS 4930: 2000-д тусгагдсан байдаг. Мөн төслийн 8.2-т "Машин механизм, тоног төхөөрөмжийг бусдад шилжүүлэхдээ ашиглалтын паспорт, гэрчилгээний хамт шилжүүлнэ" гэж заасан бөгөөд гэрчилгээг олгох асуудлыг өмнөх хуулийн дагуу хэвээр үлдээх.</p> <p>Төслийн 11 дүгээр зүйлд дараах хэсгийг нэмэх:</p> <p>11.5.Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах, худалдаалах, түгээх, цэнэглэх, тээвэрлэх үйл ажиллагаанд дараах шаардлагыг тавина:</p> <p>11.5.1.эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны хамтран баталсан химийн болон аюултай бодис хадгалах, ашиглах, устгах журмыг баримтлах;</p> <p>11.5.2.аюултай ачаа илгээгч нь гарч болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө, аюулгүй ажиллагааны зааврыг батлуулж, тээвэрлэгч байгууллага, жолооч, дагалдан яваа ажилтнуудад танилцуулах, энэ тухай баталгаажуулах;</p> <p>11.5.3.шингэрүүлсэн шатдаг хий тээвэрлэгч автотээврийн хэрэгслийн торх нь даралтат савны стандартыг хангаж, хяналтын байгууллагаас аюултай ачаа тээвэрлэх зөвшөөрөл авах;</p> <p>11.5.4.шингэрүүлсэн шатдаг хий, аюултай ачаа тээвэрлэх маршрутыг аль болох замын хөдөлгөөний эрчим, бартаа саад бага байхаар сонгож,</p>	<p>Зөвшөөрлийн тухай хуульд саналд тусгасан зөвшөөрлүүд тусгагдаагүй тул хуулийн төсөлд нэмэх боломжгүй.</p> <p>Саналыг тусгав.</p>
--	--	---

	<p>тээвэрлэх цэг хугацаа, замын хөдөлгөөнд оролцох чиглэлийг орон нутгийн онцгой байдлын болон замын цагдаагийн албанд мэдэгдэж, зөвшөөрөлдөх, аюулгүй тээвэрлэх зөвлөмж, даалгавар авах;</p> <p>11.5.5. аюултай ачаа тээвэрлэх, онцгой ажил гүйцэтгэх бүрд аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх;</p> <p>11.5.6. автомашинд хий түгээх станц нь орон сууц, олон нийтийн барилга байгууламжаас ерөнхий сүлжээний авто замын хөвөө, захаас галын аюулгүй байдлын зайг хангах.</p> <p>Гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор нэмсэн бөгөөд шаардлагатай тохиолдолд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдуулж Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулахаар боловсруулах.</p>	
<p>24.3. Хөдөлмөрийн тухай хуулийн 15.4-т заасан аймаг, нийслэлийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо нь орон нутгийн түвшинд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлаар нийгмийн түншлэлийг хэрэгжүүлнэ.</p> <p>Аймаг, нийслэлд тусдаа хороо байх нь зүйтэй тул уг заалтыг өөрчлөх.</p>	<p>Сум, дүүрэгт ХАБЭМ-ийн зөвлөл ажиллахаар төсөлд тусгасан. Аймаг, нийслэлийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо нь ХАБЭМ-ийн түншлэлийг хэрэгжүүлэхээр төсөлд тусгав.</p>	<p>Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын харьяа ХАБЭМ-ийн төрийн үйлчилгээний байгууллага тул энэ байгууллагаар ажлын албаны чиг үүргийг хэрэгжүүлж болно.</p>
<p>24.5 “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллага нь Үндэсний хорооны ажлын албаны үүргийг гүйцэтгэнэ”</p> <p>24.6 “Үндэсний хорооны үйл ажиллагааны зардлыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний, салбар хорооны үйл ажиллагааны зардлыг уг асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний жил бүрийн төсвийн багцад тус тус тусгана” тус тус хасах</p> <p>Үндэсний хороог сайд ахалж байгаа тул холбогдох төрийн захиргааны төв байгууллага нь ажлын алба байх нь зүйтэй.</p>	<p>24.5 “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллага нь Үндэсний хорооны ажлын албаны үүргийг гүйцэтгэнэ”</p> <p>24.6 “Үндэсний хорооны үйл ажиллагааны зардлыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний, салбар хорооны үйл ажиллагааны зардлыг уг асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний жил бүрийн төсвийн багцад тус тус тусгана” тус тус хасах</p> <p>Үндэсний хороог сайд ахалж байгаа тул холбогдох төрийн захиргааны төв байгууллага нь ажлын алба байх нь зүйтэй.</p>	<p>Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын харьяа ХАБЭМ-ийн төрийн үйлчилгээний байгууллага тул чиг үүргийг тусгах нь зүйтэй.</p>
<p>26 дугаар зүйл “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллагын чиг үүрэг” хасах</p> <p>Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ чиг үүргийг хэрэгжүүлэх нь зүйтэй. Төслийн 25.2-т заасан чиг үүрэгтэй давхардаж байгаа тул ийм байгууллага байх шаардлагатай эсэхийг дахин судлах. Мөн төслийн 26.1.3, 26.1.11, 26.1.12, 26.1.13-т заасан чиг</p>	<p>Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын харьяа ХАБЭМ-ийн төрийн үйлчилгээний байгууллага тул чиг үүргийг тусгах нь зүйтэй.</p>	<p>Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын харьяа ХАБЭМ-ийн төрийн үйлчилгээний байгууллага тул чиг үүргийг тусгах нь зүйтэй.</p>

	<p>үүрэг нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн зохицуулалт, улсын байцаагчийн чиг үүрэгтэй давхардаж байна.</p> <p>44 дүгээр зүйлд дараах хэсгийг нэмэх:</p> <p>44.3.Хөдөлмөрийн эрүүл мэндийг урьдчилсан болон хугацаат үзлэгт ажилтныг хамруулах зардлыг ажил олгогч хариуцна. Ажил олгогчид үүрэг болгох нь зүйтэй гэж үзэж байна.</p> <p>47 дугаар зүйл.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдлагын цахим систем</p> <p>47.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдлагын цахим систем нь дараах мэдээллээс бүрдэнэ:</p> <p>47.1.4.үйлдвэрлэлийн осол, аюултай тохиолдол</p> <p>47.1.9.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хяналт, шалгалт гэснийг тус тус хасах</p> <p>Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9.1.2-т хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг хяналт шалгалтын байгууллага хөтлөхөөр заасан. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын цахим бүртгэлийн системийг мэргэжлийн хяналтын байгууллага нь хөтөлж, хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч нар бүртгэж мэдээлдэг тул давхардал бий болохоор байна.</p> <p>49.4.3 дахь заалтыг хасах</p> <p>Эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулах нь ажил олгогчийн үүрэг, зардлыг нь ажил олгогч хариуцах нь зүйтэй. Мөн “ажил хөдөлмөрийн тохироо хийлгэх” гэдэг нь ойлгомжгүй байна.</p> <p>49.4.4 “Эрсдэл өндөртэй ажлын байранд ажилладаг даатгуулагчийг хөдөлмөрийн эрүүл мэндийн хугацаат үзлэгт хамруулах” гэснийг хасах</p> <p>Эрсдэл өндөртэй ажлын байранд олон салбарын олон ажилтан ажиллаж байгаа тул эрүүл мэндийн хугацаат үзлэгт хамруулахад гарах тооцоог хийсэн эсэх нь тодорхойгүй, даатгалын сан санхүүжүүлэх боломжтой эсэхийг дахин судлах.</p> <p>54.2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төрийн захиргааны хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу эрх</p>
	<p>Саналыг тусгав.</p> <p>Нийгмийн даатгалын сангаас УОМШӨ-ийн тэтгэвэр, тэтгэмж, телбөр олгох тухай хуулийн 16-р зүйлтэй уялдуулан ХАБЭМ-ийн нэгдсэн цахим систем байхаар зохицуулсан.</p> <p>Саналыг тусгав.</p> <p>Ажил, хөдөлмөрийн тохироо хийх нь ажилтан эрүүл мэндийн хувьд тэнцэх эсэхийг эмнэлгийн үзлэг, хөдөлмөрийн нөхцөлд үндэслэн тодорхойлдог мэргэжлийн үйл ажиллагаа юм.</p> <p>Саналыг тусгав.</p> <p>Саналыг тусгаж, давхцалыг арилгав.</p>

	<p>олгосон хөдөлмөрийн, хөдөлмөрийн эрүүл ахуйн болон нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч гүйцэтгэнэ.</p> <p>Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчид тавих мэргэжлийн шаардлага, чиг үүрэг нь өөр байдаг.</p> <p>Мөн төслийн 55.1.6, 55.1.7, 55.1.8-д заасан бүрэн эрхийг нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч хэрэгжүүлдэг.</p> <p>54.3 "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төрийн захиргааны хяналтын бодлогыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална" гэснийг өөрчлөх</p> <p>"Хяналтын бодлого" гэсэн ойлголт байх эсэх, мөн бодлогыг Засгийн газрын гишүүн батлах нь бусад хууль тогтоомжтой зөрчилдөж болзошгүй тул "бодлого" гэдгээс өөр нэр томъёо хэрэглэх нь зүйтэй.</p> <p>54.4.Төрийн захиргааны хяналтыг хэрэгжүүлэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлаар урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн хяналтыг төлөвлөхдөө энэ хуулийн 47.1-д заасан удирдлагын цахим системийн өгөгдөл, мэдээлэлд үндэслэнэ.</p> <p>Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5.1-д "Хяналт шалгалтыг төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, орон нутагт хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага /цаашид "хяналт шалгалтын байгууллага" гэх хуульд заасан үндэслэл, журмын дагуу хийх бөгөөд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн гэж ангилна" гэж заасантай уялдуулах.</p> <p>55 дугаар зүйл.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төрийн захиргааны хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх улсын байцаагчийн бүрэн эрх</p> <p>55.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төрийн захиргааны хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9-д зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ" гэснийг өөрчлөн найруулах</p> <p>Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчид тавих мэргэжлийн шаардлага, чиг үүрэг нь өөр байдаг тул бүрэн эрхийг нь ялгаж оруулах.</p>	<p>Саналыг тусгав.</p> <p>Саналыг тусгав.</p> <p>Саналыг тусгав.</p>
--	--	--

	<p>Мөн төслийн 55.1.6, 55.1.7, 55.1.8-д заасан бүрэн эрхийг нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч хэрэгжүүлдэг тул мөн тусад ялгаж оруулах.</p> <p>55.1.8 “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр хөдөлмөрийн чадвараа алдсан иргэн, ажилтанд сэргээн засан тусламж, үйлчилгээ болон мэргэжлийн нөхөн сэргээлтэд хамрагдах төлөвлөлтийг хийж, дэмжлэг үзүүлэх” гэснийг хасах</p> <p>Энэ дэмжлэгийг мэргэжлийн эмч, эмнэлгийн байгууллага хийх нь зүйтэй тул улсын байцаагчийн чиг үүргээс хасах.</p>	<p>Саналыг тусгав.</p>
--	--	------------------------

ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН ЖАГСААЛТ, ХУГАЦААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн төсөлд дараах захиргааны хэм хэмжээний актыг батлахаар тусгасан. Үүнд:

1. Хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалт, мэргэжлээс шалтгаалсан өвчний жагсаалт болон бүртгэх, мэдээлэх журам

Хуулийн төсөлд захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалтын талаарх мэдээлэл:

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт “Хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалт, мэргэжлээс шалтгаалсан өвчний жагсаалт болон бүртгэх, мэдээлэх журмыг хөдөлмөрийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.” гэж тусгасан.

Хуулийн төсөлд тусгасан захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27^{1.1} дэх хэсгийн хуулийн тодорхой зүйл, хэсэг, заалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх, тухайн хуулийн зорилго, зорилт, үйлчлэх хүрээнд нийцсэн байх, захиргааны хэм хэмжээний акт батлахад баримтлах тухайлсан зарчмыг тодорхойлсон байх, зорилго, зохицуулах харилцааны хүрээг тодорхой тусгасан байх, захиргааны хэм хэмжээний акт батлах байгууллага, албан тушаалтныг тодорхойлсон, тухайн этгээдийн хуульд заасан чиг үүрэгт хамааралтай байх, хуулиар тогтоосон иргэн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулаагүй байх зэрэг шаардлагыг хангасан болно.

Хуулийн төсөлд тусгасан хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалт, мэргэжлээс шалтгаалсан өвчний жагсаалт болон бүртгэх, мэдээлэх журам нь хуулийн төслийн 47 дугаар зүйл “Хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг, тандалт”, 55 дугаар зүйлийн “Мэргэжлээс шалтгаалсан өвчний бүртгэл, мэдээлэл, түүнтэй холбогдсон хөдөлмөр зохицуулалт”-ыг тус тус хэрэгжүүлэхэд чиглэгдсэн.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хууль хүчин төгөлдөр болж мөрдөгдөж эхэлсэн өдрөөс энэ хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт заасан журмыг боловсруулан батална.

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ

АЖЛЫН ХЭСГИЙН НЭРС

(УИХ-ын чуулган болон Байнгын хорооны хуралдаанд оролцох)

№	Овог, нэр	Албан тушаал	Утасны дугаар
1.	Тилеуханы Аубакир	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	9911-4595
2.	Баярсайханы Солонгоо	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын Дэд сайд	9999-7021
3.	Лхагвасүрэнгийн Мөнхзул	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга	9909-8704
4.	Баасансүрэнгийн Алимаа	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын газрын дарга	9900-8539
5.	Басангийн Батжаргал	Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга	9101-2211
6.	Цэнд-Аюушийн Ганцэцэг	Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга	9929-3440
7.	Дамирангийн Нарансүх	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн дарга	9400-4884
8.	Цэвэлийн Отгонтунгалаг	МҮЭХ-ны ерөнхий нарийн бичгийн дарга	9901-6953
9.	Чимэдцэрэнгийн Нанжидсамбуу	МАОЭНХ-ны дэд ерөнхийлөгч	9916-4811
10.	Жигжидийн Оюунчимэг	МҮХАҮТ-ын Бодлого стратегийн газрын дарга	9905-1399